
МҮХАҮТ болон Эдийн засгийн сэтгүүлч,
шинжээчдийн клубээс хамтран зохион
байгуулсан

COVID-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН ОРЧИН: СОРИЛТ БА БОЛОМЖ

нийтлэлийн уралдааны бүтээлүүд

ЕХ-ны "Монголын худалдааг дэмжих төсөл"
(TRAM)-ийн дэмжлэгээр хэвлүүлэв.

Эмхэтгэсэн: Батбаярын Баяртогтох
Редактор: Эрдэнэбилэгийн Адъяасүрэн

• • • • •

МЭНДЧИЛГЭЭ



МҮХАҮТ үүсгэн байгуулагдсан түүхт 60 жилийн ойг тохиолдуулан Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубтэй хамтран зохион байгуулсан " COVID-19 цар тахлын дараах бизнесийн орчин: Сорилт ба Боломж" нийтлэлийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн сэтгүүлч, нийтлэлч нартаа талархал илэрхийлье.

МҮХАҮТ нь бизнесийн төлөөллийн хамгийн том байгууллагынхаа хувьд, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, баялаг бүтээгч хувийн хэвшлээ сонсох, бодлогын өмгөөлөл үзүүлэх чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд бизнес эрхлэгчдийн дуу хоолойг илэрхийлэх, байр суурийг олон нийтэд хүргэхэд хэвлэл мэдээллийн байгууллага, тэр тусмаа сэтгүүлчдийн үүрэг, оролцоо хамгийн чухал билээ.

2020 он бол маш онцлогтой жил болон улирч байна. Эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчинд COVID-19 цар тахлын нөлөө томоохон дохио, цохилт болсон төдийгүй төрийн бодлого, шийдвэр, хувийн хэвшлийн бизнесийн төлөвлөгөөнд хүртэл эрс өөрчлөлт хийхэд хүргэлээ. Дэлхий нийтэд айдас, түгшүүр дагуулсан энэхүү цар тахлыг монголчууд бид эрүүл мэндийн хувьд харьцангуй хохирол багатай даван туулж байгаа ч эдийн засгийн хувьд багагүй хохирол амсч байна.

МҮХАҮТ-аас бизнес эрхлэгчдийг хамруулсан удаа дараагийн судалгаа явуулж, эдийн засгийг эрчимжүүлэх багц саналууд боловсруулан төр засагт хүргүүлсэн төдийгүй Эдийн засгийг эрчимжүүлэх нэгж байгуулж, хямралаас 900 хоногт гарах хөтөлбөрийг санаачлан танилцуулаад байна. Сэтгүүлчид ч мөн энэ хугацаанд бидний үйл ажиллагааг сурталчлан идэвхтэй хамтран ажиллаж ирлээ.

Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубтэй хамтран цаашид бид олон ажил хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй. Үүний нэг нь таны гарт хүрч байгаа сэтгүүлчдийн бүтээлийн эмхэтгэл юм. Зөвхөн уралдаанаар хэмжигдэхгүй энэ оны турш цар тахлын эдийн засагт үзүүлж буй нөлөө, түүний үр дагавар бизнесийн орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үүний хохирлыг хэрхэн бага байлгах боломж, гарцыг эрэлхийлсэн сэтгүүлчдийн бүтээлийг бид хамтатган хүргэж байна. Энэхүү эмхэтгэлийг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлсэн ЕХ-ны Монголын худалдааг дэмжих ТРАМ төсөлд талархал илэрхийлье.

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин

МЭНДЧИЛГЭЭ



Дэлхий нийтийг түгшээсэн цар тахлын эдийн засаг, бизнесийн орчинд үзүүлж буй нөлөө их. Аялал жуулчлал, худалдаа, тээвэр, үйлчилгээ гээд бүхий л салбар гүнзгий хохирол амсаж, мөнгөн дүн нь хэдэн тэрбум ам.доллараар хэмжигдэх болов. Хөрөнгө оруулалт, бизнесийн орчны дэг жаяг, компанийн ашиг, орлогын төлөвлөгөө ч дагаад өөрчлөгдөж байна. Хүмүүсийн амьдралын өдөр тутмын хэв маяг хүртэл ондоошиж, шинэ бизнес, шинэ харилцаа, шинэ соёл өнөөдөр бий болж эхэллээ. Улс орон болгон цар тахлын аюулд нэрвэгдэж, боломжоо алдаж, өөр нэгэн шинэ боломжийг мөн олж харж, түүнийгээ атган авах гэж мэрийж байна. Монгол Улс хөдөө аж ахуйн салбараа дэмжих, дотоодын аялал жуулчлалаа хөгжүүлэх, импортыг орлох, экспортыг тэтгэх, ажлын байрыг хадгалсан төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болов.

Эдийн засгийн сэтгүүлчдийн энэ онд хамгийн их хөндсөн, бичсэн сэдэв цар тахал, түүний хор уршиг, нөлөө байлаа. Бизнесийн орчинд одоо ч цар тахлын үр дагавар мэдрэгдсээр. Ажилгүй, орлогогүй болсон аж ахуйн нэгж, ажлын байраа алдсан олон мянган иргэд өнөөдөр хямрал, хүндрэлийн хатуу сорилтыг амсаж байна. Арав гаруй жилийн түүхтэй, бие даасан, хараат бус Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб нь 60 гаруй гишүүнтэй бөгөөд сэтгүүлчдийг мэргэшүүлэх, сургах чиглэлд анхаарч ирлээ. Цаашид ч энэ үүргээ улам далайцтай хэрэгжүүлэх болно. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын 60 жилийн ойг угтан Эдийн засгийн сэтгүүлчдийн шилдэг бүтээлийн уралдааныг Танхимтай хамтран зохион байгууллаа.

Клуб жил болгон сэтгүүлчдийн дунд шилдэг бүтээлийн уралдааныг зарлаж ирсэн. Үүгээрээ уламжлал гэж хэлж болно. “Цар тахлын дараах бизнесийн орчны боломж ба сорилт” сэдэвт уралдаанд оролцсон болон он гарснаас цар тахлын эдийн засгийн нөлөөг хөндсөн сэтгүүлчдийн бүтээлийг нэгтгэн эмхэтгэлээ. Энэхүү санааг дэмжиж, уншигчдын гарт хүргэх боломжийг олгосон МҮХАҮТ-ын удирдлагуудад талархал илэрхийлье.

Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубын Ерөнхий зохицуулагч Б.Баяртогтох



Болдбаатарын Энхцэцэг
ХУИС-д олон улсын сэтгүүлч мэргэжил эзэмшиж төгссөн бөгөөд Сингапур, Женев, Лондон, Эстонид богино болон урт хугацааны хөтөлбөрүүдэд хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн.

Телевизийн сэтгүүлчээр нэг жил, цахим хуудас болон сэтгүүлийн сэтгүүлчээр ес дэх жилдээ ажиллаж байна.

Одоо Ecomoty Media компанийн хяналтын редактороор ажилладаг. МСНЭ-ийн "Ган үзэгтэн" шагналтай.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ: ТАХЛЫГ ДИЙЛСЭН Ч АЙДАС ҮЛДЭХЭД

~LONELY PLANET~

Б.Мөнхнаран Вьетнамын эргийн хот болох Нячангаас Монголд хүйтний улирал шувтрах үе буюу гуравдугаар сард буцах байв. Хоёрдугаар сарын 1-ний өдөр ээлжит аялагчдаа тосохоор, компанийнхаа тосох хуудсыг өндөрт өргөн онгоцны буудал дээр очин хүлээжээ. Гэтэл жирийн үед 15 хүнтэй байдаг аяллын баг энэ удаад ердөө л таван хүнтэй бууж ирэхэд л тэрбээр байдал бишдэж буйг ойлгож, дараагийн аялал гэж байхгүйг мэдэв.

Монголчууд энэ үед Вьетнамд хийх аяллаа хэдийнэ цуцалж эхэлсэн байлаа. Оны өмнө Мөнхнаранд жуулчны компани нь гуравдугаар сарын дунд хүртэл аяллын группууд Монголоос завсаргүй очно. Тиймээс тэр хүртэл байрлаж ажилла гэдэг чиглэл өгч, Нячанг руу явуулжээ.

Нэгдүгээр сарын 23-нд цар тахлын голомт болсон БНХАУ-ын Уханиас Нячанг хотод ирсэн ахимаг насны эр хүүдээ халдвар тарааснаар Вьетнамд КОВИД-19-ийн анхны тохиолдол бүртгэгдсэн юм. Үүний дараа Вьетнамын Засгийн газар Ухань-Нячангийн шууд нислэгийг зогсоов. Хятад жуулчдын урсгал гэнэт татрахад гадныхны хөлд дарагддаг газрууд эл хуль болж, эзэнгүйдэж эхэлжээ. Гэсэн ч КОВИД-19-ийн шинэ тохиолдол өдөр бүр бүртгэгдэж байсан тул Нячангд үлдсэн Өмнөд Солонгос, Орос, Монголын хэдхэн жуулчин төд удалгүй буцав.

Долоохон хоногийн дотор дайжих нь дайжиж, гэртээ бүгэх нь бүгснээр нар, сар ээлжлэхээс бусдаар өдөр, шөнө нь ялгагдамгүй нам гүм руу шилжлээ. Аялагчдын хөлд дарагддаг далайн эрэг элснээс өөр ханьгүй, давалгаанаас өөр сонсогдох чимээгүй болов. Бүгд явж байхад, байгаа газраа хүлээх нь Мөнхнаранд түгшүүр төрүүлж эхлэв. Тэрбээр “Коронавирусийн тухай бид сонссоор байсан ч эхэндээ тоогоогүй. Гэвч нүдэн дээр л хот эзгүйрч, маскыг хайрцаг



Зоригийн Цэлмэг

*М УИС-ийг олон улсын
сэтгүүлч мэргэжлээр, ХУИС-д
англи хэлний орчуулагчаар
суралцаж төгссөн.*

*2015-2019 онд “Засгийн
газрын мэдээ” сонинд
орчуулагч, сэтгүүлч, Эдийн
засаг, уул уурхайн албаны
эдитороор ажиллаж байсан
бөгөөд одоо “Монголиан
экономи” сэтгүүлд сэтгүүлчээр
ажиллаж байгаа.*

*2018 онд “Балдорж сан”-ийн
нэрэмжит сэтгүүл зүйн шилдэг
бүтээлийн уралдааны шилдэг
10-т шалгарч байсан. МСНЭ-
ийн “Ган үзэгтэн” шагналтай.*

хайцгаар нь авч, үнэ нь 2-3 өдрийн дотор хэд нугарч байсан нь хүмүүс үнэхээр айж, байдал хэцүүдэж байгааг мэдрүүлсэн” гэв.

Шууд нислэг цуцлагдсан тул Нячангаас Хо Ши Мин-Хонконг-Улаанбаатар гэсэн гурван дамжлагаар Мөнхнаран болон түүний сүүлийн аялагчид буцаж иржээ. Хоосон шахам Хонконгийн онгоцны буудал тэднийг угтаж, ойр орчмын зочид буудлууд нислэгээ хүлээсэн, яарсан, айсан хүмүүсээр дүүрэн байж. Тэд бол энэ онд хил хаагдахаас 14хөн хоногийн өмнө аялж амжсан төдийгүй хорионд орчихолгүй, тусгай нислэг хүлээлгүй гэртээ ирж чадсан азтанууд.

Сурвалжлагын маань гол дүр Батмөнхийн Мөнхнаран бол азтануудын тоонд орсон хүмүүсийн нэг юм. Гаднын жуулчид нэрийг нь хэлэх гэж үйлээ үздэг тул тэрбээр MG гэх товч нэрийг өөртөө “оноожээ”. Түүний хувьд 13 жил хөтөч орчуулагчаар ажиллахдаа анх удаа англи нэрээ энэ жил ашигласангүй. MG зундаа гэрээт компаниудынхаа групп аяллуудыг ахалж, гаднын гийчдийг дагуулан Монгол орныг тойрдог бол өвлийн ид хүйтэнд гадагш аялж буй монголчууддаа үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд хүйтний улиралд дулаан орон руу тэмүүлэх монголчууд олширч байгаа ч зуны оргил үе шиг бүх хөтөч, орчуулагч хангалттай ажилтай, хүрэлцэхүйц орлоготой байдаггүй. Аа гэхдээ, улирлын чанартай энэ салбарт олон жил итгэл даан ажиллаж, салбартаа танигдчихсан MG шиг хүн-капиталуудын хувьд аялал жуулчлалын оргил үеэс бусад цагт иймэрхүү байдлаар амьдардаг. Хуваарь ёсоор бол MG өнгөрсөн оны сүүлчээр Нячанг хотод түр суурьшаад, Монголоос ирэх “Нью жуулчин турс” компанийн найман группийг аялуулчихаад, хавар гуравдугаар сарын сүүлч гэхэд Монголдоо ирэх байв. Тэрбээр хөтөч орчуулагчдын сургагч багш учраас хавар гуравдугаар сараас эхлэн салбарын шинэ залуусаа сургах, нэг ёсондоо зуны бэлтгэл ажилд ордог. “Коронадуулаад” санд мэнд наашилсан MG ирсэн даруйдаа сургалтууд зохион байгуулагдахгүйг ойлгов.

Эхэндээ бүгд л КОВИД-19-ийг түр зуурынх, тэгэхийгээд гайгүй болно гэж найдаж байлаа.

Монгол дахь аяллуудын захиалга жилийн өмнө баталгаажсан тул компаниуд хөл хорионы үеэр ч бэлтгэлээ хангаж, хорио тавигдмагц ханцуй шамлан орохоор хүлээж байв. “Нью жуулчин турс” ба Америкийн Overseas Adventure Travel (OAT) компаниудын Монголд хамтран зохион байгуулдаг групп аяллууд нь МG-ийн хувьд зуны “нуруу” аяллууд нь юм. ОАТ Монгол дахь чадавхжуулах сургалтын хуваарь болон аяллын хугацаа, хөтчүүдийн хариуцах аяллын тоог тодорхой товлосон байв. “Миний гол аяллууд дөрөвдүгээр сар гэхэд цуцлагдсанаар, энэ зун ажилгүй болж байгаагаа мэдсэн” гэж МG хэллээ.

Ийнхүү МG тэргүүтэй хөтөч, жолооч, тогооч, менежер гээд аялал жуулчлалын салбарт ажилладаг 88 мянга гаруй хүний 30 орчим хувь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж, хүчээр хүлээлтэд оров. (88 мянга гэдэг бол БОАЖЯ-наас мэдээлж буй тоо бөгөөд Монголын аялал жуулчлалын холбооноос 115 мянган хүн энэ салбарт ажилладаг гэв) Эдгээр хүмүүсийн дунд компаниараа тэг зогсолтод орж, дарга цэрэггүй ажилгүй болсон нь ч багтана. Баталгаажсан аяллын тоонд үндэслэн МАЖХ-ноос тооцсоноор энэ жил жуулчдын тоо 10 хувиар өсч, нийт орлого өмнөх жилийнхийг давахаар байжээ. Гэвч энэ бүхэн өнөө жил Монголын эдийн засгаас арчигдаад зогсохгүй дараа жил хэрхэх нь эргэлзээнд ороод байна.

~СҮҮЛЧИЙН ЖУУЛЧНЫ МӨР БА ХҮЛЭЭЛТ~

“Би ирээд явлаа. Солонгос улсын иргэн.....2020.02.06” хэмээн Монголын Үндэсний түүхийн музейг үзэж сонирхсон хамгийн сүүлийн жуулчдын нэг бичиж үлдээжээ. Түүнээс хойш долдугаар сарын 2-нд л сая нэг үзэгч “Хүүхдийн тэрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан шаттай болвол гоё” гэж бичсэнээс хойш тус музейн санал хүсэлтийн дэвтэрт монгол үзэгчдийн сэтгэгдэл нэлээд хэдэн хуудас үргэлжилнэ. Музей бүхэл бүтэн таван сарын турш хаалттай байжээ.


МG-г орж ирэхийг харсан музейнхэн баярлан угтах ч, жуулчингүй ганцаар явахыг чинь харах хачин байна шүү гэцгээв. Хөл хорионы үед засвар, тохижилтын гэх мэт дотоод ажил хийснээс бусдаар бол үзэгчдээ үгүйлэн хийцгүйрч, улмаар тасалбар, төсөл хөтөлбөрөөс цугладаг 700 сая төгрөгийн орлого тэр чигтээ тасалдсаныг музейн Маркетингийн албаны дарга Ц.Буянхишиг хэллээ.

“Энд байсан бэлэг дурсгалын дэлгүүр нүүчихэж дээ?” хэмээн МG музейн үүдний зүүн тал руу занган асуухад музейн менежер “Сувенир Хаусын салбар байсан юм. Нүүсээн” гэв. МG-ийн жуулчид музейгээ үзчихээд ихэнх нь тэрхүү бэлэг дурсгалын дэлгүүрт янз бүрийн зүйлс сонирхож, худалдаж аваад зогсож байдагсан. Харин энэ жил жуулчин ч үгүй, дэлгүүр ч үгүй.

Ийнхүү хандах зүг өөрөө тогтож, биднийг хөтөлсөн нь “Сувенир Хаус”-ын төв дэлгүүр дээр ирэхэд хүргэв. ОХУ-ын Элчин сайдын яамны баруун булангийн замын эсрэг талд орших энэ дэлгүүр 15 жил тасралтгүй “догь” байршилд буюу жуулчдын хөл хөдөлгөөн бараадан бат байршиж ирсэн. “Нээлттэй” хэмээх бичгийг хараад итгэж ядан хаалгыг нь түлхэхэд онгойж буй нь яг л гайхамшиг мэт санагдав. Гэвч үүдээр ормогц шанаагаа тулсан худалдагчаас өөр хүнгүй эл хуль байх ажээ. Биднийг угтсан Ч.Даваадорж захирал “Орлого байтугай хүнгүй иймэрхүү л байна даа” гэв. Сар шинийн баярт зориулсан үндэсний хувцасны шинэ коллекцоо борлуулахаар бэлдэж байсан ч хөл хорионы улмаас “шатжээ”. Жуулчдад Монголд аялсных нь дурсгал болдог тус дэлгүүрийн сувенируудыг 300 гаруй хувь хүн,

Хилийн хязгаарлалт


Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэдээгээр 9 дүгээр сарын байдлаар 93 улс жуулчдад хилээ нээгээгүй байна.



Source: UNWTO

Аялал жуулчлалын салбарын орлого ба зарлага


2010 оноос монголчуудын гадаадад зорчихдоо зарцуулдаг мөнгө Монгол Улсын аялал жуулчлалаас олдог орлогоос давж эхэлжээ.



Source: Монголбанк

Аялал жуулчлал дахь Ковидын нөлөө ба хүлээлт

Аялал жуулчлал дахь Ковидын нөлөө ба хүлээлт



Source: Сурвалжлах багийн санал асуулга

бичил аж ахуй нэгжүүд нийлүүлдэг байв. Гэвч одоо “**Бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн маань талаас илүү нь өөр ажил эрхэлдэг болсон байх**” гэж Ч.Даваадорж захирал хэллээ.

Орлогын тасалдал оны эцэс гэхэд 90 хувийг давах нь нэгэнт тодорхой болсон бөгөөд долоон салбараа хааж, ердөө л энэ “төв” салбар нь ийнхүү ажиллаж байгаа аж. Уг нь энэ жил шинээр хоёр салбар нээхээр төлөвлөж байжээ. Хэдийгээр бэлэг дурсгал нь хүний тав дахь хэрэгцээнд ордог ч хилийн хориг цуцлагдаж зорчих хөдөлгөөн сэргэх л юм бол борлуулалт нь идэвхжинэ. Жуулчдаас гадна гадаадад сурдаг монгол оюутнууд гол үйлчлүүлэгчид тул намар жуулчны улирлын төгсгөлөөс үргэлжлээд бараанууд овоо сайн гүйдэг байлаа. Гэвч энэ жил хилийн хориг бүх л боломжийг нь үгүй хийсэн. Одоо хамгийн наанадаж ирэх жилийн сар шинийн баяр хүртэл Ч.Даваадорж захирал ба түүний ард байгаа 300 урчууд тэсэх хэрэгтэй болох нь. Үгүй бол үлдсэн ганц салбарынх нь хувь заяа эргэж мэднэ.

“Нээрээ халаасны хулгайчид ч тоож ирэхээ больсон шүү дээ” гэхэд өнөөх нь “Халаасны хулгайчид дампуурсан. Манай хандивын хайрцаг ч бас дампуурсан. Жуулчид доллар, юань эсвэл 10, 20 мянгатын дэвсгэртүүд уг нь хийдэг юм. Тэндээс овоо юм цугладаг байсан” хэмээн Жанрайсаг бурханы сүмийн гадаа намрын нарны илч дор хийцгүйрэн суух тахилч лам ба харуул хоорондоо хөөрөлдөх аж. Үүнийг сонссон МГ “Нээрээ, Ганданд цүнх саваа ч тоохгүй ийм тайван алхаж, ингээд зогсож үзээгүй юм байна шүү дээ” гээд инээв.

Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн хурал ном эрт эхэлдэг учир үргэлж хотын аяллын маршрутын эхний зогсоол байсаар ирсэн. Харин энэ удаад МГ Гандангийн төв хаалгаар ормогцоо зүүн талын жижиг байшин руу заагаад “Тасалбар түгээгчийн оронд зурхайч суудаг болчихож” хэмээн өндөр дуугаар бидэнд өгүүлэв. Өнгөрсөн 10 гаруй жил жуулчдад тасалбар түгээхийн зэрэгцээ зав чөлөөгөөрөө зураг зурж борлуулдаг байсан Гонио (Гандангийнхан түүнийг ингэж дууддаг) энэ жил цомхотголд орж, ажлын байраа зурхайчид “тавьж” өгчээ. Түүний хаана юу хийж яваа, эргэж ирэх эсэхийг хэн ч мэдэхгүй байв. Гандантэгчэнлин хийд аялал жуулчлалын 20 гаруй компанитай гэрээлэн жилд 30 орчим мянган жуулчинд үйлчилдэг байжээ.

Ямартай ч Гандантэгчэнлин хийдийнхэн цар тахлын дараа Монголд ирэх жуулчдад зориулан шинээр барьсан Батцагаан дуганд 40 гаруй мянган үзмэртэй, нэг сая гаруй судрын фондтой музейгээ нээхээр шаргуу ажиллаж буйгаа Аялал жуулчлал хариуцсан лам Б.Дашдэмбэрэл ярьсан.

“Ойрд хэдэн америк хөгшиддөө санаа зовоод байгаа болохоор мэдээ их чагнаж байна өө. Хэд нь өнхрөөд өгсөн бол гэхээс сэтгэл зовох юм. Саяхан нэгтэй нь интернэтээр ярьсан болохоор жаахан сэтгэл амар байна” хэмээн шавилхан биетэй Т.Сайлау эгч санаа алдан хэлэв. Тэртээ өнгөрсөн зуунд Налайх хотыг бүтээн байгуулахад оролцохоор ирж байсан Э.Иврайм болон Т.Сайлау зургаан охины аав, ээж бөгөөд жуулчин хүлээн авч зочлуулдаг болоод найм дахь жилтэйгээ золгож буй. Харин энэ жилийн зун хэчнээн урт бас уйтай байгааг хоёр хөгшин ам уралдан ярина. 2005 онд нийслэлийн “Авъяаслаг гэр бүл”-ээр шалгарч байсан дурсгалтай зургаа бидэнд үзүүлэнгээ, жуулчны улирал дөхөөд л гэрээ барьж, шинэ хувцас хэрэглэл оёж хатгаж, хөгжим зэмсэг, дуу бүжгээ зэхдэг байсан тухайгаа хэлээд мөн л санаа алдав. Нас дээр гарсан ч яриа хөөрөө цовоо бөгөөд тод яруу, үйл хөдлөл нь хурц шаламгай байгаагаас ажихад хоёр хөгшний хувьд жуулчдад үйлчилнэ гэдэг мөнгөнөөс илүү амьдралынх нь баяр баясал байж ирсэн нь анзаарагдав.

Э.Иврайм гуайн эхнэр Т.Сайлау “Бид жуулчны компаниудтай хийсэн гэрээний дагуу жуулчдаа тогтмол хүлээж авдаг. Их сайхан ажил. Хүүхдүүдийн маань англи хэл сайжирч, ирэх сургаар нь маргааш бүжиглэнэ, домбордоно гээд л бөөн баяр болдог юм. Манайхаар ирсэн жуулчид маш өндөр сэтгэгдэлтэй, зарим нь бүр баярлаад уйлаад буцдаг” гэлээ. Корона хурдан намжиж, уйтай энэ цаг үе дуусаасай хэмээн ах, эгч хоёр өдөр бүр залбирдаг. Залбирал биелэлээ олвол жуулчдад зориулсан гэрээ барьж, тоглолтын ганган хувцасаа өмсөхийг тэд юу юунаас илүү хүсэж буй.

Э.Иврайм гуайнх тэтгэврээс гадна жуулчдад үйлчлээд сард сая гаруй төгрөгийн орлоготой ажилладаг аж. Нэмэлт орлогоороо өнгөрсөн жилүүдэд хүүхдээ унаа тэрэгтэй болгож, хоёр ч охиноо гэр бүлтэй болоход нь уламжлалынхаа дагуу ор дэрийг нь базаагаад өгч. Энэ жил бас нэг охиныхоо ор дэрийг зэхэхээр төлөвлөж байсан нь талаар болсонд охин нь “Заавал миний ээлж дээр корона гарах даа яах вэ дээ” хэмээн гомдоллосон гэнэ.

Э.Иврайм гуайн охинд тохиолдсонтой яг ижил явдал Тэрэлжийн Зурхайчийн аманд зусдаг Б.Ганбаатарын мөн давхацжээ. Монгол ахуйг жуулчдад сурталчлан таниулдаг Б.Ганбаатар гуайнх энэ жил нэг охиныхоо хурим найрыг хийж, орон гэрийг нь төхөөрч өгөхөөр төлөвлөсөн байж. Гэвч цар тахлаас болоод төлөвлөгөө

нэг жилээр хойшилж байгааг гэрийн эзэгтэй М.Лхамноржмаа гуай хэллээ. Налайхаас хөдөлж давхисаар харуй бүрийтэй уралдан эднийд ирэхэд М.Лхамноржмаа эгч урд саравчиндаа хурууд өрөөд дуусаж байсан билээ. Бид түүнийг даган цэмбийж цэлийсэн, өрөм цагааны тансаг үнэр хамар цоргим гэрт оров. Жуулчин ирлээ гэж “андуурч” бэлдээгүй байгаадаа гэмээр цэмцгэр гэр, идээ будаа өрөөстэй. Тэрбээр “За боорцог ид. Боорцог ч гэж дээ үйлдвэрийн боов. Жуулчингүй болохоор боорцог хааяа л хийнэ. Даанч хөгцрөөд байх юм. Орсон, гарсан улс иддэг ч жуулчид шиг сонирхохгүй. Жуулчид амтыг нь авчихвал хуруугаа зоогоод л идээд байна шүү дээ” гэсээр биднийг өрмөөр “гоёсон” ширээнд урив.

М.Лхамноржмаа эгч гаднын жуулчингүй ч энэ зун дотоодын аялагчдын хөл хөдөлгөөнд нэлээд дарагдсан гэнэ. Илүү гурван гэрээрээ дотоодын аялагчдад үйлчилж, сүү цэгээгээ зарж борлуулах зэргээр орлогоо залгуулж буй аж. Гэхдээ л жуулчдаас олдог орлоготой харьцуулахад бага. Гаднын том компанийн шалгуурт хүртэл тэнцсэн эднийх үүднээсээ цэмцийх ба бүх ажлаа түүртэхгүй амжуулж, ямар ч цаг үед асаалттай танк шиг бэлэн айл аж. Яг л шүлэг дуу, зохиолд гардаг шиг хоол унд, ааш сайн зочломтгой монгол айлын бодит жишээ байв. МG-ийн хэлснээр бол наадмаар хүртэл наадамлаад “алга болчихолгүй” жуулчнаа тосоод суудаг хариуцлагатай айл ажээ.

**БНСУ, Япон,
БНХАУ л
КОВИД-19-ийн
дараах богино
хугацааны
сэргэлтийг
Монголын
аялал
жуулчлалд
авчрах гол зах
зээлүүд.**

“Сайн мэдээ дуулгахад, манай компани 2020 оны зарим аяллаа 2021 онд шилжүүлж, бас ирэх оны аяллын захиалгаа нээсэн. Гэхдээ одоогоор Монголын аялал зарагдсан эсэхийг хэлж мэдэхгүй” гэж МG гол яриагаа эхлүүллээ. Хариуд нь “Кемпински” зочид буудлын Борлуулалтын албаны дарга Ц.Тамир “Гол нь манай хил, гааль юу болох нь уу. Хэзээ нээгдэх нь ёстой бүү мэд” хэмээн эргэлзэнгүй өгүүлнэ. Хорио тогтоож, хил хааснаар орлогынх нь цөм болдог өрөөний үйлчилгээ, хурал уулзалтын арга хэмжээ таг зогссон. “Хил хаах сургаар үйлчлүүлэгчид хугацаанаасаа өмнө гарч, баталгаажсан захиалгууд нүдэн дээр л цуцлагдсан даа” хэмээн тэрбээр ярилаа.

Гэхдээ тэд хүний нөөцөө бусдаас дээгүүрт тавьж, нэг ч ажлын байр цомхотгоогүй, толгой компаниас нь цалингийн 60 хувийг олгосоор өнөөг хүртэл тэссэн. Борлуулалтын албаныхан энд тэндгүй эрвийх дэрвийхээрээ гүйсээр долдугаар сараас гадаадаас ирсэн ирээд хөл хорионд байгаа иргэдэд үйлчилж эхэлжээ. Одоогоор хүчин чадлынхаа 20-30 хувиар л ажиллаж байгааг Ц.Тамир хэллээ.

“Ирэх жилийн тухайд хүлээлт өндөр биш байгаа. Эхний ээлжинд дотоодын жуулчлал, дараа нь зайлшгүй зорчих шаардлагатай хэсэг, албан айлчлалаар зочигчид гэсэн дарааллаар сэргэлт явагдана. Хамгийн сүүлд буюу ирэх оны сүүлчээс л жинхэнэ аялагчдын талаар ярих байх. Гэтэл тэр үед манай аялал жуулчлалын улирал дууссан байна. Тиймээс бараг 2022 оны зунаас наашгүй” гэж тэрбээр салбар дунд яригдаж буй хүлээлтээ хуваалцлаа.

Онгоцны буудлаас “Кемпински” зочид буудал руу гаднын зочин хүргэж ирдэг

байсан таксины жолооч Н.Ганзориг Оюутолгойн уурхайн ажилтнуудтай найзууд болсон гэнэ. Өөрөөр хэлбэл, онгоц буух үеэр тэдний дуудлагаар очиж тосон, зорьсон газарт нь хүргэж өгдөг. Гэхдээ л гаднын жуулчдыг зөөдөг байсан үе шиг орлого сайтай биш байгааг тэрбээр хэлж байв. Жуулчны маршрут дагуу бол дээрх бүх аяллын дараа урлагийн тоглолт үзэж, урамтай сайхан хоол идэж, боломж гарвал дэлгүүр хэсдэгсэн. Такси биднийг “Түмэн Эх” чуулгын үүдэнд авчирсан ч бид хаалттай хаалга мөргөлөө. Энэхүү байгууллага 30 жилийн түүхэндээ анх удаа ийнхүү зуны турш хаалгаа барьж, хэт урт амарч үзжээ. Магадгүй уран бүтээлчид нь найр хурим хэсч “халтуур” хийж, орлогын өөр эх үүсвэртэй болсон гэж найднам. Бид тэндээс монгол хоолны өв соёлыг жуулчдад танилцуулдаг “Modern Nomads-1” сүлжээ рестораныг зориход ямартай ч нээлттэй хаалга угтав. Гэвч хүн цөөн, орлого багатай байгааг нэгдүгээр салбарын менежер М.Энхбат хэллээ. Олон жил тасралтгүй өсөлт үзүүлсэн тус сүлжээ рестораны хувьд бат суурьтай тулдаа халаа сэлгээгүй тогтож буй аж.

Монгол оронд тухласан жуулчдын аяллын эцсийн цэг нь “Чингис Хаан” онгоцны буудал байдаг. Хар үүр, харуй бүрийгээр л биш бол, онгоцны буудал хүрэх замдаа жуулчид ноолуурын дэлгүүр ордог тул бид ч мөн дотоодын зах зээлийн 71 хувийг атгадаг “Говь” үйлдвэрийн дэлгүүрээр дайрлаа. Жуулчид ялангуяа, азиуд сүүлийн жилүүдэд багшралдах нь нэмэгдсэн “Говь” үйлдвэрийн төв дэлгүүрт орвол хэр саруул цэлгэрийг мэдэж болохоор сэлүүхэн байв. Энэ жил үйлдвэрийн орлого 80 хувиар тасалдаж, “Галлериа” төв дэлгүүрийн орлого 60 хувь буурчээ. Гэвч Говийнхон угаас аажим ахиулж ирсэн цахим худалдаагаа энэ жил улам эрчимжүүлж, цонх үеийг ашиглаж байна. Хүйтэн сэрүүний ч улирал дөхөж буй учир дотоодын худалдан авалт Говь брэндийн энэ жилийн шархыг бага ч болтугай нөхөх биз ээ.

Эндээс бид аяллаа дуусгахаар онгоцны буудал руу хөдөллөө. Аялал жуулчлалын салбарыг сөхрүүлсэн цар тахал агаарын тээврийн салбарыг шууд “шал долоолгосон”. Хуучин дүрэм журам “цонхоор шидэгдсэн” учир өдгөө онгоцны үйлчлэгч нарын байц, чиг үүргийг харвал “Нисдэг сувилагч” болон хувирчээ. Хамарт цоргим хурц ариутгалын бодис, хамгаалалтын шилэн хаалтуудыг улам олон болгосон гээд тахлын үеийн арга хэмжээнүүд нь онгоцны буудлыг эмнэлэг болов уу гэж андуурахаар өөрчилжээ.

МИАТ компани тусгай үүргийн нислэгүүд үйлдэж байгаа ч нислэгийн тоо энэ жил 75 хувь буурч, эхний хагас жилийн байдлаар орлого нь 45 хувь багасчээ. Үүн дээр 6,7,8 сарын зуны нислэгийн оргил үед алдагдсан орлогыг оруулж тооцвол бууралт нь оны эцсээр нэмэгдэнэ. Онцгой байдлын үеийн арга хэмжээнүүдийн зардал нэмэлтээр орж ирсэн, нислэг цөөрсөн, нэг талдаа хоосон нисэж буй учир нэгж нислэгийн зардал өндөрсөн. Тухайлбал, хагас жилд нэг л удаа сольдог байсан найман сая төгрөгийн өртөг бүхий шүүлтүүрийг өдгөө нислэг бүрээр сольж буй нь эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зардал хэр зэрэг нэмэгдэж буйн нэг л жишээ. Цар тахал дууссан ч, зарим нэмэлтээр орж ирсэн зардлууд нэг хэсэгтээ хадгалагдахаар байна. Зорчигчийн тоо 2019 онд 787 мянга байсан бол энэ жил 140 мянга болов. Ачаа тээвэрлэлт эхний зургаан сард 2350 тонн байсан нь жирийн үеийн нэг л сарынхтэй тэнцэнэ. Онгоцнуудын түрээсийн төлбөр болон Хөшигтийн хөндийн шинэ нисэх буудал рүү нүүх ажил ба зардлыг хойшлуулсан, Удирдлагын багийн цалинг 20 хувь бууруулсан гэх мэт арга хэмжээнүүдээр дамжуулан одоогийн үйл

ажиллагааныхаа зардлыг хааж байгааг тус компанийн мэргэжилтнүүд учирлалаа. Азаар ч гэх үү, эзээр ч гэх үү МИАТ компани Монгол-АНУ-ын хооронд тусгай үүргийн нислэг үйлдэж чадлаа. Энэ чиглэлд дахиад ч ниснэ. Ингэснээр хоёр орны хооронд шууд нислэг үйлдсэн байх гэдэг АНУ-ын Зам тээврийн яамны шаардлагыг хангаад байгаа юм. Цар тахлын дараа 11 цаг үргэлжлэх Монгол-АНУ-ын шууд нислэг тогтмолжих боломж нээгдэж, олон шаардлагаас хамгийн чухлыг нь биелүүлжээ.

Цар тахал гараагүй байсан бол MG маань Монголоос сэтгэл хангалуун буцаж буй жуулчнаа “баяртай” хэмээн үдэх байсан биз. Тийнхүү нэг нь инээмсэглэл дүүрэн агаарт хөөрөхөд нөгөө нь гэрийн зүг сэтгэл тэнэгэр алхах боломж энэ жил даанч тохиосонгүй. Тэвчээрийн шандас сорьсон энэ “уралдаанд” хэн тэсэж, хэн нь шантарч хоцорсныг илчлэх мэт энэхүү олон хүний түүхийг сонссоны дараа MG “Би энэ сурвалжлагын өмнө их өөдрөг хүлээлттэй байсан юмсан. Сэтгэл санаа нэг л хөндүүр оргичихлоо” хэмээсэн юм.

~ АЙДСЫН ХҮЧИН ЗҮЙЛС АЯЛАХ ШИНЭ ДҮРМИЙГ ТОГТООНО ~

“Халдвар авсан 3500 гаруйхан, нас барсан 59хөн тохиолдолтойгоор тахлыг амжилттай давсан улсад айлтгүй тавтай зочлоорой” хэмээн Тайланд улс өөрийгөө сурталчилж, шинэ төрлийн тусгай виза санал болгон жуулчдыг урьж эхэллээ. Энэ бол ирэх жилүүдэд жуулчид юунд тулгуурлаж сонголтоо хийхийг бидэнд хэлж өгч буй New normal буюу шинэ хэм хэмжээ юм. Тайландын дэргэд Монголын “Тахлын халдваргүй цорын ганц орон” гэдэг сурталчилгаа ямар хэмжээнд өрсөлдөх чадвартай байх бол...

Аяллын судалгааны STR компанийн мэдээлж буйгаар америкчууд далайн эргийн хүн багатай чиглэлүүдэд аялах захиалга өгөх хандлагатай болжээ. Энэ нь Airbnb-ийн босс Брайн Ческигийн хэлдгээр аяллын маршрутад ахин хуваарилалт орж байгааг баталж буй юм. Airbnb дээрх захиалгын хандлагаас харахад жуулчдыг соронз мэт татдаг газрууд анхаарлаас гарч, хөл хөдөлгөөн багатай сэлүүхэн газрууд руу жуулчид тэмүүлж байгаа нь аяллын салбар шинэ чиглэлээр тэлж буйн илрэл. Товчхондоо 20-30 жил шаарддаг байсан аялагчийн зуршил цар тахлын нөлөөгөөр хэдхэн долоо хоногийн дотор өөрчлөгдчихлөө. The Economist сэтгүүлд нийтлэгдсэн “Lonely planet” нийтлэлд “Олон хүн ажлаа алдсан учир аяллын зардлаа ойрын хугацаанд танах магадлалтай. Хорио тавигдсан ч, хүмүүст хургасан айдас хэсэгтээ арилахгүй учир зорчих орнууд, аялах зуршил нэг хэсэгтээ өөрчлөгдөнө. Хөл хорионд ороод гадаадад гацчихаж магадгүй гэдэг айдас нь хол биш буюу машинаар явах зайд аялах сонголт хийхэд хүргээд байна” хэмээн бичжээ.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэдээллээс үзэхэд 2018 онд л нийт 1.4 тэрбум гадаад аялал хийгдсэн нь 2000 оныхоос хоёр дахин өндөр байгаагаас үзэхэд аялал жуулчлал бол нүсэр бөгөөд аугаа өсөлттэй зах зээл юм. Аяга, хувцас угаагч зэрэг нүдэнд “үл үзэгдэж” буй ажилтнуудаас эхлээд өндөр цалинтай онгоцны нисгэгч, хөтөч орчуулагчид гэх мэт олон төрлийн ажлын байр нийлсэн 330 сая хүн энэ салбараас тэжээгдэж байна. “Ирэх хоёр жилд хэрхэн аяллууд зохион байгуулах нь салбарын цаашдын өнгө төрхийг тодорхойлж, үргэлжлэн хэрэгжих шинэ дүрэм байх болно” хэмээн The Economist бичжээ.

Товчхондоо, дэлхий даяар аялал жуулчлалын салбарт үндсэн гурван өөрчлөлт орж эхэлсэн.

***Нэгт,** хүмүүсийн сонголт айдаст тулгуурлах учир халдварын тархалт хамгийн багатай орныг илүүд үзэж, түүнийг дагасан аюулгүй үйлчилгээ үзүүлэгчдийг сонгох магадлал өснө.*

***Хоёрт,** цуцлах бодлого өөрчлөгдөж, төлбөрийн буцаалтын хэмжээ өндөр, цаг хугацааны хувьд тайвуу гээд маш уян хатан нөхцөлтэй болно.*

***Гуравт,** үйлчилгээний газрууд улам илүү цахимжиж, дуу хоолой, нүүр таних технологи тулхүүрийг орлож, бүртгэлийг сайтар ариутгасан машинтай харьцаж хийнэ. Нэгэнт ингээд автоматжуулсан хойно буцаах шаардлага бараг гарахгүй.*

Бас нэг зүйл маш тодорхой байгаа нь хүмүүс вакцин гарч, хил нээгдэхэд өмнөх шигээ аялаад эхэлчихгүй бөгөөд болгоомжилсон сонголтууд хийнэ эсвэл бүүр хийхгүйгээр хэсэгтээ харзана. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас цар тахлаас үлдэж хургасан айдсыг арилгахад стратеги боловсруулж, улс орнууд хэрхэн жуулчдыг аялуулах зөвлөмжийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран боловсруулаад байна. Энэ зөвлөмжийг улс орон болгон өөрт тохируулан боловсруулж, хувьдаа мөрдөх тохирсон дүрэмтэй болно. БОАЖЯ-ны зүгээс Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын дэргэдэх Аялал жуулчлалын академитай гэрээ байгуулан Ковидын дараах стратегийг хамтарч боловсруулж байгаа аж. Энэхүү стратегийн хүрээнд Монголд визгүй зорчдог, шууд нислэгтэй орнууд болох БНСУ, Япон, БНХАУ л манай ковидын дараах богино хугацааны сэргэлтийг авчрах гол зах зээлүүд гэж харж байгаа юм байна. Харин хилээ нээхтэй зэрэгцэн аялаа сурталчилж зарах, хэрхэн аялах дүрмээ танилцуулах ёстой. Хөл хорионд 14 хоног суугаад, Монголд 20 хоног аялаарай гэвэл хэн ч ирэхгүй нь тодорхой. Шинжилгээ нь үнэн бодитой, цар тахлыг хяналтандаа авсан орнуудад хилээ нээх нь тодорхой боловч яг ямар орнууд энэ жагсаалтад орох нь хил нээгдсэний дараа л тодорхой болно. Улсын Онцгой комиссоос тэр болтол хүлээх чиглэл өгсөн тухай БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Баясгалан ярилаа. Тэдний зүгээс хийж чадах ажил нь одоохондоо дүрмээ боловсруулах л ажээ.

ДАЖБ-ын мэдээллээр 73 орон тодорхой хязгаарлалтуудын хүрээнд хилээ нээгээд байна. Энэ нь долдугаар сартай харьцуулахад 24 орноор нэмэгдсэн гэсэн үг юм. Харин жуулчдад хилээ нээгээгүй 93 улс байна. Засгийн газрууд аль улсын иргэдийг ямар шалгуураар нэвтрүүлэх вэ гэдэг дээр толгойгоо гашилгаж сууна. Тэдгээрийг түүчээлж, Тайланд тухайлбал, тусгай виз санал болгож эхэлснийг Lonely Planet цахим хуудсаараа дамжуулан мэдээлсэн. 14 хоногийн хөл хориог зөвшөөрвөл 90 хоногийн виз авах боломжтой бөгөөд дахиад хоёр удаа сунгах эрхтэй гэнэ.

**Эрүүл аюулгүй
харилцааг
эрхэмлэж буй
тул одооноос
РОБОТУУД
танд үйлчилж
эхэлнэ.
Тиймээс аялагч
та ойлгож
хүлээж авна уу.
Баярлалаа.**

Монголын хувьд, хил нээх хугацааг Монгол Улсын Ерөнхий сайд коронавирусийн эсрэг вакцин гарахаас наашгүй гэж зарласан бол Улсын онцгой комиссоос ирэх жилийн зургадугаар сар гэж мэдээлсэн. Гэтэл ДЭМБ болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд вакцин гарч, дархлаажуулалт хийгдэх хүртэл дахиад жил хагасын хугацаа хэрэгтэй гэж үзэж байгаа нь Монголд 2022 оны зунаас нааш гадаадын жуулчид ирэхгүй гэсэн төсөөлөл бий болгоод байна. Энэ жил бүтэн гүрийсэн компаниуд ирэх жилийн төгсгөл хүртэл тэг зогсолт үргэлжилж магадгүй гэдэг айдаст автаж, төр засгаас аврал эрж байна. Тэдний зүгээс зээл аваад ч болтугай ажилтнуудаа тогтоож үлдээхийг хүсч буй учир энэ л үед төр засаг маань татвар төлөгчдөө дэмжээч хэмээн эв нэгдэлтэйгээр гуйж байна.

“Нью жуулчин турс” ХХК-ийн ерөнхий захирал Ш.Нэргүй “Гол орнуудын аяллын захиалга 1-2 жилийн өмнө хийгддэг. АНУ, Европын жуулчны компаниуд Монголын хил нээгдээгүй, заавар удирдамж тодорхой биш гээд ирэх оны аялалдаа одоо болтол Монголыг зарж эхлээгүй байна. Тиймээс ирэх онд тэдгээр орноос жуулчин бараг ирэхгүй, ирсэн ч маш бага ирнэ. Харин Азийн орнууд 4-6 сарын өмнөөс аяллаа зарлаж, захиалга авдаг гэж тооцвол үндсэндээ 2021 онд манайд жуулчин байхгүй” гэв. КОВИД-19-ийн өмнөх үе шиг сэргэх хүртэл наанадаж 3-4 жил зарцуулна гэдгийг салбарынхан хэлж байна. Сэргэхдээ маш их зүйл өөрчлөгдсөн байх болно. Энэ өөрчлөлтийг бодлого чиглэлээ нэгтгэж хамтдаа соргоогоор мэдэрч, хариу арга хэмжээ хурдан авч, “манёврлаж” чадсан орнууд өрсөлдөөнд өрсөнө. Тиймээс цар тахлын дараах уралдаанд Монгол Улс өөрийгөө бэлдэж, жуулчид зорчдог цэгүүд, аяллын маршрут дагуу эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийг сайтар хийлгэж, энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагаа нь тодорхой байх шаардлагатай боллоо.

*~АЯЛАХ ШИНЭ ДҮРЭМТЭЙГЭЭ ТАНИЛЦ:
CONTACTLESSJOURNEY~*

Таны ирээдүйн аялал онгоцны буудал руу ороод машины тусламжтай бүртгэлээ хийж, ачаагаа өгөөд, хамгаалалтын хаалгаар дамжихдаа халуунаа хэмжүүлж, хамраараа хоолой хүртлээ урт иштэй хөвөн дүрүүлж шинжлүүлээд, алхам тутамдаа бусдаас хоёр метрийн зай барих сануулгаар эхлэнэ. Энэ энэ зуур та бараг л хүнтэй харьцахгүй. Зөгнөл мэт санагдаж мэдэх. Гэхдээ тийм биш. Онгоцонд сууснаар сая нэг хүнтэй ярилцах боломж олдож магад. Харамсалтай нь, хүмүүс тантай бараг л харьцахгүй л болов уу. Хэн ч таны өмнө ил гарч үйлчлэхгүй. Албан бөгөөд амьд харилцааг халсан шинэ төрлийн эрүүл ахуйг дээд зэргээр хангасан энэхүү хандлагыг #contactlessjourney гэдэг.

Хэрэв бизнесүүд айдас дүүрэн 2020 онд үйлчлүүлэгчдийнхээ ахуйн хавьталд орох хэрэгцээ шаардлагыг технологижуулж чадсан бол КОВИД-19-ийн дараах цоо шинэ цаг үед нэг шат ахисанд тооцож болно. “Бид одоо үйлчлүүлэгчидтэйгээ дэлгэцийн хоёр талаас л харилцаж байна, бүх үйл ажиллагааг зочинтой амьдаар харилцахгүйгээр явуулж байгаа” хэмээн “Кемпински”-ийн Ц.Тамир хэллээ. Үндэсний түүхийн музейн хамт олон цар тахлын үед зүгээр суулгүй цахим талбарт идэвхжүүлэлт хийж буйгаас гадна музейн тайлбарыг 10 хэл дээр аудио хэлбэрээр бэлтгэсэн нь КОВИД-19 халдварын дараа эрэлтэй үйлчилгээ болж ашгаа өгөхөөр

байна. Онгоцны буудал болон МИАТ компанийн хувьд ч цар тахлын үеийн дүрэм журмын дагуу ажиллаж дадсанаар “contactlessjourney” хийх туршлагыг чамгүй хуримтлуулаад байгаа нь монголчууд бага ч гэсэн бэлтгэл хангаж буйг харуулна.

МАЖХ-ны ерөнхийлөгч Д.Гантөмөр бүх газар тоног төхөөрөмжөө өөрчилж байгааг анхааруулж хэлсэн. Зочид буудлын арга хэмжээ, үдэшлэгүүд робот үйлчлэгтэй болж, танихгүй хүмүүс хоорондоо аль болох харилцахгүй, тусгаарлах боломжтой байх зохицуулалтыг үйлчилгээний байгууллагууд хийж байна. Автомат болон биометрик хэмжигч, эрүүл мэнд аюулгүй байдлын мэдээлэл агуулагддаг тоног төхөөрөмжийн хэрэглээ хэдийнэ нэмэгдээд эхэлсэн. Технологийн чадавхтай улс орнууд хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалж чадаж байгаа учир асуудал багатайгаар шилжиж байна.

Аялал жуулчлалын оролцогч байгууллагууд бүгд л цахим орчин дахь тоглолтоо сайжруулан, маркетингийн шинэ арга барилаар цар тахлын үед ажиллаж эхэлснээ бидэнд хэлж байв. Жуулчдын худалдан авалтгүй болсон учраас “Говь” компани цахим борлуулалтаа сайжруулах зорилгоор их хэмжээний хөрөнгө оруулалт цар тахлын үеэр хийжээ. Цахим худалдаа хариуцсан баг нь өмнө нь 10 хүрэхгүй хүнтэй байсан бол одоо 80 гаруй болж өргөжсөн. “Нью жуулчин турс” гэхэд хил хаалттай энэ цаг үеийг ашиглан шинэ чиг хандлагатай хөл нийлүүлэхийн тулд аяллын багцаа өөрчилж, дижитал сурталчилгаа, маркетингдаа онцгойлон анхаарч, үйлчилгээгээ чиглүүлэхээр ажиллаж байгаа аж. Дижитал шилжилт нь зарим талаар аяллын үнийг багасгах бол коронагаас үлдсэн айдсын улмаас масс жуулчлал багасна. Тиймээс үүнд тохируулан цөөн хүнд хандсан чанартай аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх шаардлагатай болсон гэсэн үг.

~ ХӨГЖИЛ ХӨДӨӨ РҮҮ ~

Манай аялал жуулчлалын салбарын санхүүгийн баланс сүүлийн 10 гаруй жил алдагдалтай явж ирсэн. Харин энэ жилийн хувьд монголчуудыг даган гадагшилдаг тэрхүү мөнгөний гуравны нэг нь лавтай үлдсэн. Монголчууд дотооддоо идэвхтэй аялсан нь хоёрдугаар улиралд худалдаа үйлчилгээний салбар огцом сэргэхэд нөлөөлснийг аялал жуулчлалын Joinme.mn платформийн үүсгэн байгуулагчийн нэг Э.Цоморлиг онцоллоо. Тур оператор, зочид буудал, хөтөч орчуулагч нар тэг зогсож, санхүүгийн хүндрэлд орсон бол аяллын дэлгүүр, дотооддын голлох маршрут дагуух амралтын баазууд, хоолны газар, аймаг болон сумын төвийн дэлгүүр, захууд, бензин түгээх станцууд ашигтай ажилласан гэнэ.

“Модерн номадс” рестораны Улаанбаатар дахь салбарууд үйлчлүүлэгч багатай байсан ч Хөвсгөл дэх салбар амжилттай, тун ирээдүйтэй байсныг төв салбарын менежер бидэнтэй уулзахдаа хэлсэн юм. Мөн Хөвсгөл, Завханы хүнсний сүлжээ дэлгүүрүүдэд бараагаа нийлүүлдэг борлуулагчдын хэлж буйгаар бол өнгөрсөн жил сард 30 сая төгрөгийн борлуулалт хийж байсан бол энэ жил зуны саруудад 100 саяыг өлхөн давж байсан аж. Энэ нь дотоодын жуулчлал орон нутгийн худалдан авалтыг гаднын жуулчдаас хэд дахин илүү дэмждэгийг харуулж буй нэг үзүүлэлт. Цаашлаад орон нутгийн эдийн засагт аль нь илүү өгөөжтэй вэ гэдгийг эргэцүүлж судлах хэрэгцээг үүсгэж байна. Хөвсгөлийн зарим бааз орлогын хувьд шинэ

рекорд тогтоосон бол Буйр нуур орчмын гэр баазууд өмнөх жилээс хоёр дахин өндөр ашигтай ажилласан байна.

Буйр нуур руу л гэхэд түрүү жил найман мянга шахам хүн зорьсон бол энэ жил 20 орчим мянга хүрэх тооцоо байгааг “Дорнодын аялал жуулчлалын нэгдэл” ТББ-аас мэдээллээ. Тус байгууллагын зөвлөх Ч.Буянбадрах “Дорнодын аялал жуулчлалынхан ирэх жилийн хувьд нэгт, модон жорлонгоос салах хоёрт, хаягжилтаа сайжруулах гуравт, хоол үйлчилгээ ба тав тухаа сайжруулахад түлхүү анхаарч, өөрчлөлт гаргана” гэлээ. Мөн “дошныхон” дундын компани байгуулах замаар цагаан хэрэглэл угаалга, завь түрээс, морь уналга гэх мэт дангаараа хүчирдэггүй асуудлуудаа шийдэхээр зэхэж буй нь урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангадаг жишиг бүтэц юм. Буйр нуур хүрэх гэж 300 км сэгсчүүлдэг шороон замыг засмал болгочихвол ч Дорнод аймаг дараагийн Хөвсгөл болоход ойрхон. Гэхдээ тогтвортой аялал жуулчлалын жишиг хөгжлийг харуулсан анхны аймаг болох учиртайг сануулая.

Мэргэжлийн 60 гаруй компанийн дотоодын аяллын 100 гаруй бүтээгдэхүүн санал болгодог Joinme.mn платформийн дата мэдээллээр дотоодын аялал жуулчлалын хөгжил хурдаа авах эргэлтийн цэгт ирээд буй тул зөв чигт нь хөгжүүлснээр гадаадын жуулчдын урсгалыг татахад чухал нөлөө үзүүлэхийг харуулжээ. Аялал жуулчлалын компаниуд энэ жил КОВИД-19-өөс үүдэн туршилтын журмаар монголчууддаа аяллын бүтээгдэхүүн санал болгосон нь харьцангуй амжилттай байж. Мэргэжлийн аяллын үйлчилгээ авсан дотоод аялагчид сэтгэл ханамж өндөр байсны зэрэгцээ сонирхолтой төрөлжсөн аяллын бүтээгдэхүүнүүдийг дотоодын аялал жуулчлалын зах зээл шингээхэд бэлэн байгааг харуулжээ. Тиймээс том компаниуд дотоодын аяллын алба, жижгүүд нь ядаж дотооддын аялагчид хариуцсан менежертэй болохоор шийджээ. Зөвхөн гаднынханд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээтэй байсан олон аяллын компаниудад цар тахал орлогын сувгаа төрөлжүүлэх шахалтыг үзүүлж, нөгөө талаас монголчуудын амьдралын түвшин сайжрахтай зэрэгцэн хэр их мөнгийг аялалд зарцуулж байгааг бид харлаа. Энэ бол эрэлт, нийлүүлтийн шинэ тэнцвэр.

Дотоодын аяллын ирээдүй ийм “өнгөлөг” харагдаж байгаа нь нэг талаар боломж, нөгөө талаар 30 жил замнаж ирсэн одоогийн зах зээлд томоохон сорилт юм. Аялал жуулчлалын салбар энэ онд тэг зогсолт хийсэн нь ялангуяа манайх шиг улсын хувьд аялал жуулчлалын салбараа тэгээс нь эхлээд суурийг нь зөв тавих боломж олгож байгааг С.Баясгалан дарга хэлсэн. Тэрбээр “Эхлэл цэгээ зөв тавих ёстой. Өмнөх шигээ замбараагүй яваад байж болохгүй. Олон улсын жишгээр орон нутгийн хөгжил, нутгийн иргэдийн амьжиргааг дэмждэг, боловсролтой эсэхээс үл хамаарч яг л байгаа ахуйгаараа мөнгө олох боломж, соёлын өв, байгаль орчны хамгааллыг бий болгодог тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгтэй” гэлээ.

Харин сорилтын хувьд энэ салбарын хөгжлийн суурь гадаадын жуулчдын эрэлтэд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бий болгосон онцлогтойг мэргэжилтнүүд хэлдэг. Тиймээс ч энэ жил гадаадын жуулчдын урсгал тасарснаар хөтөч орчуулагч, жолооч, тур оператор, авиа компани тэг зогсолт хийсэн. Нэг ёсондоо дотоодын аялагчдын идэвхиэр энэ жил аялал жуулчлалын салбар огт царцаагүй боловч энэ мөнгөний урсгал салбарыг бүхэлд нь хамарч чадаагүй. Жам ёсоороо, улс орнуудын дотоод аяллын суурин дээр гадаад аялал жуулчлал хөгждөг бол манайд 1990 оноос

хойш эсрэг хөгжиж, нэг талаар маш том гажуудал бий болгосныг КОВИД-19 илрүүлж өглөө.

Э.Цоморлиг “Жуулчдад зориулсан арга хэмжээг гадаад, дотоод гэж ялгахгүй зохион байгуулж, дотоодын иргэдээ идэвхтэй оролцуулснаар гаднын жуулчид монголчууд хэрхэн үндэсний арга хэмжээ, баяр наадмаа тэмдэглэдэгийг үзэж харах бодит өгөгдөл болдог” гэлээ. Зөвхөн гаднынханд зориулсан арга хэмжээнүүд жүжигчилсэн тавилттай тоглолт гэдэг утгаараа үлдэц ба үнэлэмж нь бага байдаг тул одоо дотоодын аялалдаа зөв бодлого, мэргэжлийн арга зүйгээр хандах цаг ирлээ. Бидний хэрхэн байгаль дэлхий, өв соёлтойгоо харьцаж амьдарч аялж, баярлаж гунидаг үнэн төрхөөс илүү сонирхолтой зүйл байгаа гэж үү. Нөгөө талаас, монголчуудаа бохирдол үүсгэгч, байгаль сүйтгэгч хэмээн адлах бус аялал жуулчлалын мэргэжлийн үйлчилгээнд мөнгө төлдөг ухамсартай аялагчид болгохын төлөө нийгэм даяар кампанит ажил өрнүүлж, салбарынхан зорилгоо нэгтгэж, хүчтэй дуугарч, төр нь хувийн хэвшилтэйгээ хамтран бодлогоо зангидах боломжийг КОВИД олгож байна.

Ковидын үлдээсэн айдас гадаадын жуулчлалыг хэр удаан хүлэхийг таашгүй ч нэг зүйл маш тодорхой. Дотооддоо аялах монголчуудын илүү том давалгаа айсуу.

“

**Орлогын сувгаа төрөлжүүлэх, орон
нутгийн эдийн засгийг дэмжих
боломж нь дотоодын аялал
жуулчлал гэдгийг бид энэ жил
харлаа.**

”



Батболд овогтой Бямбасүрэн

2010 онд МУБИС төгссөн.

2012 онд өдөр тутмын
“Өнөөдөр” сониноос ажлын
гараагаа эхлүүлсэн. Улмаар
2016-2018 он хүртэл “Засгийн
газрын мэдээ” сонин,

2019-2020 онд “Ардчилал
таймс” өдөр тутмын сонинд
ажилласан.

2020 оны есдүгээр
сараас “Үндэсний шуудан”
сонинд Эдийн засгийн албаны
сэтгүүлчээр ажиллаж байна.

“Үндэсний шуудан” сонин

“COVID-19” ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨНД
ӨРТӨӨГҮЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАНЦ
САЛБАРАА ТҮШИН ЭДИЙН ЗАСГАА ТЭЛЭХ
МОНГОЛЫН БОЛОМЖ

“COVID-19” цар тахал гарснаас хойш Монгол Улсын эдийн засаг 2020 оны эхний хагаст -9.7 хувиар агшсан нь сүүлийн 20 жилд тохиолдоогүй муу үзүүлэлт. Дэлхийн бүхий л бүс нутгийг хамарсан коронавируст халдварын нөлөөгөөр уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр ба агуулах, худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, цэвэр экспорт гэх мэт хамаг гол салбарууд уналтад орж уруудсан бол тэр дундаас эрэлт, нийлүүлэлт талаасаас эерэг үзүүлэлттэй байж чадсан ганц салбар нь Монголын хөдөө аж ахуйн салбар байлаа.

МАА-н салбар 2018 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 10.8 хувь бүрдүүлж, экспортын орлогын 9.2 хувийг ХАА-н гаралтай бүтээгдэхүүн эзэлж, нийт ажиллах хүчний 26.7 хувь нь энэ салбарт хамаарч байгаагаас харагдана.

Газар тариалангийн салабрын өнгөрсөн оны зарим тоон үзүүлэлтийг харъя. Өнгөрсөн 2019 онд ургацын урьдчилсан балансаар нийт манай улс 420 мянган тонн улаанбуудай хураан авах тооцоо гарсан бол энэ жил урьдчилсан балансаар 487.6 мянган тонн улаанбуудай хураан авахаар төлөвлөж байгааг салбарын яам мэдээлээд буй. Өөрөөр хэлбэл, 16 хувийн өсөлттэй байх төлөвтэй.

Монгол Улс газар тариалангийн салбартаа ихээхэн хөрөнгө оруулалт хийж, технологийн шинэчлэл нэвтрүүлсний үр дүнд 1985 онд түүхэн дээд амжилт тогтоож байв. Тухайн жилд 692.3 мянган тонн улаанбуудай хураан авч байсан бол энэ онд дээр дурдсанчлан 487 мянган тонн улаанбуудайг хаягдалгүй хураан авч чадвал 1985 оны түвшингийн 70 хувьд дүйж очихоор байна. Энэ бол цар тахлаас үл хамааран өсөлттэй байж

чадсан салбар буюу манай улсад маш их нөөц боломж байгааг илтгэх үзүүлэлт юм.

Мал аж ахуйн салбарын тухайд сүүлийн жилүүдэд байнга өсөлттэй байгаа. 2019 онд ч мөн 70.9 сая толгой мал тоологдож, өмнөх оныхоосоо 4.5 сая толгой малаар буюу 6.8 хувиар өссөн амжилттай байв. Урьдчилсан дүнгээр 233.2 мянган малтай өрх тооллогод хамрагдсан нь өмнөх 2018 оноос нэг хувиар өссөн үзүүлэлт.

Цар тахал дэгдэхээс өмнө, ялангуяа 2018 онд маш сайн үзүүлэлтүүд гарсан. Тодруулбал, мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох махны экспортын тоо хэмжээ л гэхэд өмнөх оныг бодвол,

- Дайвар бүтээгдэхүүн 12.8 дахин
- Хонь, ямааны мах 2.4 дахин
- Үхрийн мах 75.8 хувь
- Адууны мах 23.3 хувиар тус тус өсөж байжээ.

Өнгөрсөн хоёр жилийн хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн статистикийг тольдоход ийм байна. Уул уурхайн салбараа түшиглэж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн ханшийн савлагааг дагадаг эдийн засагтай манай улсын хувьд хөдөө аж ахуйн салбараа хөгжүүлбэл эдийн засгийн маш том нөөц боломж байгааг цар тахлын энэ хүнд нөхцөл харуулж өгөв. Монгол Улсын хөгжлийн загварын талаарх тойм, “Уул уурхай ба оюун ухаан” хэмээх Дэлхийн банкны шинэхэн танилцуулсан судалгаагаар ч энэ тухай анхааруулсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улс уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа ба хөрөнгө оруулалтыг хүний хөгжил, хөдөө аж ахуйн салбартаа чиглүүлснээр дээрх хамаарлаас гарах боломжтой гэдгийг онцолсон.

Яагаад энд хөдөө аж ахуйн салбарыг онцолж байгаа бас нэгэн шалтгааныг хөндье. Учир нь дэлхийн улс орнууд цар тахлын үед юу юунаас илүүтэй хүнсний хомсдолд хамаг анхаарлаа хандуулж байна. Энэхүү цар тахал 2020 оны есдүгээр сар гарснаар улам бүр хүрээгээ тэлж, олон орныг хамрахын зэрэгцээ халдвар авагчдын тоо эдгэрч буй хүмүүсийнхээс хэдэн зуу даваад байгаа билээ. Үүнээс илүү том аюул нь коронавируст халдвар хүнсний бүтээгдэхүүнээр дамжиж байгаа ноцтой асуудал юм. Учир нь, сүүлийн үед улс орнуудад хүнсээр дамжин халдвар тархах тохиолдол цөөнгүй бүртгэгдээд буй. Хэрэв тийм бол хүнсний импортоо хэрхэх вэ гэдэг бодлогын том асуудал бидний өмнө тулж ирнэ.

“Ройтерс” агентлагийн мэдээлснээр, БНСУ, Хятад, Норвеги улсаас импортолсон хөлдөөсөн далайн арваалжнаас “COVID-19” өвчний халдвар илэрсэн гэжээ. Тодруулбал, ОХУ-аас БНХАУ-д импортолсон далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн(наймаалж)-ээс уг вирус илэрсэн байна. Мөн өнгөрсөн долдугаар сард Эквадор улсаас БНХАУ-д нийлүүлсэн далайн гаралтай хүнснээс бас л коронавируст халдвар илэрсэн талаар ССТV мэдээлсэн юм.

"COVID-19" цар тахал гарснаас хойш Монгол Улсын эдийн засаг 2020 оны эхний хагаст -9.7 хувиар агшсан нь сүүлийн 20 жилд тохиолдоогүй муу үзүүлэлт.

Эндээс харахад, ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог манай улс, тэр тусмаа хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 гаруй хувийг урд хөршөөсөө импортолдог Монголын хувьд энэ бол түгшүүрийн харанга мөн үү гэвэл мөн. Хүнс, бараагаар дамжин Монгол Улсад “COVID-19”-ийн халдвар орж ирэхгүй гэсэн баталгаа алга.

Иймд болзошгүй эрсдэлээс сэргийлж, далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг аль болох импортоор авахгүй байх, авсан нөхцөлд хил дээр тавих мэргэжлийн хяналт шалгалтын оношлогоо хийх боломж, хүчин чадал байгаа эсэхийг нягтлан үзэх шаардлагатай болж байгааг анхаарах хэрэгтэй. “COVID-19” нь -20 хэмээс дээш хүйтэнд 1-2 жил хугацаанд амьдрах чадвартай хэмээн зарим вирусологичид үзэж байгааг тэмдэглэе.

Тэгэхээр цар тахлыг зөвхөн хилийн хориг тогтоосноор дотооддоо бүрэн барьж чадна гэж цээжээ дэлдэж болохгүй байх нь. Бидний эдэлж хэрэглэж буй хүнс, бараа, бүтээгдэхүүнээр дамжан ороод ирэхэд тун ойрхон байна.

Гаалийн ерөнхий газрын тайланд, он гарсаар эхний найман сарын байдлаар импортоор нийт 3453.2 сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан гэжээ. Импортоор нийлүүлсэн барааны нийт дүнгийн мэдээллийг харвал, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 425.7 сая ам.доллар болсон бөгөөд дэлхийн 129 орноос гарал үүсэлтэй бараа импортолсноос ОХУ-аас 26.8, БНХАУ-аас 36.1, АНУ-аас 4.5, Японоос 7.6, БНСУ-аас 4.3, ХБНГУ-аас 3.4 хувь бараа бүтээгдэхүүн авсан ба энэ нь нийт импортын дүнгийн 82.8 хувийг эзэлж байна.

Монгол Улс цар тахлын голомт болсон улс орнуудаас импортоор төрөл бүрийн хүнсний болон бараа, бүтээгдэхүүнийг ямар нэгэн хориггүйгээр авч байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн улс хоорондын хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласнаас биш бараа, бүтээгдэхүүн, тэр дундаа, далайн хүнсний бүтээгдэхүүнд ямар нэгэн хориг тавиагүй, мөн хилийн мэргэжлийн хяналт, шалтгалтыг ямар түвшинд хийж байгаа, багаж, тоног төхөөрөмж нь бараагаар дамжин орж ирэх халдварыг илрүүлдэг эсэх нь тодорхойгүй байна.

Хэрэв ийм том эрсдэлтэй нүүр тулбал Монгол Улс бэлэн үү, хүнсний нөөцөө бэлдсэн үү гэсэн асуулт ургана. Ямартай ч, “COVID-19” цар тахлын нөлөө хийгээд бидэнд тулгарах эрсдэл, сорил ийм байна. Харин үүнээс гарах гарц, шийдэл нь хөдөө аж ахуйн салбар юм гэдгийг дахин онцолъё. Ялангуяа, “Экспорт, экспорт, экспорт”. Энэ бол манай улс эдийн засгаа богино хугацаанд тэлэх ганцхан арга зам юм. МҮХАҮТ-ын захирал О.Амартүвшин үүнийг мөн манай эдийн засгийн гол хөшүүрэг хэмээн дүгнэж байгаагаа хэлсэн. Ялангуяа, нөөц боломжоо зөв ашиглаж, төр хувийн хэвшил хамтарч, төлөвлөгөө стратегитай урагшилж, уул уурхайн бус экспортыг 900 хоногт хөгжүүлж чадвал 15 тэрбум ам.долларын хэмжээтэй Монгол Улсын эдийн засаг 2024 он гэхэд 30 тэрбум ам.доллар буюу хоёр дахин өсөн боломжтой гэдгийг тэрбээр онцолсон. Үүний тулд зөв, шаардлагатай хөрөнгө

оруулалтыг хийвэл өгөөж нь хэд дахин үржигдэж ирэх юм. Гол түлхүүр нь мэдээж хөдөө аж ахуйн салбар. “COVID-19” цар тахал ч үүнийг нотолж, Монголын хөдөө аж ахуйн салбарын үнэ цэнийг улам тодруулж өглөө.

“

**Уул уурхайн бус экспортыг 900
хоногт хөгжүүлж чадвал 15 тэрбум
ам.долларын хэмжээтэй Монгол
Улсын эдийн засаг 2024 он гэхэд 30
тэрбум ам.доллар буюу хоёр дахин
өсөн боломжтой гэдгийг тэрбээр
онцолсон.**

”

Gogo.mn



**Батболд овогтой
Эрдэнэчимэг**

2005 онд БНТУ-ын нийслэл Анкара хотын Газигийн их сургуулийг радио, телевизийн сэтгүүлч мэргэжлээр төгссөн. Их сургуулиа төгсөж ирээд ТВ9, С1, “Боловсрол”, МНС телевизэд ажиллаж байгаад 2013 оноос GOGO.MN сайтад редактор, ахлах редактороо ажиллаж байна.

2014 оноос эдийн засгийн мэдээ, сурвалжилга дагнан бэлтгэж байна.

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫНХАН
АВРАЛ НЭХЭЖ БАЙНА**

САРС, МЕРС зэрэг амьтнаас болон хүнээс хүнд халдварладаг вирусээс КОВИД 19 хамаагүй илүү өргөн газар нутагт тархаж, олон сая хүн энэ вирусээр өвчлөөд байна. Өнөөдрийн байдлаар дэлхий даяар 24 сая хүн халдвар авч, тэднээс 846 мянга нь нас баржээ.

Олон мянган гэр бүл гэнэтийн хагацал амсан, улс орнуудын эрүүл мэнд төдийгүй эдийн засгийн бүх салбар цохилтод өртөв. КОВИД 19-ийн улмаас хамгийн их хохирол амссан салбаруудын нэг нь яах аргагүй аялал жуулчлал. Аялал жуулчлал бүрэн зогсоход бүх төрлийн тээвэр, зочид буудал, хоол үйлчилгээ, гар урлал, үзвэр үйлчилгээний салбарууд ч дагаад уналтад оров. Мөн орон нутгийн иргэдийн орлого тасалдсан нь тодорхой. Орлогоо алдахын сацуу мэргэжлийн боловсон хүчнээ банк санхүү, уул уурхай гэх мэт харьцангуй баян салбарт алдах эрсдэл энэ салбарынханд нүүрлэжээ. Энэ бол ганц Монгол төдийгүй аялал жуулчлалаас тодорхой орлого бүрдүүлдэг бүх улсад нүүрлэсэн сорилт юм.

**~БИД 25 ЖИЛИЙН ӨМНӨХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
РҮҮ БУЦЛАА~**

Нэг гадаад жуулчин ирэхэд тухайн улсын арван иргэний орлого нэмэгддэг аж. Харин энэ үзүүлэлт манайд өндөр буюу нэг жуулчин 30 монгол иргэнийг ажилтай байлгадаг. Дэлхийн хэмжээнд аялал жуулчлалын салбар энэ оны эхний 6 сарын байдлаар 980 сая ам.долларын алдагдал хүлээжээ. 150 сая ажлын байр эрсдэлд орсон байна. Зургаадугаар сарын байдлаар дэлхий нийтэд жуулчдын тоо 92 хувиар, Ази, Номхон далайн улсуудад 99 хувь буурчээ. Манай улсад эхний найман сарын байдлаар жуулчдын тоо 92 хувиар, орлого 400 орчим сая ам.доллараар буурлаа. Бид 25 жилийн өмнөх үзүүлэлтүүд рүү буцлаа гэж БОАЖЯ-ны Аялал жуулчлалын

бодлого зохицуулалтын газрын дарга С.Баясгалан тайлбарлав.

Нэг жуулчин 30 монгол иргэнийг ажилтай байлгадаг.

Манай улсад 1300 орчим ААН энэ салбарт ажиллаж байна. Дотоодын жуулчдын урсгалын улмаас орон нутгийн зочид буудлууд бага боловч орлоготой байжээ. Гэвч тур оператор компаниуд хамгийн их эрсдэл үүрсэн хэвээр байна. 2019 оны байдлаар 318 тур оператор ажилласан бол энэ онд тэд бүрэн зогсож, эдгээрт ажилладаг хөтөч, жолооч нар ажлын байраа алдах эрсдэл үүслээ. Эхнээсээ ажилгүй болсон нь ч бий. Бид хилээ хаагаад найм дахь сарынхаа нүүрийг үзэх гэж байна. Энэ нь аялал жуулчлалын салбарынханд хэрхэн нөлөөлснийг тодруулахаар “Discover Mongolia” компанийн захирал Б.Барсболдтой ярилцав. Хөвсгөлд байдаг нэг малчин маань залгаад “Хүүхэд их сургуульд орсон. Сургалтын төлбөрийг нь өгөх гээд, ахдаа мөнгө зээлээч гэв. Бид олон жил хамтран ажилласан болохоор надаас асууж байгаа хэрэг л дээ. Даанч би ажилчдынхаа цалинг ч тавьж чадахгүйд хүрсэн болохоор учир байдлаа хэлсэн. Бидний байдал ийм л байна” гэснээр бидний яриа эхэлсэн юм.

*~УРЬДЧИЛСАН ТООЦООГООР ДАХИН 6 САР ТЭСЭХЭД БИДЭНД
ЦАЛИНГИЙН ЗАРДАЛД 2-3 ТЭРБУМ ТӨГРӨГ ХЭРЭГТЭЙ~*

Тэрээр “Бид дотроо халдвар алдаагүй тул бусад үйлчилгээний байгууллагууд тодорхой цагийн хязгаартай ч үйл ажиллагаагаа явуулсан. Харин манай салбарынхан бүрэн зогссон. Ажлын байрыг нь хадгалж үлдсэн ААН-үүдийн ажилтан тус бүрт 200 мянган төгрөгийн дэмжлэгийг төрөөс үзүүлсэн. Энэ мөнгийг ажилтнуудад олгосон.

Мөн нийгмийн даатгалын шимтгэлээс дөрөвдүгээр сарын 1-нээс хойш чөлөөлсөн шийдвэрт манай салбарын ААН-үүд хамрагдсан. Гэсэн ч байдал хүндэрч, компаниуд орлогогүй болж, цалин тавих, урсгал зардлаа нөхөх чадваргүй болоод байна. Иймд цомхтгол хийх, ажлын цагийг бууруулах замаар зардлаа бууруулах арга хэмжээ авч байна. Уг нь оператор компаниуд манай салбарын зүрх нь байгаа юм. Өнгөрсөн онд манай улс 577 мянган жуулчин хүлээж авсан. Тэднийг нааш авчирсан, жуулчдын урсгалыг бий болгодог хүмүүс нь оператор компаниуд. Жуулчдыг дагаад 88 мянган ажлын байр бий болдог. Хэзээ хилээ нээх нь тодорхойгүй ч жуулчид ирэхэд бид бэлэн байх ёстой. Аялал амьдралын салшгүй нэг хэсэг. Хүмүүс эргээд аялна гэдэгт би итгэж байна.

Энэ онд манай улс 1.7 их наяд төгрөгийн экспортын орлогоо нэгэнт алдчихлаа. Зочид буудал, операторуудаас гадна агаарын болон авто тээвэр эрхлэгчид, нутгийн иргэд, гар урлаачид гар дээрээ мөнгө тавьсангүй. Санхүүгийн нөөц дутагдалтай болсон энэ онцгой үед аялал жуулчлалын компаниудад дэмжлэг үзүүлээсэй. Засгийн газраас хүүгүй зээл олгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөс түр чөлөөлөхийг хүсэж байна. Урьдчилсан тооцоогоор дахин 6 сар тэсэхэд бидэнд цалингийн зардалд 2-3 тэрбум төгрөг хэрэгтэй. Ингэснээр бид эрсдэл багатайгаар хүндрэлийг давахын сацуу ажилгүйдэл, ядуурал ч буурна. Засгийн газрын нөөц сан эсвэл ЖДҮХС гэх мэт эх үүсвэрээс бидэнд дэмжлэг үзүүлэхийг хүсэж байна” гэж ярьсан юм.

Энэ бол ганц Б.Барсболд захиралд тулгамдсан асуудал биш. Дээр дурдсан 1300 ААН-ийн дийлэнхэд нь тохиолдсон тул Монголын аялал жуулчлалын холбоо асуудлаа албан ёсоор шинэ сайддаа уламжилж, гарц гаргалгааг хамтдаа эрэлхийлж эхэлжээ. Хувийн хэвшлийнхний хүсэлтэд ямар хариу өгөх бол хэмээн БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Баясгалантай уулзав:

-“Засгийн газрын тусгай зориулалтын 29 сан байдаг. Уг нь аялал жуулчлалыг дэмжих сан байсан ч 2014 онд татан буулгасан. Энэ санд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтлоцоо байгаагүй. Шууд улсын төсвөөс санхүүжиж байсан юм. Одоо яам яагаад компаниудаа дэмжиж чадахгүй байна гэхээр санхүүжилтийн тогтлоцоо төгс биш байна.

Иймд БОАЖЯ 2019 оноос хойш арилжааны банкуудтай уулзан, санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар судаллаа. Аялал жуулчлалын салбар ЖДҮХС-гаас зээл авах боломжгүй байв. Арилжааны банкуудаас л өндөр хүүтэй зээл авдаг. Дэлхийн банк, ЖАЙКА-гаас олгодог, бага хүүтэй зээлд ч хамрагддаггүй байсан тул энэ онд ХХААХҮЯ, ЖДҮХС-д хандан, аялал жуулчлалын жижиг компаниуд зээл авах боломжтой болсон. Мөн арилжааны банкуудын олгодог, 18 хувийн хүүтэй ногоон зээлд жуулчны баазуудыг хамруулах санал тавьсан юм. Энэ зээлийн хүүгийн 10 хувийн татаасыг БОАЖЯ-наас олгоно. Бизнес эрхлэгчид жилийн 8 хувь, сарын 0.6 хувийн хүүтэй зээл авна гэсэн үг. Энэ зээлд оператор компаниудаа нэмж хамруулах боломжийг судалж байна. Зээлийн санхүүжилтийг Орчны бохирдлыг бууруулах сангаас гаргах тул зээлийн зориулалт нь агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэх ёстой. Иймд энэ зээлд оператор компаниудыг хамруулж чадахгүй байна. Зөвхөн барьцаа хөрөнгөтэй жуулчны баазуудад олгох боломжтой” гэв.

Хүүгийн татаасыг төр олгоно гэхээр банкууд нааштай хүлээж авчээ. Ингэснээр банкуудын үйл ажиллагаанд ч эерэгээр нөлөөлнө. Эдийн засаг ирэх онд сэргэнэ гэж мэргэжилтнүүд зөгнөж байгаа ч -9.7 хувийн агшилтаас эргээд өслөө өслөө V хэлбэрийн буюу огцом өсөлт ирэхгүй гэдгийг АХБ-ны ахлах эдийн засагч Б.Болд анхааруулсан. Мөн тус банкны ахлах мэргэжилтэн Ясу Савада “Улс орнуудын эдийн засгийн сэргэлт рүү хүрэх зам хэцүү, тодорхойгүй” гэснийг энд ишилье.

Эдийн засаг чөлөөт уналтаар уначихсан энэ нөхцөлд бид гэнэтийн сэргэлтээс илүүтэй бүх салбарт тогтвортой байдлыг бэхжүүлэх нь эрх баригчдын эхний зорилго байх ёстой. Энэ нөхцөлд БОАЖЯ-наас боловсруулсан, ногоон зээлийн бүтээгдэхүүн ихээхэн онцлогтой. Хэрэв БОАЖЯ арилжааны банкуудтай тохиролцон, ирэх оны сайдынхаа багцаас 2 тэрбум төгрөгийг ногоон зээлд зарцуулбал ААН-үүдэд өгөх нийт зээлийн хэмжээ 20 тэрбум төгрөг болж арвижна. Банкууд өөрсдийн хөрөнгөөр зээл олгоно. Төр буюу БОАЖЯ зээлийн хүүгийн 10 хувийг төлөх юм. Хоёр тэрбум төгрөг олон ААН-д хүрэлцэхгүй тул БОАЖЯ аль болох олон компанийг зээлд хамруулахын тулд эргүүлээд банкуудад зээлийн нийт дүнгээ өсгөх болзол тавьж, зөвшөөрүүлсэн байна. Онцгой нөхцөл бүхий энэ зээлийг олгох замаар санхүүжилтийг шийдэхгүй бол бүх зээлийг улсын төсвөөс 100 хувь хангах ямар ч боломжгүй. Улсын төсвийн орлого энэ оны эхнээс байнга тасалдан, 2.7 их наяд төгрөгийн алдагдал хэдийнэ үүсчихээд байна.

Бид өнөөдрийг хүртэл дотоодод халдварыг хянаж чадсан нь бидний давуу тал болно. КОВИД-ын улмаас жуулчдын сэтгэл зүйд маш том өөрчлөлт орлоо. Ирэх жилүүдэд масс буюу хэт олуулаа явдаг аялал жуулчлал буурна.

2021 оны улсын төсвийн төсөөллийг яамдууд саяхан боловсруулж дуусжээ. Одоо Сангийн яам нэгтгэх ажил ид явагдаж байна. Дараа нь ирэх сарын 1-нд эхлэх УИХ-ын намрын чуулганаар Монгол Улсын 2021 оны улсын төсвийн төслийг хэлэлцэнэ.

Ямартаа ч БОАЖЯ-наас санаачилга гарган, Сангийн яаманд хандаж, аялал жуулчлалын салбар хүнд байдалд орсон тул эргэн сэргэхэд нь зориулж, санхүүжилт олгохыг хүсжээ. Тэдний боловсруулсан төсөлд ирэх онд 10 тэрбум төгрөгийг БОАЖ-ын сайдын багцад оруулах, үүнээс 2 тэрбум төгрөгийг ногоон зээлийн санд төвлөрүүлэхээр тусгасан байна.

Эдийн засаг хүндэрч, төсвийн гол эх үүсвэр болсон уул уурхайн экспорт саатсан энэ үед Сангийн яамны мэргэжилтнүүд зарлагад нарийн шинжилгээ хийж, зайлшгүй гаргах зардал мөн эсэхийг нягтлах нь гарцаагүй. Тэдний шалгуурыг давбал Засгийн газрын хуралдаанаар аялал жуулчлалын салбарыг 2 тэрбум төгрөгөөр дэмжих, эсэхийг хэлэлцэнэ. Үнэндээ энэ нь нийслэлийн төвд барьсан, шинэ цэцэрлэгт хүрээлэнгээс ч бага зардал.

Мөн улсын төсвөөс ердөө 2 тэрбум төгрөг зарцуулахад, энэ мөнгө ААН-үүдэд нийт 20 тэрбум төгрөгийн зээл болж үржинэ гэдгийг Д.Сарангэрэл сайд сайтар тайлбарлан ойлгуулах биз. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ гэж их ярьдаг өнөө үед энэ загварыг бусад салбарт ч хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Аялал жуулчлалын салбарын 88 мянган ажилтан шинэ сайддаа итгэл тавин, ногоон зээлийг эрх баригчдаар хэлэлцүүлэн, шийдүүлнэ гэсэн хүлээлттэй байна. Тэд хилээ нээ, бид ажилгүй хоцорлоо гэсэнгүй. Харин арга ядсан тул хөнгөлөлттэй зээл олгохыг л хүсэж байна.

Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал гэж үг бий. Б.Барсболд захирал “Манай салбарт төрөөс их хэмжээний хөрөнгө гарган, томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан удаагүй. Бид анх удаа л төрөөс дэмжлэг хүсэж байна. Өндөр хөгжилтэй орнууд КОВИД 19-ийн эсрэг вакцин гаргахаар шаргуу ажиллаж байгаа тул байдал эргээд хэвийн болно гэдэгт би итгэдэг. Гэхдээ манай улс хилээ нээн, эрсдэл үүрэх ямар ч шаардлагагүй. Аялал жуулчлалаа аварна гээд бусад салбарыг эрсдэлд оруулж болохгүй. Аялал аюулгүй байх нь хамгийн чухал. Тэр үед бид жуулчдаа хүлээн авахад бэлэн байх ёстой. Бид өнөөдрийг хүртэл дотоодод халдварыг хянаж чадсан нь бидний давуу тал болно. КОВИД-ын улмаас жуулчдын сэтгэл зүйд маш том өөрчлөлт орлоо. Ирэх жилүүдэд масс буюу хэт олуулаа явдаг аялал жуулчлал буурна. Сингапур, Хонконг гэх мэт хүн ам шигүү суурьшсан улсууд руу жуулчид зорчихгүй. Харин онгон зэлүүд байгальтай газар руу гэр бүлээрээ аялах хүсэлтэй болсон. Энэ шаардлага, эрэлтэд Монгол Улс бүх талаараа яв цав тохирно” гэсэн юм.

Хэрэв бид энэ давуу талаа дөвийлгөсөн, сайхан байгальтайн сацуу гол нь аюулгүй улс мөн гэдгээ баталж чадвал энэ онд алдсан 1.3 их наяд төгрөгийг ирэх жилүүдэд амархан нөхөх боломж байна. Тэгээд ч ААН-үүдэд олгосон хөнгөлөлттэй зээл эргэж ирнэ. Гагцхүү төр эргүүлээд ажлын байраа хадгалах хатуу амлалтыг л ААН-үүдээс заавал авах ёстой. БОАЖЯ-наас анх удаа хэрэгжүүлэхээр зэхэж буй ногоон зээл нь аялал жуулчлалын компаниудыг торгоон барихын сацуу тэдгээрт ажиллагсдыг АЖИЛТАЙ БАЙЛГАХ давхар зорилготой. Аялал жуулчлалын салбарт 88 мянган хүн ажилладаг. Нэг өрх дунджаар 4 гишүүнтэй гэхээр 350 орчим мянган хүний

амьжиргаанд эрх баригчдын шийдвэр шууд нөлөөлнө. Энэ нь Эрдэнэт хотын хүн амын тоотой тэнцэх юм.

Төгсгөлд нь энэ нийтлэлдээ аялал жуулчлалыг яагаад онцлов, яагаад энэ салбарыг одоо л дэмжих ёстойг хэдхэн баримтаар танилцуулъя.

- Дэд бүтэц сул хөгжсөн манай улсад алс бөглүү суугаа айл өрхүүдэд хүрч, нэмэлт орлого олоход нь тусалдаг,
- Уул уурхайн дараа, экспортын хоёр дахь том эх үүсвэр болж, валютын орлого оруулдаг (2019 онд 607 сая ам.долларын орлоготой ажилласан),
- Монголбанкнаас хийсэн судалгаагаар хөрөнгө оруулалтын өгөөжөө хурдан нөхдөг салбаруудын нэг,
- Худалдаа, үйлчилгээний салбарын гарцыг тус бүр 25-иас дээш хувиар нэмдэг нь бусад салбараас өндөр үзүүлэлт,
- Ажлын байрыг олноор нь бий болгодог, дэлхий дахинд шинээр бий болдог 5 ажлын байр тутмын 1 нь энэ салбарт байна. Мөн хүнд суурилсан үйлчилгээ үзүүлдэг тул хиймэл оюун ухаанаар орлуулах боломжгүй,
 - Дотоодын аялал жуулчлалаас 2019 онд 870 орчим тэрбум төгрөгийн орлоготой ажилласнаар салбарын нийт эргэлт 3 тэрбум төгрөгт хүрсэн,
 - Урт хугацаандаа Монгол Улсын гол тулгуур салбар болж хөгжинө,
 - Монгол ёс заншил, нүүдлийн ахуй, бидний ялгарал ондоошил гэх мэт монгол үндэстний үүх түүх, өвөрмөц онцлогийг дэлхий дахинд түгээн, МОНГОЛ-ын нэрийн хуудас болдог,
 - Аялал жуулчлал тээврийн салбарт ямар эерэг нөлөө үзүүлдгийг судалсан албан ёсны судалгааг хараахан хийгээгүй. Мөн манай улс экспортын орлогоо зөвхөн бараа бүтээгдэхүүний худалдаанд үндэслэн тооцоолдог. Бусад улсууд үйлчилгээний экспортыг тусгайлан тооцдог жишиг манай улсад мөн л нэвтрээгүй байна. Энэ судалгааг хийснээр аялал жуулчлалын үр шимийг илүү бодитой дүгнэх боломж бүрдэх юм.



Батбаярын Баяртогтох

*“Засгийн газрын мэдээ”
сонинь Эдийн засаг, уул
уурхайн мэдээллийн албаны
Эдитор*

*Батбаярын Баяртогтох
нь 2010 онд МУБИС-ийн
Байгалийн ухааны сургуулийг
Газарзүйн багш, Аялал
жуулчлалын менежер
мэргэжлээр, 2011 онд Хэвлэлийн
Хүрээлэнгийн дэргэдэх Сэтгүүл
зүйн дээд курсыг Сэтгүүлч
мэргэжлээр тус тус дүүргэсэн.*

*2010-2011 онд үндэсний
өдөр тутмын чөлөөт хэвлэл
“Ардчилал” сонинь Нийгэм,
эдийн засгийн албанд сэтгүүлч,
2011-2015 он хүртэл эдийн
засаг, бизнесийн Mongolian
Economy сэтгүүлд сэтгүүлчээр,*

*2015 оноос өдөр тутмын
“Засгийн газрын мэдээ” сонинь
Эдийн засаг, уул уурхайн
мэдээллийн албаны сэтгүүлч,
албаны даргаар ажиллаж
байна.*

“Засгийн газрын мэдээ”

УЛС ОРНУУД АЖЛЫН БАЙРАА ХАДГАЛЖ,
НИЙГМИЙН ХАЛАМЖААР ИРГЭДЭЭ
ДЭМЖИЖ БАЙНА

***АНУ болон БНХАУ татварын хөнгөлөлт үзүүлэх
замаар хувийн хэвилээ “халамжилж” байна***

Дэлхийн эдийн засгийг бүхэлд нь сульдаах COVID-19 цар тахлын эсрэг өөрсдийн хамаг байдаг нөөц боломжоо хүн төрөлхтөн шавхаж буй. Хүмүүс олноор ажилгүй болж, өрхийн орлого буурч, бараа таваарын эрэлт эрс багасаж байгаа учраас эдийн засгаа дэмжих бодлого дэлхий нийтийн чиг хандлага боллоо. Засгийн газрууд өндөр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэхээ мэдэгдэж, түүхэнд байгаагүйгээр улс орнууд мөнгөний бодлогоо зөөлрүүлж байна. Тэр жишгээр манай улсын төв банк бодлогын хүүгээ хоёр нэгж хувиар бууруулж, ес болгосон. Засгийн газар аж ахуйн нэгжүүдийг дэмжихээ илэрхийлсэн ч тодорхой болсон нь цөөн байна. Тэгвэл дэлхийн тэргүүлэх эдийн засаг болох АНУ-ын Засгийн газраас COVID-19 цар тахлын тархалтын үед жижиг, дунд бизнесээ аварч үлдэхийн тулд чек хэлбэрээр олгох 350 тэрбум ам.долларын нөөц өнгөрсөн пүрэв гарагт дууссан байна. Зээлдэгчийг 14 жил хангаж чадах хэмжээний мөнгө 14 хоногт дууссан ч зээлэнд хамрагдах хүсэлттэй хүмүүс эсвэл хүсэлтээ илгээсэн ч хамрагдаж чадаагүй бизнес эрхлэгчид зээлийн хүсэлтээ цахимаар илгээсээр. Энэхүү санхүүжилт нь ажлын байраа авч үлдсэн, цомхотгол хийгээгүй, цалингаа тогтмол өгч байсан 500-гаас цөөн тооны ажилчинтай жижиг бизнес эрхлэгчдэд нэг удаагийн буцалтгүй тусламж хэлбэрээр олгогдох юм байна. АНУ-ын Сангийн сайд 250 тэрбум ам.долларын нэмэлт санхүүжилт авах талаарх асуудлаар конгресст мэдэгдэл хэдийн хүргүүлжээ. Мухардалд ороод байгаа ард иргэдэд, ялангуяа бизнес нь маш хүнд байдалтай байгаа, мөн жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дээрх хөрөнгөнөөс санхүүжилт

олгохоо илэрхийлжээ. Эдийн засгийн хямралд хамгийн их өртөж буй хэсэг бол жижиг, дунд бизнес эрхлэгчид. Үйл ажиллагаа нь хараахан тогтворжиж чадаагүй, хөрөнгө оруулалтаа нөхөж амжаагүй, тодорхой хэмжээний санхүүгийн хуримтлалгүй шинэ бизнесүүд ташраараа хүнд байдалд ордог. Үүнээс сэргийлэх үүднээс АНУ дээрх арга хэмжээг аваад байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк зах зээлийг тогтворжуулах, санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх үүднээс бондын худалдан авалтаа эрчимжүүлж, 1.5 их наяд ам.доллараар нэмэгдүүлж 5.8 их наяд ам.долларт хүргэжээ. Энэ нь түүхэн дээд түвшинд тооцогдох аж. Бондын худалдан авалтаа нэмэгдүүлсэн нь эдийн засгийн уналтыг сааруулж, хувийн хэвшлээ дэмжсэн алхам гэж үзэж байна. Улс орнуудад ажилгүйдлийн түвшин нэмэгдсээр байгаа. Тухайлбал, АНУ-ын ажилгүй иргэдийн тоо өнгөрсөн сард 7.1 сая давж, ажилгүйдлийн түвшин 4.4 хувьд хүрсэн. Зөвхөн сүүлийн хоёр долоо хоногт гэхэд 10 сая иргэн ажлаа алдаж бүртгүүлсэн бол энэ сард ажилгүйдлийн түвшин даруй хоёр оронтой тоонд хүрч болзошгүй байна. Дэлхийн гурав дахь том эдийн засаг Япон ДНБ-ийхээ 20 орчим хувьтай тэнцэх хэмжээний эдийн засгийг дэмжих багц

**АНУ-д сүүлийн
хоёр долоо
хоногт гэхэд
10 сая иргэн
ажлаа алдаж
бүртгүүлсэн
бол энэ сард
ажилгүйдлийн
түвшин даруй
хоёр оронтой
тоонд хүрч
болзошгүй.**

хөтөлбөр хэрэгжүүлж байна. Мөнгөн дүнгээр 989 тэрбум ам.доллар бөгөөд тус багц арга хэмжээний хүрээнд бага орлоготой өрхүүдэд 300 мянган иен буюу 2800 ам.доларын мөнгөн туслалцаа үзүүлэхээр болсон байна. БНХАУ-ын хувьд COVID-19 цар тахалтай холбоотойгоор татварын хөнгөлөлт, нийгмийн халамжийн бодлогоос гадна тусгай зориулалттай бондын хэмжээ нэмэгдэж, төсвийн алдагдал нь энэ онд 6.4 хувь буюу түүхэн дээд хэмжээнд хүрэхээр байна. Тус улсын Засгийн газраас нэмэлт төсвийн дэмжлэг зарлах тохиолдолд төсвийн алдагдал нь оны эцэст ДНБ-ий 9.5 хувьд хүрч нэмэгдэхээр байгаа аж. Дотоод эрэлтийг дэмжих татварын хөнгөлөлтүүд болон нийгмийн халамжийн бодлогын хүрээнд төсвийн орлого нь 900 тэрбум юань буюу ДНБ-ий 0.8 хувьтай тэнцэх хэмжээгээр тасрах нь. Хятадын Ардын банк жижиг банкны заавал байлгах нөөцийн хувийг нэг хувиар бууруулсан. Цаашид ч заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулж магадгүй байна.

• • • •

ГАШУУНСУХАЙТЫН БООМТ ХААГДСАНААР МОНГОЛ УЛС ӨДӨРТ 27.5 ТЭРБУМЫГ АЛДАЖ БАЙНА

42 сая тонн нүүрс экспортлох төлөвлөгөөг коронавирус салхинд хийсгэх нь

Дэлхий нийтийг түгшээж буй шинэ төрлийн вирусийн улмаас Монголын эдийн засаг хүндхэн сорилттой нүүр тулах нь. Орлогын гол эх үүсвэр нүүрсний экспорт ирэх сар хүртэл зогссоноор нөхцөл байдал улам эмзэг болж ирэв. “Монгол нүүрс ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал Ж.Золжаргалын хэлснээр манай улс энэ оны эхний улиралд нүүрсний экспортоос олох орлогоо бүрмөсөн алдах нь нэгэнт тодорхой боллоо. 2020 оны төсөвт 42 сая тонн нүүрс экспортолж, үүнээс татварын орлогоор 1.4 их наяд төгрөг олохоор Засгийн газар тооцоолсон. Гэвч коронавирусыг улбаатай хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтаас үүдэн манай улс багагүй алдагдал амсахаар байна. Хэрэв бид дээр дурдсан төлөвлөсөн хэмжээнд нүүрсний экспорт хийж чадахгүй бол цалин тэтгэвэр тавих асуудал цаашид хүндэрнэ гэсэн үг. Орлогогүй төсөв ийм нөхцөлд зардлаа танахаас өөр хувилбаргүй. Төсвөө тодотгоод ч эдийн засгийн уналтыг зогсоож дийлэхгүй. 42 сая тонныг экспортлох Засгийн газрын төлөвлөгөөг коронавирус ийнхүү салхинд хийсгэх нь. БНХАУ-ын Баяннуур хот, Гашуунсухайтаас 130 км-ийн цаана байгаа Халиут гэх газар коронавирусийн халдварын хоёр ч тохиолдол бүртгэгдсэн. Үүнтэй холбоотойгоор ирэх сарын 2-ныг хүртэл Гашуунсухайт, Шивээхүрэн, Бичигт, Булган боомтоор нүүрсний экспорт хийхийг хориглох шийдвэр Улсын онцгой комиссоос гаргасан билээ. Монгол Улсын нүүрсний нийт экспортын 51 хувийг Гашуунсухайтын боомтоор тээвэрлэдэг. Зөвхөн тус боомтоор гэхэд жилд 3.5-4 орчим тэрбум ам.долларын уул уурхайн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийдэг. Тэгвэл Гашуунсухайтын боомт хаагдсанаас хойш манай улс өдөрт 10 гаруй сая ам.доллар буюу төв банкны мягмар гарагт зарласан албан ханшаар тооцож үзвэл 27.5 тэрбум төгрөг алдаж байна. Үүнийг 30 хоногоор үржүүлж тооцвол 300 гаруй сая ам.долларын орлогоо бид тавиад туух нь. Бусад боомтыг оруулж тооцвол үүнээс илүү өндөр тоо гарах нь дамжиггүй. Төсөв нь орлогогүй, улсын сан хөмрөг нь хоосон улс яаж дэлхий нийтийг хамарсан цар тахалтай тэмцэж, эрүүл мэндийн салбараа тэтгэж, тэжээх чадах билээ. Хамгийн ноцтой нь, Хятадын тал Монголоос авах уул уурхайн бараа бүтээгдэхүүний худалдан авалтаа 30-60 хүртэлх хоногоор хойшлуулж байгаа нь эдийн засагт урилгагүй хямрал дуудлаа. Ядаж байхад ярьж чаддаг манай улс ирэх жилүүдэд 2.9 тэрбум ам.долларын гадаад өр төлбөр барагдуулах хатуу хуваарьтай. Гаалийн ерөнхий газрын мэдээлснээр, нэгдүгээр сард улсын нийт экспорт 459 сая ам.доллар болж, 2019 оны мөн үетэй харьцуулахад 24.4 хувиар ахисан. Гадаад худалдаа 14.3 сая ам.долларын алдагдалтай гарч, энэ нь эдийн засгийн хямрал нүүрлэсэн 2015 оныг дахин давтлаа. Уул уурхайн эдийн засагч Л.Наран баатар ”2020 он сорилттой жил болохоор байна. Аж ахуйн нэгжүүдийн өглөг, авлага хугацаанаасаа хоцорч, зээлийн эргэн төлөлт муудаж байгаа нь ажиглагдах болсон. Уул уурхайн компаниудын сэлбэгийн хангалт тасарснаас болж техникүүд нь сул зогсож эхэллээ. Үүнийг дагаад ажил эрхлэлт муудна. Нөхцөл байдал энэ чигээр дахиад сар үргэлжлэхэд манай эдийн засагт томоохон хямрал авчирч мэдэхээр байна” хэмээн өөрийн нүүр номдоо бичжээ.

Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк тэргүүтэй олон улсын санхүүгийн донор байгууллагууд манай улсын энэ оны эдийн засгийн өсөлтийг ихээхэн өөдрөг төсөөлж, тогтвортой өснө хэмээн таамаглаж байсан. Тэгвэл нүүрсний экспорт хумигдаж, аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын үйл ажиллагаа саармагжсанаар эдийн засаг агших дүр зураг ажиглагдаж эхэллээ. Хэрэв төмөр замтай байсан бол нүүрсний экспортод өнөөдрийнх шиг хүндрэл үүсэхгүй байсныг “Монгол нүүрс ассоциаци” онцолсон юм. Өмнөд хөршийн нүүрсний эрэлт ихэсдэг хугацаа гэвэл дөрөвдүгээр сараас эхлээд наймдугаар сард оргилдоо хүрч, аравдугаар сараас уруудаж эхэлдэг. Энэ үед дэд бүтэц сайтай орнууд илүү давуу боломж эдлэх нь бий. Харин манай улсын хувьд авто замаар нүүрсээ тээвэрлэдэг учраас урт удаан хугацаанд зогссон салбарынхан бэлтгэл ажлаа хангаж, жигдэртэл багагүй хугацаа орно. Нүүрсний биет хэмжээгээ үлэмж ахиулахад төмөр замын ач холбогдол их. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км урт төмөр зам ашиглалтад орсноор жилд 30 сая тонн нүүрс экспортод гаргах боломж бүрдэнэ гэж үзэж буй. Гэвч өнөөдрийг хүртэл уг төмөр зам ашиглалтад орсонгүй. “Чингис” бонд болон “Эрдэнэс Тавантолгой”-н 2018 оны цэвэр ашгаас багагүй хэмжээний мөнгийг энэхүү төсөлд юүлсэн билээ. “Эрдэнэс Тавантолгой”-н нэг тонн нүүрс төмөр замтай болбол тээвэрлэх өртөг найм орчим ам.доллараар буурах бөгөөд автозамын тээврээс дөрөв дахин бага зардлаар нүүрсээ өмнөд хөрш болон гуравдагч зах зээлд хүргэх боломж бүрдэхээр байгаа юм. Нүүрсний экспортоос гадна ирэх тавдугаар сард ОУВС-тай байгуулсан “Өргөтгөсөн санхүү жилтийн хөтөлбөр” дуусахаар байгаа. 2017 оноос хойш хэрэгжсэн энэхүү хөтөлбөр зогссоноор манай улсыг чиглэх гадаадын хөрөнгө оруулалт буурч болзошгүй гэсэн таамгийг мөн хийгээд байна. Тэрчлэн УИХ-ын ээлжит сонгууль энэ онд тохиож байгаа нь ДНБ-ий өсөлт уруудах ээлжит үндэслэлд тооцогдоно. Корнонавирүсийн тархалт намжихаас Монголын эдийн засаг өсөх, уруудах нь хамаарахаар байна. Хятадын эдийн засгийн зогсонги байдал тус улсаас хараат эдийн засагтай орнуудад хамгийн хүндээр нөлөөлөх аж. Өмнөд хөршийн эдийн засаг энэ онд агших таамгийг Bloomberg болон J&P Morgan, Economist Intelligence Unit тэргүүтэй байгууллагууд дэвшүүлсэн юм.

**Хэрэв төмөр
замтай байсан
бол нүүрсний
экспортод
өнөөдрийнх
шиг хүндрэл
үүсэхгүй
байсныг
“Монгол нүүрс
ассоциаци”
онцолсон юм.**



**Түмэнжаргал овогтой
Хулантахь**

2011 онд Кино урлагийн
дээд сургуулийг Сэтгүүл зүйн
бакалавр,

2013 онд МУИС-ийн НШУС-
ийн Сэтгүүл зүйн магистрт
суралцаж төгссөн.

2011-2017 онд шуурхай
мэдээ, мэдээллийн www.24tsag.mn
сайтад улс төрийн албанд
сэтгүүлч, парламентын
сурвалжлагч,

2018-2019 онд өдөр тутмын
www.medeemn.mn сайтад улс
төрийн албанд сэтгүүлч,

2019 оноос одоог хүртэл шинэ
тутам www.isee.mn сайтад
редактороор ажиллаж байна.

**О.АМАРТҮВШИН: ХЯМРАЛ БОДИТООР
НҮҮРЛЭСЭН. САНГИЙН ЯАМ ХОЙРГО
БАЙСААР БАЙВАЛ ГОРЫГ НЬ ГУРВАН
САЯУЛАА АМСАНА**

Дэлхийн 100 гаруй оронд дэгдсэн
коронавирусийн халдварын улмаас аж, ахуй
нэгжүүд санхүүгийн хувьд их хэмжээний
алдагдалд орж, үүд хаалгаа барихад хүрсэн
тухайгаа шат, шатандаа уламжилсаар байна.
Хэрвээ энэ хүнд нөхцөл байдал дахин гурван
сар үргэлжилбэл улсын эдийн засагт сөргөөр
нөлөөлж, том зургаараа бид элгээрээ хэвтэх
аюултай тулгарна.

Бид дээрх асуудлын хүрээнд энэ цаг үед үйл
ажиллагаагаа явуулж буй компани, аж, ахуй
нэгжүүдийн бодит нөхцөл байдал болон нэн
даруй төрөөс ямар арга хэмжээ авах ёстой
талаар Худалдаа аж, үйлдвэрийн танхимын
ерөнхийлөгч О.Амартүвшинтэй ярилцлаа.

*~МАНАЙ ЗАСГИЙН ГАЗАР, САНГИЙН
ЯАМ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДУТУУ ҮНЭЛЖ,
АСУУДАЛД ХОЙРГО ХАНДАЖ БАЙНА~*

-Манай улсын хувьд коронавирусээс
сэргийлсэн үйл ажиллагааг явуулаад хоёр сар
гаруйн хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд
худалдаа эрхлэгчид болон аж, ахуй нэгж,
компаниудын үйл ажиллагаа нэлээн доголдлоо.
Өнөөдрийн байдлаар аж, ахуй нэгжүүд эдийн
засаг, санхүүгийн хувьд ямар эрсдэлд ороод
байна. Мэдээж тэд энэ талаарх зовлонгоо та
бүхэнд учирласан байх. Тийм үү?

-Уг өвчний эсрэг Улсын онцгой комисс,
Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ,
ажлууд зохион байгуулалт сайтай байгааг
юуны өмнө дурдах ёстой. Гэхдээ бүх зүйл
зэрэг, сөрөг талтай. Дэлхийн улс орнууд
өвчний тархалтын эсрэг арга хэмжээ авч

хэрэгжүүлэхээс гадна жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг тэлэх чиглэлд мөн адилхан анхаарч ажиллаж байгаа. Харин манай улсын хувьд уг хоёр хүчин зүйлийн нэгийг нь орхигдуулж байна. Тодорхой салбаруудын үйл ажиллагааг шууд зогсоох, цагийн хязгаартай ажиллуулдаг болгочихлоо. Ажиллах хөдөлгөөнийг шууд хорьсны дам нөлөө нь бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэллээ. Бид 1100 гаруй компани, аж, ахуй нэгжийн дунд судалгаа явуулсан.

Уг судалгааны дүнгээс харвал аж, ахуй нэгж компаниудын 88 хувийнх нь үйл ажиллагаанд нөлөө үзүүлж эхэлсэн байна. Уг 88 хувийн 60 орчим хувьд нь нэлээд хүчтэй нөлөөлж байна гэсэн дүн судалгаагаар гарсан. Харин 30 орчим хувьд нь дунд зэрэг нөлөөлж байна гэсэн. Мөн үүнээс найман хувь нь хэлэхэд эрт байна гэсэн бол хоёр орчим нь ямар нэгэн байдлаар нөлөөлөл үзүүлээгүй байна гэсэн. Мэдээж тухайн бизнесийн онцлог, шинж чанараас хамаарч ингэж хэлсэн байх. Хоёрдугаар сарын тухайд улирлын шинж чанартай ажлууд бүхэлдээ зогссон байдаг үе юм. Нэг болон хоёрдугаар сард хамгийн бага дүнтэй нийгмийн даатгал төлдгийг статистикаас харж болно.

Харин дөрөв болон тавдугаар сараас барилга, уул уурхай, газар тариалан гээд Монголын гол салбаруудын хөдөлгөөн эхэлнэ. Энэ үед л бодитой хүндрэлүүд гарч эхэлнэ. Дахин хэлэхэд, судалгаанд оролцсон аж, ахуй нэгжүүдийн 66 хувь нь банкны зээлийн төлбөр, хүү, торгууль, алданги энэ үед хүндрэл учруулж байна гэсэн. Харин 20 гаруй хувь “Үйл ажиллагаа зогссон үед түрээсийн төлбөр төлөхөд хүндрэлтэй байна” гэж хэлсэн. Ийм үед компаниуд хувьсах зардлаа байж болох хамгийн бага хэмжээнд хүргэж байгаа. Харин тогтмол зардлаа бууруулж чадахгүй. Тодруулбал, цахилгаан, дулаан, ажилчдын цалин, татвар, нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт тогтмол зардлаа шийдэхэд төвөгтэй болсон гэсэн үг.

Бусад улс орнууд эдийн засгийнхаа чадавх, чадамжид тулгуурлан компани, аж, ахуй нэгжүүдийнхээ тогтмол зардалд нэлээн их дэмжлэг үзүүлж байна. Төлбөр, хураамж төлөх хугацааг нь хойшлуулахад дэмжлэг үзүүлэх эсвэл хөнгөлөх, чөлөөлөх гэх мэт арга хэмжээг авч байна.

-Харин манай улсын хувьд компани, аж, ахуй нэгжүүдээ дэмжих ямар нэгэн ажлыг одоогоор хийж эхлээгүй байна. Байр, байдлаас нь харвал цаашид дэмжихгүй ч байх магадлалтай харагдаад байна?

-Дэлхийн улсууд нэн даруй арга хэмжээ авч буйг та бүхэн харж байгаа биз дээ. Өнөөдөр асуудал үүслээ гэхэд маргааш нь парламент нь хуралдаж, Засгийн газар нь шийдвэрлэж байна. Мөн банкууд нь идэвхтэй арга хэмжээг их сайн авч байгаа. Харин манай Засгийн газар асуудалд нэлээн хойрго хандаж байна. Тэр тусмаа эдийн засгийн асуудлыг шууд удирдан зохион байгуулах ёстой Сангийн яам асуудалд хойрго хандаж буйг бизнес эрхлэгчид шүүмжилж байгаа.

-Сангийн яам хойрго хандаж байна хэмээн та шүүмжиллээ. Европт коронавирус илэрсэн даруйд G7 хуралдаж бодлогын хүүгээ буулгаж, Дэлхийн банк, Олон улсын валютын сантай хамтран ажиллахаа мэдэгдсэн. Гэтэл манай улсын Сангийн сайд улсын төсөвтөө тодотгол хийхгүй, зардлаа танахгүй, ямар нэгэн арга хэмжээ авахгүй гэж мэдэгдэж буйг та хэрхэн дүгнэж байна вэ?

-Бодит нөхцөл байдал дээр манай төсвийн орлого буурах нь тодорхой болсон. Экспортын орлого нэлээд хэмжээгээр буурна. Орлого буурч буй тохиолдолд

хүссэн, хүсээгүй төсвийн тодотгол хийх ёстой. 2020 оны төсвийг хоёр их наяд төгрөгийн алдагдалтай баталсан. Өнгөрсөн 2019 онд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайн байсан учраас төсвийн орлогоо 25 хувиар өсгөсөн. Харин энэ жил дэлхий даяар 2020 оны эдийн засгийн өсөлтийг 2-3 удаа бууруулж байж 2.5 хувийн өсөлттэй байна гэдэгт тогтсон. Ийм байхад Монголын эдийн засаг 25 хувь өсөлттэй гарна гэдэг нь эдийн засгийн утгаараа ямар ч боломжгүй. Маш өндрөөр баталсан төсөв гэсэн үг. Сонгуулийн жил учраас маш их хэмжээний утга, учиргүй хөрөнгө оруулалтыг хийж, үр дүнгүй ажлыг нэмж санхүүжүүлэхээр тооцоолсон. Төсөв хэлэлцэх үеэр Худалдаа аж, үйлдвэрийн танхимаас яг энэ асуудлаар саналаа хүргүүлсэн. Бидний саналыг анхаарч авч хэлэлцээгүй.

2020 он дөнгөж гарсны дараа Дэлхийн банкнаас манай улсад зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжид Монгол улс саарал жагсаалтад орсон мөн сонгуулийн жилтэйг дурдаад төсвөө эргэж хараарай гэсэн байсан. Гэтэл эдгээр хүчин зүйл дээр вирусийн маш том нөлөөлөл нэмэгдээд ороод ирлээ шүү дээ. Тэгэхээр хүссэн, хүсээгүй тодотгохгүйгээр цааш явахгүй. Өөдрөгөөр тооцоолж, орлогоо бүрдүүлж чадна эсвэл Ирээдүйн өв сан гэх мэт сангуудын мөнгийг ашиглана гэж бодсон бол хөрөнгө оруулалтаа маш зөв эрэмбэлэх шаардлагатай байна. Шаардлагагүй хөрөнгө оруулалтыг танаад хэмнэсэн мөнгөөрөө экспортыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, үйлдвэр үйлчилгээг дэмжихэд чиглэсэн нэн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр болгон ашиглах хэрэгтэй. Ингэж чадвал маш зөв зүйтэй алхам болж хувирна.

-Улсын төсвийн хоёр их наяд төгрөгөөр огт шаардлагагүй буюу хөшөө дурсгал барих, соёлын төвийг засах гэх ажлуудыг хийхээр төсөвлөсөн байна. Энэ мөнгөөр аж, ахуй нэгжүүдээ дэмжээч гэж та хэлээд байна уу?

-Статистикаас харахад аж, ахуй нэгжүүдийн төлдөг НӨАТ болон бусад татвар 25 орчим хувиар тасарсан байна. Нийгмийн даатгалын шимтгэл мөн тасарсан байгаа юм. Эндээс үзвэл байгууллагууд бодитоор хямралд өртсөн байгаа биз. Ирэх сард энэ хямрал илүү гүнзгийрнэ. Би яагаад үүнийг хэлээд байна вэ. Хоёр сарын өмнө коронавирусийн халдвар дөнгөж тархаж эхлэх үед шинжээчид “Дэлхийн эдийн засаг буурсан ч буцаад V хэлбэрийн өсөлт гарч, богино хугацаанд сэргэнэ. Энэ хямрал түр зуурынх” гэж дүгнэж байсан. Үүнээс хойш шинжээчдийн дээрх таамаглалууд маш хурдацтай өөрчлөгдөж байна.

Яг өнөөдрийн байдлаар эдийн засаг хэзээ сэргэх нь тодорхойгүй нөхцөл байдалтай байна. Энэ бүхнийг манай Засгийн газар тооцох ёстой. Бидэнтэй хамгийн их хамааралтай БНХАУ-ын эдийн засаг энэ жил өсөлтгүй гарахаар байна. БНХАУ-ын эдийн засаг нэг хувиар буурахад Монголын эдийн засагт нөлөөлдөг нөлөөлөл ойролцоогоор 4.8 хувь. Тэгэхээр манай улсын эдийн засаг өсөх үндэслэлгүй байна. Энэ үед л тал, талаасаа зөв шийдвэр гаргахгүй бол болохгүй гэдгийг бид сануулж байгаа юм. Бидний танилцуулсан судалгаа, “Эдийн засгийн эрсдэлийг удирдах таван багц 21 санал” -д ч энэ талаар тусгасан.

*~ОДОО ЛАРГА ХЭМЖЭЭ АВАХГҮЙ БОЛ СОНГУУЛИЙН ДАРАА ЭДИЙН
ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ЯМАР Ч БОЛОМЖГҮЙ ШҮҮ~*

-Худалдаа аж, үйлдвэрийн танхимаас “Эдийн засгийн эрсдэлийг удирдах таван багц 21 санал” -ыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. Уг саналын талаар та бидэнд тодорхой мэдээлэл хэлээч?

-Төсвийн болон экспортын орлого буурах нь тодорхой байна. Нөгөөтэйгүүр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, аж, ахуй нэгж, компаниудын үйл ажиллагаа зогсож, орлогогүй болчихлоо. Цаашид нөхцөл байдал энэ хэвээр үргэлжилбэл ажилгүйдлийн түвшин 20 хувь руу орох нь. Үндсэндээ 200 мянган хүн ажилгүйчүүдийн эгнээ рүү шилжинэ. Энэ бүхний цаана банкны 18 их наяд зээлийн 50 хувь нь чанаргүй болно гэсэн үг. Нийгэм, эдийн засаг, банк санхүү гэх мэт бүхий л салбарт эрсдэлийг үүсгэнэ. Ядаж сонгуулийн жил давхцаж байна. Эдийн засагт төвөг учруулдаг популизм гаарна. Сонгуулийн дараа эдийн засгийг буцааж сэргээх ямар ч боломжгүй байдал үүснэ шүү.

Тиймээс ажлын байрыг хадгалахад чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг нэн яаралтай гаргах нь хамгийн чухал байна гэдгийг бид санал болгосон. Нэгэнт үйл ажиллагаа нь саарсан компаниудын татвар, нийгмийн даатгалын төлөлтийг хойшлуулж, хүү торгууль оногдуулахгүй байх арга хэмжээг авч өгөхийг мөн санал болгосон юм. Монгол банк шуурхай арга хэмжээ авч бодлогын хүүгээ нэг нэгжээр бууруулж, банкуудын заавал байх нөөцийг бууруулаа. Эндээс нэлээд их мөнгийг зах зээл рүү нийлүүлэх боломжтой болж байна.

Гэхдээ Монгол банктай зэрэгцэж Засгийн газар ч мөн арга хэмжээ авах шаардлагатай. Монгол банк эцсийн зээлдүүлэгчийн хувьд арилжааны банкууд руу доод тал нь 500 тэрбум төгрөгийг нэн хөнгөлөлттэй зээлийн зориулалтаар нийлүүлэх шаардлагатай байна. Эндээс банкууд аж, ахуй нэгжүүдийн үндсэн зээл, хүүний төлбөрийн төлөлтийн хугацааг хойшлуулах эсвэл дахин санхүүжүүлэх ажлыг хийж болно. Асуудлыг даван туулахад 500 тэрбум төгрөгийг энэ зах зээл рүү нийлүүлэх шаардлагатай байна. Жижиг, дунд аж, ахуй нэгжүүд таван сар хүртэл ажлын байраа хадгалчихвал хамгийн том зорилт юм.

Ихэнх аж, ахуй нэгжүүд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Түрээслүүлэгчидтэй бид уулзсан. Тэд уулзалтын үеэр “Ойрын хугацаанд хамгийн багадаа 30 хувиар түрээсээ хөнгөлж болж байна. Гэтэл газрын татвар 30 хувиар, дулаан цахилгааны төлбөр мөн л адил нэмэгдсэн. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор ажилчдын цалингийн зардал өссөн. Ингээд бодохоор хэтийн зардал их өснө. Энэ үед бид түрээсээ нэмээгүй. Бидэнд саад болж буй газрын болон үл хөдлөх хөрөнгийн татварыг хойшлуулчихвал бид түрээсийн төлбөрөө нэмээд буулгахад бэлэн байна” гэсэн. Шийдлүүдийг тал, талаас нь бид гаргаж тавьсан. Банкуудын холбоотой ч уулзсан. Энэ бол ойрын хугацааг эрсдэл багатай даван туулах арга.

Харин цаашид экспортын чиг баримжаатай боловсруулах үйлдвэрийг нэн яаралтай хөгжүүлэх шаардлагатай юм байна. Тэгэж байж дараа, дараагийн хүндрэлийг эрсдэл багатай даван туулах юм юм байна. Мөн Эрсдэлийн сан, Баялгийн санг зайлшгүй бий болгох ёстой. Төсвийн зардлыг жил бүр нэмэгдүүлэх биш тэр мөнгөөрөө Баялгийн сангаа арвижуулах хэрэгтэй юм байна. Сангийн

мөнгөө яг ийм хүндрэлтэй цаг үед төсвийн орлогыг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор ашигладаг болно гэсэн үг.

-Та бүхний явуулсан саналд хариу ирүүлсэн үү?

-Санал тус бүрийг үзээд зайлшгүй хийх ёстой ажлууд мөн байна гэж үзсэн. Энэ ажлыг хийхийн тулд Засгийн газар өөрийнхөө эрх хэмжээнд шийдвэр гаргаж болохоос гадна УИХ-аар хэлэлцэх ёстой асуудлууд мөн бий. Тэгэхээр УИХ-аар хэлэлцэж хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийх шаардлагатай саналууд бий гэсэн үг. Санаачлагч нь Сангийн яам. Гэтэл Сангийн яам хувийн хэвшлийг дэмжсэн, хамгаалсан чиглэлд одоогоор ямар нэгэн идэвх чармайлт гаргахгүй байгаа учраас уг ажил хойш тавигдчихаад байна.

~НӨХЦӨЛ БАЙДАЛ САНГИЙН САЙДЫН ЯРЬСНААС ТЭС ӨӨР БАЙНА.

100 ТЭРБУМ ТӨГРӨГ АЖ, АХУЙ НЭГЖҮҮДЭД ШААРДЛАГАТАЙ БАЙГАА~

-Боломжгүй гэсэн хариу хэлээд байгаа юм уу. Эсвэл судлах хүсэлгүй байгаа юм уу. Та хэрхэн харж байгаа юм?

-Үүссэн нөхцөл байдлыг маш дутуу үнэлж байна. Уржигдар Сангийн сайд хэвлэлийнхэнд ярилцлага өгөхдөө “V хэлбэрийн эдийн засгийн сэргэлт гарна. Энэ бол богино хугацааны асуудал. Бид өөрийнхөө нөөцөөрөө энэ хямралыг асуудалгүй даван туулна” гэж ярьсан. Гэтэл нөхцөл байдал, тоон үзүүлэлт Сангийн сайдын ярьснаас асар өөр байна. Гадаад зах зээл хүндрэлтэй үед жижиг эдийн засагтай манай улс сөрж амжилттай байх боломжгүй.

-Монгол банк бодлогын хүүгээ нэг нэгжээр бууруулах нь хангалттай юу?

-Монгол банк харьцангуй хурдан арга хэмжээ авсан. Үүнтэй зэрэгцээд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай. Бодлогын хүүгийн бууралт 3-6 сардаа нөлөөлнө. Ирээдүйд авах зээлийн хүүнд нөлөөлнө шүү дээ.

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү явуулсан та бүхний 21 санал дотор “Хориг, хязгаарлалтад орсон салбаруудын зээлийн хүүгийн 50 хувийг төр даах. Үүнд зарцуулагдах 100 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргах” тухай байна. Энэ өөрөө хэр бодитой тооцоолол вэ?

-Хэрвээ энэ ажлыг хийвэл маш олон эрсдэлээс хамгаалах томоохон алхам болно. Нийт гурван сарын зээлийн хүүг 100 орчим тэрбум төгрөгөөр шийдвэл ирээдүйд үүсэх хямрал, эрсдэлээс сэргийлэх юм. Дахин хэлэхэд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай.

-Улсын төсвөөс 100 орчим тэрбум төгрөгийг гаргаад шийдчих боломж хэр байгаа юм бол?

-За яахав дээ, 2020 оны төсвийг харъя л даа. Шинээр нэмж хөрөнгө оруулалт хийх 1.8 их наяд төгрөгийн 5 хүрэхгүй л хувь шүү дээ. 1.8 тэрбум төгрөг нь үнэхээр чухал юм байж. Энэ мөнгөөр хөдөө орон нутгийг хөгжүүлж, ард иргэдийн ая тухтай байдлыг дээшлүүлэхэд зарцуулах юм байна гэж ойлгоё. Гэтэл нэн яаралтай биш тэвчиж болох 500 гаруй тэрбум төгрөгийн төсөв байна. Энэ мөнгийг хэний ч амьдралд нөлөөлөхгүй ажилд зарцуулах нь байна. Харин 100 тэрбум төгрөгөөр 200 гаруй мянган иргэнийг ажилгүйчүүдийн эгнээнд оруулахгүй байх боломжтой.

~ГОРЫГ НЬ БИД ГУРВАН САЯУЛАА АМСАНА~

-100 тэрбум төгрөгийг шийдээд өглөө гэж бодъё. Тэгвэл энэ мөнгийг ямар зохион байгуулалтаар аж, ахуй нэгжүүдэд хүргэх юм?

-Банкаар дамжаад аж, ахуй нэгжүүдэд хүрнэ.100 тэрбум төгрөгийг нэг дор гаргахгүй. Гурван сарын хугацаанд бага, багаар шаардлагатай аж, ахуй нэгжүүдэд нь хүргэнэ. Өрийн дарамтад орсон, үйл ажиллагаа нь хүндэрсэн бичил, жижиг, аж ахуй нэгжүүд л хүрэх мөнгө юм.

-Нүүрсний экспорт нэгдүгээр улиралд 0 заалаа. Энэ нь эдийн засагт нөлөө үзүүлнэ. Удахгүй ноолуур гарна. Ноолуурын салбарт ямар өөрчлөлт гарахаар байна вэ?

-Бид дахиад л том зургаа харах ёстой. Манай улс дэлхийн зах зээлийн түүхий ноолуурын 40 орчим хувийг нийлүүлдэг. Үүнийхээ 7-8 орчим хувийг Монголдоо эцсийн бүтээгдэхүүн болгодог. Ойролцоогоор 10 мянган тонн ноолуурын тухай яриад байна шүү дээ. Бид энэ хэмжээний ноолуурыг бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болговол зэх зээлд нэмүү өртөг нэмэгдүүлнэ. Дэлхийн улс орныг хамарсан өнөөдрийн эдийн засгийн хямрал нэлээд их өөрчлөлтийг авчирна. Европ бүхэлдээ төвөгтэй байдалд байна. Энэ нь ноолуурын зах зээлд тодорхой хэмжээнд нөлөө үзүүлнэ. Тэгэхээр ноолуурын салбарт дахиад л төрийн дэмжлэг хэрэгтэй. Зөв менежмент л шаардлагатай. Манай улс жилдээ хоёр сая ноолууран бүтээгдэхүүн хийдэг.

Үүнийхээ саяыг нь экспортолдог. 500 мянган бүтээгдэхүүнийг дотооддоо зардаг бол үлдсэн 500 мянгыг нь гадны жуулчид ирж авдаг. Вирустэй холбоотойгоор аялал жуулчлал зогсчихлоо. Үүнийгээ дагаад тээвэр, зочид буудал гээд бүх салбар уналтад орж байна. Энэ нь манай ноолуурын борлуулалтад нөлөө үзүүлнэ. Дотоодын худалдан авалт ч буурна. Учир нь иргэдийн худалдан авах чадвар муудна шүү дээ. Тэгэхээр бид бүх талдаа маш сайн ярилцаад зөв шийдвэрийг гаргаад явах ёстой. Бүх нийтийг хамарсан цар тахлаас үүдэн дэлхийн улс орнууд урьд өмнө нь болж байгаагүй эдийн засгийн хямралтай нүүр туллаа. Энэ үед хувийн хэвшил дангаараа асуудлаа шийдэж чадахгүй. Үйлдвэр эрхлэгчид хаалгаа барих шиг амархан зүйл үгүй. Ашиггүй ажиллаж байхаар хаачихсан нь дээр.

Гэтэл энэ нь урт хугацаандаа Монголын эдийн засгийг эрсдэлд оруулж нийгмийн хямрал руу оруулна шүү дээ. Тэр үед эдийн засгийг сэргээхэд хэцүү. Нөхцөл байдал 1929-1932 оны их хямралаас ноцтой болоод байна шүү дээ. Дэлхийн улс орнуудын харилцаа хандлагад хүртэл нөлөөлж эхлээд байна. Тэгэхээр энэ цаг үед хувийн хэвшил дангаараа эрсдэлээ үүрээд гарахад хэцүү. Хямралгүй үед бол эрсдэлээ үүрээд л гардаг шүү дээ. Харин одоо төрийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Өмнө нь болоод өнгөрсөн асуудал гэж хандаж байгаа бол буруу алхам шүү. Горыг нь бид гурван саяулаа амсана. Аль нэг нам, эвсэл амсахгүй шүү дээ

-ЯРИЛЦСАНД БАЯРЛАЛАА.



***Доржссэнгээ овогтой
Эрдэнэтуяа***

*1998 онд “Хан хөхий”
дээд сургуулийг орчуулагч,
сэтгүүлч мэргэжлээр
төгссөн.*

*Ажлын гараагаа 1998 онд
Монголын үндэсний чөлөөт
хэвлэл “81-р суваг” сониноос
эхлүүлсэн. Өдөр тутмын
“Нийслэл таймс” сонин
Улс төрийн албаны дарга,
эдийн засгийн “Брэнд”
сэтгүүлийн редактор,
“Дэлхийн монголчууд”
сонин эрхлэгч, “Мэдээ.мн”
сайтын редактораар тус
тус ажиллаж байсан.*

*2019 оноос өнөөдрийг
хүртэл News.mn сайтын
редактораар ажиллаж
байна.*

**ДУНДАЖ ДАВХАРГА ЯДУУСЫН ЭГНЭЭ РҮҮ
ШИЛЖИЖ БАЙНА**

Б.Бат-Ирээдүй амьдралын шаардлагаар ачигч хийж буй тухайгаа хуучиллаа. Тэрбээр “Цагтаа аялал жуучлалын томоохон компанид менежер ажилтай, эхнэр гурван хүүхдээ сарын 1.6 сая төгрөгийн цалин, нэмэлт бас бус орлогоороо бусдаас дутаахгүй тэжээгээд болоод л байлаа. Гайтай цар тахлын улмаас аялал жуулчлалын бизнес тасарч, нэг л өдөр ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн. Компанийн орлого буурч, үйл ажиллагаа зогссон шалтгаанаар миний үеийн 18 залуу ажлаасаа нэг өдөр чөлөөлөгдсөн.

Эхний долоо хоног ч яах вэ, ажилгүй болсон “шок”-ноосоо гараагүй. Дараагийн долоо хоногоос “Эхнэр, хүүхдүүдээ цаашид яаж тэжээх вэ” гэдэг бодол толгойноос салахгүй, нойргүй хоноход хүрсэн. Юм юм хийх гэж оролдлоо. Гайгүй ажилд орлоо гэхэд цалингаа цагт нь тавьж чадахгүй юм. Үйлчилгээний байгууллагад таван сар ажилласан цалингаа одоо хүртэл авч чадаагүй явна. Аргагүйн эрхэнд ингээд “Барс” худалдааны төв дээр ачигч хийж байна даа. Ядаж өдөртөө хоолны мөнгөө олчихоод байгаа болохоор бас сэтгэл жаахан уужуу байна. Заримд маань ажил олдохгүй, архи уугаад өдөр хоногийг өнгөрөөж байгаа олон хүн байна шүү.

Миний хувьд хүүхдүүд минь бага байгаа учраас өвдөх ч эрх байхгүй. Цаашид тэднийхээ ирээдүйд яаж хөрөнгө оруулалт хийх арга ухаанаа олохгүй явна” хэмээн ярьсан юм. Б.Бат-Ирээдүй цар тахлын улмаас ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн дундаж давхаргынхны төлөөлөл.

Өнөөдөр коронавирусийн халдварын улмаас ажилтай орлоготой байсан иргэд цомхтголд өртөн, ажлын байргүй болсны улмаас ядуусын эгнээ рүү “гулсан” орж байгаа нь бодит үнэн билээ.

2020 оны хоёрдугаар улиралд нийт 8000 ажлын байр цомхтголд орох (“Covid-19” вирусийн ажлын байрны нөлөөллийн судалгааны тайлан. МҮХАҮТ) тооцоо судалгаа гарч байв. Ажлын байрны тооны өөрчлөлтийг салбараар харвал зочид буудал, нийтийн хоолны 52%, аялал жуулчлалын 44%, банк санхүүгийн 42%, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 39% нь ажлын байрны тоогоо бууруулжээ.

Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр, өнөөдрийн байдлаар ажлын байрны тоо нийт 6000 орчмоор буурсан дүнтэй байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2020 оны эхний найман сард 13.7 мянган хүнд 33.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 666 (4.6 хувь) хүнээр буурч, олгосон тэтгэмжийн хэмжээ 7.8 (29.8 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Манай улсад зөвхөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 19 мянга дөхөж байгаа статистик мэдээлэл бий бөгөөд насны хувьд 15-54 насныхан байгаа юм. Ид хийж бүтээх насны иргэдээ ажилтай, орлоготой байлгах асуудалд төр засгаас анхаарлаа хандуулахгүй бол улс орны ирээдүй бүрхэг болж, асуудал улам хурцдаж болзошгүйг эдийн засагчид анхааруулсаар байна.

Эдийн засагч Б.Лхагважав ажлын байр бий болгож, жаахан ч гэсэн хөрөнгө гаргасан хүн бүр эргээд дарамтад орж байгааг өгүүлсэн. Тэрбээр хэлэхдээ, 50 сая ам.доллар, цаашлаад нэг тэрбум долларын хөрөнгө босгоод, ажлын байр гаргаад явж байгаа компаниуд үнэндээ Засгийн газрын хийх ёстой ажлыг хийж байгааг тэмдэглээд, тэднийг байхгүй болговол орон зайг нь хэн эзлэх вэ гэдгийг төр сайтар бодох хэрэгтэйг анхааруулсан юм.

Б.Лхагважав “Цар тахлын үед асуудлыг яаж хамтдаа давж гарах вэ гэдэг л чухал. Өмнөх туршлагуудаас харахад, төрийн зөөлөн бодлогоор хямралаас гарч байсан. Засгийн газар, МҮХАҮТ компаниудтайгаа хамтарч ажиллаж байсных. Хөрөнгө оруулалтын асуудалд ч харилцан ойлголцож, тэр орон зайг нь бий болгож байсан. Түүнээс хонь, чонь болоод, харилцан эсрэг байвал нэгийг ч давж гарахгүй” хэмээн хатуухан хэлсэн билээ.

Монгол Улсын хувьд өнгөрсөн 2016-2018 оны хооронд хөдөө орон нутагт ядуурал буурсан нь хөдөө аж ахуйгаас олдог орлого нэмэгдсэнтэй холбоотой байв. 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанаас харахад нийт малчдын 90 хувь нь ямаатай буюу ноолуур зардаг гэж гарсан бол 2020 онд ноолуурын үнэ хоёроос гурав дахин буурчээ.

Хөдөө орон нутагт “Covid-19” гарсан ч хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн 98%-д нь нөлөө үзүүлсэнгүй. Харин эдгээр өрхийн 58% нь бүтээгдэхүүнээ борлуулж чадалгүй, орлого нь буурсан байна. Үүнийг сайн судлаад, дутагдаж байгаа, хязгаарлах хүчин зүйл рүү түлхүү анхаарах замаар хөдөөгийн өрхийн амьжиргааг тэтгэж болно хэмээн эдийн засагч Б.Дөлгөөн санал бодлоо хуваалцсан юм.

Мөн тэрбээр “Хотын хувьд арай өөр бодлого шаардлагатай. Хотод амьдарч буй хүмүүсийн орлогыг харахад хөдөө аж ахуйн орлого гэхээр зүйл байдаггүй. Мөн хотын ядуу бүлгийн хүмүүс олсон орлогынхоо бараг тал хувийг хоолондоо зарцуулдаг, энэ нь хангалтгүй байдаг. Гэтэл хүнсний үнэ нэмэгдчихвэл улам л тарчиг болно гэсэн үг. Хүнсний бүтээгдэхүүний үнэ тогтворжуулна гээд махыг 8000 төгрөг, будаа 2500-гаас ихгүй байх ёстой гэж хуульчилж огт болохгүй. Харин махны үнийн мөчлөгийг хэрхэн удирдах вэ, үнийн савлагааг хэрхэн бууруулах

вэ гэдэг дээр илүү анхаарч ажиллах ёстой. Ингэснээр улирлын чанартай үнийн хөөрөгдлийг бууруулах замаар хүмүүсийн хэрэглээг нэмэгдүүлж болно” гэж үзэж байгаагаа хуваалцсан юм.

Дэлхий даяар “Covid-19”-ийн нөлөө нэн ядуу хүмүүсийн тоог 100 саяар, харин ядуусын тоог 176 саяар нэмнэ гэсэн тооцоо гарсан.

Өнөөдөр цар тахлын улмаас эдийн засгаас гадна нийгмийн том хямрал болохыг үгүйсгэхгүй. Нийгмийн хямрал болгохгүйн тулд дэлхийн улс орнуудад нийтийн төлөө ажилладаг бүх байгууллага хамтарч нэгдэж байгаа юм. Мөн нийгмийн байгууламжаа, үнэт зүйлээ авч үлдэхийн тулд төр нь тодорхой хэмжээгээр мөнгө хүртэл хэвлэсэн тохиолдол бий. Тухайлбал, АНУ чөлөөт зах зээлээ авч үлдэхийн тулд юугаа ч хайрлахгүй тэмцэж, өнгөрөгч гуравдугаар сард хоёр их наяд ам.доллар хэвлэж тараасан билээ.

Өнөөдөр бид нийгмийнхээ үнэт зүйлсийг авч үлдэхийн тулд нэгдэхийн зэрэгцээ өнгөрсөн 30 жил олж авсан чөлөөт эдийн засгаа авч үлдэхийн тулд хөдөлмөрийн зах зээл рүүгээ мөнгө гаргах зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

Tusgal.mn

О.АМАРТҮВШИН: 46 МЯНГАН АЖЛЫН БАЙР АЛДАГДААД БАЙНА

Манай улс “COVID-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд хөл хорио тогтоогоод 100 хоног өнгөрчээ. Энэ байдал бизнес эрхлэгчдэд хүнд цохилт болж 46 мянган иргэн ажилгүй болоод байна. Цаашид нөхцөл байдал улам хүндрэх төлөвтэй байгаа учир ажлын байрыг хадгалахад төр засгийн дэмжлэг зайлиггүй шаардлагатайг МҮХАҮТ-аас сануулж байгаа юм. Тус байгууллагаас 4 дүгээр сард 10 мянган хүнд хийсэн “Ажлын байраас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлт” судалгаагаар хөл хорио судалгаанд оролцогсдын 73 хувийнх нь орлогод маш их нөлөөлсөн, 21 хувьд нь дунд зэрэг нөлөөлсөн буюу нийт судалгаанд хамрагдагсдын 94 хувь нь санхүүгийн бэрхшээлтэй нүүр тулсан гэжээ. МҮХАҮТ-ийн Ерөнхийлөгч О.Амартүвшинтэй ажлын байрны нөхцөл байдал, хийсэн судалгаа, шийдвэрлэх арга замуудын талаар ярилцлаа.

-Коронавирусийн шалтгаантайгаар аж ахуйн нэгжүүд, тэдний ажлын байрны нөхцөл байдал өнөөдөр яг ямар байна вэ?

Хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалж, бодлогын өмгөөлөл үзүүлэн тэдний дуу хоолой болдог, өөрийн гэсэн бие даасан хуультай цорын ганц ТББ бол МҮХАҮТ. Манайх 5000 аж ахуйн нэгжийг өөртөө нэгтгэдэг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 95 хувь гэсэн үг. Боловсон хүчний 70 орчим хувь нь манайд харьяалагддаг эдгээр байгууллагуудад байна. Гишүүн байгууллага маань 5000 гэж байгаа боловч бидний үйл ажиллагаа Монголын бүх хувийн хэвшил, аж ахуйн нэгжийг хамардаг.

2019 он бол бизнес эрхлэгчдийн хүлээлт аятайхан сэргэж ирж байсан үе. 2015, 2016 оны хямрал өнгөрсөн жил хамгийн дээд цэгтээ сэргэсэн. Дэлхийн томоохон судалгааны байгууллагууд 2020 оныг дэлхийн эдийн засгийн хямрал эхэлж болзошгүй гэж таамаглаж байсан. Дээрээс нь коронавирус дэлхийн эдийн засагт маш хүчтэй цохилт өгч байна. Дэлхийн улсууд хилээ хааж байсан тохиолдол дайн, тулааны нөхцөлийг эс тооцвол сүүлийн 100 жилд болж байгаагүй байх.

Маккензи танилцуулж байгаагаар АНУ-д нас барсан хүмүүсийн тоо Вьетнамын дайныхтай адилхан байгаа бол эдийн засгийн байдал нь дэлхийн II дайны үетэй зэрэгцэж очсон гэж байна. Ямар том асуудлуудтай өнөөдрийг жишиж байгааг та бүхэн анзаарч байгаа байх.

Монголын эдийн засаг бүхэлдээ БНХАУ-аас хамааралтай. Уул уурхайн түүхий эдийн экспорт, дамжин тээвэр гэх мэт бүх л зүйл урд хөршөөр дамждаг.

Хятад эдийн засгаа сэргээхийн тулд том том алхмууд хийж байна. Харин манайд бол вирус нэвтрүүлэхгүйн тулд л бүх арга хэмжээг өндөр түвшинд авч байгаа. Европын зарим орнууд, АНУ болон бусад улсууд вирусийн эсрэг тэмцлээ хожимдуулсан байдал ажиглагдсан ч “асуудал” гэдгийг хүлээн зөвшөөрч арга хэмжээ авч эхлэх тэр мөчдөө эдийн засгийн хямралтайгаа давхар тэмцэж эхэлсэн.

Манайх бол энэ асуудлаа бүр алдчихсан. 100 хоног эдийн засагтаа ямар ч арга хэмжээ аваагүй.

Өнгөрсөн долоо хоногоос л эхний асуудлууддаа ойлголцож эхэлж байх шиг

байна. Танхим бол хоёдугаар сарын гуравнаас эхлээд найман төрлийн судалгаа явуулж, үүнд үндэслэн ямар ямар арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа саналаа өнөөдрийг хүртэл тасралтгүй хүргэж ирсэн. Гэтэл 100 дахь хоногоос ганц нэг асуудал шийдэгдэж байгаа нь харамсалтай. Маш их цаг алдсан.

Сургууль, сургалт, цэцэрлэг, үзвэр үйлчилгээ, нийтийн арга хэмжээг 100 хувь хориглох нь дотоод худалдааг шууд блок хийчихэж байгаа л хэрэг.


Мэдээж бүх зүйлийг хааж болно, гэхдээ сэтгэл хөдлөлөөр биш, математик загварчлалаар тооцож болно шүү дээ. Бусад улсууд асуудлуудыг жишээд л шийдвэр гаргаж байгаа. Тооцоолол судалгаатай гэхээсээ илүү сэтгэл хөдлөлд суурилсан энэ олон шийдвэрийн дүнд эдийн засаг бодитой хүндэрсэн.

Бидний тоолж чадаж байгаагаар 46 мянган ажлын байр байхгүй болсон. 10 гаруй мянган хүнээс авсан судалгаагаар жижиг бизнес буюу түрээслэгчдийн 90 орчим хувь нь дампуурсан байна.

Энэ хүмүүсийн цаана хэдэн хүний амь амжиргаа яригдаж байгаа бол гээд харвал ямар хүнд зүйл энэ улс оронд болоод байгааг ойлгож болох байх. Судалгаанд оролцсон компаниудын 67 хувийнх нь орлого эрс буюу 90 хувь хүртэл буурч, аялал жуулчлал зогсчихсон, буудлуудыг бүр лацдаад лацдаад явчихсан. Шийдвэрүүдээ тооцоо судалгаанд үндэслэж гаргахгүй байгаа нь өнөөдөр нээж маргааш хаана, нөгөөдөр нээж маргааш нь хаана. Нэг ийм үймрээ хүн шиг. Аливаа шийдвэрийнх нь үндэслэл тоо, судалгаа байхгүйгээс ажил олгогчид маш их хохирч байгаа.

“Шийдье” гэдэг санаачлага үнэхээр төрд байгаагүй. Өнгөрсөн 100 хоногт хувийн хэвшил бүх нөөцөө шавхсан. Үүнээс цааш тэд чадахгүй гэдгийг ядаж ойлгоосой. Өнөөдөр асуудлаа тал талаас нь зөв томъёолж, цаг алдахгүй шийдэж явахгүй бол энэ хямралыг давах боломжгүй.

Covid-19: Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлтийн судалгааны дүн



-Өнгөрсөн 100 хоногийн хугацаанд хийсэн судалгааны дүн, авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдээсээ онцлооч?

-Ядаж л эмийнхээ нөөцийг тооцоолж чадахгүй байгаа юм. Бид бүх эмийн компанийг хамарсан судалгаа хийж өгөөд энэ энэ эмийн нөөц тасрах гээд байна, эмийн компаниуддаа нөөц бүрдүүлэхэд нь туслаач ээ гэсэн. Гэтэл өнөөдөр эм экспортлогч улсууд нь эмээ гадагш гаргахаа хориглоод эхэлчихлээ. Манайх ийм юмаа ойлгохгүй байгаа нь эмгэнэл шүү дээ. Ноолуур байна. Бид бас л судалгаа гаргаж өгсөн. Гэтэл яасан Улаан сайд, зүгээр явж байсан бизнесийг зогсоогоод, малчдыг тэнэг байдалд оруулж, хувийн хэвшилтэй нь муудалцуулж эцэстээ өөрсдийнх нь гаргасан шийдвэр нь шийдвэр ч биш, хачин юм болчихоод байна. Нийгмийн даатгал гэж өгнө өгөхгүй гэж бас л сар гаруй маргалаа.

Бизнес эрхлэгчдийн бухимдаад байгаа зүйл бол шийдвэр гаргавал гаргасан шиг гаргаж, хэрэгжүүлсэн шиг хэрэгжүүлэх.

Чадахгүй бол нэг мөсөн орхисон нь шулуухан. Тэгэхгүй маш их хүлээлт бий болгоод тэр хооронд компаниуд бүхнээ дэнчинд тавьж тэсээд, сүүлдээ хөрөнгөө зарах, ломбарданд тавьж болохоо тавиад эхэлж байна. Цааш хөдлөх эцэсгүй болж байна.

-Эрүүл мэндээс өөр үнэтэй зүйлгүй, коронавирусийг дотооддоо алдахгүйн тулд өнгөрсөн хугацаанд шийдвэрүүд гарч тэр нь ч үр дүнтэй байна? Алдчихвал өнөөдрийнхөөсөө дор байдал эрүүл мэнд, эдийн засагт үүсэх байх?

-Та нар юмыг загварчлалаар ярих ёстой. Америк, Европчууд биднээс тэнэг биш шүү дээ. Бүх асуудлаа математик загварчлалаар тооцоод аль нь хамгийн бага эрсдэлтэй юм бэ гэдгээрээ л шийдвэрүүдээ гаргаж байгаа. Өнөөдөр Монголд вирус орж ирэх эсэх нь цаг хугацааны л асуудал. Бид вакуум орчинд хэр удаан амьдрах вэ? Дэлхийг эзэлчихээд байгаа ханиаднаас бид ангид байх боломжгүй. Энэ бол цаг хугацааны асуудал. Механикаар ингээд хориод байж болно. Хоригдоод юу болох вэ? иргэд орлогогүй болно.

Экономист сэтгүүл хөгжиж байгаа орнуудыг санхүүгийн чадавхиар нь эрэмбэлэхэд 66 улсаас манайх 59 дүгээр байрт орсон байна.

Ажилгүйдэл 260 мянга хүрлээ, 1,5 сая ядуучууд бий боллоо, хоногийн хоолоо ч олж идэж чадахгүй. Дараа нь юу болох вэ? хулгай дээрэм, нийгмийн самуун байдал бий болно. Энэ нь хэдэн хүн өвдөхөөс хүнд тусах болов уу?

Онцгой байдал гээд л байна, гал сөнөөгчид дээр суурилсан л байгууллага шүү дээ. Тэд риск менежментийг гаргаж чадахгүй. Шийдвэр бүхэн нь хаах. Ард түмэнд таалагдаж л байна, гэхдээ дараа нь ирэх нийгэм эдийн засгийнхаа том хямралыг хэн яаж даван туулах гэж байгаа юм бол?

Бид нийт таван багц 34 санал гаргасан байгаа. Түүнийг уншиж ойлгох хэрэгтэй. Ямар үндэслэлтэй, ямар арга хэмжээ хэрэгтэй байгааг салбар бүрээрээ хуралдаад гаргаж тавьсан гарц, шийдлүүд байгаа. Түүнээс биш Засгийн газар шиг санаанаасаа өнөөдөр гарч ирж зарлаад маргааш нь ер нь чадахгүй юм байна гэх хэмжээний зүйл тэнд ерөөсөө байхгүй.

Хамгийн багадаа 1100 компани, 10 мянган хүнийг хамруулж судалсан судалгаанууд байгаа. Нийгэм эдийн засагт учирч болзошгүй эрсдлүүд байгаа.

Ядаж л ноолуурыг 50-60 мянган төгрөгт үнэ тогтвол хамгийн боломжит хувилбар байна гэж бид үзсэн. Гэтэл яасан Улаан гэж нөхөр гарч ирээд би 100 мянгаар авна гэж зарлаад л бүтэн салбарыг “алсан”.

За чадахгүй бол энэ байгаа махаа экспортлоочээ гэсэн. Өнгөрсөн оны өдийд дотоодын зах зээлд махны үнэ өсөөд байна гэж хэлээд махны экспортоо хаасан, өөрсдөө нөөцөө бүрдүүлээгүй, нөөц бүрдүүлсэн компанийнхаа агуулах руу буу барьж дайрч орсон.

300 сая долларын мах компаниудын зооринд байна. Хүү, зоорины зардал гэх мэт үргүй зардлаа дийлэхээ байгаад махны компаниуд бүгд дампуурч байна. Салбарын сайд нь өөрөө самраад байгаа.

Ерөнхий сайд гарч ирээд долоон шийдвэр танилцуулсан, маргааш нь сангийн сайд үгүйсгэсэн, нийгмийн хамгааллын сайд нь бүр өөр юм ярьсан, хууль гарсан дахиад үгүйсгэсэн. Ийм балай тодорхойгүй шийдвэрийг хүлээхдээ хувийн хэвшлийнхэн ажлын байраа хадгалах уу, түүхий эдээ нөөцлөх үү гэж бас эргэлзээд маш их санхүүгийн алдагдалд орж байдаг. Ингээд компани хохироод байгаа юм шиг харагдана л даа. Гэтэл компанид ард түмэн ажиллаж байж орлоготой байна биз дээ, тэр бүхнийг төр цалинжуулж чадахгүй шүү дээ. Тэгчихээд ард түмнийг хувийн хэвшлийнхнийхээ эсрэг турхираад байж болохгүй. Нарантуул зах дээр очоод үз л дээ, тэнд бүгдээрээ тоосон дотроо масктай, маскгүй хоёр метр байтугай байцгааж л байна. Тэгвэл яагаад сургалтын төвийг нээчихэж болохгүй гэж. Маш энгийн ойлголт. Кино театрууд яагаад ажиллаж болохгүй гэж сандлынх нь тоог зааж өгөөд хол суулгаад ажиллаж болж л байна. Энэ ялгааг би ч, ард түмний зарим нь ч ойлгохгүй болоод л бухимдаад байна шүү дээ. Шийдвэрүүдийг ангилаад үзэхээр хоорондоо ямар ч уялдаа холбоогүй. 10 цаг хүртэл ресторан ажиллаж болно, 12 хүртэл болохгүй. Ахуйн архидалт замаа алдаж байна гэж бас л тэнд мэргэжлийн хүн нь хэлээд байдаг. Тоодоггүй. Ахуйн архидалт гэж юу юм, хүүхдүүдийнхээ дэргэд аав ээжүүд ууж байна гэсэн үг. Ингээд л хүчирхийлэл. Ийм дүр зураг дэлхий даяараа өсч байгаа учраас бусад улс орнууд нийтийн үйлчилгээг нээж болно гээд нээж байна. Ямар ч тооцоололгүй, нийгмийн сүлжээний сэтгэгдлээр нээж, хааж бодлогогүй байж болохгүй.

-Хамгийн хүнд салбар нь аялал жуулчлалын салбар байгаа юу?

-Бидний өгсөн судалгаанд байгаа. Аялал жуулчлалын компанийн 90 хувь нь үндсэндээ дампуурч байна. Хувь хүн ч ялгаагүй. 10 мянган хүнээс судалгаа авахад 72 хувь нь ямар ч мөнгөгүй байна. Долоо, арав хоног цалингаа хүлээж байгаа. Тэдний 14 хувь нь 30 хүртэлх хоногийн, найман хувь нь гурван сар хүртэлх мөнгөтэй байна.

Компани ч ялгаагүй. Ямар ч орлогогүй болчихоод эхний сар түрээсээ төлнө, хоёр дахь сар цалингаа тавьна, хүүгээ төлнө, гурав дахь сараас боломжгүй шүү дээ. Бүх нислэг зогссон учраас аялал жуулчлалын компанид гаднаас жуулчин нэг ч орж ирэхгүй. Энэ жил, дараа жил ч орж ирэхгүй. Үүний дараа зочид буудал, ресторан, нийтийн хоолны бизнесүүд бүгд байхгүй болж байна. Хөдөө орон нутгийн жуулчны баазууд, тээвэр логистик байхгүй. Би энгийн жишээ хэлье. Гаднаас нэг жил 400 мянган жуулчин ирдэг, тэд 500 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүн авдаг байна. Энэ байхгүй. Энэ худалдан авалт байхгүй болчихоор ноолуурын компаниуд үүдээ бариад энэ салбарын 10 мянган ажлын байр байхгүй болчихож байгаа юм. Нэг салбартаа л нөлөөлдөг зүйл байхгүй, бүгд гинжин хэлхээгээр явна. Арьсан бүтээгдэхүүн, сувинер, худалдаа бүгд байхгүй. Баяр ёслол тэмдэлүүлэхгүй гээд хориод л байгаа. Гэтэл тэр бүхний цаана бүгд хэрэглээ, худалдан авалт байдаг.

Нэлээд хэдэн хүний зардал, худалдан авалт бизнесийн байгууллагыг бий болгож, тэр нь эргээд ажлын байр үүсгээд явдаг гинжин хэлээ тасарч байна.

Хамгийн бага өртөж байгаа нь мэдээлэл технологийн салбар л байх шиг байна. Төрийн эрчим хүчний компани зүгээр байх шиг харагдаж байгаа. Бусдаар бол өртөөгүй салбар алга.

-Энэ мэтээрээ нэг хоёр сар үргэлжилж, магадгүй гурван сар үргэлжилбэл эдийн засаг юу болох бол? Таны сая ярьсан яриа ер нь хаах, лацдахын эсрэг байж бизнесийнхний замыг чөлөөлөх тухай ярьж байх шиг байна?

Улс орон дампуурах л байх. Та нарын хүрсэн бүх амжилт байхгүй болно, иргэдийн өнөөдрийг хүртэл бий болгож хуримтлуулсан бүх юм байхгүй болно, компаниудын үнэ цэнэ үгүй болно. Ажилгүй баахан иргэдтэй, бид нар өөрсдөө шоолж инээгээд байдаг Зимбав, Венесуэль л болно.

-Манай компаниудын эдийн засгийн нөөц боломж дунджаар хэр хугацаанд амь бөхтэй орших чадамжтай бол?

-Ер нь гурван сарын нөөцтэй санхүүгийн компани гэж манайд байхгүй. Ямар ч орлого олохгүй байж түрээсээ төлнө, цалин, татвараа төлнө, зээлээ өгнө гэх мэт асуудлаа 100 хоног шийднэ гэдэг боломжгүй зүйл. Америкт дундаж компани нь 28 хоногийн л нөөцтэй байдаг. Америкийн жишээ, вирусний эсрэг тэмцэлтэйгээ зэрэгцээд эдийн засгийн хямралтайгаа тэмцэж эхэлсэн. Иргэд нь хоол хүнсэндээ оочерлохоос гадна, буу зэвсгэндээ дугаарласан. Яагаад гэвэл маш олон үймээн самууныг даван туулсан туршлагатай ард түмэн. АНУ-д дөрвөн хүний нэг нь ажилгүй болох тухай яригдаж байна. Америк 2,1 их наяд долларыг ажлын байр, жижиг дунд үйлдвэрлэлээ дэмжиж, иргэдийн орлогыг хамгаалахад шууд зарцуулж байна.

-Бүх улс орон өөрийн санхүүгийн нөөц бололцоондоо л тулгуурлаж байна. Манайх бол хүчтэй чадавхгүй улс шүү дээ?

-Сүүлийн дөрвөн жил 2,1 их наядыг зээлж амьдарсан байдаг. Монгол өрх жилд 700-800 мянган төгрөгийн өрөнд орж амьдардаг юм байна. Угаасаа цалин нь хүрдэггүй, сард 70-80 мянган төгрөгийг хэн нэгнээс зээлдэг. Жилээр нь бодвол нэг өрхөд жил бүр 800 мянган төгрөгийн өр нэмэгдэж байдаг гэж ойлгож болно. Жилээс жилд ингэж нэмэгдсээр л байгаа. Яг үүн шиг Монгол улсын өр жилд 2 их наядаар нэмэгддэг. Энэ мөнгө хаачдаг вэ? тендерээр дамжаад эрх мэдэлтэй, мэдээлэлтэй нөхдөд л шингэдэг.

Судалгаагаар 10 хүний ес нь 30 хоног амьдрах мөнгөгүй байна.

Нэг хүн л учиртай харагдаж байгаа. Энэ юу гэсэн үг юм бэ гэвэл зөв бодлого гэдэг юм чинь үгүйлэгдээд байна гэж. Америкт эсрэгээрээ. Хүмүүсийнх нь 12 хувь нь л хадгаламжгүй. Ихэнх хэсэг нь гурван сарыг хөнгөхөн тэсчих санхүүгийн чадамжтай байна. Тэгсэн нь ч төр иргэдээ тайвшруулж санхүүгээр нь дэмжиж байна. Аж ахуйн нэгжийг маш их дэмжиж байгаа. Аж ахуйн нэгжийг дэмжиж байна гэдэг нь ажлын байраа дэмжиж байгаа л хэлбэр.

Хүн ч өрхийн зардлаа эрэмбэлж нэн шаардлагатай зардлаа түрүүлж гаргадаг. Хэн татвар төлж байна тэр хүмүүсийнхээ үгийг сонсохгүй, сүүлдээ аж ахуйн нэгжүүд гэж ашгаас өөр боддог зүйлгүй, хүн чанаргүй амьтад гэдэг “пи ар”-ыг сангийн сайд хийгээд эхэлсэн. Гэтэл эд наргүйгээр яаж 1,3 сая хүнийг тэжээх гээд байгаа

юм. энэ зарчмыг нь ойлгохгүй. Тэгсэн хэрнээ үргүй зардал гэж хөдөө орон нутгаар дүүрэн.

-Бидний санаа бол төсвөө танаж, хэрэггүй зардлаа хойшлуулаад өгөөч гэж байгаа юм. Сумын төвд хоёр давхар соёлын төв ашиглалтад ороод иргэдийнхээ амжиргааг дэмжих үү? Та гэрээ шүүгээ авах хугацаагаа хойшлуулж чадна биз дээ.

-Яг ийм замаар 1,2 их наяд төгрөгийг хэмнээд аж ахуйн нэгжүүддээ нэн хөнгөлөлттэй зээл өгчих өө, дараа нь сэргэхээрээ төлчихөж чадаж байнаа гэдэг зүйлийг л тайлбарлаад ойлгуулж чадахгүй байгаа юм. Одоо тэгээд ч сар хүрэхгүй засгаас юу ч шаардах юм, ингээд мухардалд орчихлоо. Энэ олон аж ахуйн нэгж дампуурвал дараагийн сөрөг үзэгдэл юу байж болохыг мэдэхгүй, мэдсэн ч хэлэхгүй, хэлсэн ч шийдэхгүй. Төсвийн зардал дандаа 20 хувиар өсч ирсэн. Энэ бол маш том тоо шүү. Гэтэл иргэдийн орлого ийм хувиар өссөн үү? Аж ахуйн нэгжийн орлого 20 хувиар өссөн үү гэвэл үгүй шүү дээ.

-Банкууд зээлийн хүү, эргэн төлөлтийн асуудал дээр хатуурхсан. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хэр нөлөөлсөн бол?

-Монгол банк бол энэ үед үүргээ сайн биелүүлсэн. Банк санхүүтэй холбоотой олон асуудлыг түргэн шуурхай шийдсэн. Судалгаанаас харахад компаниудын 67-68 хувьд нь санхүүгийн зардлын бэрхшээл байна гэж байгаа юм. Энэ нь банкны зээлийн эргэн төлөлт, хүүгийн асуудал. Үүний эргэн төлөлтийг хойшлуулж, хүүгийн тодорхой хэмжээг өөр дээрээ аваад өгөөч гэж хүссэн. Мөн зээлийн хүүгийн хувьд, барьцаа, батлан даалтын хувьд бүх талыг харж, судлах мэдэрч зах зээлийг тэлэх хэрэгтэй байсан.

Манайхаас гуравдугаар сарын 23 нд танилцуулахдаа Хятадын нийгэм эдийн заасгийн нөлөө, өсөлт бууралт Монголд 3-6 сарын дараа хүчтэй нөлөөлж эхэлдэг гэдгийг хэлсэн. Энэ хандлагаас харвал тавдугаар сарын дундаас наймдугаар сарын дунд хүртэл хамгийн том хямрал манайд ирнэ.

Монголчууд 4-10 сарын хооронд идэвхитэй ажиллаад улирлын шинж чанартай, цаг агаарын циклээ дагасан бизнестэй, өвөлдөө амарцгаадаг. 11-3 сар дуустал нөгөө хуримтлуулсан мөнгөө хэрэглээд дуусдаг. Одоо таван сар гарчирлаа. Нөгөө улирлын шинж чанартай ажлууд эхэлье гэтэл чадахгүй болчихсон, жуулчдыг дагадаг бүх зүйл таг. Өнөөдөр ажлаас халагдсан хүн буцаад ажилдаа орно гэдэг ойлголт байхгүй болсон.

Яг өнөөдрөөс эхлээд маш олон компаниуд уналт хийж эхэлж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг нь шийдлээ гэсэн, энэ компанийн орлогыг нэмэхгүйгээс хойш үйл ажиллагааг бодитоор дэмжсэн болохгүй. Яагад гэвэл иж бүрэн арга хэмжээ авч байж тэсч үлдэх боломж үүсэх байсан.

Энэ бүхнийг харж чадаагүй учраас компани нэгэнт цалингаа тавьж чадахгүй болчихсон юм чинь яахын цомхотгол л хийж таарна. Банк зээл өгөхгүй шүү дээ. Ямар ч баталгаагүй мөнгө тараачихаад яаж эргэж олж авах юм бэ л гэж бодно. Банк ч өөрөө эрсдлээ харна. Гадаадынхан харин яасан гэхээр энэ бүхнээ мэдрээд компаниудын батлан даалтыг төр өөрөө хариуцаад эхэлсэн. Буцаад жилийн дараа үйл ажиллагаа нь сэргэх үед төр өөрөө хариуцаад зээлийг нь төлүүлэх жишээтэй. Анхнаасаа харилцан ойлголцоод, хувилбараа зөв тооцоод явах ёстой байтал би ганцаараа мэдэж байна гээд явчихсан. Энэ алдааны гор нь энэ сараас гарч эхэлнэ,

төр өөрөө бэлэн байх хэрэгтэй. Үндсэндээ хоёр долоо хоногийн дараанаас сонгууль гээд л нөгөө хорьж байсан нөхдүүд өөрсдөө ч гараад давхих байх. Хэн ч үүнийг сөхөж санаа зовохгүй.

Бид нарын тооцоогоор ямар нэгэн дорвитой арга хэмжээ авахгүй бол найман сар гэхэд манай эдийн засаг бүрэн утгаараа дампуурна.

-Өнгөрсөн хугацаанд мэргэжлийн байгууллага, хүмүүсийн үгийг төр, эрх баригчид сонсоогүй гэсэн үү?

-Тийм. Үнэхээр сонсоогүй. Нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх асуудал байна. Үүн дээр салбараар нь ялгаад эхэлсэн. Тэгвэл өгнө, тэхгүй бол өгөхгүй гээд. Уул уурхайд ажилладаг бол өгөхгүй ч гэх шиг. Аль компанид ажилладагаасаа болоод тэр хүн гадуурхагдаад эхэлж байгаа юм. Үнэндээ бол 1100000 хүнээс ердөө 10 хувь нь л тэр чөлөөлөлтөд хамрагдах байсан, шалгуураар нь бол.

Нөгөө 200 мянган төгрөг өгөх шийдвэр бас байна. Үүнийг үнэндээ авах компани өнөөдөр байхгүй. Ямар ч орлогогүй болчихсон хэрнээ 100 хүн хадгалаад байж байдаг компани гэж байхгүй. Нэгэнт үйл ажиллагаа нь зогсчихосон юм чинь 100 хүнээсээ 20-ийг нь хална. Халагдсан хүмүүс чинь ажилгүйдлийн тэтгэмж 70 хувиа авчих байгүй юу. Асуудал ажил олгогч, ажилтан хоёртоо бараг л ээлтэй тусна.

12 сая төгрөгийн дэмжлэг авах гэж 20 хүнийг 60 сая төгрөгөөр гурван сар хадгалах хэмжээний ухаантай хүн бизнес хийх үү. Ийм утгагүй. Гаргасан шийдвэр бүхэн нь дандаа хэрүүл маргаан, гайхшрал, өрсөлдөөн дагуулсан нэг тийм сонин. Зөрчил дандаа үүсгэдэг.

-Эдийн засгийг их хол хямрааж алдахын хэрээр эргээд сэргээх асуудалд их хугацаа, их хүч шаардах байх?

Ер н вакциныг хүнд яах гэж тарьдаг юм гээд өөрөөс тань асуучихъя. Вакцин хийчихвэл ямар ч өвчинг эрсдэл багатай даван туулна, эсвэл өвчнөөр өвдөхгүй. Вакцин хийхгүйгээр өвчин тусч хүндрүүлбэл юу болох вэ? маш их зүйлийг даван туулах болно. Эрх айлыг аваад үзье. Гурван сарын өмнөх хүртэл 10 гаруй жил тогтвортой хөдөлмөр эрхэлсэн хүн лизингээр ч болтугай байр, унаатай болчихсон байна. Өөрийнхөө хэмжээнд амьдралаа босгосон байна. Гэтэл өнөөдөр тэр айлын өрхийн орлого нь 0 заавал юу болох вэ?

Өнгөрсөн хугацаанд хураасан бүхнээ буцаагаад алдана л гэсэн үг. Ингээд дахиад анхныхаа түвшинд очлоо. Тэгсний дараа дахиад босгоход хэр хугацаа хүч зарцуулах бол? Босгосон шиг нь л хугацаа орно шүү дээ. Улс орон ч ялгаагүй.

Коронавирусийн нөлөөллөөс эдийн засгаа аврах оролдлого аль эрт хоцорчихсон.

Сонгуулийн дараа наадам. Үүний дараа жигдлэе гээд ч жигдлэх юм үлдэхгүй болчихоод байна. Үүнийг ойлгуулах гэж бүх талаар оролдсон. Гэхдээ цөөхөн гайгүй салбар байгаа ч ийм маягаар асуудалд хандвал аажмаар хумигдах л болно.

Хятадын нийгэм эдийн засгийн нөлөөлөл 3-6 сарын дараа манайд мэдрэгддэг гэдэг бол өмнөх түүхэн давтамжаас харагддаг үзэгдэл. Бид өнөөдрөөс найман сарын дунд хүртэл маш хүнд үеийг туулах болно. Сонгууль давхцаж байна. Ард иргэдийн орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих тал дээр эрх баригчид үнэхээр хөдөлсөнгүй. Гарсан шийдвэр бүхэн нь сонгуулийн санал авахад чиглэсэн шүү. Шууд л хэлье.

-Аж ахуйн нэгжүүд бол хувийн л бизнес. Ашгийн төлөө л байгууллага. Баялаг бүтээгч гэж нэг хэсэг нь хардаг ч эцсийн дүндээ хувийн л өмч шүү дээ гэх хандлага байдаг. Магадгүй ийм зүйл тэднийг дэмжихэд саад болдог уу? Татвар шимтгэл төлөх асуудал бол хуулийн хүрээний л хэрэг гэж үздэг байх.

Бизнес эрхлэгчдийн зорилго мэдээж ашиг. Гэхдээ юу гээч. Компани ашиг олж, амжилтанд хүрэх явцдаа маш их зүйлийг нийгэмд бүтээж, ард түмэнд өгдөг учраас баялаг бүтээгч болдог. Наад захын жишээ нь сургууль төгссөн ямар ч чадваргүй, мэдлэггүй залуусыг цалинг нь өгөөд мэргэшүүлж, туршлагажуулж сургаад жинхэнэ боловсон хүчин болгодог. Энэ бүхэн маш их зардал.

Боловсон хүчин бэлддэг, маш олон хүнийг ажлын байраар хангадаг, гадны хөрөнгө оруулалтыг татдаг үндсэндээ эдийн засгийг удирддаг.

Яг компанийн эзний хувьд энэ цаг үед бүх хүнээ халаад, хаалгаа түгжээд эдийн засаг сэргэтэл хүлээгээд суучихаж болно. Тэр хүн турж үхэхгүй. Яах ч үгүй. Харин ч ашигтай, эрсдэлгүй. Маш олон компанийн эзэн ийм зан гаргарвал ажилгүй болох хэдэн мянган хүн хаачих вэ гэдэг л асуудал. Тэдний ар гэрийг хэн тэжээх вэ гэдэг л асуудал.

Ажлын байр гэдэг зүйл бол улс орны амин сүнс нь. Үүнийг л ойлгож чадахгүй улс төрчид гэдэг эмгэнэлтэй. Хувийн хэвшилд ажиллаж байгаа нэг сая гаруй хүн, 100 мянган аж ахуйн нэгжийн төлдөг татаас татвар дээр л эрүүл мэнд, боловсролын тогтолцоо оршиж байна.

Тэр улс төрчид гээд байгаа нөхөд нь өөрийнхөө халааснаас өгч байгаа юм шиг аашилж аяглах нь тохуурхалтай. Хадгаламжийн хүүг ерөөсөө буулгаж болохгүй байна гээд банкууд гомдоллоод байгаа. 14 их наяд хадгаламжийн 95 хувь нь маш цөөхөн хадгаламж эзэмшигч дээр байгаа, хадгаламж хэт төвлөрсөн. Маш цөөн хүний маш их хэмжээний бэлэн мөнгө. Ердийн иргэн 12 хувийн хүүтэйгээр мөнгөө банкинд хийдэг бол тэр хүмүүс тусгай нөхцөл гээд 14,15 хувийг хүү авна.

Энэ хадгаламжийн эзэд хэн бэ гээд үзвэл тэр дотор нь бизнес эрхлэгчид эзлэх хувь маш бага. Ихэнх нь уул уурхайн лиценз зарсан хүмүүс болон улс төрчдийн мөнгө байдаг. Үүнээс нөгөө гажуудал нь бий болдог.

-Ноолуурын үнийн асуудал малчдыг бухимдуулахаас гадна манай улсыг дэлхийн зах зээлд чирч гаргах энэ тэргүүний салбар асуудалд орлоо гэж харж байна?

Монголын ноолуур түүхий эдийнхээ хувьд дэлхийн ноолуурын 40 хувийг дангаараа бүрдүүлдэг. Энэ салбарт манай 200 компани оршин тогтнож, 10 мянган ажлын байр үүсгэдэг.

Ноолуурын салбар бол эдийн засгийн хямралыг хамгийн түрүүнд мэдэрдэг онцлогтой. Ямар нэгэн хямрал боллоо гэхэд 35-40 хувь нь шууд унадаг. 1993 оноос хойших бүх түүхийг харахад уналт нь 18 сар орчим үргэлжилдэг болохыг харж болно. Хэн ч гэсэн эдийн засаг хямарч байхад үнэтэй ноолууран хэрэглээнд хөрөнгө оруулахгүй. Тэр тусмаа эрэлт ихтэй Итали зэрэг улсууд нь өнөөдөр хямарч байна. Ийм байхад өнгөрсөн оных шиг ноолуур үнэтэй байх ямар ч боломжгүй байсан. ийм нөхцөлд төр ноолуурын компанийг зөв дэмжих байтал малчдыг дэмжиж байна гэж шоудаад өнөөх 200 компанийнхаа хоолойд хутга тулгасан. Одоо бушуухан

арга хэмжээ аваад тэднийг дэмжихгүй бол тэдний бий болгодог ажлын байр үгүй болно. Ингээд салбар нь дампуурна.

-Цаг гаргаж ярилцсанд баярлалаа.

“

Монголын ноолуур түүхий эдийнхээ хувьд дэлхийн ноолуурын 40 хувийг дангаараа бүрдүүлдэг. Энэ салбарт манай 200 компани оршин тогтнож, 10 мянган ажлын байр үүсгэдэг. Ноолуурын салбар бол эдийн засгийн хямралыг хамгийн түрүүнд мэдэрдэг онцлогтой. Ямар нэгэн хямрал боллоо гэхэд 35-40 хувь нь шууд унадаг.

”



Төрбат овогтой Энхбат

“Өнөөдөр” сонины Эдийн засаг, бизнесийн мэдээллийн албаны сурвалжлагч, тоймчоор 2013 оноос хойш ажиллаж буй Т.Энхбат нь “Оюуны өргөө” дээд сургуулийг 2008 онд сэтгүүлч мэргэжлээр дүүргэснээс хойш эдийн засаг, бизнес, уул уурхайн сэдвээр дагнан нийтлэл, сурвалжилга, ярилцлага бэлтгэж, уншигчдад хүргэж байна. “Монголын мэдээ” сонин, www.businessnews.mn, www.time.mn портал сайтад эдийн засгийн сэтгүүлчээр ажиллаж байсан. Монголын хэвлэлийн хурээлэнгээс зохион байгуулдаг Эдийн засгийн шилдэг нийтлэл шалгаруулах уралдаанд “Хөрөнгөө өсгөх зам” нийтлэлээр 2013 онд тэргүүн байр эзэлсэн. Мөн “Хариуцлагатай уул уурхайн эрэлд” сэдэвт цуврал хамтын бүтээлээрээ 2018 онд сэтгүүл зүйн дээд Балдорж шагналын гранпри шагналыг хүртсэн.

“Өнөөдөр” сонин

ӨРИЙН ДАРАМТЫГ ХОЁР ДАХИН НЭМЭХ ТОДОТГОЛ

УИХ энэ оны төсвийн тодотголыг хэлэлцэж эхэллээ. Хуулийн дагуу 2020 оны төсвийг өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 15-наас өмнө баталсан. Тухайн үед дэлхий дахинд коронавируст халдварын цар тахал тархаагүй байв. Цар тахал гарснаар дэлхийн эдийн засгийн орчин огцом өөрчлөгдсөн. Монгол Улсын эдийн засгийн орчин ч өөрчлөгдсөнийг бид бүхэн мэдэрсэн. Төсвийн орлого, зарлагад гэнэтийн өөрчлөлт гарч, өмнөх онд төсөөлж байсан эдийн засгийн тооцооллуудын дийлэнх нь зөрсөн юм. Тиймээс “Ковид-19” өвчнөөс шалтгаалсан эдийн засгийн нөхцөлтэй уялдуулан төсвөө тодотгох гэж байна. Мөн УИХ-ын сонгуулийн үр дүнгийн дагуу шинээр эмхлэн байгуулсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орууллаа. Мэдээжийн хэрэг энэ нь төсвийг тодотгох нэг үндэслэл болно.

Засгийн газраас нэгдсэн төсвийн нийт орлого 10.7 их наяд, нийт зарлага 14.6 их наяд төгрөг байхаар төсөөлжээ. Ингэснээр төсвийн алдагдал 3.8 их наяд төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 9.9 хувьтай тэнцэв. Энэ оны төсвийг анх батлахдаа 11.7 их наядын орлого, 13.8 их наяд төгрөгийн зарлагатай байхаар тусгасан. Ийм тооцооллын дагуу төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувьтай тэнцээд байсан юм. Гэвч дээр дурдсанчлан “Ковид-19” бүх тооцооллыг “эвдлээ”.

Цар тахлаас шалтгаалан төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр буурах нь тодорхой болжээ. Тэгвэл зарлага нь 800 тэрбум төгрөгөөр өсөв. Төсвийн тодотголын төслийг хийхдээ өмнө нь гаргана гэж тооцоолсон зарлагаа нэлээд танажээ. Тодруулбал, төсвийн хөрөнгө оруулалтын зарлагыг 500 тэрбумаар бууруулж, 1.3 их наяд төгрөгт хүргэсэн байна. Мөн улсын

нэгдсэн төсвийн урсгал зардлаас 118 тэрбум төгрөг танажээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагын эд хогшлоо шинэчлэх, дарга нар нь шинэ машин худалдан авч унах зардлыг танасан гэсэн үг. Өмнө нь зарцуулна гэж тооцоолж байсан дүнгээс 700 орчим тэрбум төгрөг танаад буй нь энэ.

Гэтэл яагаад төсвийн тодотголд зарлагыг 800 тэрбум төгрөгөөр өсгөчихсөн юм бэ гэсэн асуулт ургана. “Ковид-19”-өөс шалтгаалан нийгмийн халамжийн зардлыг нэмсэн. Хүүхэд бүрт сар тутамд олгодог 20 мянган төгрөгийг энэ оны дөрөвдүгээр сараас хойш 100 мянган болгон нэмэгдүүлсэн. Нийгмийн халамжийн мөнгийг 100 мянган төгрөгөөр өсгөсөн. Хорио цээрийн дэглэмээс шалтгаалан үйл ажиллагаагаа нь доголдсон ч ажлын байраа хадгалж байгаа зарим аж ахуйн нэгжид төсвийн дэмжлэг үзүүлж буй. “Ковид-19” өвчин тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулж байгаа. Эрүүл мэндийн сайдын зарцуулах хөрөнгийг 100 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, “Ковид-19” туссан иргэдээ анагаах, энэ өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийн хямралын үед иргэдийнхээ орлогыг хамгаалахын тулд 1.5 орчим их наяд төгрөгийн зардал гаргахаар төлөвлөөд байна гэсэн үг.

Төсвийн орлого буурсан гол шалтгаан нь уул уурхайн түүхий эдийн экспортын хэмжээ багассан явдал гэж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар онцолсон. “Өмнө нь баталсан төсөвт олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 5991, нүүрснийхийг 75-125 ам.доллар байхаар тооцож, уул уурхайн салбараас 3.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолсон. Үүний 46.8 хувь буюу 1.5 их наяд төгрөгийн орлогыг нүүрс, 36.3 хувь буюу 1.16 их наяд төгрөгийн орлогыг зэсээс, 16.9 хувь буюу 540.7 тэрбум төгрөгийн орлогыг бусад ашигт малтмалаас бүрдүүлэхээр тооцсон. Гэвч олон улсад тархаад байгаа коронавируст халдварын цар тахлын нөлөөгөөр эхний хагас жилд дэлхийн эдийн засгийн идэвхжил удааширч, улмаар зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ огцом савлалаа. Энэ оны эхний хагаст зэсийн үнэ тонн тутамд дунджаар 5489.6 ам.долларт хэлбэлзсэн. Мөн коронавируст халдварын цар тахлын нөлөөгөөр нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоо буурч, эхний хагас жилийн байдлаар 8.7 сая тонн нүүрс экспортолсон. Ингэснээр нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээ болох 42 сая тоннд хүрч чадахгүйд хүрэв. Иймд уул уурхайн салбарын орлого төлөвлөсөн хэмжээнээс 498 тэрбум төгрөгөөр буурч, 2.69 их наяд төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт орлогын 26 хувийг бүрдүүлэхээр тооцлоо” гэж Сангийн яамныхан тайлбарлажээ. Төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр тасарсны тэн хагас нь уул уурхайн салбараас шалтгаалжээ. Үүнээс гадна хувийн хэвшилд ажиллагсдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, жижиг аж ахуйн нэгжүүдийн татварыг тэглэсэн шийдвэр төсвийн орлого буурахад нөлөөлсөн нь дамжиггүй.

Энэ удаагийн төсвийн тодотголын анхаарал татах гол асуудал нь өндөр хэмжээний алдагдал юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 10 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай төсөв батлахаар зэхэж буйг зарим улстөрч шүүмжилж байна. Нэгэнт төсвийн орлого багассан учраас түүнд тохируулан төсвийн зардлаа танаж болно. Ингэвэл төсвийн алдагдал буурч, аль хэдийн өндөр хэмжээнд хүрсэн өрийн дарамт нэмэгдэхгүй. Гэвч бодлогын ийм сонголт хийх нь зохимжгүй. Төсвийн зардлыг танах тусам эдийн засгийн хямрал гүнзгийрнэ. Тиймээс зардлаа танахаас илүү нөхцөл байдалтайгаа уялдуулан яаж орлогоо нэмэгдүүлэх вэ гэдгийг бодох ёстой. Нүүрсний экспортыг өсгөх арга хэмжээ авах нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх нэг

гарц. Засгийн газраас “Ногоон гарц” хөтөлбөр хэрэгжүүлж, нүүрсний экспортыг нэмэгдүүлэхээр төлөвлөснийг Сангийн сайд дуулгалаа.

Манай улсын эдийн засаг энэ оны эхний хагас жилд 9.7 хувиар буурав. Дотоодын нийт бүтээгдэхүүн зургаагаас дээш хувиар өсвөл эдийн засаг эрүүл байна гэж үздэг. Тэгэхээр манай эдийн засаг аль хэдийн “өвчин” тусжээ. Өвчнийг анагаах “эм” нь төсвийн зардлаа тэлэх явдал. Төсвийн зардлыг 800 тэрбум төгрөгөөр тэлээд байхад ч эдийн засаг оны эцэст нэг хувиар агших тооцоог Сангийн яамныхан хийсэн. Төсвийн зардлыг бууруулбал үүнээс ч илүү хохирол амсана. Тэгэхээр эдийн засгийн хямралтай энэ үед өрийн дарамтаа нэмж, эдийн засгаа тэлэхээс өөр гарцгүй.

Сангийн яамныхан төсвийн алдагдлаа нөхөхийн тулд дотоодын зах зээлд 1.2 их наяд төгрөгийн бонд гаргахаар төлөвлөжээ. Ингэхээр төсвийн 2.6 их наяд төгрөгийн алдагдлыг гадаадын зээл, тусламжаар нөхнө гэсэн үг. Их хэмжээний алдагдалтай төсөв батлах эдийн засгаа “их уналт”-аас хамгаална, харин өрийн дарамтыг нэмэх сөрөг талтай.

Засгийн газрын өр өнгөрсөн онд 24.1 их наяд төгрөгт хүрсэн. Тэгвэл энэ оны төгсгөлд найман хувиар өсөх тооцоо гарчээ. Манай улс 2021-2024 онд 2.9 тэрбум ам.долларын бондын өр төлөх хуваарьтай байгаа. Эл өрийг хэрхэн төлөх нь шинэ Засгийн газарт сорилт болох юм. Үүнээс гадна өрийн үйлчилгээний төлбөр буюу жил бүр төлөх зээлийн хүүгийн зардал байнга өсөх аж. Тодруулбал, зээлийн хүүгийн төлбөр энэ онд төсвийн орлогын 19, дараа жил 29.2, 2022 онд 38.4 хувьд хүрэх гэнэ. Ингэснээр төлбөрийн төсөвт үзүүлэх зээлийн хүүгийн дарамт хоёр жилийн дараа хоёр дахин нэмэгдэх нь. Өр тавьж, дарамтыг нь нэмэх нь бодлогын муу сонголт. Гэвч эдийн засгаа их хэмжээгээр агшаах нь түүнээс муу сонголт билээ. Хэзээ ч тохиолдож мэдэх хямрал, эрсдэлийг давах хуримтлалгүй, авдартаа алт хадгалаагүй Монгол Улс хоёр муугийн арай дээрийг нь сонгож байна.



Цар тахал гарснаар дэлхийн эдийн засгийн орчин огцом өөрчлөгдсөн. Монгол Улсын эдийн засгийн орчин ч өөрчлөгдсөнийг бид бүхэн мэдэрсэн. Төсвийн орлого, зарлагад гэнэтийн өөрчлөлт гарч, өмнөх онд төсөөлж байсан эдийн засгийн тооцооллуудын дийлэнх нь зөрсөн юм.





**Цэвэгдорж овогтой
Мягмарбаяр**

1996 онд МУБИС, 1997 онд
Сэтгүүл зүйн дээд курс тус тус
төгссөн.

1998 онд ажлын гараагаа
“Хөвсгөлийн долгио” радиогоос
эхлүүлсэн.

2002 оноос өөрийн үүсгэн
байгуулсан “DES” телевизийн
гүйцэтгэх захирал, ерөнхий
редактороор ажилласан.

2004 онд Хөвсгөл аймгийн
ХА УТ-аас шилдэг хэвлэл
мэдээллийн байгууллагаар
шалгарч оны гранпри шагнал
хүртсэн.

2008 онд MBDA компанийн
гүйцэтгэх захирал,

2011 оноос одоог хүртэл “
Зууны мэдээ” сонины Эдийн
засаг, уул уурхай, байгаль
экологи, бизнесийн албаны
сэтгүүлчээр ажиллаж байна.
Мөн Компаний засаглалын
үндэсний зөвлөлөөс эрхлэн
гаргадаг “Сайн засаглал”
сэтгүүлийн редактороор
ажилладаг.

1990 оноос хойш хэвлэл
мэдээллийн салбарт 23 жил
тасралтгүй ажиллаж буй.

“Зууны мэдээ” сонин

**О.АМАРТҮВШИН: ТӨСВИЙН ТОДОТГОЛД
ХОРИГ ТАВИХ САНАЛЫГ ЕРӨНХИЙЛӨГЧИД
ХҮРГҮҮЛСЭН**

*МҮХА УТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшинтэй
төсвийн хүрээнд дэх асуудлаар ярилцлаа.*

- Шинээр байгуулагдсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт танхимын зүгээс ямар байр суурьтай ажиллаж байна. Өмнөх Засгийн газартай хэрхэн хамтарч ажиллав, нааштай үр дүн гарсан уу?

- Шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт танхимын зүгээс албан ёсны байр сууриа илэрхийлж саналаа хүргүүлсэн. Тухайлбал, хувийн хэвшлээ зөв зохион байгуулалттайгаар дэмжих, томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд бодитой тусалцаа үзүүлэх зэргээр асуудлаа дэвшүүлсэн. Одоогоос хоёр долоо хоногийн өмнө Засгийн газрын бүрэлдэхүүнтэй 150 аж ахуйн нэгж, бизнесийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагууд хамтарч уулзалт хийсэн. Шинэ Засгийн сайд нарын санаачлага асуудлыг шийдвэрлэе гэсэн эрч хүч, шинэлэг арга барил, хандлага бидэнд итгэл өгсөн. Түүнчлэн Үндсэн хуулийн өөрчлөлтөөр УИХ-ын гишүүн давхар дээлтэй байснаар аливаа ажилд саадтай, зөрчилтэй байсныг өөрчилсөн нь үр дүнгээ өгсөн. Ялангуяа хувийн хэвшилтэй Засгийн газрын сайдуудын хамтарч ажиллах ерөнхий хандлага, байр суурь зөв байгаа нь анзаарагдсан. Мөн хувийн хэвшлийн санаачлагаар гадна дотны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эдийн засгийг тэлэх, дэмжихэд нэмэр болох 20 орчим төслийг танилцуулсан. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар баталгаа гаргах, хамтрах бусад олон хэлбэрээр дэмжинэ гэдгээ илэрхийлсэн. Оны өмнө эдийн засгийг эрчимжүүлэх, тэлэх зайлшгүй шаардлагатай нэгж байгуулья, ингэснээр эдийн засгийг улс төрөөс салгая, 30 тэрбум төгрөгийн эргэлттэй эдийн засагтай болгоё гэсэн саналыг өгсөн. Энэ удаагийн сонгуулиар эрх баригч нам хэвээр

үлдсэн. Тиймээс УИХ залгамж чанараа хадгалж эдийн засгийг эрчимжүүлэхэд хамтарна гэдэгт найдаж байгаа. Одоо Засгийн газар хувийн хэвшлээ дэмжих дэмжлэгийн бодитой сувгийг бий болгох хэрэгтэй. Хүнд сурталгүй, эрүүл, аль болох хувийн хэвшлээ дэмжих замаар ажлаа урагшлуулах. Төр мэдээж хөрөнгө мөнгө гаргаж бүгдийг хийж чадахгүй. Хөрөнгө оруулалт байнга эрсдэл дагуулж байдаг. Мөр эрсдэлд орвол татвар төлөгчдийн мөнгө л үргүй зарцуулалт болно. Хувийн хэвшил хамгийн үр ашигтайгаар тооцоолж ажлаа урагшлуулахыг эрмэлздэг. Харин хууль, эрх зүйн орчинг тогтвортой болгож засч сайжруулахад төр анхаарч зарим нэг хяналтын чиг үүргээ төрийн бус байгууллагад хуулийн дагуу үүрүүлэх үүргээ биелүүлэх хэрэгтэй. Үүнтэй холбоотойгоор хувийн хэвшил зохион байгуулалтад орж асуудлаа зөв тавьж хамтраад урагшлах хандлагад шилжих хэрэгтэй.

- Төсвийн тодотгол нэлээн шүүмжлэл дагуулж байна. Танайхаас сая өргөн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Гол асуудлууд нь юу байв?

- Төсвийн тодотгол тойрсон асуудлаар шилдэг эдийн засагчид, хувийн хэвшил, эдийн засгийн клубын сэтгүүлч нарыг оролцуулсан өргөн хэмжээний хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энд хэд хэдэн гол асуудал ярьсан. Нэгдүгээрт, Засаг хууль зөрчихгүйгээр ажлаа хийх. Хоёрдугаарт, төсөв зохиож байгаа үйл явцыг тодорхой хуультай, дүрэмтэй болгох. Гуравдугаарт, хэрэгжилтэд хяналт тавьдаг болгох. Одоогоор хяналт тавих субект байхгүй байна. Аудитын ерөнхий газар шүүмжлэлтэй дүгнэлт гаргадаг ч тухайн эзэнд хариуцлага тооцож хэрэгжүүлдэггүй. Одоо үйлчилж байгаа хуулиар тойргоос сонгогдсон гишүүд төсвийг ач холбогдлоор нь эрбэлэхгүйгээр тарааж, үргүй зардал нэмэгдэж иргэдээс шүүмжлэл дагуулсаар байна. 2020 оны төсвийн тодотголоор 9.1 их наядын орлого олоод түүнийнхээ 50 хувьтай тэнцэх хэмжээний алдагдал хүлээхээр байна. Нэг үгээр хэлбэл, хоёр төгрөг олоод гурван төгрөгийн зардал гаргасан гэсэн үг. Зөрүүг хаанаас олох вэ. Гадны шууд хөрөнгө оруулалт үндсэндээ зогссон. Тэгэхээр 100 хувь зээлээр санхүүжихээр байна. Гэтэл манай гадаад өр одоогоор 30.8 тэрбум ам.доллар. Дээр нь хүүгийн дарамт арван хувиар нэмэгдэнэ. Жил бүр төсвийн орлогын 70-80 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг санхүүгийн зардалд гаргаж байна. Энэ янзаараа цааш үргэлжилбэл, улсаараа дампуурах аюул ойрхон байна. Төсөв, мөнгөний бодлого макро эдийн засгийн үзүүлэлтийн хүчин зүйлүүдийг эерэг болгож сайжруулахад чиглэх ёстой. Гэтэл үүнийг муутгах шийдвэр олон дахин гарсаар байна. Нөгөөтэйгүүр, төсвийн орлогыг нэг сая 200 мянган татвар төлөгч иргэд болоод 90 мянган аж ахуйн нэгж бүрдүүлдэг. Эдгээрээс цуглуулсан орлогыг тэдэнд огт хамааралгүйгээр зарцуулаад байж болохгүй. Тэгэхээр төсөв зохиох, батлах үйл явцад татвар төлөгчид, судлаач, эдийн засагчдын үгийг тусгадаг механизмийг бий болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, төсвийн тодотголыг тав дахь өдөр нь өргөн бариад нэг дэх өдөр нь шууд хэлэлцэж байгаа тохиолдолд хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд харах нь бүү хэл гишүүд нь бүрэн танилцаж амжихгүйгээр зохицуулагдсан. Төсөвт анализ хийх хугацаа хангалттай байх хэрэгтэй. Цаашдаа төсөвт тавих хяналтын механизмыг сайжруулахгүйгээр үр ашигтай болохгүй.

- Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад 2020 оны төсвийн тодотголтой холбоотой санал хүргүүлсэн гэсэн үүнийгээ тодотгоно уу?

-Монгол Улсын Ерөнхийлөгчид 2020 оны төсвийн тодотголд хориг тавьж өгөх саналыг үндэслэлүүдийн хамтаар өргөн барьсан. Мөн сарын дараа УИХ-д өргөн

баригдах 2021 оны төсвийн төсөлд хяналтын механизмыг ажиллуулах тухай хүсэлт тавьж байна. Төсөв дан ганц Засгийн газрын, УИХ-ын гишүүдийн анхаарах зүйл биш. Бүх хүмүүсийн өдөр тутмын амьдралд шууд нөлөөлдөг гэдэг утгаар Монгол Улсын Ерөнхийлөгч анхааралтай хандана гэж найдаж байна. Түүнчлэн ковидоор далимдуулан төсөвт хүний сэтгэлээр үрэлгэн хандаж болохгүй. Үрэлгэн хандсанаар макро эдийн засгийг хүндрүүлнэ. Ингэснээр зээлийн хүү нэмэгдэх, валютын ханш алдагдах, өр нэмэгдэх зэргээр маш олон сөрөг үр дагавар үүсэхээр байна. Ковидоос болж аж ахуйн нэгжийн орлого тодорхойгүй байдалд байна. Үүнийг дагаад татвар төлөлт, ажлын байр буурч улмаар макро эдийн засгийн өсөлт буурах тохиолдолд зөв бүтэцтэй төсөв оруулж ирэх нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

-УИХ-ын гишүүдийн хуулиас давсан эрхийг төсөв батлахад нөлөөлөхгүй байх зохицуулалтыг хэрхэн хийх вэ. Энэ ер нь боломжтой юу?

-Төсөвтэй холбоотой хуулиудаа мөрдөх шаардлагатай. Мөрдөж чадахгүй бол огцруулах ёстой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд алдагдлыг хоёр хувиас хэтрүүлэхгүй байх зарчимтай. Тэгэхээр хуулийн хүрээнд ач холбогдлоор нь эрэмбэлээд зарцуулах ёстой зүйлд нь зарцуулаад явмаар байна. УИХ-ын 76 гишүүн бүгд тойрогтоо асуудлаа шийдвэрлэх гэж оролддог. Хэн шийдвэр гаргалтад ойр байгаа нь хүчтэй лоби хийж чадна төдий чинээгээр үрэлгэн зардал гардаг. Үүний цаана авлига, ашиг сонирхол байсаар байна. Энэ нь төсөвт илүү тодоор илэрч байна. Мэдээж хөдөө хотгүй жигд хөгжих нь тодорхой. Гэхдээ хэт элсэнд хийсэн ус мэтээр асгах нь төсөвт халгаатай. Улс төрийн намууд иргэдийн саналыг авахын тулд төсвийн мөнгийг халамж байдлаар тараасаар 30 жил боллоо. Шийдвэр гаргагчид мэдсээр байж төсөв батлах үеэр өөрсдийнхөө байр суурийг хамгаалж үлддэг. Түүнчлэн төсвийн хөрөнгөөр хийсэн бүхэн 2-3 дахин үнэтэй бөгөөд чанаргүй. Ер нь төр зээл авч хүүтэй мөнгөөр хөрөнгө оруулалт хийх нь зөв үү. Хувийн хэвшлийн барьж байгуулсан барилга байшинг түрээслэх нь өртөг бага байх боломж бүрдэхээр байна. Санхүүгийн зөв менежмент хийхгүйгээр төсвийн зөв бодлого гаргаж чадахгүй. Төсвийн буруу бодлогын үр дүнд макро эдийн засгийн өсөлт буурч, ядуурал нэмэгдэж, ажлын байр хумигдан, аж ахуйн нэгжийн татварын орлого буурна.

-Аймаг орон нутгийн төсөв захирагч нар төсвөөс их мөнгө авахын тулд УИХ-ын гишүүнд нөлөөлдөг гэдэг?

-Орон нутгийн төсөв захирагч нар төсвөөс ахиухан мөнгө авч өөрийн хамаарал бүхий компанид өгөх замаар ашиг сонирхлоо гүйцэлдүүлсээр ирсэн. Үүнийг таслан зогсоож сууриар нь өөрчлөөгүйгээс болж төсвийн мөнгийг уралдаж тараах хэлбэрээр явсаар байна. Энэ нь хөгжлийг боймилж байна. Орон нутгийн удирдлагууд төсвийг уралдаж зарцуулахдаа биш тухайн орон нутгийнхаа үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих замаар татварын орлогоо нэмэгдүүлж өөрөө өөрийгөө хэрхэн санхүүжүүлэх вэ гэдэгт анхаарах ёстой.

Төсвийн бодлогоор муудсан эдийн засгаа макро төвшинд хэрхэн өөд татах вэ гэдэгт эрх баригчид төвлөрч ажиллах хэрэгтэй. Төсвийг ковидтой холбож алдагдалд оруулж болохгүй. Бодит алдагдал эрх баригчдын буруутай шийдвэрээс болж байна. Ялангуяа хямралын үед популизм хол явахгүй. Нэгдсэн төсвөөс хэн илүү мөнгө авч хэдэн ажил хийснээрээ дүгнүүлж иргэдээс үнэлгээ авах байдлаар хэдий болтол явах юм. Ингэснээр манай эдийн засаг тэлж, төсөв эрүүлжихгүй

гэдгийг бид харлаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хангалттай ажиллахгүй байна. Тиймээс төсөвт хяналт тавих ажлыг хамтарч хийе гэсэн санал тавьсан. Татвараа төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж хариуцлага хүлээдэг шиг үргүй зарцуулж байгаа төсөв батлагсад болоод захирагчид бүр илүү хариуцлага тооцох ёстой. Энэ үүднээс төсвийн хөрөнгө оруулалттай ажлыг мөшгөө. Хэн хэдэн төгрөгийн ажлыг ямар өртөгөөр хийв. Өртөгийн харьцуулалт хийе. Түүнчлэн ямар компани хийсэн. Мэргэжлийн компани уу, даргын цүнхэнд дэх компани уу гэх мэтээр мөшгих нь төсвийн боловсруулалт, батлах үйл явц, зарцуулалтад сайнаар нөлөөлнө. Ер нь эдийн засгаа 2-3 дахин тэлэх хэрэгтэй байна. ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээг дэлхийн дундаж руу ойртуулмаар байна.

-Цаашид төсөв боловсруулах, батлах явцыг эргэж харах, төсвийн үрэлгэн байдал, чанарт хяналт тавих зэргээр танхимын зүгээс Засгийн газарт санал тавих биш шахаж ажиллана гэж ойлголоо. Төсвийн зарцуулалтыг хянаж, мөшгинө гэлээ. Үүнийгээ тодруулна уу?

- Жишээлбэл, хөдөө орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар ойролцоогоор 3.4 тэрбум төгрөгийн, хувийн хэвшил 1.4 тэрбум төгрөгийн ажил хийжээ. Гэтэл төрийн хийсэн ажил чанаргүйгээс гадна жилийн дараа засварын зардал тавигддаг. Тэгвэл хувийн хэвшлийн барьсан барилгыг төр яагаад түрээсэлж болохгүй гэж. Магадгүй жил бүр төсөвлөдөг засварын зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын хүүгийн зардалд төсөвлөсөн мөнгөнөөс түрээсийн мөнгө бага тусна. Жил бүр алдагдалтай төсөв батлаад байвал алдагдлын цар хүрээ улам тэлсээр байна. Ялангуяа суманд үүнийг хэрэгжүүлэх боломжтой. Архангай аймгийн нэг суманд жил бүр худаг барих төсөв батладаг, барьдаг, нээдэг. Гэтэл барьсан компани нь Засаг даргын хамаарлын компани байдаг. Энэ мэт жишээ олон. Үүнийг олж илрүүлэх, таслан зогсооё, хариуцлага тооцоё гээд байгаа юм. Тэгж байж төсөв эрүүлжинэ.

BUSINESS.MN



***Ганбаатар овогтой
Даваадорж***

2013 онд Москва хотод ОХУ-ын Ард Түмний Найрамдлын Их Сургууль (РУДН) төгссөн.

2013-2016 онд “Vip76 expert” сэтгүүлд сэтгүүлч орчуулагчаар ажилласан.

2016-2018 онд Mongolian eсopотy сэтгүүлд сэтгүүлч орчуулагч,

2018 оноос Business.mn сэтгүүл, сайтын редактороор ажиллаж байна.

**ШИНЭ ҮЙЛДЛИЙН СИСТЕМ
АЧААЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ**

Эдийн засгийн хөгжлийн загвар бол нэг ёсны бидний амьдралдаа ашиглаж буй үйлдлийн систем. Харин өнөөгийн үйлдлийн системд хоёр том гажуудал бий. Нэг нь баяныг улам баяжуулж, ядууг улам үгүйрүүлдэг. Нөгөө нь тансаглах дондоо автсан хүмүүс байгаль орчноо ямар ч энэрэх сэтгэлгүй сүйтгэхэд хүргэдэг.

Тэгээд байгаль эх эдгээр гажуудлыг засч, системийг дахин ачаалж, вирусыг SHIFT+DELETE хийх арга олсон нь Ковид-19. Гэхдээ уг цар тахал бол өнөөдөр өрнөж буй маш том өөрчлөлтүүдийн зөвхөн нэг нь.

Цаашдаа залхуу, сэтгэж шинийг бүтээхдээ хойрго, байгальд бэлэн байгааг ухаж, зулгааж, түүж, огтолж, уудалж, хөнөөж ашиглах дуртай нийгмүүд энэ хэвээрээ доллар халааслаад сууна гэж найдах хэрэггүй. Энэ загвараас бид өнөөдөр татгалзах боломжгүй ч өнөөдрөөс эхлээд татгалзах алхмуудаа хийж эхлэх учиртай.

Үүнийг дагаад бизнес хийдэг арга барил ч орвонгоороо өөрчлөгдөж байна. Хэрэв компаниудыг программ хангамж гэж үзвэл үйлдлийн систем дахин ачааллаад дуусахад өөртөө update хийж чадахгүй бол үйл ажиллагаа доголдоно, эсвэл систем чамайг спам, вирус гэж үзнэ.

Тэгвэл та, хувь бизнес эрхлэгч Ковидын дараах эриний ертөнцөд бизнесээ хэрхэн бэлдэх вэ? Энэ асуултад хариулахын тулд урт болон дунд хугацаандаа та доорх хэдэн чухал зүйлсийг бизнесээ төлөвлөхдөө зайлшгүй харгалзаж үзэх хэрэгтэй болох нь.

1. Ногоон фактор

Аль 1974 онд Месарович болон Пестель хэмээх хоёр том эрдэмтэн Ромын клубт тавьсан илтгэлдээ “Хүний үнэт зүйлст суурь өөрчлөлт гарч, шинэ ёс суртахуун, байгальд чиглэсэн шинэ хандлага төлөвшсөн цагт л хүн төрөлхтөн дэлхий дахины сүйрлээс аврагдана” гэж сануулж байсан. Өнөөдөр дээрх сүйрэл бодит болж, дэлхийн хамгийн шилдэг толгойнууд шийдэл олохын төлөө гашилж, “байгальд ээлтэй” гэдэг хэмжүүр хүний амьдралын бүхий л чиглэлд хүчээ авч байна.



Хүдэрбат овогтой Цолмон

2015 онд МУИС-д олон улсын сэтгүүлч мэргэжлээр суралцаж төгссөн.

2015-2018 онд “Forbes Mongolia” сэтгүүлд сэтгүүлчээр,

2019 оноос Business.mn сэтгүүл, сайтын сэтгүүлчээр ажиллаж байна.

Нүүдэлчин амьдралын хэв маягтай монголчууд саяхныг хүртэл газар дэлхийгээ хайрладаг, харьцангуй “ногоондуу” үндэстэн гэгдэж байсан ч ХХ зуунд, ялангуяа хоёр мянганы зааг дээр гэнэт баргар өнгө давамгайлж эхэлсэн. Гэвч ирээдүйд бизнес ямар нэгэн байдлаар “ногоорохоос” өөр аргагүй.

Ногоон хөгжил, ногоон эдийн засаг, ногоон барилга, ногоон сэтгэлгээ гэх мэт үгс хол сонсогдохоо больж, төрөл бүрийн хууль, дүрэм, стандарт, хэм хэмжээнээс бүрдэх тогтолцооны шинжтэй болсон. Манай улс тогтвортой хөгжлийн зарчмууд, ногоон хөгжлийн бодлогоо батлаад удаагүй. Гэхдээ зарим дэвшил илт мэдрэгдэж, ялангуяа санхүүгийн салбарт ногоорох хандлага хүчтэй байгаа. Тухайлбал, “ТоС” гэж нэрлэгдэх ногоон санхүүжилтийн хөтөлбөрийг 2013 онд Монголын банкууд санаачилж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь өнөөдөр хэд хэдэн зээлийн бүтээгдэхүүнийг

зах зээлд гаргаад эхэлжээ. 2020 оны хоёрдугаар улирлын байдлаар Монголын банкны салбарын нийт зээлийн багцын 2.5 хувийг ногоон зээл эзэлж байна. Цаашдаа банк, санхүүгийн байгууллага байгаль орчинд халтай төсөлд зээл олгохгүй гэсэн шалгуур улам чангарна. Нөгөө талаас “Ногоон мөнгө”-ний хэмжээ олон улсад үлэмж ихэсч байгаа бөгөөд зөвхөн ухаалаг төсөл боловсруулах эздээ хүлээж байна.

Тиймээс бизнес эрхлэгч та дор хаяж ойрын 10, цаашлаад 30 жил тогтвортой бизнес эрхлэхийг хүсч байгаа бол, өртөг багатай санхүүжилт хэрэгтэй байгаа бол энэ хүчин зүйлсийг заавал харгалзаж үзэх шаардлагатай. Ялангуяа байгаль, нийгэмд хамгийн их нөлөө үзүүлдэг уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, боловсруулах салбарт энэ төрлийн зээлийн хэмжээ ихэснэ. Хэрэв та үндэсний хэмжээнд найдвартай ажиллах бизнес цогцлоомоор байвал Монголын тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн хөтөлбөрүүдэд тохирох, гадагшаа экспорт хиймээр байгаа бол 2030 он хүртэл хэрэгжих Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудад тохирох бизнесийн санаагаа хэрэгжүүлвэл богино хугацаанд бэрхшээл учрах ч урт хугацаандаа хожно.

Сэргээгдэх эрчим хүчний салбарын эрх зүйн

болоод тогтолцооны сул талууд засарч, санхүүжилтийн боломжууд тэлнэ гэдэгт та итгэх ёстой. Харин Монгол Улс зөвхөн эрдсийн түүхий эд экспортлоод, үүнийг тойрсон ханган нийлүүлэлтийн бизнес эрхлээд урт насална гэдэгт хэзээ ч итгэж болохгүй.

Үүнтэй холбоотой гарч ирэх хоёр дахь чухал зүйл бол дараагийн 30 жилд бид өөрсдийгөө эдийн засгийн хувьд “Хэн байх вэ?”, “Дэлхийд юугаа зарж болох вэ?” гэдэг асуулт. Энэ асуултын хариулт нь муу ч, сайн ч аялал жуулчлал, хөдөө аж ахуй болж таардаг.

Зөвхөн Улаанбаатарын радиус дотор, цэвэр бизнесмэн хүний нүдээр харвал бид онгоцны билетээ хямдруулаад Хөшигийн хөндийд жуулчдыг хэдэн мянгаар нь “асгах” бололцоо бий. Хүй Долоон худагт морин тойруулгын орчин үеийн төв байгуулж, дэлхийн хамгийн хурдан морьдыг уралдуулах боломж байгаа. Зайсангийн аманд том казино байгуулан дэлхийн баячуудыг тоглуулж, түүнээс нь татвараа аваад суух гарц бий. Тэрэлжид маш том усан парк, наадам цэнгээний цогцолбор барьж жуулчдыг зугаацуулах потенциалтай. Энэ бол мөрөөдлийн жагсаалт биш, зах зээлийн бодит боломж юм.

Сүүлийн үед Эдийн засгийн коридор, Торгоны зам зэрэг концепцийн хүрээнд зарим судлаач улам бүр хэтэвч нь зузаарч буй Хятадын жуулчдыг хэрхэн Монголд авчирч мөнгийг нь үрүүлэх вэ гэдэг дээр сонирхолтой шийдлүүд санал болгож байна. Тухайлбал, Оросын судлаач В.Бережных “Цайны замыг сэргээх нь” төслийн хүрээнд Улаанбаатарыг, тодруулбал Тэрэлж орчмыг Хятадаас Оросыг, цаашлаад Европыг чиглэсэн жуулчдыг амраах, зугаацуулах зангилаа өртөө болгон хөгжүүлэх санал дэвшүүлжээ. Үүний тулд Монголын эрх баригчид Хятадын жуулчид Монголын нутаг дэвсгэр дээгүүр машинтайгаа явж Орос руу гарах бололцоог олгох ёстой аж.

2. ДИЖИТАЛ ФАКТОР

Бизнесийн ертөнцөд хамгийн хүчтэй явагдаж байгаа өөрчлөлт бол дижитал шилжилт гэдэгтэй хэн ч маргахаа больсон. Энэ үйл явц яг л өртөө рүү ойртон ирж яваа хурдан галт тэрэг шиг байж, энэ галт тэрэгнээс хоцорсон бизнесүүд өрсөлдөөний талбараас арчигдах аюултай болж ирэв. Энэ галт тэргэнд та ажилтан, хэрэглэгч, хөрөнгө оруулагч, түнштэйгээ хамт, үйлдвэрлэл, санхүү, маркетинг, хүний нөөц, борлуулалт гэх мэт бизнесийнхээ бүх процессыг аваад суух ёстой. GSMI институтийн үүсгэн байгуулагч, Стратегийн зөвлөх Ц.Оюунжаргал цар тахал намжихаар хуучин нөхцөл байдал эргээд сэргэнэ гэж бодож байгаа бизнес эрхлэгчид, компанийн захирлууд байгаа бол энэхүү ташаа ойлголтоо маш хурдан таягдан хаяарай гэж сануулж байна. Учир нь нэг талаас нийгмийн харилцаа, хэрэглэгчдийн зан төлөв хурдацтай өөрчлөгдөж байгаа. Ихэнх хэрэглэгч онлайн орчинд урд өмнөхөөс илүү цагийг өнгөрөөж байгаа учир бизнесүүд онлайн орчин дахь үзэгдэцээ хэд дахин өсгөх хэрэгтэй гэдгийг тэрбээр онцлов.

Цар тахал намжихаар хуучин нөхцөл байдал эргээд сэргэнэ гэж бодож байгаа бизнес эрхлэгчид, компанийн захирлууд байгаа бол энэхүү ташаа ойлголтоо маш хурдан таягдан хаях хэрэгтэй.

2020 оны 2-9 дүгээр сар хүртэлх хугацаанд ямар компаниуд илүү дархлаатай, тэсвэртэй байсныг харвал үйл ажиллагаандаа технологийн давуу талыг нэвтрүүлж чадсан компаниуд байна.

Ийм компани Монголд цөөнгүй. Жишээ нь, Ковид-19 дэгдсэн ч “Digitalworks” ХХК-ийн дотоод үйл ажиллагаа, процесст ноцтой хүндрэл учраагүй. Тус компанийн захирал Б.Нямцэрэнгийн ярьснаар анхны сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс хойш бүх ажилтан сарын турш гэрээсээ ажилласан бөгөөд оффист нэг ч хүн үлдээгүй. Өмнө нь тэд ERP систем нэвтрүүлээд үйл ажиллагаандаа төлөвшүүлчихсэн, үндсэндээ технологийн талаас бүх боломжийг хангасан байсан болохоор гэрээсээ хэвийн ажиллах боломжтой байжээ. “Ковид-19 компаниудын хувьд алтан үе. Энэ цаг үеийг ашиглаад жинхэнэ дотоод процессоо цэгцэлж, систем нэвтрүүлэх, сайжруулах цаг, зав нь гарч байгаа юм” гэж Б.Нямцэрэн хэллээ.

Дижитал шилжилтийг амжилттай хийж буй өөр нэг сонирхолтой жишээ бол олон улсын тээвэр зуучийн үйлчилгээ эрхэлдэг “Ландбридж ХХК”. 2008 онд байгуулагдсан энэ компани мэдээллийн системээ хоёр ч удаа үндсээр нь өөрчилж, 2012-2020 онд 5,500 гаруй үйлчлүүлэгчийн 2,800 орчим агентийн сүлжээгээр дамжсан 40,000 орчим тээврийн талаар маш их өгөгдөл цуглуулжээ.

Компанийн бизнес хөгжил хариуцсан захирал Б.Тулгаагийн ярьснаар анхандаа мэдээлэл бүртгэх үйл явц нь үр дүн шууд харагдахгүй, явдал чирэгдэлтэй, ажлын ачаалал нэмсэн уйтгартай ажил мэт байлаа. Өмнө нь нэг тээвэрт ердөө 30 гаруй өгөгдөл бүртгэгддэг байсан бол өнөөдөр тухайн тээвэртэй холбоотой 2,000 орчим өгөгдөл бий болов. Эхэндээ ч ажилчдын бүтээмж 13.2 хувиар буурч, үйл ажиллагааны зардал 25.4 хувиар өсөв.

Гэвч тээвэр зуучийг дэлгүүр орохтой адил хялбар болгоно гэсэн зорилгодоо үнэнч байсны хүчинд тодорхой хугацааны дараа үр дүн гарч, эцэстээ цаасан бүртгэлийг 80 хувь халж, хайлт хийх цагийг 70 хувь хэмнэж, ажилтнуудын хооронд мэдээлэл дамжуулан ашиглах хурдыг 90 хувь, үйлчлүүлэгчдэд мэдээлэл дамжуулах хурдыг 60 хувь нэмэн бүтээмжийг 50 хувь орчим өсгөжээ. Ажилтнууд өгөгдлийг бүртгэх, хянах, боловсруулах ажилд ямар нэгэн байдлаар оролцдог болж, нийт ажилтны 92 хувь нь дижитал бизнесийн соёлд суралцсанаар компанийн үр ашигт байдал нэмэгдэж, нуугдмал зардлаа 40 хувиар бууруулжээ.

Эндээс харахад дижитал шилжилт бол зөвхөн техник, технологийн асуудал биш гэдэг нь харагдаж байна. Америкийн ManpowerGroup хэмээх рекрутингийн компанийн мэргэжилтэн Бекки Франкевичийн “Хямралын дараа компаниудад ямар ажилтан хэрэгтэй вэ” нийтлэлдээ бичсэнээр дижитал шилжилт бол ерөөсөө технологийн тухай яриа биш, энэ бол авьяасын тухай яриа аж. Тиймээс ERP системийг нэвтрүүлсэн, нэвтрүүлж байгаа том, жижиг компаниудын хувьд дижитал шилжилт бол нэг удаа техник, технологи худалдаж аваад шийдэх зүйл биш, энэ бол бизнесийн загвар, процесс, стратеги, бүтэц, хүмүүс гээд олон талын өөрчлөлтийг хамарсан урт хугацааны аялал гэдгийг ойлгох нь чухал байна.

~ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНД~

1. ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ ӨӨРЧЛӨГДӨНӨ

Цар тахлаас үүдэж олон салбарт бизнесийн загварууд шинэчлэгдэж байна. Гэрээс ажиллах, ажлын цагийн уян хатан хуваарь зэрэг нь энэхүү өөрчлөлтийн зөвхөн нэг хэсэг нь. Энэ дундаас хамгийн их өөрчлөгдөх нь хэрэглэгчид. Америкийн “Eddie

Would Grow” хэмээх зөвлөх үйлчилгээний байгууллагын стратегийн зөвлөх Эдди Юны бичсэнээр цар тахлын нөлөөгөөр хэрэглэгчдийн зан төлөвт хоёр том хувьсгал гарах ажээ. Нэгдүгээрт, зайнаас ажилладаг хүмүүсийн тоо өмнөхөөсөө эрс ихэснэ. Ийм хэрэглэгчид гэрээсээ бараа, үйлчилгээ захиалах нь олширно. Ялангуяа хоол үйлдвэрлэлийн салбарт энэ өөрчлөлт хүчтэй байх бөгөөд гэртээ хоол хүргэлтээр авах нь элбэгшинэ. Хоёрдугаарт, цар тахлын үеэр хэрэгжиж байсан хоорондын зай барих дүрэм цар тахал дууссан ч алга болохгүй. Дэлхийн олон орны хэрэглэгчид олон нийтийн газраар явахаас болгоомжилдог болно. Тиймээс нэг ангид олон хүүхэд сургадаг хувийн сургуулиуд, нэг талбайд болон бүхээгт олон зорчигч суулгадаг усан, хуурай, агаарын замын компаниуд дампуурахад хүрнэ.

Цар тахлын хямралын дараа үндсэн хөрөнгийн ашиглалт, өртгийн удирдлага, өргөжилтийн үр өгөөж зэрэг бизнесийн стратегийг эргэн дүгнэх шаардлага тулгарна.

Хэрвээ зайнаас ажиллагсдын тоо нэмэгдэж, хоорондын зайн хязгаарыг баримталсан хэвээр байвал хуучны арга барилаар ашиг орлого олно гэж мөрөөдөөд ч хэрэггүй.

Гэхдээ цар тахлыг боломж болгон ашиглах орон зай багагүй бий. Судалгааны олон улсын “Ipsos” компанийн судалгаанаас харахад хямралын үед 10 хэрэглэгч тутмын дөрөв нь шинэ бүтээгдэхүүн туршиж үзэхэд бэлэн байдаг аж. Тиймээс цар тахлын үед бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг эргэлзэлгүй шууд эхлүүлэх хэрэгтэй гэж судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” компанийн Судалгаа, хөгжил хариуцсан захирал Ч.Даваасүрэн хэлэв. Мөн 100 гаруй жилийн түүхтэй менежментийн зөвлөх үйлчилгээний “Booz & Company”-ийн 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямралын үед хийсэн судалгаанаас харахад, тухайн үед дэлхийн түвшний инновацилаг ТОП 100 компани хямралын үед R&D буюу бүтээгдэхүүн, хөгжүүлэлтийн зардлаа 3.9 хувиар нэмэгдүүлж байжээ.

Вирусын тархалтаас үүдэлтэй хямралын өнөөгийн нөхцөлд бизнесүүд нэгэнт худалдан авалт буурч байгаа учраас борлуулалтыг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх гэхээс илүүтэй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ үнэгүй хэрэглүүлэх, үнэгүй зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр хэрэглэгчдэд танигдах ажлуудыг хийх хэрэгтэй аж. Учир нь нэг удаа хэрэглээд үзчихсэн хэрэглэгч үнэхээр таалагдвал “Энэ ер нь дажгүй юм байна, дараа авч хэрэглэж болох юм байна” хэмээн хэрэглээнийхээ сагсанд оруулах боломжтой гэж Ч.Даваасүрэн ярилаа.

Цар тахлыг хэсэгхэн хугацааны асуудал гэж бизнесээ төлөвлөж хэрхэвч болохгүй. Яагаад гэвэл эдийн засгийн хямрал үргэлжилж, хэрэглэгчид 2-3 жилдээ шокноос гарахгүй. Тэгэхээр компани өөрчлөгдөж, хэрэглэгчдийн худалдан авах зан төлөвт судалгаа хийж, бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг хүргэх аргаа шинэчлэхээс аргагүй болж байна. Тухайлбал, коронавирусын тархалтын дараа хэрэглэгчдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүн, гэр ахуйн цэвэрлэгээ, гал тогооны хэрэгсэлд хандах хандлага өөрчлөгдөж, аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа өмнөхөөсөө өндөр эрүүл ахуйн шаардлага тавьдаг болно.

Коронавирусын тархалтын дараа хэрэглэгчдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүн, гэр ахуйн цэвэрлэгээ, гал тогооны хэрэгсэлд хандах хандлага өөрчлөгдөж, аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа өмнөхөөсөө өндөр эрүүл ахуйн шаардлага тавьдаг болно.

Цар тахал компаниудын маркетингийн стратегид хүчтэй нөлөөлж, ирээдүйд ашиг олох гэхээсээ илүү нийгэм, олон нийтийн асуудлыг шийдвэрлэх бизнесүүд олширно. Үүнтэй холбоотой Техасын их сургуулийн профессорууд болох Тэд Уолдрон, Жэймс Уэтерби нар HEART гэсэн концепцийг боловсруулжээ. Тэдний санал болгож буйгаар хэцүү цагт хэрэглэгчдээ авч үлдэхийн тулд дараах таван зүйлийг хийх хэрэгтэй. Үүнд:

- *Компаниа илүү хүнлэг болгох (Humanize your company)*
- *Өөрчлөлтийг таниулах (Educate about change)*
- *Тогтвортой байдлыг хангах (Assure stability)*
- *Санал болгож буй зүйлээ бүрэн шинэчлэх (Revolutionize offerings)*
- *Ирээдүйг харж ажиллах (Tackle the future)*

Тэдний өгч буй гол мессеж нь танай компани нийгэм дэх хүнд хэцүүг ойлгож, зөвхөн ашиг олох сонирхолтой биш гэдгээ хэрэглэгчдэдээ ойлгуулах явдал аж.

2. БАЙГАЛИЙН ШАЛГАРАЛД БЭЛДЭЭРЭЙ

“Route-22” рестораны эзэн Н.Болормаа 50 орчим хүнээс бүрдсэн жижигхэн компанитай. Хоол үйлдвэрлэлийн салбарт ажилладаг түүний компанид 2020 оны 2-4 дүгээр сарууд маш хүнд байлаа. Ресторанууд нь ерөөсөө хүнгүй болж, тэр шоконд оров. Тэднийх өөр концепцтэй дөрвөн ч бизнестэй байсан бөгөөд хоёрдугаар сар гармагц нээгээд удаагүй байсан “Fig & Olive” гэх аятайхан газраа яаралтай зарахаас өөр аргагүй болжээ. Учир нь ямар нэгэн аргаар бэлэн мөнгөтэй байх хэрэгтэй байлаа.

Засгийн газрын шийдвэрээр ажил олгогчдын өгдөг НДШ-ийн 10 хувийг зургаан сараар хөнгөлсөн ч энэ нь зардлыг яльгүй багасгасан болохоос эргэлтийн хөрөнгөд ямар ч нөлөө үзүүлсэнгүй. Угаас рестораны бизнес зардал өндөртэй ч ашиг багатай, зарим тооцооллоор бүр таван хувийн ашигтай гэж гардаг учраас орлого ийнхүү эрс багассан нь хүнд цохилт болсон нь мэдээж.

Тэдний компанийн хувьд сарын тогтмол зардал 200-гаад сая төгрөг болдог. Хоол үйлдвэрлэлийн салбар уул уурхайтай харьцуулахааргүй доогуур орлоготой ч уул уурхайгаас олон хүнийг ажиллуулдаг, байрны түрээс, гал тогооны тоног төхөөрөмж зэрэг нь ресторан хаалттай эсэхээс үл хамаардаг зардал учраас олон төрлийн зардал хэвээр байдаг онцлогтой.

Энэ нөхцөлд Н.Болормаа яаж “амьд үлдэх” тухай л бодож байлаа. Ямар зардлуудыг танаж, тэвчиж, ямар функциудыг нэгтгэж болох талаар эргэцүүлэв. Ялангуяа зардлын тэн хагасыг эзэлдэг бараа, материалын худалдан авалт дээр хатуу хяналт тавьж байв. Энэ мэтээр бизнесийнхээ орлого, зардал, цаашлаад бизнес загвартаа хүртэл бүрэн шинжилгээ хийхэд хүрчээ. Өнөөдөр нөхцөл байдал эргээд сайжирч байгаа ч өмнөх шиг тайван байдаг үе эргэж ирэхгүй. Энэ бүхний эцэст Н.Болормаа зөвхөн нэг салбарт бүх өндгөө хийчихэж болохгүй, эрсдэлээ хуваах зорилгоор арай өөр салбарын бизнесүүд рүү орох хэрэгтэй гэсэн дүгнэлт хийжээ.

Зарим бизнес эрхлэгч хэдийнэ тэмцлийн хэлбэрт шилжсэн. Тэдний нэг нь Comedy Lab клубийн гишүүн, комедиан Д.Амартүвшин. Тэрбээр Засгийн газраас бизнесүүдэд бэлэн мөнгө тараах тухай яриа гарахад эсрэг байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Үүнийгээ тайлбарлахдаа “Маш олон бизнесмэн бэлэн мөнгө хэрэгтэй байна гэж ярьж байсан. Гэхдээ үнэн хэрэгтээ бидэнд юу хэрэгтэй байсан гэхээр мөнгө хэвлэж бэлэн мөнгө тараах биш, харин бараа бүтээгдэхүүний солилцоо

хурдтай явагдах орчин л хэрэгтэй байсан” гэж ярилаа. Цар тахлын үеэр Comedy Lab клубийн орлого тасарсан ч орлого олох өөр арга зам эрэлхийлж, онлайн контент хийдэг болсон нь хандалт сайтай байгаа гэлээ.

Н.Болормаа болоод Д.Амартүвшингийн түүх бол 2020 оны эхний хагаст олон мянган компанид өрнөсөн үйл явцын зөвхөн өчүүхэн хэсэг нь. Дөнгөж дөрөвдүгээр сар гармагц бизнесийнхний орлого 50 хувиар буурсан тухай МҮХАҮТ мэдээлсэн. Цар тахалтай холбоотой Засгийн газраас авч хэрэгжүүлсэн багц арга хэмжээ хувь хүн, өрхөд чиглэсэн болохоос компаниудыг дэмжих, ажлын байрыг хадгалахад ямар ч нөлөө үзүүлээгүй гэдгийг бизнес эрхлэгчид хэлж байна.

Цар тахалтай холбоотой Засгийн газраас авч хэрэгжүүлсэн багц арга хэмжээ хувь хүн, өрхөд чиглэсэн болохоос компаниудыг дэмжих, ажлын байрыг хадгалахад ямар ч нөлөө үзүүлээгүй гэдгийг бизнес эрхлэгчид хэлж байна.

Энэ нөхцөлд компаниудад төр засагт нөлөөлөх хүчтэй лобби явуулахаас өөр сонголт харагдахгүй байна. Бизнесийг төлөөлсөн гол байгууллага МҮХАҮТ, салбарын болон мэргэжлийн холбоод зохион байгуулалтад орж, эрх баригчдад хүчтэй шахалт үзүүлэх арга зам бий. Эс бөгөөс төсвийн үрэн таран зарцуулалт, эдийн засгийн төлөв, төгрөгийн ханшийн уналт, зээлийн хомсдол зэрэг нь ирээдүйд итгэхэд улам хэцүү болгож байгаа учраас таны бизнес маш том “байгалийн шалгарал”-д орно гэж хүлээх л үлдэж байна.

КОМПАНИ ОРШИХУЙ ДОР ТӨР БУЙ

Монголчууд сүүлийн 30 жилд хүн төрөлхтний сүүлийн 200 жилд хийснийг амжуулах Их үсрэлтийн оролдлого хийжээ. Бид асар том өөрчлөлтүүдийг асар хурдтай хийж чадсан нь монголчуудын цусанд байдаг дасан зохицох чадварын гайхамшиг гэлтэй.

Гэвч асар их хурд бас асар их эрсдэл бий болгодог. Дагуул улсын статусаас чөлөөлөгдсөний дараах сэтгэл хөөрөл богино хугацаанд үргэлжилж, нэг мэдэхнээ Монгол Улс нийгэм, эдийн засгийн маш том асуудлуудтай гав ганцаараа үлдсэн. Ийнхүү өөрийгөө, өнгөрснийгөө, ирээдүйгээ, хөгжлийн зам болон тулах цэгээ хайсан өнгөрсөн 30 жилд маш их “өвдөлттэй” өнгөрлөө. Энэ эрэл хайгуул одоо ч үргэлжилж байгаа. Тэгвэл бид юун дээр хийдэл гаргачихав, яагаад төөрчихөв?

Юуны түрүүнд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхэд улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, сонгох, сонгогдох эрх байгаад хангалтгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Юуны түрүүнд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхэд улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, сонгох, сонгогдох эрх байгаад хангалтгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бид эрх чөлөө эдлэхийг дураараа авирлах гэж буруу ойлгосон бөгөөд дураараа авирласны үр дагаврын төлөө хэн ч хариуцлага хүлээхээ больсон. Ингээд “Хариуцлага хүлээдэггүй эрх чөлөө”-г сул тавьж, хариуцлагын баримжаагаа алдсан нь 1992 онд бидний Үндсэн хуулиараа баталгаажуулан олж авсан бүх амжилтыг үгүй хийх магадлалтай том хар хүч болон хувирчээ. Сүүлийн 30 жилийн туршлагаасаа бид хүний эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл нь эдийн засгийн эрх чөлөө юм гэсэн том сургамж авлаа.

Төр бол нийгэмтэй байгуулсан гэрээний дагуу хүмүүсийн эрүүл, аюулгүй,

чинээлэг амьдралд баталгаа гаргадаг. Харин тийм амьдрах үндсийг бүрдүүлдэг нь социализмд “мөлжигч” хэмээн адлуулж байсан ч зах зээлийн нийгэмд “баялаг бүтээгч” хэмээн дээдлэгдэх учиртай компаниуд юм. “Татвар оршихуй дор төр буй, төр оршихуй дор татвар буй” гэдэгтэй адил зах зээлийн эдийн засагт “Компани оршихуй дор төр буй, төр оршихуй дор компани буй”. Төр үнэ цэнийг бүтээдэггүй, харин бизнесийн бүтээсэн үнэ цэнийг дахин хуваарилах үүрэгтэй.

Харамсалтай нь төр өөрөө “хариуцлага хүлээдэггүй эрх чөлөө” эдэлж, баялгийг шударга хуваарилан нийгэмд үйлчлэх бус нийгмийг өөртөө үйлчлүүлэх гэж оролддог, иргэдийнхээ болон ААН-үүдийнхээ эрхийг хязгаарладаг тогтолцоо болж хувирснаас өнөөдрийн хамаг холион бантан бий болжээ. Төр баялаг бүтээдэг иргэдээ дэмжиж, хамгаалах бус өөрөө бизнес хийж, баялгийг булаах гэж зүтгэдэг болсон. Нам хэмээх институци улс орон, ард түмэнд хөгжлийн хамгийн шилдэг хөтөлбөрийг санал болгож хоорондоо өрсөлдөх учиртай ч эсрэгээрээ цөөн тооны хүмүүсийн явцуу ашиг сонирхолд үйлчилдэг бүтэц болон хувирчээ.

Монголчууд өнгөрсөн 30 жилд улс төрийн эрх чөлөөгөө эдэлж, тодорхой хэмжээнд хариуцлага хүлээж сурсан. Гэвч одоо бидний ашиглаж буй систем үеэ өнгөрөөж, шинэчилсэн хэлбэрээр дахин ачаалах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, бид эдийн засгийн хариуцлагатай эрх чөлөөг эдэлж сурах, энэ эрхийг хамгаалж, бэхжүүлэх нь дараагийн 30 жилд хийх үндсэн ажил юм.

“

Цар тахалтай холбоотой Засгийн газраас авч хэрэгжүүлсэн багц арга хэмжээ хувь хүн, өрхөд чиглэсэн болохоос компаниудыг дэмжих, ажлын байрыг хадгалахад ямар ч нөлөө үзүүлээгүй гэдгийг бизнес эрхлэгчид хэлж байна.

”



Сэтгүүлч Ц.Элбэгсайхан

2014 онд МУИС-ийг олон улсын сэтгүүлч мэргэжлээр төгссөн, одоо Asia Mining Magazine сэтгүүлд ажиллаж байна.

“Asia Mining” сэтгүүл

ОРЛОГО НЬ ТАСАЛДСАН Ч ТАНСАГЛАЛАА НЭМСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛ

УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцсэн чухаласуудлын нэг нь 2020 оны төсвийн тодотгол байсан. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого, нийт зарлага, төсвийн тэнцэл зэрэг эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг Засгийн газрын өргөн мэдүүлснээс өөрчлөлгүйгээр нийт тэнцвэржүүлсэн орлогыг 9.7 их наяд, нийт зарлагыг 14.6 их наяд төгрөг буюу 4.8 их наяд төгрөгийн алдагдалтайгаар баталсан. Энэхүү алдагдал нь ДНБ-ий 12.5 хувьтай тэнцүү байхаар тооцсон байна.

Ингэснээр энэ оны батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг хоёр их наяд төгрөгөөр буурууж, зарлагыг 700 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдүүлэв. Орлогыг бууруулахад уул уурхайн салбарын орлого ихээхэн буурч байгаа нь голлон нөлөөлжээ. Энэ оны батлагдсан төсөвт олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 5,991 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 75-125 ам.доллар байхаар тооцож, уул уурхайн салбараас нийт 3.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолж байсан юм.


Гэвч “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн савлагаа нэмэгдэж, тэр хэрээр төсвийн орлого бүрдэлтэд уул уурхайн салбараас төвлөрүүлэх төлөвлөгөө биелэх эсэх нь эргэлзээтэй болж ирсэн. Тухайлбал, энэ оны эхний хагаст зэсийн үнэ тонн тутамд дунджаар 5,489.6 ам.долларт хэлбэлзсэн. Мөн нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоо буурч, эхний хагас жилийн байдлаар 8.7 сая тонн нүүрс экспортолсноор нүүрсний экспорт анх төлөвлөсөн хэмжээ болох 42 сая тоннд хүрэхгүй нь үндсэндээ тодорхой болсон юм.

Нөхцөл байдал ийм болсон тул тодотголоор нүүрсний экспортын төлөвлөгөөг 40 гаруй хувиар бууруулж 25 сая тонн нүүрс экспортлох зорилт тавилаа. Өөрөөр хэлбэл оны сүүлийн

хагаст эхний хагасаас даруй гурав дахин их экспорт хийхээр зэхжээ. Монгол-Хятадын хилийн боомтуудад “Ногоон гарц”-ын түр горим хэрэгжиж эхэлсэн учраас энэ зорилт биелнэ гэж тооцож буй. Энэхүү түр журмын хүрээнд Замын-Үүд - Эрээн, Баянхошуу - Өвдөг, Гашуунсухайт - Ганцмод, Шивээхүрэн - Сэхээ, Бичигт - Зүүнхатавч, Бургастай - Лаомяя, Булган - Такашикен боомтоор тээвэр хийж байгаа жолооч нарт хилийн цаана хоноглох боломжийг бүрдүүлж, хилээр нэвтрэх цагийг уртасгасан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны эхний долоон сарын гүйцэтгэлийг харвал 5,761.6 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс нэг их наяд гаруй төгрөг буюу 15.1 хувиар буурсан байна. Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 1,084.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 751 тэрбум төгрөг буюу 41 хувиар буурчээ. Ингэж буурах нь аргагүй бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 101 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 358 сая ам.доллараар буурсан нь татварын орлого буурахад гол нөлөөг үзүүлж байгаа юм. Үүнд, чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,232 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин алтны экспорт нь тоо хэмжээний өсөлттэй холбоотойгоор өнгөрсөн оны мөн үеэс 884 сая ам.доллараар өссөн байна. Гэсэн ч алтнаас төвлөрөх татварын орлого нүүрсний тасалдсан орлогын тавны нэгд ч хүрэхгүй юм.

График 17. Уул уурхайн салбарын орлого, тэрбум төгрөг.




Хэдийгээр уул уурхайн салбарын орлогыг бууруулж тооцсон ч итгэл найдвар өвөртөлсөн эерэг төсөөллөөр тодотголын төслийг боловсруулсан тал ажиглагдаж байна. Тухайлбал, БНХАУ-ын үйлдвэрлэл нэмэгдэж буйтай холбоотойгоор түүхий эдийн эрэлт нэмэгдэж, зэсийн гол нийлүүлэгч улсуудад “Ковид-19” цар тахлын тархалт өндөр байгаатай холбоотойгоор нийлүүлэлтийн доголдол үүсэх эрсдэлтэй байгаа тул сүүлийн хагас жилд зэсийн дундаж үнийг тонн тутамд 6,400 ам.доллар байхаар тооцжээ.

Цар тахлын улмаас бизнесүүдийн үйл ажиллагаа ихээр хумигдаж, ажлын байр цөөрч ирсэн учир зөвхөн уул уурхайн орлого ч бус татвар, нийгмийн даатгалын орлого ч тасалдах эрсдэлтэй байгааг эдийн засагчид сануулж, төсвийг зайлшгүй тодотгох нөхцөл үүссэн гэдгийг хэлж байв. Гэвч Сангийн сайд Ч.Хүрэлбаатар ажлаа авснаас хойш “төсөв тодотгохгүй” гэсэн бодлого баримталж, УИХ-ын сонгууль болтол хэлсэндээ эзэн болж ирсэн. Сангийн яамны тооцсоноор Монгол

Улсын нэгдсэн төсвийн татварын орлого оны эцэст 8.8 их наяд төгрөгт хүрч, батлагдсан төсвийн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурах хүлээлттэй байгаа юм. Үүний дотор Нийгмийн даатгалын орлого 882.6 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 347.9 тэрбум, Орлогын албан татвар 170.9 тэрбум төгрөгөөр тус тус буурч буй нь томоохон бууралт болохоор байна.

Төсөвт тодотгол хийсэн нь өөрөө дэвшил гэж эдийн засагчид үзэж байгаа ч тодотголоор юуг сайжруулсан бэ гэдэг дээр өөр өөр байр суурьтай байна. Тухайлбал, тодотгол өргөн баригдах үедээ л хуульд нийцэхгүй байсныг эдийн засагч Н.Энхбаяр хэлж байгаа юм. Тодотголоор хийгдэж байгаа өөрчлөлтүүд төсвийн зарчим, тусгай шаардлагад нийцэхгүй байхад хүлээн авч хэлэлцэж эхэлсэн нь УИХ-ын Тамгын газар хуулийг үл тоомсорлосон явдал гэж тэрбээр шүүмжлэв. “Үүнийг УИХ-ын Тамгын газар хуульд нийцсэн байна уу гэдгийг шалгаж хүлээж авах ёстой. Хууль хэлэлцээд эхэлсний дараа, зөрчигдөж байгаа заалтаа өөрчилж байгаа дараалал нь буруу” хэмээн тэрбээр ярьсан юм.

График 18. Нүүрсний экспортын төсөөлөл, сая.тн



Төсвийн тодотголын тухай хуулийн төслийг наймдугаар сарын 14-нд өргөн барьж, 16-ны өдөр анхны хэлэлцүүлгийг хийсэн билээ. Харин Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тухай хуулийн төслийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар наймдугаар сарын 19-нд өргөн барьсан юм. Төсвийн тодотголыг өргөн барихаас эхлээд үйл явц нь төдийгүй төлөвлөсөн зарим хөрөнгө оруулалт нь ч хуулийн шаардлага хангахгүй байгааг Нээлттэй нийгэм форумын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам хэлж буй. Тодотголд хэрэгжих эсэх нь тодорхойгүй төслүүдийг санхүүжүүлэхээр их хэмжээний мөнгө төлөвлөсөн байгаа тухай Д.Оюунбадамын манай сэтгүүлд өгсөн ярилцлагаас илүү тодорхой унших боломжтой.

Төсвийн тодотголыг хэлэлцэж батлах үйл явц хурдан өнгөрсөн. Төсвийн алдагдлыг ийн их хэмжээгээр баталж, төсвийн тогтвортой байдлын хуульдаа хүртэл өөрчлөн оруулан баталсны дараа тодотголын гол зорилго юу байсныг хэлэхэд бэрх. Төсвийн орлогыг их хэмжээгээр бууруулсан боловч зардлаа бууруулаагүй, тэр тусмаа цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг хасаж тооцсон бараа, үйлчилгээний зардлыг 147.6 тэрбум, тоног төхөөрөмжийн зардлыг 75 тэрбум төгрөгөөр тус тус 2020 оны батлагдсан төсвөөс нэмэгдүүлжээ. Мөн төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 19.6 тэрбум төгрөгөөр нэмсэн атал хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 31.6 тэрбум төгрөгөөр бууруулжээ. Засгийн газар

энэ зардлын өсөлтүүдээ юунд зарцуулж буйгаа тайлагнах, тайлбарлах ёстой. Эс бөгөөс эх орон бүсээ чангалахад эрх ямбатнууд тансаглалаа барьж дийлээгүй гэж дүгнэхээр байна. Удахгүй 2021 оны Төсвийг УИХ хэлэлцэж эхэлнэ. Тодотголд суусан завхрал бүхэн ирэх оны төсөвт дамжин суух магадлал ч өндөр юм.





**Лхагвасүрэн овогтой
Нандинцэцэг**

*2017 онд Оросын Улс Түмний
Найрамдлын их сургуульд
сэтгүүлзүйн бакалаврын зэрэг,*

*2019 онд М.В.Ломоносовын
нэрэмжит Москвагийн Улсын
их сургуульд Стратегийн
харилцааны чиглэлээр
магистрын зэрэг тус тус
хамгаалсан.*

*2017-2019 онд Үндэсний
мэдээллийн МОНЦАМЭ
агентлагийн Москва дахь
тусгай сурвалжлагчаар ажлын
гараагаа эхэлж,*

*2020 оноос МОНЦАМЭ
агентлагийн Дотоод мэдээний
нэгдсэн редакцад Тоймчоор
ажиллаж байна.*

МОНЦАМЭ

**ШУУРГАН ДУНДАХ БАМБАР БУЮУ
БАНКНЫ САЛБАР ДАХЬ ЦАР ТАХЛЫН
НӨЛӨӨ**

Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас хүн ардаа хамгаалахын тулд зайлшгүй хэрэгжүүлсэн хөл хорио, хилийн боомтуудын хязгаарлалт манай улсын эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхай, худалдаа, тээврийн салбарт хүчтэй нөлөөлж, улмаар эдийн засаг 2020 оны нэгдүгээр улиралд 10.7 хувиар, хоёрдугаар улиралд 9.7 хувиар агшсан. Угийн саарч байсан эдийн засгийн идэвхжил коронавирусний нөлөөгөөр улам дордож банкны салбарын үзүүлэлтүүдэд хүчтэй нөлөөлж байгааг Монголын банкны холбоо /МБХ/-ноос гаргасан Банкны салбарын эхний хагас жилийн үзүүлэлтээс харж болохоор байна.

**~ ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН
ЭРЭЛТ ӨСӨВ~**

2020 оны нэгдүгээр улиралд банкуудын зээл олголт жилийн хоёр хувиар буурч байсан бол хоёрдугаар улиралд хурдасч 11 хувиар буурчээ. Нэг талаас ААН-үүд мөнгөн урсгалын дутагдалд орсноор банкны харилцах дансны дүн буурсан, нөгөө талаас борлуулалт буурч буй ААН-д олгох банкны зээл буурсан нь нийт зээл буурахад ихээхэн нөлөөлсөн байна. Түүнчлэн Монголбанкнаас макро зохистой бодлогын хүрээнд “гаарсан” гэж хэлж болох хэрэглээний зээлийг хязгаарласнаар эхний хагас жилд энэ төрлийн зээл олголт 17 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм. Бүх зээл дундаас ганц эерэг үзүүлэлттэй буюу өсөн нэмэгдэж байгаа нь хадгаламж барьцаалсан зээл байгааг доорх зургаас харж болно. Энэ төрлийн зээл оны эхнээс 3 хувиар өссөн нь иргэдийн орлого муу байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

• • • • •

*~ТӨГРӨГИЙН ХАНШ СУЛАРСНААР АМ. ДОЛЛАРЫН ХАДГАЛАМЖ
ОГЦОМ НЭМЭГДЖЭЭ~*

Өнгөрсөн оны 10 дугаар сараас хойш ам.долларын ханш төгрөгийн эсрэг тогтмол чангарч өнөөдрийн байдлаар 1 ам.доллар 2,853 төгрөгтэй тэнцэж байна. Долларын ханшийн өсөлттэй зэрэгцэн төгрөгийн хадгаламжийн хүү буурч түүхэн доод хэмжээнд буюу 10.5 хувьд хүрсэн нь иргэд, ААН-үүдийг төгрөгийн хадгаламжаа ам.долларт хөрвүүлэхэд хүргэжээ. Оны эхэнд ам.долларын хадгаламж нийт хадгаламжийн 20 орчим хувийг эзэлж байсан бол, зургаан сарын дотор бараг 50 хувиар огцом нэмэгдэж 29 хувьд хүрчээ. Энэхүү өсөлт банкуудын нийт хадгаламжийн багц оны эхнээс 16 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Хадгаламжийн буюу эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх, зээлийн долларжилт буурах үзэгдэл нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн үргэлжилсэн сулралтын үед явагдах хандлагатай байдаг. Учир нь төгрөгийн ханш суларснаар банкны хадгаламж эзэмшигчдийн төгрөгт итгэх итгэл буурдаг. Нөгөө талаас төгрөгийн ханшийн уналтаас үүдэн ирээдүйд төлөх төлбөрийн хэмжээ нэмэгдэх учир зээлдэгч нар валютын зээлийг сонирхохоо больдог. Долларжилт ихсэх нь эдийн засагт сөрөг нөлөөтэй тул Төв банк иргэд байгууллагуудын валютын гүйлгээг зогсоож, харилцах дансанд хүү тооцохыг хориглох, алтны нөөцийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч байгаа юм. Валютын томоохон гарах урсгал байхгүй тул хүлээлтэд суурилсан ам.долларын хадгаламжийн өсөлт оны эцэст саарах төлөвтэй байгааг эдийн засагчид хэлж байна.

*~УУЛ УУРХАЙН ГУРВАН ЗЭЭЛ ТУТМЫН НЭГ НЬ ЧАНАРГҮЙД
ШИЛЖИЖ БАЙНА~*

Манай улс Covid-19 цар тахлаас хүн ардаа хамгаалж эдийн засгаа золиосонд гаргасан. Тэр дундаа нэгдсэн төсвийн орлогын 23 хувь, экспортын орлогын 87 хувийг дангаараа бүрдүүлдэг уул уурхайн салбар цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртөж буй. Монголбанкнаас мэдээлснээр уул уурхайн салбарын нийт зээлийн үлдэгдлийн 61.5 хувь буюу 862.3 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 8.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 29.8 хувь буюу 417.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгджээ. Өөрөөр хэлбэл, уул уурхайн гурван бизнес эрхлэгч тутмын нэг нь банкны өмнө хариуцлага хүлээх нөхцөл үүсээд байгаа юм. Экспортын хязгаарлалт мөн дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт энэ салбарт бизнес эрхлэгчдэд хүндээр тусаж байгаа нь тодорхой. Нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байгаа хэдий ч, Хятадын нүүрсний хэрэглээ 30 гаруй хувиар буурч, цар тахлын нөлөөгөөр эхний улиралд нүүрсний экспорт тасалдсан. Экспортын орлогын 40 хувь, төсвийн орлогын 15 хувийг бүрдүүлдэг зэсийн үнэ эхний улиралд 6300-аас 4700 ам.доллар болж буурсан. Төр, засаг цар тахлын үед уул уурхайн бүтээгдэхүүний экспортын процедурыг хөнгөвчилж хэмжээг нэмэгдүүлэхээр Хятадын талтай тохиролцон арга хэмжээ авч байгаа хэдий ч эрдэс бүтээгдэхүүний борлуулалт өнгөрсөн оных шиг түүхэн дээд хэмжээнд хүрэхгүй нь тодорхой болсон билээ.

~МОНГОЛД АРИЛЖААНЫ БАНК ДУНДЖААР 10 ХУВИЙН АШИГТАЙ
АЖИЛЛАДАГ~

Эхний хагас жилд банкны салбарыг хамарсан нэг томоохон ажил бол зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын ээлжит бус чуулганаар баталсан явдал байлаа. Энэ хүрээнд 16 хувь байгаа зээлийн хүүг ирэх дөрвөн жилд дөрвөн нэгж хувиар бууруулж жилийн 12 хувьд хүргэхийг зорьж байгаа юм. Зээлийн хүүг бууруулах хүрээнд 47 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс 38 нь макро түвшинд бодлого тодорхойлогчдоос хамаарах ажил байна. Харин банкуудын хувьд үйл ажиллагааны зардлаа бууруулах, дундын дэд бүтэц бий болгох замаар давхардаж буй зардлуудаа танах ажлыг эхлүүлээд байгаа юм. Зээлийн хүү өндөр байгааг шүүмжилж банкыг мөнгө хүүлэгч мэтээр хүлээж авах нь элбэг. Тэгвэл зээлийн хүүг бүрдүүлэгч гол хүчин зүйл нь эх үүсвэрийн зардал буюу гадны зээл, иргэд, байгууллагын хадгаламжид өгч буй хүүгийн зардаг байдаг байна. Тодруулбал, банкны зээлийн хүүгийн 62 орчим хувь нь эх үүсвэрийн хүү, 15 орчим хувь нь банкны үйл ажиллагааны зардал, 11 хувь нь зээлийн эрсдэлтэй холбоотой зардал, үлдсэн нь ашиг байдаг байна. Өнгөрсөн онд л гэхэд 13 арилжааны банк нийт 368 тэрбум төгрөгийн ашигтай ажилласныг төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой компанийн нэг тэрбум төгрөгийн ашигтай харьцуулахад бараг гурав дахин бага тоо юм. Зээлийн хүү, түүнээс улбаатайгаар банкны ашиг хэр үндэслэлтэйг харуулдаг хэмжүүр нь ROA буюу активийн өгөөж болон ROE буюу өөрийн хөрөнгийн өгөөж байдаг. Хятадын үйлдвэр худалдааны банкны Байгууллагын банкны хэлтсийн менежер О.Дорждамбын хийсэн судалгаагаар Монголд арилжааны банк дунджаар 10 хувийн ашигтай ажиллаж байгаа бол банкны эзэд нь дунджаар нэг хувийн ашиг хүртэж байгаа нь дэлхийн стандарттай ижил түвшинд байгааг харуулжээ.

МОНЦАМЭ



Батмөнхийн Болд

ОХУ-ын Уралын их сургуулийг сэтгүүлчээр төгссөн. Монголын радио, өдөр тутмын сониноос ажлын гараагаа эхлүүлсэн. 1999-2004 онд “Зууны мэдээ”, 2005-2009 онд “Өдрийн сонин”-д сэтгүүлч, редактор, тоймчоор ажиллаж байсан. 2010-2017 он хүртэл МҮХА УТ-ын “Бизнес Таймс” сонины хариуцлагатай нарийн бичгийн даргаар ажиллаж байв. 2018 оноос үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагт эдийн засгийн сэтгүүлчээр ажиллаж байна.

“COVID-19”-ӨӨС ОЛДСОН БОЛОМЖ

Улаанбаатар /МОНЦАМЭ/. Дэлхий нийтийг хамарсан шинэ коронавирустийн цар тахал бусад улс орны адил, манай улсын эдийн засаг, бизнест хүндээр туссан. Өнөөдөр тодорхой цаг хугацаа туулж өнгөрсний эцэст бид энэ талаар ярихаас илүү энэ нөхцөл байдлаас манай улсын бизнес эрхлэгч нарт ямар боломж үүссэн талаар дурдах нь цагаа олох болов уу.

~НЭГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА~

Сэтгүүлч бид амьдралын дунд явах учиртай, энэ үүднээс олон хүнтэй уулзаж учирдаг. Саяхан “Сүү” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Гантулгатай уулзвал тэрээр, “Монголчууд бид чинь нэгдэж нийлж юм хийдэггүй, өөр хоорондоо өрсөлдөж байдаг хүмүүс. Нэгэнтээ энэ жижигхэн зах зээлд ингэж байхын оронд том зах зээлд, олон улсад гарахаа бодож нэгдэж нийлэх цаг хэдийнэ ирсэн. Ийм боломжийг “COVID-19”-ийн нөхцөл байдал олголоо. Удаан хугацаанд тухайн бизнес дээр оршин тогтнож чадах үгүйг коронавирус нэг ёсондоо шигшиж өглөө” хэмээн шүүмжлэлтэй хандсан дохио (мессеж) бүхий саналыг хэлж байлаа. Хатуу ч гэсэн үнэн үг. Үндэсний анхдагч “Сүү” компаниа хөрөнгийн зах зээлд гаргаж байсан тэрээр одоо өөрөө “Ард лайф”-ыг удирдан үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хөл тавиад буй, нэг ёсондоо “гал тогоо”-нд байдаг хүний хувьд “COVID-19”-ийн үеэр хувийн хэвшлийнхэнд гарсан нэг боломжийг ийнхүү хэлж байв.

Тэрээр боломжийг цааш нь дэлгэрүүлж хэлэхдээ, “Одоо бид сарнисан зүйлсээ нэгтгэж нийлүүлж аваад нэг хувьцаат компани болдог ч юм уу, нэг зорилго тавиад, үйлдвэрүүд нэг чиглэл дор ороод явах юм бол хангалттай хэмжээнд өсөх боломж хувийн хэвшлүүдэд байна” гэдгээр тодотгов. Ганцхан жишээгээр тайлбарлая. Өнөөдрийн Улаанбаатарын замын хөдөлгөөний түгжрэлээс болоод компаниудын

зардал 20-30 хувиар өссөн гэдэг тоон судлагаа байна. Зардал яаж өссөн гэхээр нэг бизнесмен өдөрт 10 компанитай уулзан харилцдаг байсан бол одоо 5 компанитай уулзаж чадахгүй байна. 30 цэгт очоод борлуулалт хийдэг байсан бол одоо 20 цэгт л дөнгөж хүрч байна. Энэ нь зөвхөн замын түгжрэл бизнесийн бүтээмжид нөлөөлж байгааг харуулах.

Энэ мэт бэрхшээлийг зохицуулах боломж байна уу гэвэл байна аа. Төсөвт хөрөнгө оруулах. Зээл олгох биш шүү гэдгийг тэрээр онцолж байв. “Нэг салбарын 2 компани нэгдэх гэж байвал улсаас мөнгө гаргаж өгөөд, ингэхдээ тэдгээр компанийн 10-20 хувьд үнэлгээ хийгээд тухайн компаниа хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргахыг шаардах. Хувьцаагаа гаргангуут 20 хувийг нь худалдаж аваад үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь хөрөнгө оруулж хэдэн жилийн дараа оруулсан хөрөнгө оруулалтаа мөнгө болгоход л болоод явчихна”. Эдийн засаг руу оруулах боломжид илүү ухаалаг хандах саналыг тэрээр ийнхүү тавьж байсан юм.

Нэгдэж нийлэх үйл ажиллагаа зөвхөн дотооддоо бус олон улсад өрнөх үйл явц юм гэдгийг коронавирусний нөхцөл байдал тавьж өгснийг МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин хэлэхдээ, “Дэлхий нийтийг хамарсан “COVID-19”-ийн цар тахлаас үүдэн бид том сорилттой тулгарч буй энэ цаг үед олон улсын хамтын ажиллагаа, үндэстэн хоорондын нөхөрлөлийн үнэ цэнэ, ач холбогдлыг улам бүр үнэлж, мэдрүүлж байна” хэмээн онцолсоон.

~“COVID-19”-ИЙН ДАРАА ЯАХ ВЭ? ЦАХИМ БИЗНЕС БА ЭКСПОРТ~

Энэ талаар “Да Хүрээ трейд” ХХК-ийн захирал Ц.Алимаагаас асуувал тэрээр, “Коронавирусний дараа бизнес ямар байхыг мэдэхгүй. Харин бидний хувьд ямар байхыг хүсэж байна гэвэл бизнес илүү нээлттэй, хүртээмжтэй болох байх гэж бодож байна” гэж хариулсан юм. Тэрээр мөн Б.Гантулгын адил бизнесүүд, салбар чиглэлээрээ илүү нэгдэж, “COVID-19”-ээр гарсан боломжуудыг ашиглаасай гэсэн санааг давтан хэлж байв.

• *“COVID-19”-ийн цар тахлын улмаас уналтад орж хамгийн их нөлөөнд өртсөн аялал жуулчлааны салбарыг эргэн сэргээхийн тулд олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу шинэ стратегиар ажиллах шаардлага тулгарсан.*

• *“COVID-19”-тэй холбоотой эдийн засгийн хүндрэл хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж байж цаашид гарах эрсдлийг даван туулна гэдэг нь харагдсан. Ийм боломж, сорилт “COVID-19”-ийн дараа харагдаж буйг бизнес эрхлэгчид салбар салбараараа жишиг татан хэлж байна.*

Шинэ коронавирусний цар тахлын нөхцөл байдалд цахим бизнес голлож гадаад, дотоодын бизнес эрхлэгчдийг, ажил хэрэгч хүмүүс, компани, ААН-үүдийг чухам л холбох гол гүүр нь цахим холбоо хэлхээ харилцаа болж, үүний гол чиглэл цахим худалдаанд төвлөрсөн. Төр, засаг ч гэсэн бараг бүх үйлчилгээгээ цахим шилжүүлээд амжив. (Энэ нь МҮХАҮТ-аас бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх талаар төр, засагт тавьж ирсэн шаардлагын нэг үр дүн юм).

Бизнест цахим худалдаа голлох болсны нэг жишээнд бизнесийн төлөөллийн байгууллага МҮХАҮТ “COVID-19”-ийн халдвар дэгдэхийн өмнө, 2019 оны эцсээр Монголын ААН-үүдийн бараа бүтээгдэхүүнийг БНХАУ-ын зах зээлд гаргахаар цахим худалдааны платформ талбарыг албан ёсоор эхлүүлж, 2020 оны 1 дүгээр

сард бараа, бүтээгдэхүүний эхний ачилтыг хийгээд байв. Гэвч цар тахлын улмаас хоёр улсын хил тодорхойгүй хугацаагаар хаагдан зогссон юм. Энэ нь “COVID-19”-ийн дараа сэргэх нэг бизнес болон цар тахлын дараах үед хүлээгдэж байна.

“COVID-19”-ийн нөхцөлд жишээ нь, МҮХАҮТ зүгээр суугаагүй, цахим холбоо харилцааг ашиглан “Монголын худалдааг дэмжих” ТРАМ төслийн үйл ажиллагаа болон “Берлин дэх Монголын Мэдээлэл худалдааг дэмжих Европын төв”-ийг байгуулсан.

Ингэснээр Монгол Улс болон Европын холбооны иргэд, ААН, байгууллагуудыг холбох гүүр болж Монголын байгалийн түүхий эдээс гаралтай, өндөр чанартай, өрсөлдөх чадвартай органик бараа бүтээгдэхүүнийг хямд өртгөөр Германы болон ЕХ-ны зах зээлд гарах гарцыг бий болгосон. Энд Монголын арьс шир, чацаргана, эсгий эдлэл, ноос ноолуур, модон эдлэл, цай, ургамал, жимсний чанамал болон бусад сайн чанарын, байгалийн гаралтай бараа бүтээгдэхүүнүүдийг нэн тэргүүнд экспортлох боломж нээгдээд байна.

Мөн Монгол Брэндийн холбооноос үүсгээд буй цахим талбараар дотоодын компани, ААН-үүд, ЖДҮ эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгч нар өөрсдийн бараа, бүтээгдэхүүнээ үнэ төлбөргүй сурталчлах боломжтой болсон зэрэг олон жишээг энд хэлж болно.



Р.Оюунцэцэг

*/ iKon.mn Орлогч эрхлэгч/
2006-2014 "Өнөөдөр" сонинд
сэтгүүлч,*

*2014-2018 "Засгийн газрын
мэдээ" сонинд эдитор,*

*2018-аас iKon.mn сайтад
ажиллаж байна.*

iKon.mn

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРААС
УЛААНБААТАР ХОТ 325 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
ШУУД БУС АЛДАГДАЛ ХҮЛЭЭВ**

Шинэ коронавирусийн халдварын нөлөөгөөр хамгийн хүнд цохилтод ороод байгаа салбарын нэг нь АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ.

Энэ салбар дэлхий даяар анх удаа ТЭГ ЗОГСОЛТ хийж байна.

Тэгвэл Монгол Улсын аялал жуулчлалын салбар, тэр дундаа Улаанбаатар хот өнгөрсөн гурван сарын хугацаанд ямар алдагдал хүлээсэн талаар Монголын Үндэсний их сургуулийн багш, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн гишүүн, судлаач Б.Ербахыг сонирхолтой судалгаа хийжээ.

Түүний тооцоолсноор өнгөрсөн гурван сарын хугацаанд Улаанбаатар хотын эдийн засагт аялал жуулчлалын салбараас шууд олох боломжтой байсан 30.5 тэрбум, шууд бусаар 325 тэрбум төгрөгийг алдаад байгааг дараах тооцооллуудаар гаргаж тавьжээ.

НЭГ. ШУУД АЛДАГДАЛ

Өнгөрсөн он Монгол Улсына аялал жуулчлалын салбарт өсөлт авчирсан жил байв. Нийт жуулчдын тоо 570,262 буюу дээд хэмжээнд хүрч, 607 сая ам.доллар буюу 1.7 их наяд төгрөгийн цэвэр ашиг олсон статистик(БОАЖЯ, 2020) байна.

Аялал жуулчлалын салбараас орж ирсэн 1 ам.доллар эргэлтэд орж, 1.42 ам.долларын борлуулалтыг бий болгох замаар эдийн засагт шууд бус болон дам байдлаар 862 сая ам.доллар буюу 2.4 их наяд төгрөгийн борлуулалтыг бий болгож, эдийн засгийг тэтгэжээ.

2019 онд Монгол Улсын ДНБ 36.9 их наяд төгрөгт хүрсэн. Тэгвэл аялал жуулчлалын салбарын орлого ДНБ-ий 6.48%-ийг бүрдүүлсэн гэсэн үг.

Шинэ коронавирусийн нөлөө (МҮХАҮТ)



2019 онд нийт ирсэн жуулчдын 78.7% нь буюу 452,957 жуулчин Улаанбаатар хотоор дайрч, 2-3 хоног саатсан байдаг. Гэвч 2020 оны эхний гурван сарын байдлаар Улаанбаатар хотыг дайран өнгөрсөн жуулчдын тоо өмнөх онтой харьцуулахад -91.3%-аар буурсан дүнтэй байна. Ийнхүү буурснаар хотын эдийн засагт жуулчдын оруулах орлого -96.9%-аар буурчээ. 2019 онд нийслэлийн эдийн засагт гаднаас ирсэн жуулчид 155.7 сая ам.доллар буюу 432 тэрбум төгрөгийн шууд орлого оруулж байж.

Сар сараар нь задлаад харвал шинэ коронавирусийн улмаас нийслэлийн эдийн засагт аялал жуулчлалын салбараас ирэх орлого ийнхүү буурсан байна.

- *Нэгдүгээр сард -7%*
- *Хоёрдугаар сард -61.8%*
- *Гуравдугаар сард -96.8%-аар тус тус буурчээ.*

2019 оны эхний гурван сард 18 сая ам.доллар буюу 50 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2020 оны эхний гурван сард 7 сая ам.доллар буюу 19.6 тэрбум төгрөгийн орлого оруулжээ. Өөрөөр хэлбэл, эхний улиралд 11 сая ам.доллар буюу 30.5 тэрбум төгрөгийн “шууд алдагдал” хүлээгээд байна.

ХОЁР. ШУУД БУС АЛДАГДЛЫН ХЭМЖЭЭ

2018 онд Улаанбаатар хотын ДНБ 21.4 их наяд төгрөгт хүрч, улсын ДНБ-ний 64.7%-ийг бүрдүүлжээ. 2020 оны нийслэлийн төсвийг 915 тэрбум төгрөг байхаар баталснаас төсвийн орлого 889.9 тэрбум төгрөг байхаар тооцжээ. Тэгвэл нийслэлийн төсөвт ямар дам нөлөө үзүүлэхээр байгааг судлаач Б.Ербахыг тооцохдоо дараах салбаруудад өнгөрсөн гурван сард гарсан өөрчлөлтүүдийг нэг бүрчлэн авч үзсэн байна.

~ДЭН БУУДЛУУДЫГ ХААСНААР ₮1.97-2.4 ТЭРБУМЫН АЛДАГДАЛ ХҮЛЭЭХЭЭР БАЙНА~

Цар тахалтай холбоотойгоор 2020 оны хоёрдугаар сарын 26-наас дөрөвдүгээр сарын 30-ны өдөр хүртэл дэн буудлуудын үйл ажиллагааг түр буюу 64 хоног зогсоох шийдвэрийг Нийслэлийн Засаг дарга гаргасан. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2020 оны судалгаагаар Улаанбаатар хотод нийт 2,648 өрөө, 3,636 ортой 312 дэн буудал үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээр ихэвчлэн дотоодын иргэд үйлчлүүлдэг бөгөөд жилийн турш ор дүүргэлт дунджаар 33.3 хувьтай байдгийг судлаач тооцоолжээ. Үүнээс нарийн судалгаа байдаггүй тул ор дүүргэлтийг өдөрт 33.3%-аар тооцсон бөгөөд нэг

өрөөний үнийг 35,000-45,000 төгрөг гэж дундажлан гаргасан байна.

Тэгвэл дэн буудлуудыг 64 хоног түр хаахад 1,024 хүн ажилгүй болж, нэг өдөрт 509-654 сая төгрөг, 2020 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдөр хүртэл нийт 1.97-2.4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байгаа аж.

~ЗОЧИД БУУДЛУУД 24 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛ ХҮЛЭЭЖ БАЙНА~

Улаанбаатар хотод 290 зочид буудал ажиллаж байгаагаас 75 нь одны зэрэглэлтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Зочид буудлын нийт үйлчлүүлэгчдийнх нь 20 орчим хувь нь гадаадын жуулчид, үлдсэн нь дотоодын үйлчлүүлэгчид байдаг бол одны зэрэглэлтэй буудлуудын хувьд гаднын жуулчид 90 хувийг нь эзэлдэг ажээ.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд зочид буудлын үйл ажиллагааг зогсоогоогүй ч хилийн хорио цээр тогтсон, хүмүүсийг гэртээ байхыг зөвлөсөн зэрэг нь тус салбарын үйлчилгээнд шууд нөлөөлжээ. Тандалт судалгаагаар энэ хугацаанд зочид буудлуудын ор дүүргэлт 1-10%-тай байгааг Монголын зочид буудлуудын холбоо мэдээлсэн байна.

Нийслэлийн хэмжээнд байгаа зэрэглэлтэй 215 зочид буудал нэг өдөрт 111.4-139.3 сая төгрөг, хорио цээр цуцлагдах хүртэл 7-9 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх нь. Харин одтой зочид буудлууд энэ хугацаанд өдөрт 377.4 сая, нийт 24 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх тооцоололтой байна.

~АМРАЛТЫН ГАЗАР ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН АЛДАГДАЛ НЭГ ТЭРБУМ ТӨГРӨГТ ШҮРГЭНЭ~

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар 576 амралтын газар, жуулчны бааз байдгаас 151 нь нийслэл орчимд байрлалтай. Жуулчны баазуудын дийлэнх нь 5-10 дугаар сард ажилладаг. Харин Улаанбаатар хот орчимд жилийн турш ажилладаг 1,064 өрөө бүхий 51 амралтын газар байгаа ба ихэнх нь амралтын өдөр зочид хүлээж авч, бусад өрдүүдэд зочингүй эсвэл хаалттай байгаа аж.

Тиймээс 80%-ийн дүүргэлттэй байдаг амралтын өдрүүдээр тооцоолоод үзэхээр 2020 оны 2, 3, 4 дүгээр сард нийт 20,500 хүн хүлээж авах боломжтой байжээ. Өөрөөр хэлбэл, 717.5-922.5 сая төгрөгийн алдагдал хүлээсэн дүр зураг харагдаж байна.

~ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН АВАЛТААС ОЛОХ БОЛОМЖТОЙ 260 ТЭРБУМ ТӨГРӨГ ҮГҮЙ БОЛОВ~

Багц үнийн аяллаар ирж байгаа жуулчдын төлсөн мөнгөн дүнгийн тодорхой хэсэг нь хоолны салбар, үзвэр үйлчилгээ, жуулчны тээврийн салбарт ордог. Харин багц үнэд ордоггүй нэг чухал зүйл бол жуулчны худалдан авалт. 2010-2014 он буюу 5 жилийн хугацаанд жуулчдын худалдан авалт Улаанбаатар хотын эдийн засагт 1,272 сая ам.доллар буюу 3.3 их наяд төгрөгийн орлого оруулжээ (Маркетметрикс, 2015). Уг тоонуудыг үндэслэн тооцоолсноор 2019 онд жуулчдын шууд худалдан авалтаар 562.9 сая ам доллар буюу 1.6 их наяд төгрөгийн орлогыг Улаанбаатар хотын эдийн засагт оруулжээ.

2020 онд энэ дүн 10.1%-аар өсөж, 619.8 сая ам.доллар хүрэх төлөвтэй байв. Тэгвэл энэ дүнгээс 90%-ийг цар тахлын нөлөөгөөр алдах төлөвтэй.

Хорио цээр тогтоосон 2,3,4 дүгээр сард нийт 94.03 сая ам.доллар буюу 261 төгрөгийн ашгаа хэдийн алдчихаад байгаа билээ.

~3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АШИГ ОЛОХ БОЛОМЖОО АЛДЖЭЭ~

Улаанбаатар хотод нийтийн хоолны 3,482 газар ажилладаг бөгөөд хотод саатсан жуулчид зөвхөн ресторан, баар, кофе шопоор үйлчлүүлдэг.

Уг тоонд зочид буудлын дотор ажилладаг ресторан, кофе шопуудыг ч багтаажээ. Ингээд тооцвол Улаанбаатар хотын нийтийн хоолны газруудын 52.6 хувиар нь жуулчид үйлчлүүлдэг байх нь. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хоолны газрууд 2010-2014 онд нийт 147.7 сая ам.доллар буюу 410 тэрбум төгрөгийн ашгийг зөвхөн аялал жуулчлалын салбараас олжээ (Маркетметрикс, 2015).

Энэхүү тооцоонд үндэслэснээр 2019 онд тус салбар 65.3 сая ам.доллар буюу 181 тэрбум төгрөгийн ашгийг аялал жуулчлалын салбараас олсон байна. Прогноз өсөлтийг хувьчлан тооцож үзэхэд 2020 онд жилийн турш 71.87 сая ам.доллар буюу 199 тэрбум төгрөгийн ашиг олох тооцоолол гарсан байна. Үүнийг сар бүр ирдэг жуулчдын ачаалалтай харьцуулахад 2, 3, 4 сард нийт 1.09 сая ам.доллар буюу 3 тэрбум төгрөгийн ашиг олох боломжоо алджээ.

Үүнээс гадна үзвэр үйлчилгээ, тээврийн салбарыг оролцуулаад тооцвол дараах байдлаар боломжууд алдагдсан байна.

Ийнхүү 2020 оны 2, 3, 4 дүгээр сарууд буюу коронавирусын эсрэг арга хэмжээ авч, хорио цээр тогтоосон үед Улаанбаатар хотын эдийн засаг бүхэлдээ зогсонги байдалд орж, нийт 31,500 хүний ажлын байранд шууд нөлөө үзүүлжээ. Аялал жуулчлалын салбараас ашиг хүртдэг дээрх салбарууд ихээхэн алдагдал хүлээснийг уг судалгаа харуулж байна.

Салбаруудын алдагдал




Товчхондоо

- гаднын жуулчдаас шууд олох боломжтой 30.5 тэрбум төгрөгийн “шууд алдагдал”
- аялал жуулчлалын нийт салбараас 320-325 тэрбум төгрөгийн “шууд бус алдагдал хүлээжээ

Уг мөнгөн дүн шууд болон шууд бус, дам байдлаар эдийн засагт борлуулалт үүсгэж, тэрхүү нийт орлогын 60% нь ажилчдын нийгмийн даатгал, ХХОАТ, ААНОАТ, нийслэлийн 1%-ийн татвар, төрөл бүрийн хураамж хэлбэрээр нийслэлийн төсөвт төвлөрөх боломжтой байв.

2020 оны турш зөвхөн аялал жуулчлалын салбараас нийслэлийн төсөвт төвлөрөх ёстой 600 тэрбум төгрөгийг алдах ба энэ нь Улаанбаатар хотын ДНБ-ний 6%-тай тэнцэж байна.



Үндсэндээ аялал жуулчлалын салбар зогсонги байдалд орсноос болж тус салбараас Улаанбаатар хотын ДНБ-ий 1.49-1.51%-тай тэнцүү хэмжээний алдагдал буюу нийслэлийн төсөвт төвлөрөх ёстой байсан 195 тэрбум төгрөгийг алджээ.



Сэрээнэн овогтой Бэрцэцэг

2015 онд Соёл урлагийн их сургуулийн Радио телевиз медиа урлагийн сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгсөөд Монгол Улсын их сургуулийг судалгааны сэтгүүл зүйн магистраар эрдэмийн зэрэг дээшлүүлсэн.

2017 оноос Үндэсний шуудан өдөр тутмын сонинд сэтгүүлчээр ажилласан.

2019 оноос Дорноговь аймгийн Ди медиа агентлагийн сэтгүүлч, редактораар ажиллаж байна. Тэргүүний залуу сэтгүүлч шагнальтай.

**Ө.СУГАР: ГОВЬ НУТАГТ ГАЗАР ТАРИАЛАН
ЭРХЭЛДЭГ ХҮМҮҮУСТ ДЭМЖЛЭГ
ХЭРЭГТЭЙ БАЙНА**

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын “Далай бумбат” хэмээх газар найман хүүхэдтэй айлын хоёр дахь хүүхэд нь болон мэндэлсэн хүү бол Өлийхутагийн Сугар юм. Тэрбээр 1964-1972 онд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын бага, дунд сургуульд суралцан наймдугаар анги дүүргэжээ. Улмаар 1972 оноос Эрдэнэ суманд мал маллаж байгаад 1975-1978 онд цэргийн албанд татагдан Ховд аймгийн 123-р ангид алба хаасан байна. 1978 онд МХЗЭ-ийн илгээлтээр Дорноговь аймгийн Мандах сумын “Цагаанцав” ногоо бригадаас ажлын гараагаа эхэлсэн тэрбээр 12 жил тасралтгүй ажилласан байна. Энэ л цагаас ирээдүйн амжилтын үрийг суулгаж байсан гэлтэй. 1990 оноос одоог хүртэл хувиараа газар тариалан эрхэлж байгаа Монгол Улсын тэргүүний тариалч Ө.Сугартай ярилцсанаа уншигч танд хүргэж байна.

-Сайн байна уу. Танд алтан намрын налгар өдрийн мэнд. Ногоо тариалах болсон тэр үеийн дурсамжаар ярилцлагаа эхлэх үү?

-Та бүхэн сайхан намаржиж байн уу. Би Эрдэнэ суманд төрсөн. Мандах сумын “Цагаанцав”-аас газар тариалангийн ажлаа эхлүүлж байсан. Тэр үеэс л ногоо тарих дуртай болсон. 1978 онд цэргээс халагдаад Мандах сумын Цагаанцавд анх ногоочноор ажиллаж байгаад 12 жил дезилчин хийсэн. 1990 оноос эхлээд газар тариалан хувиараа хийж эхэлсэн. Анхнаасаа л зөвхөн тарвас тариалсан. Сүүлийн 20 гаруй жил Зээгийн хөтөлд тарвас тариалж байгаад сүүлийн үед жимс, хүнсний ногоо тариалж байгаа. Газар тариалан эрхлэх сонирхолтой, өөрөө дуртай байсан болохоор олон жил тасралтгүй ажиллаж байна.

-Газар тариалангийн бизнес эрхлэх үедээ хэдэн настай байсан бэ. Сонирхолтой санагдаж байна. Харьцангуй сүүлд хувиараа ногоочин болсон

байна шүү дээ. Энэ нь тухайн үеийн ажлын үр дүнд нөлөөлнө биз дээ?

-40 орчим наснаасаа эхлээд л өөрийнхөө бизнесийг хийсэн дээ. Сүүлийн үед газар тариалан эрхлэх сонирхолтой залуучууд олон болж байна. Залуу, хөгшин гэлтгүй бизнес эрхлэх боломжтой шүү дээ. Анхлан ногоо тарьж байгаа залуучуудад хандан туршлагаасаа хуваалцахад үрээ зөв сонгож, газраа хагалахдаа анхаарах хэрэгтэй. Хөрсөө хамгаалахгүй бол ургац хураахгүй шүү дээ.

-Таны хувьд туршлага гэдэг мэргэжлийн байхаас илүү суурьшжээ. Харин гэргий тань мэргэжлийн ногоочин гэсэн. Та хоёр яаж танилцаж байв. Ногоо та хоёрыг учируулчихав уу?

-Би мэргэжлийн ногоочин хүн биш. Манай гэргий мэргэжлийн ногоочин. Өмнөговь аймгийн Хөдөө аж ахуйн сургуулийн жимс ногооны анги төгссөн. Дорноговь аймгийн ногооны чиглэлээр анхны төгсөгчдийн нэг. Илгээлтийн эзнээр “Цагаанцавд” хуваарилагдан ажиллаж байх үедээ ханьтайгаа танилцсан. Тэр цагаас л олон жил хамтдаа ногоо тариалж амьдралын хатуу хөтүү, жаргалтай үеийг туурлсаар явна даа. Үр хүүхэд минь үр тариа шиг ургаж том болсон.

-Олон жил ханьтайгаа хамт хөдөө аж ахуйн салбарт ажиллаж яваа таниарбахархаж байна. Энэ хугацаанд дотроо бодож санаж явсан эрхэм зорилгоо хуваалцна уу?

- Тэгэлгүй явах. Олон жил ажиллахдаа нэг ч удаа шантарч үзээгүй. Зорилгодоо хүрэхийн тулд бүхнийг даван туулах ёстой. 40 гаруй жил ногоо тариалахад олон саад бэрхшээл тулгарна шүү дээ. Шантрахгүй, зогсолтгүй л хөдөлмөрлөсөөр байна. Ногоо тарих шиг сайхан зүйл үгүй. Зорьсон л бол зорилгодоо заавал хүрэх нь миний эрхэм чанар. Үр дүнгээ үзэхийн тулд хөлс дуслуулан ажиллах учиртай. Болохгүй зүйл, чадахгүй юм гэж үгүй шүү дээ. Саад, бэрхшээлийг даван туулах тусам илүү туршлага мэдлэгтэй чадвартай болж үр дүнд хүрнэ гэж боддог. Миний хань бас ижил бодолтой. Бид хамтдаа хөдөлмөрлөж байгаа нь энэ өндөрлөгт хүргэсэн. Одоо манай гэр бүлийнхэн бүгд ногоо тариална. Ач, зээ нар хүртэл ногоо тарих дуртай. Өвөө, эмээдээ их тус болно. Ногоо тарих бол үнэхээр гайхамшиг. Тарьчихсан зүйлээ ургуулах мөч гайхалтай. Хүн цэцэгнээс төрсөн гэж ярьдаг. Хутагтын энергийн нутагт ногоо тарих нь ажил амьдралыг минь тэтгэж байгаа гэж боддог.

-Өндөрлөг гэснээс энэ өндөрлөгт хүрэхэд байнгийн үйлчлүүлэгчид таны нэг шат болсон байх. Аливаа бизнес эрхэлхэд үйлчлүүлэгч гэдэг хамгийн чухал. Нутгийнхан таныг андахгүй юм. Энэ нь бас таны нэг амжилт. Тийм үү?

-Нутгийн түмэн олныхоо хэрэгцээг хангаж, хөдөлмөрлөж байгаа даа үргэлж баярлаж явдаг. Маш зөв асуулт. Манай нутгийнхан намайг сураглаад л ирдэг. Ямар сайндаа манай гэрийнхэнээс авахгүй зөвхөн надаас л тарvas худалдаж авдаг гээд бод л доо. Зөвхөн нутаг гэхгүй би Улаанбаатар хот руу нийлүүлэлт хийдэг. Жишээ нь, Худалдаа хөгжлийн банк, Магнай трейд, Таванбогд компаниуд байнга худалдаж авдаг. Өөр олон хувь хүн бий. Жил бүр тарvas хүлээгээд, намайг сураглаад, надаас л тарvas авдаг хүмүүстээ баярлаж явдаг шүү.

-Таны олон жилийн хөдөлмөрийг төр, засаг, аймаг, сум үнэлж олон шагнал өгч байж ээ. Хамгийн сонирхолтой нь дандаа хос медаль харагдаж байна. Хос медалиар хосоороо энгэрээ мялаалгаж тэр агшин сайхан уу. Хамгийн хүндэтгэлтэй шагналаа дурдана уу?

—Анхны шагнал Эвлэлийн төв хорооны хүндэт үнэмлэх авч байсан. Хамгийн том шагнал бол 1981 онд “Тэргүүний тариаланч залуу” хос алтан медаль авч байсан. Анхны шагнал л хамгийн үнэ цэнтэй байдаг даа. Гэр бүлийн хүнтэйгээ дандаа хос медаль авах тэр мэдрэмж бол үгээр хэлэхээргүй сайхан байдаг. Бид 40 гаруй жил ажиллахдаа аваагүй шагнал гэж алга даа. Үүний дараа говь нутгаас 2016 онд Монгол Улсын тэргүүний тариаланч болж байлаа. Ер нь говьд ногоо тарина гэдэг амаргүй л дээ. Манай аймгий хэмжээнд Улсын тэргүүний тариаланч хоёр л байдаг.

-Манай улсын хувьд хангай нутагт л ногоо, тариа элбэг байдаг. Харин говьд төдийлөн олон тариаланч байхгүй гэдгийг та дээрх хариултаар хэлсэн. Аймгийн хэмжээнд хоёр Улсын тэргүүний тариаланч байдаг гэлээ. Улсын тэргүүний тариаланчийн өөрийн гэсэн арга барил гэж байдаг уу?

- Ургамал, ногоо тариалахад маш их хүч хөдөлмөр шаарддаг. Ногоо ургуулна гэдэг навч ургуулахын нэр биш. Нэг төмснөөс хэдий хэмжээний ургац авахыг тооцоолж 60-70 хувь үржүүлж авахгүй бол төмс тариалсан гэж ярилтгүй. Өдөр бүр ногоочдын ажил өрнөдөг. Зэрлэгийг нь зулгааж, хөрсийг нь сулалж өгдөг. Манай говийн хөрс бол тоосго хийдэг шавар шүү дээ. Тиймээс байнга бордож, торддог. Жил бүр 2-3 га газар ногоо тариалдаг. Сүүлийн жилүүдэд хоёулахнаа болохоор хүч хүрэхгүй байна. Ажиллах боловсон хүчин ч олдохгүй юм. 2004 онд хамгийн их ургац хурааж авч байлаа.

-Газар тариалан эрхэлхэд ямар нэгэн зээлд хамрагдаж байсан уу. Ер нь газар тариалан эрхлэгчдийг төр засгаас ямар бодлогоор дэмждэг вэ?

-Би газар тариалан эрхлэхдээ нэг ч удаа зээл авч байгаагүй. Аймгийн жижиг дундын төслөөс 11 сая төгрөгийн зээл авах гэж хөөцөлдөөд бүтээгүй. Манай аймгийн хувьд газар тариалан хөгжихөд хүндрэлтэй. Мэргэжилтэн, салбарынхан ажлаа мэддэггүй. Аймгийн хэмжээнд 10 гаруй тариаланчид ногоо тарьж байна. Говьд тарвас тарих нь олширч байгаа ч гэсэн хятад сортын тарвас хурдан тариалж, хурдан зарахаа боддог. Би бол тэгдэггүй. Ард түмэнд чанартай бүтээгдэхүүнээр үйлчилж, байнгын хэрэглэгчдийнхээ итгэлийг алдахгүй байхыг хичээж өдөр бүр ажлаа дуртайяа хийдэг шүү дээ. Сугар гуайн тарвас амттай гэж хэлдэг үйлчилүүлэгчдийн итгэл бол миний хөдөлмөрийн үр дүн. Муу бүтээгдэхүүнд хүнд худалдаалж болохгүй гэсэн зарчимтай.

-Өөрийнхөө салбарын холбоо, төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилладаг уу. Газар тариалан эрхлэгчид зарим нь нэгдэж хоршоо байдлаар үйл ажиллагаагаа өргөжүүлдэг болжээ. Энэ тухай юу гэж боддог вэ?

-Мөн Монголын Худалдаа Аж Үйлдвэрлэлийн Дорноговь дахь салбар зөвлөлийн гишүүнээр элссэн. Зөвлөлийн гишүүн байсанаар өөрт тулагмддаг асуудлаа шийдүүлэхийг хүссэн. Хувиараа бизнес эрхлэгчдийг Улаанбаатар хотын үйлдвэрүүд, тариаланчидын газраар аялаж байсан. Сайхан санагдсан. Туршлага судалж, өөрийн бизнест тусгах санааг олж харсан. Яг зөв. Хоршоо болоод хамтараад ногоо тариалвал ажлын бүтээмж их байх болно. Гэвч хүн бүр тус тусдаа өөрсдийн жижиг газраа бага ногоо тариалж байна. Хоршоо байгуулах гээд хэд хэдэн хүмүүст санал тавьж байсан. Тус тусын талбайтай байсан ч гэсэн хамтараад ажиллах хэрэгтэй байгаа юм. Нэг, нэг ногоогоор дагнаж тариалж болно. Нэгдсэн хэмжээнд ургацаа хураагаад цэцэрлэг, хоолны газарт нийлүүлэхэд төр засгаас анхаарч менежмент хийж өгөх хэрэгтэй байгаа юм. Цэцэрлэгт өгч байсан удаа бий.

Гэвч олон татвар суутгал хийгээд ямар ч ашиггүй байсан. Намар болохоор зөвхөн нутгийн ногоочдын ургацыг цэцэрлэгт нийлүүлдэг байхад л болох юм. Аймгийн агорномчин ногоочдын тариаланг шинжээд зохион байгуулалтад оруулаад өгвөл тун зүгээр байна. Ер нь говь нутагт газар тариалан эрхэлдэг цөөн хэдэн хүмүүст дэмжлэг, урамшуулал үзүүлдэг болох хэрэгтэй байна.

-Таны хувьд зөвхөн өөрийн гар дээрээс тарьсан ногоогоо худалддаг онцлогтой. Энэ нь ямар давуу талтай вэ?

-Би бөөндөж худалддаг дургүй. Миний тариалсан тарвасыг өөр тарвастай холиод зарчих магадлалтай. Чанарын хувьд миний тарьж байгаа тарвас Оросын Казкастаны сорт болохоор тээвэрлэлт, хадгалалт сайн даадаг, чихэрлэгээрээ онцлог. Хятадын сорт манай говийн хөрсөнд хурдан болдог. Хурдан болох тусмаа хурдан мууддаг гэсэн үг.

-Цаг үеийн байдал цар тахалаас болоод улс эх орон төдийгүй, дэлхийн эдийн засгийн үзүүлэлт буурч байгаа энэ үед та бүхний бизнест хэрхэн нөлөөлж байна вэ?

-Энэ жил цар тахал гарсантай холбогдуулан үйлчлүүлэгчид бага байлаа. Өглөө эрт ногоогоо зарах гээд зогсоно. Хүн байхгүй. Орой болтол зогсоход цөөн үйлчлүүлэгчид л явж байна. Мөн энэ намар ногоо бага байгаа шалтгаан нь хил хаасан учир дотоодын ногоо гайгүй зарагдаж байгаа юм. Аймагт тариалсан ногоог аймгийн иргэд зорьж авдаг болсон. Энэ жил 300 тонн төмс борлуулсан. Сэлэнгийн тарвас гэж өмнө нь зарагдаж байсан бол энэ жил нэг ч байсангүй. Учир нь Сэлэнгэ нэрээр Хятад тарвас зарж байгаа нь ажиглагдсан. Ногоочид нь өөрсдийн тариалсан ногоогоо худалдах гэхээр ченж нартай нэг дор зогсож байгаа нь бидний борлуулалтад нөлөөлж байна.

-Хятадаас хүнсний ногоо орж ирэхгүй байгаа нь дотоодын газар тариалан эрхлэгчдэд ашигтай байх гэж хараад байна. Энэ талаасаа цар тахал та бүхний бизнест нэг талаасаа давуу тал болсон уу?

-Өнгөрсөн жилүүдэд сумдаар явж зардаг байсан бол энэ жил сумдаар явахгүй Сайншанд хотын төвд худалдаалсан.Тэр талаараа ашигтай байлгүй яахав. Учир нь өөр аймгийн ногоо бага, мөн хятадаас ногоо орж ирээгүй. Тэгэхээр зөвхөн аймгийн тариаланчдын ногоо илүү их хувь борлуулагдсан. Гэхдээ л эдийн засгийн нөхцөл байдлаас хамаараад иргэдийн худалдан авалт бага байлаа. Бид ч гэсэн энэ жил бага ногоо тариалсан.

-Энэ жил бага ногоо тариаллаа гэсэн өнгөрсөн жилүүдэд хэдэн га талбайд тариалдаг байсан бэ. Ер нь хэд орчим төгрөг танай бизнест эргэлддэг вэ?

-Бид хоёр олон жилийн туршлагаар өөрсдийн гэсэн арга барилаар тарвас тариалж байна. Нэг га талбайд 10 гаруй сая төгрөгөөр ногоо тариалж намар нэг дахин нэмсэн ашиг авдаг даа. Ажил их шүү дээ. Байгалиас өрсөж ажлаа хийнэ гэдэг хүнд. Үүрийн гэгэнээр ажилдаа гараад үдшийн бүрийгээр л гэртээ орно доо. Ногоо тариалж байгаа хугацаанд салхи, шороо бага байж, үер ус, мөндөр буухгүй бол тун давгүй. Салхинаас хамгаалж мод тариад л байдаг. Нэмэргүй. Говьд газар тариалан эрхэлж байгаа ногоочдын усны асуудлыг шийдэж өгмөөр байгаа юм. Би 3000 гаруй мод тарьсан. Цөлжилт байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд маш их мод тарьдаг. Гэвч аймаг, сумаас дэмжлэг бага. Усны төлбөрийг чөлөөлж өгдөг бол сайхан байна. Цаашид хэчнээн ч мод тарих боломжтой шүү дээ. Хамгийн гол нь говийн нөхцөлд усны асуудлыг шийдэж өгөөсэй гэж бодож явдаг. Миний

хувиараа худаг гаргаад 10 орчим жил болж байна. Үүнээс хойш миний амьдрал ахуй дээшилсэн. Зоорь барьсан, байшинтай болчихлоо. Таван га газартай. Ногоо тарих нь эв, ухаан, туршлага шаарддаг ажил. 40 гаруй жил ногоо тариалах хугацаанд нэг ч жил завсардаагүй ажилласан. Өвөл амардаг. Хавар дөрвөн сард ажилд гарна. Бидэнд наадам үзэх зав байхгүй. Амрах ямар ч эрхгүй шүү дээ.

“

**Энэ жил цар тахал гарсантай
холбогдуулан үйлчлүүлэгчид
бага байлаа. Өглөө эрт ногоогоо
зарах гээд зогсоно. Хүн байхгүй.
Орой болтол зогсоход цөөн
үйлчлүүлэгчид л явж байна.**

”



Б.Занданхүү

/Хятадын төв телевиз CCTV-д Монгол улсаас ажиллаж буй мэргэжилтэн/ Монгол улсын Боловсролын их сургууль, Өвөрмонголын Багийн их сургууль төгссөн. 1996-2000 онд хайрын "Хонгорзул", мэдээллийн "Алаг хорвоо" сонины нэгдсэн редакцид сурвалжлагч, 2000-2002 онд Монголын үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн Дотоод мэдээллийн редакцид сурвалжлагч, 2000-2004 онд тус агентлагийн Засгийн газар хариуцсан сурвалжлагч, 2004-2008 онд "МОНЦАМЭ-гийн мэдээ" сонин, сэтгүүлийн эрхлэгч, 2008-2010 онд "Монгол" телевизийн Мэдээний албаны дарга, 2010-2011 онд МОНЦАМЭ агентлагийн Теле студийн найруулагч, 2011-2015 онд МОНЦАМЭ агентлагийн ӨМӨЗО-ны төв Хөхот дахь төлөөлөгч,

2015-2018 онд МОНЦАМЭ агентлагийн Гадаад сурталчилгааны студийн найруулагч, 2018 оны 7-р сараас Хятадын төв телевиз /CCTV/-д мэргэжилтнээр ажиллаж байна.

Хятадын төв телевиз CCTV

**ДААТГАЛГҮЙ ИРЭЭДҮЙГ ЭРСДЭЛГҮЙ
ТУУЛАХ БОЛОМЖ**

Хэлж ирээгүй тахлын сүүдэрт хийсчихэлгүй үлдэхээр чармайж байгаа бизнесийн салбарынхныг бодохоор хүрэл зүрх хайлна. Дэлхий нийт цар тахлын шоконд орохтой зэрэгцэн үйлдвэрлэл үйлчилгээний олон салбар гэнэт зогтуссан билээ. Хурдтай урагшилж байсан аварга биетүүдийн зарим нь гэнэтийн тоормозонд массаа дийлэхгүй шууд унаж, уналт нь үхлээр төгсөж байхад нөгөө хэсэг нь уналтаа удаашруулах гэж чармайн, чиглэлээ өөрчлөх зэргээр оролдож, харин нэг хэсэг нь эмнэлгийн орон дээр гэмтэл бэртлээ тоочиж, сэхээн амьдруулахад төрийн сүлдэндээ залбиран хэвтэж байна.

Дэлхий нийтийг хамарсан өвчин тахал, осол гамшиг гэхчилэн гэнэтийн өөрчлөлтүүд нь хүн төрөлхтөнийг амьдралын шинэ хэв маягтай болгож байгаа ч амьдрал үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Харин бизнесийн салбарын стратегичид шинэ гарц, боломжийг уйгагүй хайж, судалгаанд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсаны дүнд шинэ үеийн бизнес нь үйлдвэрлэлээс үйлчилгээ рүү илүү хэлбийх бөгөөд технологид түшиглэсэн цахим хэлбэртэй байна гэсэн урьдач дүгнэлт гаргажээ. Үнэхээр ч цар тахлын үеэр кино үйлдвэрлэгчид сул зогсож, кинотеатрууд үүдээ барьсан ч кино үзэлт урьд өмнө түүхэндээ байгаагагүйгээр нэмэгдсэн бөгөөд үүнээс хожигсод нь онлайн кино, тоглоомын сайтууд байв. Мөн хүргэлтийн үйлчилгээ, цахим дэлгүүрийн олз ашиг мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Эдгээр нь цаашдаа удам өргөжиж ирээдүйн амьдралын хэлбэр болох нь ч тодорхой харагдав. Ганц жишээ дурдахад зөвхөн энэ жилийн 1-7-р сарын хугацаанд л гэхэд Хятадад онлайнгаар нийт 6 078 500 000 000 юанийн бараа бүтээгдэхүүн борлуулжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс

0,9 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Хятадын энэ салбарын өсөлт 2013 оноос хойш тогтмол нэмэгдсээр сүүлийн жилүүдэд тэдний өмнө гишгэх улс орон гарсангүй. 2020 онд 50 тэрбум хүргэлт тоологдож. Өнгөрөгч онд тус улсын түргэн хүргэлтийн орлого 700 тэрбумыг давж байв.

Далай шиг энэ уудам зах зээлтэй хаяа залгаа манай улс үйлдвэрлэлээ больё гэхэд үйлчилгээг нь дагалдан хөгжүүлж зуучлах эдийн засгийн хөгжлийн шинэ гарц хайж болмоор. Дэлхий нийтийн эдийн засгийн хямралыг ажиглахад манайх шиг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар нь төдийлөн хөгжөөгүй, ашигт малтмал, түүхий эд ханган нийлүүлэгч улсуудын хувьд илүү хүндхэн тусах нь машид тодорхой бөгөөд хөдөлмөрийн зах зээлээ аварч үлдэхийн тулд хөрвөх чадвар, шинэ нөхцөл боломжийг эрэлхийлэх нь эн тэргүүний зорилт болоод байна. Гэтэл тархи зүрх нь тасралтгүй ажиллаж байх ёстой Засгийн газар нь бэлэн мөнгө тарааж, сонгуульдаж, бизнесийн салбарынхан дотуур цус алдаж, МҮХАҮТ гэх ганц байгууллага л нойргүй хонож байх жишээний. Эдгээрийг үл дурдан, хямдралын энэ цаг үед Хятад улсад ажиллаж амьдарч байгаагийн хувьд тэдний эдийн засгаа аврах чиглэлээр хийж буй зарим онцлог арга хэлбэрүүдээс танилцуулахыг зорилоо. Авах хүнд алт нь биш арга нь сонин байх болов уу гэж мунхаглав.

Хятад улс цар тахлын дараах бизнес эрхлэлтийг дэмжихэд зориулж 120 тэрбум ам.долларын нэмэлт төсөв баталсан нь энэ салбарынхныг эрхбиш уужуу амьсгаа авахуулаад байгаа юм. Японы 1,1 их наяд, Америкийн 350 тэрбум доллартай харьцуулахад бага ч, төрийн дэмжлэгт дулдуйдаж том жижиг асуудлаа саадгүй зохицуулдаг хятадын эдийн засгийн хөдөлгөгч хүч болох томоохон бизнесүүдэд энэ бол чамлахааргүй тоо. Мөнгөний хувьд ийм. Харин бодлогын хувьд төр болоод хувийн хэвшил нь эгээ л социализмынхаа уриа шиг нэгдмэл хүчээр уухайлан зүтгэж байгаа нь хүнд цаг үеийг хөнгөнөө байг гэхэд хүнд гарз багатай туулах найдварыг төрүүлж байгаа юм. Хятадын сангийн яамны хамгийн сүүлийн үеийн мэдээллээс харахад 8-р сард Хятадын орон нутгийн засаг захиргааны бондод 199.7 тэрбум юань гаргасан нь 7-р сараас 927.5 тэрбум юаниар өсч, 5-р сард гаргасан хэмжээ 1 их наяд юанийг давжээ. Сангийн яамнаас мөн 10-р сарын сүүлчээр шинэ тусгай бонд гаргахыг шавдуулж байгаагаас харахад 9-р сард тусгай бондын цар хүрээ томорсон хэвээр тул хөрөнгийн хүртээмж хурдацтай явагджээ.

Хятад улс цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулахад макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, дотоодын зах зээлийг сэргээх бодлогын арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлж байгаа юм. Дээр дурдсан Засгийн газрын болон орон нутгийн бонд гаргахаас гадна хувь хүний орлогын албан татварыг бууруулах, нийгмийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх, мөнгөний уян хатан бодлого хэрэгжүүлэх, тусгайлсан зээлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор зээлийн хүүг бууруулж, үйлдвэрлэлийн зээл олгох, гадаадын компаниудыг хөнгөлөлтийн бодлогоор дэмжиж зэрэг арга хэмжээг шат дараалан авч байна.

Хятадын эдийн засгийн мэргэжилтнүүд энэхүү арга хэмжээг үр дүнтэй болно гэдэгт бат итгэлтэй байгаагийнхаа үндэслэлийг Хятадын дотоодын хэрэглээний зах зээл, үйлдвэрлэлийн хүчин чадалтайгаа холбон тайлбарлаж байгаа билээ. Тус улсын эдийн засгийн 2020 оны сүүлийн гурван улирлын үзүүлэлт 2019 оны мөн үеийн өсөлтийн түвшинд байвал 2020 оны жилийн өсөлт 3-3.5 хувь байх болно. Гэхдээ

энэ таамаглал нь ажил эрхлэлт хэвийн байх нөхцөлд суурилж байгааг анхаарах хэрэгтэй. Хятад улс макро эдийн засгийн бодлогоос илүүтэйгээр хөдөлмөрийн зах зээлийн хэвийн харьцлыг хангах гэж чармайж байгаа юм. Хямралаас болж ажлаа алдаж байгаа иргэдийг бусад салбарт хөрвүүлэн шингээх, шинэ ажлын байр гаргах талаар онцгойлон анхаарч байгаа нь хөдөлмөр алдалттай холбоотой нийгмийн хямрал үүсгэхгүйн төлөө. Тухайлбал, цар тахлын ид дэгдэлтийн үед бүрэн зогсолтод орсон нийтийн хоолны салбарын ажилчдыг хүнсний сүлжээ их дэлгүүрийн хүргэлт, бэлтгэлийн ажилд нэмэлт хүч болгон дайчлах зэргээр хөдөлмөрийн хуваарилалт хийж байв. Хөл хорионы онЦ байдал зарлагдсан тухайн үед хүнсний сүлжээ их дэлгүүрүүдийн ачаалал хэт ихэссэн билээ.

Олон улсын валютын сангийн урьдчилсан прогнозоор 2020 онд дэлхийн эдийн засаг гурван хувиар буурах бол БНХАУ-ын эдийн засаг 1,2 хувиар өсөж, 2021 онд Хятадын эдийн засаг 9.2 хувийн өсөлттэй байна гэжээ. Гэхдээ энэ таамаглалыг дэвшүүлэхдээ 2020 оны сүүлийн хагаст цар тахлыг бүрэн хяналтдаа оруулсан тохиолдолд биелэгдэнэ гэдгийг онцолсон байна.

“Ковид-19”-ын үеэр бусад улсууд БНХАУ-аас хөрөнгө оруулалтаа татаж үйлдвэрлэлээ нүүлгэх үзэгдэл байгаа ч энэ нь тэдэнд ихээхэн эрсдэлтэй бөгөөд тухайн үйлдвэрлэлийн салбарт Хятадыг харьцуулах хэмжээний том зах зээл, таатай хэрэглэгч олоход нэн бэрх гэдэг нь ойлгомжтой билээ. Цар тахал хэдий хугацаанд үргэлжлэхийг таах арга алга. Ийм үед Хятад улс үйлдвэрлэлээ түргэн сэргээж, өвчнийг хазаарлаж чадсан нь мөн худалдаа үйлчилгээний таатай хөрс болж чадсан. Нэг үгээр хэлэхэд Хятадууд тус өвчнийг хэдийнэ танилцаад, энэ нөхцөлд ажиллаж амьдраад сурчихлаа. Дэлхий нийт үйлчилгээний бизнес рүү хошуурч байгаа энэ цаг үед үйлдвэрлэлийн хамгийн том бааз болох Хятад улс хэрэглээний зах зээлд хүндтэй хэвээр байх нь дамшиггүй л болов уу.

“Цар тахлын нөлөөллөөс үүссэн олон тодорхойгүй хүчин зүйлс дунд тодорхой харагдаж буй нэг зүйл бол БНХАУ, АНУ-ын хоорондох зөрчил өрсөлдөөн юм. Энэхүү зөрчил нь дэлхийн улс орнуудын улс төр, эдийн засгийн бодлогод илүү их сорилтыг авчрахаар байна. Ардчиллын жишиг болсон АНУ, Баруун Европын улсууд “Ковид-19” тархаж эхлэх үед гаргасан хандлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, арьс өнгөөр ялгаварлах үзэл нь тэдний эрхэмлэн тунхагладаг үнэт зүйлтэй харшилж байсан бол нөгөө талд Азийн улс орнууд халдварын тархалтын үеэр нийтийн эрх ашгийг хүндэтгэх үзэл, соёл ёс суртахуун, сахилга батаараа ялгарч бодлого арга хэмжээ нь үр дүнтэй байлаа. “Ковид-19” гарахын өмнө Хятадын зарим судлаачид, барууны улсуудад олон зуун жил байсан технологийн давуу тал, эдийн засаг хөгжлийн чадамж Ази тив рүү шилжих үйл явц явагдаж “Азийн эрин” ирж байгаа талаар санал бодол байр сууриа илэрхийлж байв. Харин “Ковид-19”-тэй холбоотой гарсан арьс өнгөний үзэл нь зөвхөн Хятад хүмүүс гэлтгүй нийт ази хүмүүст чиглэсэн хандлагатай байсан нь Азийн улс үндэстнүүдийн сэтгэл зүйд барууны орнуудад итгэх итгэлд тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлсөн ба ардчиллын зөөлөн хүчинд халтай энэхүү үйл явдал нэг талаараа Азид өөрийн онцлогоор хөгжиж буй БНХАУ-д ашигтай байж ч болох юм” хэмээн Монгол улсын ШУА-ын Олон улсын харилцааны хүрээлэнгээс гаргасан “Ковид-19: Олон улсын нөхцөл байдал, сорилт, үр дагавар, хандлага” тайланд дурджээ.

Цаашид “Ковид-19” глобалчлалд сөргөөр нөлөөлж, дэлхийн олон улс дотооддоо үйлдвэрлэлээ татах хандлагатай байгааг “Гадаад харилцаа ба олон улс улсын тинк танк байгууллага”-ын (Charhar Institute) судлаач Ван Чун (王冲) анхааруулж байна. Энэ тохиолдолд Монгол улс яах вэ, юу хийх ёстой вэ гэдгийг бодож тунгааж, төлөвлөж төсөвлөж байх ёстой цаг үед МҮХАҮТ энэхүү нийтлэлийн уралдааныг



зарлаж сэтгүүлчдийн мэдээллийг нэгтгэн дүгнэх оролдлого хийж байгаа нь талархууштай. Дэлхий нийт даяаршлаас дангааршил руу буцах үйл явцыг Ковид-19 хэмээх энэхүү цар тахал улам хурдасгаж байгаа нь булзашгүй үнэн билээ.


MN.CCTV.COM
 @cctvmongol - Media/News Company

Home Videos Photos About More

Like Comment Share

MN.CCTV.COM
 September 27 at 11:21 AM

Дэлхий нийт даяаршлаас дангааршил руу буцах үйл явцыг Ковид-19 хэмээх энэхүү цар тахал улам хурдасгаж байгаа нь булзашгүй үнэн билээ.



MN.CCTV.COM
ДААТГАЛГҮЙ ИРЭЭДҮЙГ ЭРСДЭЛГҮЙ ТУУЛАХ БОЛОМЖ
 МҮХАҮТ-ын “Цар тахлын дараах бизнесийн орчин: Боломж ба сорилт” сэдвэт нийтлэлийн...

Like Comment Share

Хэл: Монгол | English 中文简体 中文繁體


央视网 蒙古网

Эхлэл Мэдээ Видео Нэвтрүүлэг

CCTV.com Монгол - Нийтлэл

ДААТГАЛГҮЙ ИРЭЭДҮЙГ ЭРСДЭЛГҮЙ ТУУЛАХ БОЛОМЖ

09-27-2020 11:11



МҮХАҮТ-ын “Цар тахлын дараах бизнесийн орчин: Боломж ба сорилт” сэдвэт нийтлэлийн уралдаанд зориулав

Хэлж ирээгүй талын сүүдэрт хийсчиглүү үлдэхээр чармайлж байгаа бизнесийн салбарыг бодохор хурал зурх хайлна. Дэлхий нийт цар тахлын шоконд орохтой зэрэгцэн үйлдвэрлэл үйлчилгээний олон салбар гэнэт зогтуссан билээ. Хурдтай уралшилж байсан аварга биетүүдийн зарим нь гэнэтийн тоормоонд маасса дийлэхгүй шууд унаж, уналт нь уулзур төгсөж байхад нөгөө хэсэг нь уналтаа удаашруулах гэж чармайлч, чиглэлээ өөрчлөж зургуур оролдож, зарим нэг хэсэг нь замныг өөрчлөж дээр дээр гэмтэл бүртгээ тоочиж, сэтгэн амьдрүүлэхэд төрийн сүлдэндээ залбирал хөтөж байна.

Шинэ мэдээ	Шинэ видео
1 Арван сарын эцсий дотоо хонгийн бүх нийтийн авралт	Шинэ видео
2 Элбэг хураалтын баяр	
3 Дашин нисэх буудлаар 10 сая зорчигч үйлчлүүлээ	
4 Шя Жиньин НҮБ байгууллагданы 75 жилийн ойн дэвд уралтлага үзэглээ	
5 НҮБ-ын төв байрар зочлорой	
6 Цаа бутын тоо толгой нэмэгдээр байна	
7 Ри-Лан худны зам удахгүй ашиглалтад	

Энэхүү нийтлэл нь Хятадын төв телевиз ССТВ-гийн www.mn.cctv.com сайт болон, тус байгууллагын монгол хэлээрх фэйсбүүк хуудсанд тавигдсан болно.



Маналжав овогтой Төгөлдөр

2012 онд КУДС-ийг “Радио, телевизийн сэтгүүлч” мэргэжлээр төгссөн.

2012 онд Дорнод аймгийн “ТВ-6” телевизээс ажлын гараагаа эхлүүлсэн.

2012-2014 онд “ТВ-6” телевизийн сэтгүүлч,

2014-2015 онд БОАЖЯ-ны харъяа “Буйр нуур-Халх голын сав газрын захиргаа”-нд олон нийт хариуцсан мэргэжилтэн,

2019 онд “ТВ-8” телевизийн нэвтрүүлгийн албанд сэтгүүлч, редактор

2020 оны 9 сараас эхлэн “Зариг.мн” сайтад сэтгүүлчээр ажиллаж байна.

Зариг.мн

“ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН ОРЧИН: “БОЛОМЖ БА СОРИЛТ”

ОУ-ын судалгааны байгууллагууд энэ жил дэлхийн эдийн засагт олон эерэг өөрчлөлтүүд гарч, дэлхий нийтийг хамарсан аж үйлдвэрийн уналт зогсох хандлагатай болно гэж үзэж байсан. Тухайлбал өнгөрсөн онд 2.9 хувийн өсөлттэй байсан дэлхийн эдийн засагт энд онд 3.3 хувийн өсөлт үзүүлнэ гэж төсөөлж байсан юм. Дэлхийн эдийн засагт үүсч болох эрсдэлийг ОУ-ын судалгааны байгууллагууд их гүрнүүдийн худалдааны тарифын маргаан болон геополитикийн шилжилт байж болох ч, эдийн засгийн өсөлт тогтворжиж, тэр дундаа эдийн засгийн гол хөдөлгүүр нь, Ази тив рүү чиглэхийг дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрч байсан. Гэтэл өнгөрсөн оны сүүлээр БНХАУ-ын Хубэй мужийн Вүхань хотод гарсан шинэ төрлийн Корона вирусийн тархалтаас болж дэлхийн эдийн засаг төсөөлж байснаас буурсан. Учир нь давагдашгүй хүчин зүйл болох байгалийн аливаа гамшиг нь дуусах хугацаа, гарч болох эрсдэл, түүнээс учирсан хохиролыг тооцож болохуйц байдаг бол энэ удаагийн COVID-19 вирусийн тархалтын зогсох хугацаа болон эдийн засагт учирч болох хохиролыг тооцох ямар ч боломжгүй, цаашид хэр зэрэг удаан үргэлжилж, дэлхийн эдийн засагт ямар хэмжээний хохирол үзүүлэх нь, өнөөдрийг хүртэл тодорхойгүй байсаар байгаа юм.

Бид ойрын ирээдүйд юу болох тухай гэхээсээ илүү маргааш юу болохыг ч төсөөлж, тааварлашгүй цаг үед амьдарч байна. “Дэлхийн эдийн засгийн 50 дахь чуулган” 1 сарын 22-23нд Швейцарын Давос хотод болоход дэлхийн 50 гаруй улс орнуудын төрийн тэргүүнүүд, дэлхийн эдийн засагт нөлөө бүхий компаниудын

2000 орчим төлөөлөгчид чуулахдаа уг вирусийн тархалт дэлхийн эдийн засагт эрсдэл үүсгэж болзошгүй тухайд хэн ч анхаарлаа хандуулаагүй байдаг. Гэтэл өнөөдөр энэ нь бүс нутгийн асуудал байхаа больж нөхцөл байдал маш хурдацтай өөрчлөгдөж, уг вирус дэлхийн бүх оронд тархаж ДЭМБ-аас COVID-19 вирусийн тархалтыг “Пандемик” буюу “Цар тахал” гэж зарласан. Судлаачдын үзэж байгаагаар энэхүү цар тахлаас үүссэн эдийн засгийн уналт нь 2008 оны санхүүгийн хямралаас үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан уналтаас ч их байх болно гэж үзсээр байгаа. Анх 1918 оны 1 дүгээр сараас 1920 оны 12 дугаар сар хүртэл бараг 3 жил үргэлжилсэн “Spanish flu” буюу Испани ханиад нь дэлхийн хүн амын дөрөвний нэгийг буюу 500 сая хүнийг халдварлуулж, 50 сая хүний амийг авч одсон байдаг. Зарим судлаачид хүн амын эрүүл мэнд амь насанд заналхийлсэн тархалтын хурд өндөртэй COVID-19 вирус буюу үүссэн нөхцөл байдлыг 100 жилийн давтамжтайгаар болж байна гэж дүгнэсэн нь бий. 100 жилийн өмнөх энэхүү тахлын дараагаар дэлхийн улс орнуудын эдийн засаг эрчимтэй унаж 1929 оны “Great depration” буюу их уналттай залгаж байсныг хүн төрөлхтөний шинэ түүх ийн гэрчилж байна. Түүгээр ч зогсохгүй маш олон бэрхшээлтэй нэгэн зэрэг нүүр тулж байгаагүй юм байна гэдгийг олон улс орнуудын удирдагчид, шийдвэр гаргагчид хүлээн зөвшөөрсөн. Харин эдийн засагч, судлаачид эдийн засгийн энэхүү уналтыг “Дипрэшиний цуурай сонсогдож байна, энэ бол «Хар хун» гэх үзэгдэл юм” гэж анхааруулж байсан.

Ийнхүү дэлхий нийт нэг том гүрнээс ихээхэн хамааралтай байснаа ч ухаарч, олж харж чадлаа. БНХАУ-ын эдийн засаг саарч, импортоо хумьсан нь дэлхийн зах зээл дээрхи эрдэс бүтээгдэхүүний үнэ унаж, хөрөнгийн зах зээл савалгаанд ороход хамгийн том нөлөө үзүүлсэн юм. Дэлхийн том улс орнуудын эдийн засаг хүн ам ихтэй, худалдан авах чадвар сайтай байдгаас үүдэн тэр болгон шоконд автдаггүй. Нэг үгээр хэлвэл гадаад орчноос харьцангуй бага хамаардаг учир энэ шуурганд төдийлөн хохирол амсаагүй байж болох ч гадаад хүчин зүйлээс шууд хамааралтай манайх шиг нээлттэй, жижиг эдийн засагтай улсад ихээхэн хүнд тусч байгаа. Бид үүнийг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнүүд болон бензин, машин механизм, эм тариа гэх мэт ихэнхи бараа бүтээгдэхүүнийг гаднаас импортолдоогоос харж болно. Харин цөөн тооны бүтээгдэхүүн болох нүүрс, зэс зэрэг уул уурхай, эрдсийн бүтээгдэхүүнийг экспортлодог тулдаа төсвөө бүрдүүлсэн болоод явж байна.

Манай улс энэ жил эдийн засгийн өсөлтөө 6 хувьтай байхаар өөдрөгөөр төсөөлж төсвийн орлогыг өмнөх оноос 16.6 хувиар өснө гэж анх тооцож байсан. Сангийн яам төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болох эрсдэлийг “Эрдэс бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл байх болно” хэмээн үзэж дэлхийн зах зээл дээрхи нүүрс, зэсийн үнийг унах байдлаар, төмрийн хүдэр болон алтны үнийг өсөх байдлаар төсөөлж, тогтворжуулалтын санд 125 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон. Төсвийн орлогыг 12,3 их наядаар /тэнцвэржүүлсэн орлого 11,8 их наяд/ төсвийн зарлагыг 13,9 их наяд төгрөг байхаар баталсан. Гэтэл уг вирусээс болж экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ буурахад хүрч, нүүрсний экспорт хэсэг хугацаанд зогсож, өнөөдөр төсвийн алдагдал 5 их наядад хүрчихээд байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө тасалдана гэдэг нь эдийн засагт тулгарах хамгийн том эрсдэл. Гэтэл бид сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг үргэлж 2 орчим их наяд төгрөгөөр давуулан баталсаар ирсэн. Харин эдийн засагчид төсвийг зоригтойгоор танах тухай вирусийн тархалт эхэлсэн цагаас эхлэн хэлж, ярьсаар байсан ч ЗГ үүнд

арга хэмжээ авалгүй удсаар төсөвт энэ сард тодотгол хийхдээ илүү хохиролтой тодотголыг хийсэн байдаг. Энэ бүгд нь улс төрийн оноо авах гэсэн, сонгуульд зориулсан үйл явц байсан нь тодорхой харагддаг.

Энэ хугацаанд Засгийн газраас авсан арга хэмжээнүүдийг бүхэлд нь харах юм бол эдийн засгийг эрчимжүүлэх гэхээс илүү эдийн засгийг хамгаалахад чиглэгдэж байсан нь харагддаг. Хэдийгээр маш эртнээс хөл хорио тогтоож эхэлсэний үр дүнд вирусийн голомтоос буюу хөрш улсаасаа уг вирусийг орж ирүүлэхгүй байж чадсан ч, бусад орноос зөөвөрлөгдөн орж ирсээр байгаа. Энэ хугацаанд эрүүл мэндээ аврах гэж хичээхдээ эдийн засгаа орхигдуулсан нь нууц биш. Сангийн сайд нь маш олон удаа төсөвт тодотгол хийх шаардлагагүй, бидэнд даваад гарах нөөц бий гэж байсан ч хэлж байсан V хэлбэрийн огцом уналт, сэргэлт нь ёроол нь үл мэдэгдэх түвшинд хүрсэн байна.

МУ-ын эдийн засаг сүүлийн 10 жилийн хугацаанд 3 удаа хямарсан талаар ОУВС тодорхойлсон байдаг. 2008 онд дэлхийн эдийн засгийн хямрал, 2013-2014 оны дэлхийн зах зээл дээрхи түүхий эдийн үнийн уналт, 2016 оны төсвийн хямрал зэргийн нөлөөгөөр хямарч байсан түүх бидэнд бий. Эндээс анхаарч үзвэл сонгуулийн жилд төсвийн хямралд өртдөг мөчлөг харагдаж байна. Харин энэ удаад төсвийн хямрал дээр вирусээс үүдсэн эдийн засгийн уналт нэмэгдэж байгаа нь ирээдүйд хүндхэн жилүүд биднийг угтаж байгааг илтгэж байна.

Энэ хугацаанд хөл хорио тогтоосны улмаас эдийн засагт маш өндөр эрсдэл үүсэж байгааг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, “Stimulus package/bill” буюу “Эдийн засгийг дэмжих багц” гэх төлөвлөгөө гарган хөдөлмөрийн болон санхүүгийнхээ зах зээлээ хамгаалах, үйлдвэрлэл үйлчилгээний газруудаа болон ЖДҮ эрхлэгчдээ хохирол багатайгаар даван туулахад нь туслах маш олон төрлийн арга хэмжээнүүдийг дэс дараатай, хурдтайгаар авч хэрэгжүүлж байсан юм. Дэлхийн эдийн засгийг тодорхойлогч том гүрнүүд ДНБ-хээ 10 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг эхний ээлжинд гаргасан. Үүнд АНУ, Англи, Япон, Өмнөд Солонгос гээд олон улс орон энэ арга хэмжээг хурдацтай хэрэгжүүлсэн. АНУ 2 их наяд долларыг зах зээл дээр гаргахаар төлөвлөж, Парламентийн дээд танхим нь баталж, иргэдийн гар дээр шууд очих зарчимтайгаар нэг удаа бүх иргэддээ 1200 доллар, хүүхдэд 500 доллар, 500 тэрбум долларыг томоохон компаниудад, 367 тэрбум долларыг жижиг бизнес эрхлэгчдэд зээл хэлбэрээр өгсөн. Ажлаа алдсан хүмүүст мөнгө өгөхөөс өөр арга зам бидэнд үлдсэнгүй гэдгийг нөлөө бүхий улс төрчид нь удаа дараа мэдэгдэж байсан юм.

Гэтэл манай улсын хувьд хөл хорио тогтоож эхэлсэн цагаас л эдийн засагчид авч болох арга хэмжээнүүдийн тухай ЗГ-т санал болгож байсан ч авч хэлэлцэлгүй явсаар дээрхитэй ижил арга хэмжээнүүдийг удаашралтайгаар авч хэрэгжүүлсэн байдаг. Тухайн үед МХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин хөл хорио тогтоосны улмаас 260 мянган хүн ажлын байраа алдаж, 25 мянган аж ахуйн нэгжүүд дампуурч хаалгаа барих дээрээ тулж байгааг анхааруулж, сануулсаар байсныг энд дурьдах нь зүйтэй. Бид тэгвэл нэгэнт бий болсон эдийн засгийн уналтаас 3 үе шаттайгаар давж гарах төлөвлөгөө боловсруулж болно. Урт болон дунд хугацаанд бодлогын хүүг шат дараатай бууруулах, дунд болон богино хугацаанд ХАА-н үйлдвэрлэл түүний дотор, газар тариалан эрхлэгчдийг бодитой дэмжих, богино хугацаандаа ажиллах хүчээ нэмэгдүүлэх, одоо байгаа хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах арга

хэмжээг авах хэрэгтэй. Хөл хорионы үед ЗГ-аас эдийн засгийг эрчимжүүлэх талаар авсан арга хэмжээнүүд нь төдийлөн оновчтой зөв байсангүй.

300 тэрбум төгрөгийг 3%-ийн хүүтэйгээр ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд олгож тэд малчдын гар дээрээс нэг кг ноолуурыг 100 мянган төгрөгөөр заавал худалдаж авах тухай ЗГ мэдэгдсэн. Малчдаас гадна тариалан эрхлэгчдээ дэмжих зорилгоор бас л 150 тэрбум төгрөгийг 3-5%-ийн хүүтэйгээр олгоно гэж 4 дүгээр сарын 2-ны өдөр харьяа яамны сайд нь мэдэгдсэн байдаг. Энэ мөнгө болон ХАА-г дэмжих сан, тариалан эрхлэгчдийг дэмжих сангийн мөнгө, ХХАХҮЯ-н дээр байгаа 25 сая долларын өртөгтэй 9.9 мянган га талбайг услах усалгааны систем болон 10 сая евро долларын үнэ өртөг бүхий газар тариалангийн тоног төхөөрөмжтэй гээд бодит дэмжлэг болж чадах боломж байсан ч амжилтыг эс олсон.

Тэгвэл бидэнд өнөөдөр дотоодын үйлвэрлэл, газар тариалангийн үйлвэрлэлээ цаг алдахгүй дэмжихээс өөр аргагүй байдал бий болсон байна. Бид мах, гурилтайгаа байхад хүнсний хомсдолд орохгүй тухай бүгд ярьдаг. Гэтэл өнөөдөр хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, төрийн дэмжлэг ямар байгаа тухай ярих цаг нь болсон байна. Газар тариалангийн салбар хүнсний хэрэгцээг хангадаг хамгийн чухал салбар. Манай улсын төсвийн орлогын гуравны нэгийг дангаараа бүрдүүлдэг уул уурхайн салбар биднээс үл шалтгаалан уналтанд орж, төсөв тасалдаж байгааг өнөөдрийн нөхцөл байдлаас бид харж, мэдэрч байна. Тиймээс дан ганц уул уурхай гэлтгүй ХАА-н салбараа тэр тусмаа газар тариалангийн салбараа өөд татахаас өөр аргагүй байдалд орчихлоо. Өнөөдрийн байдлаар манай улс газар тариалангийн хэлбэрээр ашиглаж болох 1.3 сая га газартай байна. Үүнийхээ 840.0 га газрыг буюу 65%-ийг газар тариаланд ашиглаж байгаа гэсэн судалгаа байдаг. Өнгөрсөн онд нэгэн жарныг туулсан газар тариалангийн салбарын түүхийг өгүүлэх “Атар газар эзэмшсэний 60 жилийн ой” тохиосон. Харин үүний дараа буюу улсын төсөв батлагдсанаас хойш МУ-ын Ерөнхий Сайд “Атар-4” аяныг зарлаж байгаагаа мэдэгдсэн. Гэтэл төсөвт уг аяныг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ямар нэгэн нэмэгдэл зардал төсөвлөгдөөгүй гэж ойлгогдож байгаа. Манай улсын жилийн нийт гурилын хэрэгцээнд 350.0 тн улаан буудай шаардлагатай гэж үздэг. Өнгөрсөн оны хувьд 410.0 тн улаанбуудай хурааж авснаас 65-70 хувь нь гурил үйлдвэрлэлд, үлдсэн нь спирт рүү шилжсэн байна. ААН-үүд дараа оныхоо үрийг нөөцөлж, тэжээл рүү мөн бага хэмжээгээр шилжсэн гэж үзвэл энэ тооцоогоор харахад гурил үйлдвэрлэлд 247.0 тн хүнсний улаанбуудай нийлүүлэгдсэн байх юм. Тиймээс 55-60 орчим мянган тонн улаанбуудай дутна гэж үзэж оны төгсгөлд гурил үйлдвэрлэгчдийн дунд сонгон шалгаруулалт явуулж 60.0 тн улаан буудайг импортлох шийдвэр ч гарч байсан.

ХХААХҮЯамны газрын дарга нь энэ жил бид 360.0 га талбайд тариалах тухайгаа мэдэгдсэн байдаг. Ингэхдээ “25 сая ам доллараар 9 мянга гаруй га талбайг усжуулах боломжтой. Нэг мянган га талбайн усжуулалтын тоног төхөөрөмжийн үнэ нь 2.5 сая гаруй ам доллар. Газар дээрхи байгууламжийн төхөөрөмжийг 7 тэрбум төгрөгөөр төр худалдаж авсан” тухай ярьдаг. Гэтэл хувиараа усжуулалтын тоног төхөөрөмж оруулдаг компаниуд үүнээс хэд дахин хямдаар усжуулалтын тоног төхөөрөмжийг тариаланчдад санал болгодог. Хэрвээ үнэхээр бид өөрсдийн дотоод нөөцөө ашиглаж уул уурхай, эрдэс бүтээгдэхүүний экспортоос өөрөөр дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлье гэж байгаа бол төрөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, га-ын ургацыг 20 центнерт хүргэн дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй экспортлох хэмжээнд ч хүрч болох юм.

Мөн макро эдийн засгийн түвшинд интервеншин хийх зайлшгүй шаардлага үүсээд байгаа тухай мэргэжилтнүүд хэлдэг. Хамгийн том худалдагч, худалдан авагч бол засгийн газар. ЗГ татвар цуглуулж, түүнийгээ үрдэг гэж энгийн үгээр хэлж болно. Тэгэхээр ЗГ иргэд аж ахуйн нэгжтэй эн тэнцүү зах зээлийн харилцаанд оролцогч гэсэн үг юм. Харин үүнийг Төв банк буюу бидний нэршлээр “Монгол банк” зохицуулах үүрэгтэй. “Монгол банк” худалдан авагч, худалдагчаас өөр учир **ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ МӨНГӨ БОЛОН КРЕДИТИЙН ХЭМЖЭЭГ УДИРДДАГ**. Үүнийгээ 2 замаар хийдэг. Энэ нь нэгдүгээрт бодлогын хүүнд өөрчлөлт оруулах, хоёрдугаарт мөнгө хэвлэх замаар уг процесс явагддаг. Ийм учраас “Монгол Банк” макро эдийн засагт нөлөөлж чадах хамгийн том нөлөө бүхий **ГОЛ ТОГЛОГЧ** юм. Монгол банкнаас авсан арга хэмжээнээс шалтгаалж эдийн засгийн тэлэлт, агшилтын чиг хандлага тодорхойлогдоно. Зээлийн хүү өндөр байвал зээлдэгч нар зээл авахыг хүсдэггүй. Харин цар тахлын энэ үед мөнгөний оновчтой бодлого баримталж бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээлийг санал болгож боломж бидэнд бий гэж найдаж байна.

Гэхдээ бид зах зээл дээр зээлдэгч, зээлдүүлэгч 2 яг адилхан байдалтай байгааг анхаарч үзэх нь зүйтэй. **ЭДИЙН ЗАСАГ ӨӨРӨӨ НАЙДВАРГҮЙ ЗЭЭЛДЭГЧ БОЛСОН** ч байж болох юм.

Эхэнд дурьдсанчлан бид эрүүл мэнддээ хэт анхаарч эдийн засгаа орхигдуулсан тал бий гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай. Мөнгөгүйгээр эрүүл мэндийн салбараа тэтгэж чадахгүй, мөнгөгүйгээр вирусээс урьдчилан сэргийлж чадахгүй, цалин орлогогүйгээр бүр ч чадахгүй, дархлаагаа дэмжих хоол хүнсгүйгээр амьд явах боломжгүй.

Дэлхий өнөөдөр даярчлагдаж байгаа тухай ярьж, энд бид уусч байсан ч дангаарчлалыг хэсэгтээ сонгох нь дотоод нөөцөө ашиглах асар том боломжийг бий болгож байна. Тогтвортой хөгжил, жигд хөгжил, аль нэг улс орнуудын хүч хүрэхгүй байгаа том төслүүдийг хамтарч хийх, хамтарсан дэд бүтэцтэй болох, байгаль орчин эх дэлхий ногоон байгууламж гэх үгнүүд ямар их үнэ цэнэтэй, бид ямар их өөр хоорондоо хамааралтай болсон, дэлхий гэх нэг гэрт амьдарч 7 тэрбум хүн нэг агаараар амьсгалж байгаагаа улам бүр мэдэрсэн, бид аюулт өвчний өмнө тэгш эрхтэй байдаг гэдгийг ойлгуулж, бид бие биенээсээ ямар их хамааралтай болохыг мэдэрсэн өдөр хоногууд өнгөрсөөр байна. Хэдийгээр глобалчлалыг буцааж болохгүй ч гэсэн, энэ удаагийн “ХАР ХУН” гэх үйл явцаас улс орнууд ямар нэг хэлбэрээр дохио авч өөрчлөлт, шилжилт үргэлжилсээр байх болно. Хөл хорионы дараа эдийн засгийн бүтэц асар их өөрчлөгдөнө. Дэлхийд аялал жуулчлалын салбар уналтад орж магадгүй ч манай улсын хувьд дотоодын аялал жуулчлал хөгжих, онлайн худалдаа, онлайннар хөдөлмөр эрхлэх хандлага нэмэгдэх төлөв харагдаж байна.

Бүх асуудалд хариулт байхгүй, гэхдээ бид ямар нэг хэмжээгээр хариулт олох хэрэгтэй. Энд хожих хүн, хожих улс төрийн хүчин байх ёсгүй. Ямар ч байсан бүх юм, харилцаа хандлага өөрчлөгдөнө. Бид үнэхээр том үйл явдлын ГЭРЧ болж байна. Ийм үйл явдал дэлхий дээр тийм ч олон тохиолдохгүй байх гэж итгэж байна. Энэхүү үйл явдал дэлхийн 2 дугаар дайны дараа тохиолдож буй хамгийн том үйл явц гэж хэлж болно. Үүний дараа бид өөр орчинд амьдарна. Амьдралын өөр хэв маяг үүснэ. Өөр чиглэл рүү дэлхий, дэлхий эдийн засаг явна. Эдийн засаг

хэзээ ч дахин хуучин хэвэндээ орохгүй. Дэлхийн бараг бүх улсууд Хятадын эдийн засгаас хамаарч байсан бол бие даасан эдийн засагтай байхыг зорьж, глобалчлал нэг хэсэгтээ ухарч экспорт, импортоос хамааралгүй эдийн засагтай болох гэж оролдох болно.

ЦАР ТАХЛЫН ГАМШГИЙН ДАРААХ ДЭЛХИЙД БИД ХЭРХЭН АМЬДРАХ ВЭ

~ЭРСДЭЛ БА БОЛОМЖ~

~ЭРСДЭЛ~

Цар тахлын дараах үеийн эрсдлийг ерөнхийд нь гадаад ба дотоод хүчин зүйлийн эрсдэл гэж хуваан авч үзье. Дотоод хүчин зүйлийн эрсдэлд бид бүхэн зохицуулалт хийх эрх нь нээлттэй бий. Харин гадаад хүчин зүйлийн эрсдэл нь биднээс хамаарахгүй. Энэ нь дэлхийн эдийн засгийн саармагжилт, БНХАУ-н түүхий эдийн хэрэглээ буурч байгаа хүчин зүйлүүд юм.

Цар тахлын идэвхижилттэй зэрэгцэн Монголын ЗГ онцгой байдал зарлаж, хил гаалиа хаасан. Аюулт өвчнийг оруулахгүй барьж чадсан гэж үнэлэгдэж байгаа ч импортын олон нэр төрлийн барааны хомсдолыг үүсгэж, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхолыг түдгэлзүүлж, экспортоо нэн хязгаарлан, валютын орлогоо хаасан. Нэг уут цементний үнэ Цайз зах дээр 16 000-18 000 төгрөг, хөдөө суманд 25 000 төгрөгнөөс дээш гарсан нь импортын барааны хомсдол үүссэнийг нэн тодорхой илэрхийлээд зогсохгүй дотоодын цементний үйлдвэр эрэлтээ хангаж хүрэлцдэггүйг илчилж орхив. Энэ бол импортын бараанууд хомсдолд орж буйг харуулсан гол төлөөлөл. Яаралтай анхаарах ёстой дохио.

Хил хааснаар олон төрлийн уул уурхайн түүхий эдийн экспорт хязгаарлагдав. Оюутолгой хэдийгээр хилийн хориггүйгээр зэсээ гаргаж байгаа ч БНХАУ-н зүгээс таталт нь багассан ба энэ нь цар тахалтай холбоотой тэдний дотоодын үйлдвэрлэл саармагжсан нь ойлгомжтой. Нүүрс, төмрийн хүдэр, жоншны экспорт өмнөх оныхоос илт буурав. 2020 онд түүхий эдийн экспорт өмнөх оныхоос 1,6 тэрбум доллараар буурч 6.06 тэрбум болно хэмээсэн Төв банкны прогноз одоо биеллээ олж байна. Экспорт буурахад валютын орлого буурч эдийн засаг хүндэрнэ. Хөрөнгө оруулагчид шийдвэрээ хойшлуулж, хөдөлмөрийн зах зээл хямарч байна. Эдгээр нь макро эдийн засагт хамаатай.

Гэтэл микро түвшинд жижиг дунд үйлдвэрлэл, бичил үйлчилгээ, бөөний болон жижиглэн худалдаа, өдрийн цалинтай ажлаар өрхийн амжиргаагаа залгуулдаг маш олон мянган бичил бизнесмен, хөдөлмөр эрхлэгчдийн орлого хорио цээртэй холбоотой зогсоод байна. Тэдгээр өрх айл, иргэд өөрсдийн гар дээрх бэлэн мөнгө, материалын нөөц, хуримтлалаараа амьдарч, өр шир тавьж өдөр хоногийг аргацааж байна. Тэд ийм байдлаар удаан тэсэхгүй. Энэ бол хамгийн том эрсдэл нь. Нэн даруй хөдөлмөрлөх боломжийг нь нээхгүй бол архаг ядуурал, өвчлөл, нийгмийн ноцтой хямралд түлхэнэ. Тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх юм.

• • • • •

~ТЭСВЭРЛЭХ, ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР~

Хамгийн өргөн хэрэглээний стратегийн хүнсний гол бүтээгдэхүүн мах, гурил, хүнсний ногооны хомсдол үүссэнгүй. Энэ нь манай орны уламжлалт МАА-н үйлдвэрлэлтэй холбоотой. 2011 онд Японы Фукушимад атомын цахилгаан станцын дэлбэрэлт болсны дараа тэр мужаас гарсан үхрийн махыг буцаан татахад зэргэлдээх мужуудад үхрийн махны эрэлт огцом нэмэгдэж байсан. Голлох хүнсний бараа бүтээгдэхүүн хомсдолд орох эрсдэлгүй байсан нь хүнсний нөөцийн аюулгүй байдлын нөөц чамлахааргүй байгаа нь ажиглагдлаа. Эрэлтээс давсан нөөцүүд ч бий. Энэ бол давуу тал юм.

Мөн нөгөөтэйгүүр хүн ам цөөн, нягтаршил бага, аймгийн төв, сум суурингууд нь хоорондоо алслагдсан зайтай орших газар зүйн онцлог нь цар тахал түргэн халдварлах боломжыг, олон хүнд зэрэг хүртэх нөхцөлгүй болгож байна. Энэ нь гамшгийн аюул эрсдэл бага, өртөмтгий бишийг харууллаа. Удаан хугацааны хорио цээрт олон нийтийн зүгээс гарах эсэргүүцэл, бухимдал бага байгаа нь цар тахлын үеийн гамшгийн нөхцөлд дасан зохицож байгааг харуулж байна.

~БОЛОМЖ~

Хил хаалттай байснаар дотоодын аялал жуулчлал эрс нэмэгдсэн.

Мөн түүнчлэн цар тахлыг дотооддоо тархварлан дэгдэх нөхцлөөс урьдчилан сэргийлж чадсан дэглэмээрээ гадаадын аялагчдын сонирхлыг багагүй татаж жуулчдын сонирхол, хандалт ихэссэнийг БОАЖЯ-аас мэдээллээ. Цар тахлын дараа аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг улс төдийгүй, цар тахлын нөхцөлд ч орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид дор бүрнээ орлогоо нэмэгдүүлэх боломж байна.

~СОРИЛТ БА АСУУЛТ~

- *Монгол улс хэр удаан бараа экспортлохгүйгээр хилээ хаалттай байж чадах вэ*
- *Төв банкны валютын нөөц хэр удаан тэсэх вэ*
- *Хомсдож буй импортын бараа бүтээгдэхүүнийг юугаар орлуулах вэ*
- *Гадаад валютын орлогыг хаанаас олох вэ*
- *Эм, эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн дутагдлыг хэрхэх вэ*
- *Орлого нь зарлагадаа хурч байх хатуу зарчимтай эдийн засгийн амьд организмыг хэдий болтол улс төрийн шийдлээр хүчээр аргалаад явах вэ*

Эдгээр асуултаудад үр дүнтэй хариулт өгч чадах шийдлийг олж амжилттай хэрэгжүүлбэл манай улс цар тахлын дараа ч, цар тахлын нөхцөлд ч өрсөлдөх чадвар нь сайжирна.

~ШИНЭ НӨХЦӨЛД БЭЛТГЭХ~

Хөдөлмөрийн зах зээлд зайнаас ажиллах, боловсролын харилцаа цахимд суурилах, онлайн худалдаа хөгжих, хувь хүн ба гэр бүлүүд нийгмээс хөндий харьцангуй бие даасан нэгж хэлбэрт дасан зохицох шинэ нөхцөл байдлууд нэгэнт үүсч байгаа нь ажиглагдаж байна.

Энэ үед олон талт түншлэл, салбар хоорондын уялдааг хангаж эрүүл мэнд нийгмийн хамгаалалд чиглэсэн бизнес өсөн нэмэгдэхийг шинжээчид хэлж байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт ихсэнэ гэж мэдэгдсэн ба бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нь онлайн болон зайнаас ажиллах нөхцөлд суурилах юм. Энэ нь мэдээллийн технологи болон программ хангамжийн салбарыг бүхэлд нь хамрах боломжтой. Гэрээсээ хийх боломжтой ажлууд юм. Энэ чиглэлд холбогдох бизнес эрхлэгчид анхаарлаа хандуулах бизээ.

Крымийн хойгийн хямралын үеэр умард хөрш ОХУ-д барууны орнууд эдийн засгийн хориг арга хэмжээ авсан. Энэ хоригт Европ, АНУ-с ОХУ-руу импортолдог 30 000 нэр төрлийн бараа багтсан. Улс төр, эдийн засгийн хаалттай энэ үед ОХУ дотоодын үйлдвэрлэлээ богино хугацаанд сэргээж дээрх 30 000 нэр төрлийн бүтээгдэхүүнийг одоо өөрсдөө үйлдвэрлэн эрэлтээ хангаад зогсохгүй, зарим бүтээгдэхүүний илүүдлийг валют болгохоор гадагш экспортлоход бэлэн болоод байна. ОХУ-н улс төр, эдийн засгийн энэхүү хаалттай хүнд нөхцөлтэй харьцуулахад Монгол улс харьцангуй давуу, гадаад зах зээлд хориг саадгүй эрх чөлөөтэй байгаа юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага COVID19-н үеийн болон түүний дараах шинэ нөхцөлд хэрхэн бэлдэх талаар Засгийн газрууд болон компаниуд, стартапууд, ажил олгогчдод дараах зөвлөмжийг өгч байна.

- *Төр хувийн хэвшлийн ойлголцол, итгэлцэлийг нэмэгдүүлэх алхамууд хийх*
- *Хууль эрх зүйн уян хатан зохицуулалт, бодлогын дэмжлэг*
- *Бизнес эрхлэгч, ажил олгогчдод эрх олгох, зөвшөөрөл өгөх,*
- *Гадаадын хөрөнгө оруулагчидтай үндэсний аж ахуйн нэгжүүдээ холбон зуучлах, баталгаа гаргах*
- *Компаниуд, хувийн хэвслүүд шийдвэр гаргахдаа хүчтэй, чөлөөтэй, бие даасан, ардчилсан байх/
төрийн хүч хэрэглэсэн зохицуулалт нөхцөл байдлыг муутгана гэж үзсэн/*
- *Хөрөнгө оруулалтын шинэ орчныг нээх*

Монгол улс бол хөрөнгө оруулалтын шинэ орчин нээх таатай бүс юм. Өмнөд талдаа нэг тэрбум гаруй хүн амтай дэлхийн хамгийн том хэрэглэгч хөрштэй, цаашлаад Ази хэмээх өлсгөлөн зах зээл дэргэд байна. Технологийн компаниуд, автомашин үйлдвэрлэгчид салбар үйлдвэрээ нээх газар хайж байна. Энэ компаниудын өмнө төлбөргүй газар, татваргүй зах зээлийг санал болгож хөрөнгө оруулалтын диваажин, үйлдвэрлэлийн арал бий болгоё. Харин тэр үйлдвэрт нь иргэдээ ажиллуулъя, тэд бүхэнд түүхий эдээ зарья, эндээс валютын орлого олъё.

Хүн ба материаллаг биетийн алсын шилжилт хөдөлгөөн - үйлдвэрлэл, түүхий эдийн тээвэрлэлт, эдгээр хэлхээ нь хөдөлмөр ба цаг хугацаа орон зайг туулах шинж чанараараа их хүч хөдөлмөр, зардал, хурд хугацаа шаарддаг. Энэ хэрээрээ эрсдэл асуудал дагуулж байдаг. Жишээ нь нүүрс олборлох, тээвэрлэх, дахин дамжуулахад хөдөлмөр, хугацаа, ихээхэн зардал орно. Байгаль орчин хохирно.

Харин материаллаг бус, бодит биетийн хөдөлгөөн үгүй, материаллаг нөөц шаардахгүй, хил хязгаар орон зайд цаг хугацаагаар баригдахгүй валютын урсгалыг татах бизнес- ашгийн шинэ бүс хүчтэй хөгжин тэлж байна. Энэ бол программ хангамжийн үйлдвэрлэл, цахим технологийн хөгжүүлэлт.

Япон, Энэтхэгт сургууль төгсөж ирсэн залуус Зүүн өмнөд азийн компаниудын мэдээллийн технологийн зөвлөх, контент үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг хийж байна. Тэд эндээсээ захиалгаа аваад, эндээ үйлдвэрлэлээ хийгээд, бүтээгдэхүүнээ интернэтээр дамжуулан худалдан борлуулж байна. Далайд гарцгүй гэж шалтаг хэлэх хэрэггүй. Газар зүйн саад байхгүй, улс төрийн нөлөө хамааралгүй.

Энэ зүгт анхаарлаа хандуулж хурдацтай эрэл хайгуул хийе. Монгол улс эл зах зээлээс жилдээ 6 тэрбум доллар олдог болоход нүүрсний бүх уурхайг, хилийн боомтуудтай хамт хаасан ч ажрахгүй.

HumanZ.mn



**Мөнхбаяр овогтой
Баасандэлгэр**

2017 онд МУБИС-ийн
Сэтгүүл зүйн ангийг төгссөн.

2017 онд Зууны мэдээ
сониноос ажлын гараагаа
эхэлж,

2018-2019 онд *newspress.mn*
сайтад сэтгүүлчээр ажилласан.

2019 онд өөрийн *HumanZ.mn*
сайтыг нээж, одоог хүртэл
ерөнхий редактораар ажиллаж
байна.

ТООЖИЖ, ОНЛАЙНЖСАН, ... “ШИНЭ
ХЭВИЙН” АМЬДРАЛ

*Нэг. Цар тахал эхэлсний дараах бизнесийн орчны
тухай зарим баримт*

Дэлхийд

НҮБ-ийн ЭЗНХГ-ын ЭЗАБХ-ийн Глобал Эдийн Засгийн хяналтын тасгийн дарга Хашид Рашидын “Дэлхийн Э/З-ийн 2020 оны дунд үеийн байдал ба төлөв” нэртэй судалгааны материалд дараахи мэдээлэл тусгагджээ. [1].

Сүйрлийн аюултай, улангассан цар тахалтай тэмцэн туйлдсанаас 2020 онд дэлхийн эдийн засаг 3.2 хувиар агших төлөвтэй. 2020 онд хөгжингүй орнуудад ДНБ нь 5 хувь буурч, хөгжиж буй орнуудынх 0.7 хувь агших дүр зураг харагдаж байна. Тооцоогоор 2020-2021 онуудад, Дэлхийн ДНБ нийтдээ, 8.5 их наяд ам доллараар хорогдож, урьдах дөрвөн жилд бий болсон өсөлт үгүй болох магадлалтай. Үүнтэй зэрэгцээд ажлын байр, ялангуяа “gig” буюу зөвлөх, богино хугацаанд гэрээгээр ажиллагсад зэрэг тогтмол бус ажлын байр хэдэн саяаараа буурч байсан хандлага урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй.

Гэтэл хязгаарлалт, тусгаарлалт, зай барихаас шалтгаалсан хямрал нь онлайн борлуулагчид, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны тоон платформууд ба дата дамжуулах үйлчилгээ үзүүлэгчдэд хор хүргэсэнгүй, харин ч тэд энэ хугацаанд борлуулалтаа өсгөсөн. Дээрх салбарын биш атлаа тоон технологи, мэргэжилтнүүдээ сургах зэрэгт хөрөнгө оруулалт хийж амжсан компаниуд хямралын үеийг бусдаасаа харьцангуй амжилттай давж байна. Алсаас ажиллах боломж бий болгох нь компаниудад бизнесээ үргэлжлүүлэх амин чухал шийдэл болжээ.

Шуурхай тоожуулалт (digitalization), эдийн засгийг онлайнжуулах давалгаа нь одоо байгаа

маш олон ажлын байрыг үгүй болгож, тоон эдийн засгийн шинэ ажлын байр бий болгох төлөвтэй.

Боловсролын салбарт бол, цаашид, тоожуулалтын төвшин өндөртэй, бас өргөн зурвасын үйлчилгээ ихээр нэвтэрсэн улс, орнууд сургуулиуд хаагдахын сөрөг нөлөөг минимум хүртэл багасгаж байна.

Тоон чадавхи нь илүү хөгжсөн улсууд хавьтлыг мөшгөх, ажиглалтад авах боломжоо ашиглан цар тахлын дахин дэгдэлттэй илүү оновчтой тэмцэж чадаж байна.

Х.Рашид “Дэлхийн эдийн засаг цар тахлын дараа эргэж хуучин хэвэндээ орох уу, эсвэл “шинэ хэвийн” байдалд шилжих үү” гэсэн асуулт (Back to normal of a new normal?) тавьлаа.

Монгол Улсад

УСХ-ноос гаргасан Монгол Улсын Нийгэм, Эдийн Засгийн байдал, 2020, I-VIII-д Аж үйлдвэрийн салбар 2020 оны эхний наймдугаар сард өмнөх оны мөн үеээс 18.4%, уул уурхай 25.5%, төрсөн хүүхдийн тоо 1.3хувиар тус, тус буурсан ажээ. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарч.

Гэхдээ өмнөх оны мөн үеээс Төмөр замын тээврийн орлого 8.9% өссөн, халдварт өвчнөөр өвчлөгсөд 24.6%, бүртгэгдсэн гэмт хэрэг 22.1% тус, тус буурсан нааштай мэдээ бас байна. [2].

НҮБ-ийн шинжээч Х. Рашидын дурьдсан “..нийгмийн сүлжээ..., харилцаа холбооны тоон платформууд, дата дамжуулах үйлчилгээ үзүүлэгчид” гэсэн ангилалд дөхүү “монгол улсын харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчид” -ийн нийт орлого 2020 оны эхний 6 сард өмнөх оны мөн үеээс 11.6% өсчээ. [3].

2020 оны наймдугаар сарын 24-нд МУ-ын ЗГ, Улсын онцгой комиссоос “Олон талт Түншлэлийг бэхжүүлэх замаар Ковид-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх нь” хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгууллаа. [3].

МУ-ын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар нээж үг хэлэхдээ “Хэдийгээр манай улс дотооддоо халдвар алдаагүй, нас барсан тохиолдол бүртгэгдээгүй хэдий ч эмчлэгдэн гарсан иргэдээс КОВИД-19 халдвар дахин илрэх, халдварын тохиолдол гарахгүй гэдгийг дэлхийн нийгмийн эрүүл мэндийн салбар баттай нотолж чадаагүй байгаа энэ үед уг өвчин хүн амын дунд тархах эрсдэл өндөр байгааг илтгэж байна” гэж анхааруулаад, “Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлсноор бид “Шинэ Хэвийн” амьдралын хэв маяг гэдгийг өөрийн улсын онцлогт нийцүүлэн бий болгох шаардлагатай байгаа гэж үзсэн. Аюулт өвчний улмаас иргэдийн аж амьдрал, улс орны хөгжлийн чиг хандлага бүрэн өөрчлөгдсөн байгаа энэ үед бид нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэрхэн сэргээн хөгжүүлэх талаар бид шинэ арга барил, шинэ шийдэл, шинэ гарцуудыг эрэлхийлэх том сорилттой тулгарч байна” гэсэн юм.

Хоёр. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараах бизнесийн орчны эрсдэл

Монголчууд гадаад оронд очиж ажиллах төдийгүй суралцах боломж багасав. ЕБС төгсөгчдийн дунд АНУ, БНХАУ зэрэг улсуудад очиж суралцах уралдаан зарлагдсангүй.

Манай иргэд гадаадад жуулчлах, гадаадын жуулчид манай улсад ирэх боломж

буурав. Бизнесийнхэн, өнөөдрийн байдлаар, Эрээнд ч очих аргагүй байна.

Гурав. Боломж, сорилтыг хэрхэн давах талаар хайлт, судалгаа хийсний үндсэн дээр боловсруулсан саналууд нь интернет дээр байгаа Г. Оюунбаяр гуайтай ярилцав.

М.Баасандэлгэр: Сайн байна уу Оюунбаяр гуай. Ваabar.mn-ийн bloggers, gmobile.mn, news.gogo.mn, бусад сайтууд дээр байгаа таны илтгэл, танилцуулга зэргийг судалж үзээд цар тахлын дараах бизнес орчинг сайжруулах талаар ярилцах саналтай байна. Та цаг гаргана уу.

Г.Оюунбаяр: Болно. Та миний бичээд <http://baabar.mn/article/bayar-uwuu-dakhij-urikhand-orow-shine-uikh-zasgiin-gazartaa-2020-2024-onii-khutulbur-khemeen-uchuukhen-zorilgo-batlaad-ugchikh-wii> дээр байрлуулсан материалыг лав уншсан юм байна. Тийм үү?

М.Баасандэлгэр: Тийм, өөр ч сайт дээрх материалтай танилцсан. Цар тахал манай улсын төдийгүй Дэлхийн эдийн засагт маш их хохирол учруулж, сая гаруй хүний амийг авч одлоо. Цар тахлын хөнөөлийг сааруулах ямар боломж байна гэж та бодож байна?

Г.Оюунбаяр: Бидэнд эдийн засгаа тоожуулах (digitizing хийх), Төр, засгийн газрын шийдвэр, судлаач, эрдэмтдийн судалгаа шинжилгээг математик загварчлал ашиглан суперкомпьютерээр симуляци хийн оптимальжуулах, үйлдвэрлэлийн автоматжуулалтын төвшинг нэмэгдүүлэх, улмаар ухаалагжуулах, SnD систем нэвтрүүлэх, дэлхийд эрэлттэй, өрсөлдөх чадвартай контент, үйлчилгээг бий болгох зэрэгт саад харагдахгүй байна, эдгээр нь бидэнд байгаа боломжийн зарим нь.

Харин УИХ маань Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт МУ-ын ДНБ, ХХИ-г хэд хүргэх тухай тусгасангүй. Энэ тун хариуцлагагүй явдал. Иргэдэд УИХ-аас ХХИ-г “Алсын Хараа 2050” -д заасанд хүргэнэ үү гэсэн шаардлага тавих өөр нэг боломж бас нээлттэй.

М.Баасандэлгэр: Таны дурьдсан боломжийг хэрхэн ашиглах вэ, энэ нь сорилтыг даван туулахад сайн нөлөө үзүүлж чадах уу?

Г.Оюунбаяр: Эдийн засгаа тоожуулах нь өргөн ойлголт, зайлшгүй шаардлагатай 2 шийдэл дурьдъя. Бид сумд руу татсан 40 гаруй мянган км шилэн кабельтай. Тариф нь маш өндөр, ₮80000/mbps, тул МУ-ын тоон үйлчилгээнд хамрагдсан нутаг дэвсгэр ~160000 кв км, 10% орчим, энэ талбайд хурд хангалттай биш, үйлчилгээний тариф маш өндөр. Тэшиг сумандаа хэд хонохдоо би гар утсаараа БГД-ийн IV хороололд хэрэглэдэгтэйгээ адил үйлчилгээ (cnn.com, youtube.com, FB, chess.com, viber, parliament.mn, nso.mn, сонингууд унших, дотоодын зарим ТВ үзэх төдийд) авахад 110000 төгрөг болж байна билээ, гэтэл би хүүгийн дээ байхдаа WiFi-г нь хэрэглээд мөнгө төлдөггүй. Тэд сарын 33000 төг төлдөг, харин интернетээр хэдэн гига байтугай терабайт хэмжээтэй файл татсан ч үнэ нэмэгдэхгүй! Шударга бус зүйлийн нэг энэ мөн. УБ хотын гэр хорооллын айлуудад нөхцөл мөн адил. Тэдэнд зайнаас ажиллах боломж тааруу тул хот руу биеэр явж түгжрэлд “хувь нэмэр” оруулахаас аргагүй.

Үүний тулд УИХ-ын хаврын чуулганаар хүчингүй болгосон УИХ-ын 2016 оны 19-р тогтоолын хавсралтын 2.1.5-ын зорилт 7-ийн “интернетэд байршил үл харгалзсан ижил үнэ тариф “ гэсэн заалтыг дахин сэргээж мөрдөх.

Шилэн кабелийн сүлжээг төмөр, автозам, цахилгаан дамжуулах сүлжээний

зарчмаар төлөвлөх, санхүүжүүлэх нь цар тахалтай тэмцэхэд, бас улсын хөгжлөө эрчимжүүлэхэд их нэмэр болно. Өндөр тарифаас шалтгаалаад харилцаа холбоо, гар утас, эпликэшнд оруулсан 1.2 илүү их наяд ₮-ийн хөрөнгө оруулалтын өгөөж 10% төдий байгаа. Энэ нь бусад судалгаагаар ч илэрдэг, тухайлбал Дэлхийн 63 улсыг хамруулсан өрсөлдөх чадварын 2019 оны тайланд харилцаа холбоонд оруулсан хөрөнгө оруулалтаараа бид №3-т атлаа “мэдлэгийн солилцоо” гэсэн үзүүлэлтээр №63-т буюу хамгийн сүүлд. Энэ байдал сургууль хаагдаж хичээл ТВ-д шилжсэнээр бас л илэрсэн, өнгөрсөн зуунд байгаатай адил байлаа. НҮБ-ийн ХАС-ны судалгаагаар сурагчдын 53% нь ТВ хичээл тогтмол үзэж чадаагүй, 57% нь ТВ хичээлийн хурд, бүрэн ойлгомжтой байдлыг “дунд зэрэг”, “муу” гэж үнэлсэн. [6].

Бидний ном хэвлэх чадавхи сайжирч байгаа ч сул хэвээр. Номнуудынхаа агуулгыг тоон болгоод номын сангуудаа интернет дээр нээлттэй болгоё. Ингэвэл номын санд очно гэж хотын төв рүү, УБ явах шаардлага багасна, мэдлэгийн солилцооны нэг нь энэ. Оюуны өмчийн тухай яриа гарна, бид ганцаар энэ асуудалтай тулгараагүй. Бусад улсын жишгийг харгалзаад гарц олж болно.

Шилэн кабелийн дамжуулахын тарифыг дээр дурьдсаны дагуу шийдвэл төсөвт 40 Тб₮ орчим буух ч эдийн засгийн идэвх эрчимжиснээр ДНБ 99Тб₮-759Тб₮-р өсөх тооцоо гарсан. [5].

Суперкомпьютерийн хангалттай хүчин чадал бүхий Cloud байгуулах тухай [5]-д арай дэлгэрэнгүй дурьдсан, үүнийг хэрэгжүүлэхэд ДНБ өсгөх фактор нэгээр нэмэгднэ, өсгөх хэмжээ нь 1 хувиас доошгүй.

SnD систем гэдэг нь МУ-ын бүх ААНБ, өрх, зарим иргэн өөрийн үйлдвэрлэсэн бүх бүтээгдхүүн, явуулдаг үйлчилгээгээ байрлал, чанарын үзүүлэлт, үнэтэй нь ВЭБ дээрх апп-д байрлуулах тухай юм. Хэрэглэгч өөрт хэрэгтэй бүтээгдхүүн, үйлчилгээний мэдээллийг байрлалтай нь бас байршуулж болно. Апп бие биенийг нь олж санал болгох үйлчилгээтэй. Энэ систем бүтээгдхүүнээ дэлгүүрт аваачих, худалдан авагчид дэлгүүр хэсэх явдлыг эрс бууруулна, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлнэ.

Дэлхийн зах зээл чиглэсэн контент, үйлчилгээ бий болгох нь бидний холын биш, бүр ойрын зорилт. Надтай ажиллаж байсан инженер Ч. Анар инженер lend.mn нэртэй сайтаар үйлчилгээ явуулж эхэлсэн, та мэдэж байгаа байх, хаана ч очиж, хэн нэгэнтэй уулзалгүй мөнгө зээлддэг, мөн хүний тусламжгүй буцаагаад авдаг үйлчилгээ бий болгосноо Филиппин, Мексик зэрэг улсад нэвтрүүлэх тухай хэлэлцээр хийж байна.

М.Баасандэлгэр: Шинэ нөхцөл байдалд дасан зохицох, бэлтгэхэд юу шаардлагатай вэ?

Ө.СУГАР: ГОВЬ НУТАГТ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ХҮМҮҮСТ ДЭМЖЛЭГ ХЭРЭГТЭЙ БАЙНААНБ-ууд үйл ажиллагааны процессуудаа тоожуулах, ухаалагжуулах, онлайнжуулах чиглэл баривал дасан зохицох төдийгүй хүчирхэгжиж байгаа хэрэг. Хувь хүн дижитал буюу тоон технологи ашиглах, бас бүтээлчээр нэвтрүүлэх чадвартай болж байвал дасан зохицож байгаагийн нэг хэлбэр нь.

М.Баасандэлгэр: Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх ямар боломж байна?

Г. Оюунбаяр: Төр хотын зах, хөдөө тийш татсан дата дамжуулах үндсэн шугам буюу шилэн кабелийн УБ-сум хоорондын тарифыг тэглэж, хөдөөгийн үйлчилгээний үнийг УБ-ынхтай адил болгон хувийн хэвшилд үйлчилгээгээ, бас

төрийн үйлчилгээг орон даяаар, тэрбайтугай дэлхий даяаар, нэмэлт зардалгүйгээр хүргэх боломж олгох нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны маш сайн хэлбэр. Ийм ажиллагаа боловсрол, эрүүл мэнд, хил хамгаалах, төмөр, авто зам, ЦДШ-д байна.

М.Баасандэлгэр: Хөрөнгө оруулалт татах боломж байна уу, байвал нэрлэнэ үү.

Г.Оюунбаяр: Шилэн кабелийн УБ-хөдөө хооронд мэдээлэл дамжуулах тарифыг 0 болгоно гэвэл хөдөөгийн хөдөлгөөнт дата үйлчилгээ хүрээгүй багууд, олон улсын, аймаг, сум хоорондын зам дагуу гм үүрэн холбооны станц барих сонирхолтой, WiFi үйлчилгээ хүргэх, ТВ үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж олон бий. [7].

SnD систем нэвтрүүлэх, нийтийн үйлчилгээний Cloud дата сентер байгуулах зөвшөөрөл өгнө гэвэл ОУ-ын байгууллага дэмжлэг үзүүлэх, банкууд зорьсон ААНБ-д нь зээл олгох сонирхлоо илэрхийж байсан. Жишээ нь EBRD-тэй энэ сэдвээр харилцаж байсан.

М.Баасандэлгэр: Таны ярьсан шинэлэг санаа мөн үү? Энэ гарц байж болох уу? Шийдвэр гаргагчдад танилцуулж болох уу?

Г.Оюунбаяр: УБ-сум хоорондын дамжуулахын тарифыг 0 болгохын хувьд энэ нь шинэ санаа биш, 2016 онд яригдаж, бүр УИХ баталсан байсан шүү дээ. Харин өнөөдрийн цар тахлын аюул бий болсон үед энэ санаа, номын агуулгыг тоо руу хөрвүүлэх, номын сангуудыг онлайн болгохтой хамт оновчтой шийдлүүд мөн. Тоожуулах, онлайнжуулах бол хөгжингүй улсуудад шат шатаар хэрэгжээд явж байна. SnD систем бол МУ-ын хувьд шинэ санаа, БНХАУ-д төстэй систем саяхан нэвтэрсэн байна лээ. Хүйтэн, сэрүүнийг ашиглах барилга бүхий датасентер болон нараар халах барилгын хувьд, энэ шинэ санаа мөн, учир нь МУ-ын оюуны өмчийн гэрчилгээ, патент зэрэг нь надад бий. [8]. Шийдвэр гаргагчдад танилцуулж болно, ер нь нэмэлт мэдээлэл хэрэгтэй гэвэл би хэдийд ч өгөхдөө баяртай байх болно.

Гарц мөн эсэхийг санал бүрийг минь ХХИ, ДНБ-ийг өсгөх зорилтот математик загварчлалд оруулж симуляци хийн бодуулж үнэлгээ өгвөл бүр сайн, мөн гэж хариу гарна гэдэгт итгэлтэй байна.



**Энхбаатар овогтой
Энхчимэг**

*2014 онд МУИС-ийг Олон
улсын сэтгүүлч мэргэжлээр,*

*2017 онд МУИС-ийн
Сэтгүүл зүйн магистраар
төгссөн. 2012 онд
Шинэ Монгол радиод
сурвалжлагчаар ажлын
гараагаа эхлүүлсэн.*

*2014 онд Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн
мэдээлэл, сурталчилгааны
мэргэжилтнээр,*

*2015-2018 онуудад
Архивын Ерөнхий газрын
хэвлэлийн төлөөлөгч, УИХ-
ын гишүүний ажлын албанд
хэвлэл мэдээлэл хариуцсан
ажилтнаар тус тус
ажиллаж байв.*

*Одоо Япон улсад
суралцаж, фрийлансерээр
ажиллаж байна.*

ЦАР ТАХАЛ БА БИЗНЕСИЙН ОРЧИН:

*Улс орнууд бизнесийн тогтвортой орчинг
хамгаалахын тулд ямар арга хэмжээ авч байна
бэ?*

Орчин цагийн түүхэнд буюу 1800 оны дунд үеэс хойш дэлхий дахинд нийтдээ 14 удаагийн эдийн засгийн хямрал тохиожээ. Харин Дэлхийн эдийн засгийн форумын эрсдэлийн шинжээчдийн үзэж байгаагаар коронавирусын тархалтаас улбаатай энэ удаагийн эдийн засгийн хямрал нь Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи хамгийн хохирол ихтэйд тооцогдож байна.

Энэхүү гэнэтийн нөхцөл байдал нь дэлхий дахины эдийн засаг хийгээд санхүүгийн зах зээлд асар хүчтэй нөлөөлж байгаагаас том болон жижиг дунд бизнесүүд ээлж дараалан дампуурлаа зарлаж, хэдэн арван саяар тоологдох хүмүүс ажлын байраа алдах эрсдэл өндөр гэж тэдгээр шинжээчид мөн анхааруулав. Энэ мэтчилэн аж ахуйн нэгжүүд дампуурч, ажилгүйдэл нэмэгдэх нь эдийн засаг буцаж хямралын өмнөх хэвийн түвшиндээ очиход нэн төвөгтэй саад болох тул хямралыг сөрсөн төрийн сангийн удирдлага бүхий эдийн засгийн бодлого эрчимтэй хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл, улс орнуудын Засгийн газрын нэн тэргүүний зорилт болох ажлын байрыг хамгаалан үлдэх зорилгоор том, жижиг гэж бизнесүүдийг ялгалгүй төрөөс бүхий л талын санхүүгийн тусламж, дэмжлэгийг үзүүлж байна.

Тухайлбал, Япон улсын Засгийн газар ДНБ-ы 40 орчим хувьтай тэнцэх 1,1 их наяд долларын нэмэлт төсөв баталж, улсын харьяалал харгалзахгүй хүн бүрт 950 ам.доллар бэлнээр олгох, үйл ажиллагаа нь доголдож буй жижиг, дунд бизнес эрхлэгч нарт 2 сая иен хүртэлх (19 мянган ам.доллар) буцалтгүй тусламж олгох, 10 сая иений хүүгүй, барьцаагүй 5 жил хүртэл хугацаатай зээл олгох арга хэмжээг авч байна. Мөн БНХАУ санхүүгийн зах зээлдээ 120 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний

юанийн санхүүжилт хийж бизнес эрхлэгчдээ дэмжихээр болов. АНУ-ын Холбооны нөөцийн сан гэхэд 350 тэрбум ам.долларыг жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээл олгохоос гадна нийт , 100 хувь баталгаа өгнө гэж зарлалаа. Герман (ХБНГУ) Цар тахлын хөл хорионы улмаас үүсэж болох эдийн засгийн хямралаас сэргийлэхийн тулд бизнес эрхлэгч аж ахуй нэгжүүдэд “хязгааргүй” нөхцөлтэй зээл өгөхөөр боллоо. Энэхүү зээлийг бизнесийн хэмжээнээс үл хамааран, ялгаваргүй олгохоос гадна төлөх ёстой их хэмжээний татварыг түр хугацаанд хойшлуулна гэв. БНСУ жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 50 их наяд вон буюу 39 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний яаралтай санхүүгийн тусламжийг үзүүлж, зээлийн нөхцөлийг хөнгөлөхөөр боллоо.

Харин манай улсын хувьд аж ахуйн нэгжийг НДШ, татварын торгууль, алдангиас чөлөөлөх, 1,5 тэрбум төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжийг ААНОАТ-аас түр чөлөөлөх, 500,0 сая төгрөг хүртэл үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй зээлийн хүүг бууруулах, хөнгөлөх, ЖДҮ эрхлэгчдэд зориулсан зээлийн батлан даалтын дээд хэмжээг бууруулах, борлуулалтын орлого нь буурсан ч ажлын байраа хадгалж үлдсэн аж ахуйн нэгжийн ажилчдад сар бүр 200,000 төгрөг олгох зэрэг шат дараалсан арга хэмжээг авч байна.

“Манай орны хувьд борлуулалтын орлого нь 50 хувь буурсан үед ажилчид нь тэтгэмж авах эрхтэй гэж заасан нь хямралыг тэсч үлдэх хэмжээний нөлөө үзүүлэхүйц байж чадахгүйгээс гадна аж ахуйн нэгжүүдэд нэн шаардлагатай байгаа санхүүжилтийн эх үүсвэрийн дэмжлэг байхгүй байна.”

Бусад улс орны Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хямралын эсрэг бодлого, шийдвэрүүдийг ерөнхийд нь авч үзвэл, бодлогын хүүгээ буулгаж, жижиг дунд бизнесүүд ажлын байраа хамгаалахад нь зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна нэн шаардлагатай байгаа хямд өртөг бүхий санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж байна. Харин манай орны хувьд борлуулалтын орлого нь 50 хувь буурсан үед ажилчид нь тэтгэмж авах эрхтэй гэж заасан нь хямралыг тэсч үлдэх хэмжээний нөлөө үзүүлэхүйц байж чадахгүйгээс гадна аж ахуйн нэгжүүдэд нэн шаардлагатай байгаа санхүүжилтийн эх үүсвэрийн дэмжлэг байхгүй байна. Өөрөөр хэлбэл, олон сарын өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд бизнесийн үйл ажиллагаа нь хаалттай байсан үйлчилгээний салбарын хувьд ямар ч борлуулалтын орлогогүйгээс наад захын цалин, түрээсийн төлбөрт шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр олж чадахгүй, банкуудын хувьд ч зээл гаргах сонирхолгүй байгаа юм.

Нөгөөтэйгүүр, улс орнууд өөрсдийн боломжит хувилбараар бизнес эрхлэгчдээ дэмжиж, тогтвортой бизнесийн орчинг хадгалж үлдэхийг зорьж байгаа ч одоогийн хямралын тодорхойгүй нөхцөл байдал нь бизнесийн салбар бүрт харилцан адилгүй нөлөөлж байгаа нь олон жишээнээс харагдана. Аливаа зүйл хоёр талтай байдгийн адилаар хямралын нөлөөнд үл автаж бизнесийн үйл ажиллагаа нь улам өсдөг салбар гэж байдаг. Энэхүү цар тахлын үеийн нөхцөл байдал нь хүн хоорондын зай барьж, тусгаарлах хэв маягтай байна. Үүнийг дагаад онлайн бизнесийн хэрэгцээ хэд дахин өслөө. Тухайлбал, цахим худалдаагаар дэлхийд тэргүүлэгч компаниудын нэг АМАЗОН-д цар тахлын оргил үеэр секундэд 11 мянган долларын худалдан авалт хийгдсэн байна. Түүнчлэн цахим төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд ашигтай ажиллаж байна гэж ВВС мэдээллэв.

Цар тахал цахим бизнес ямар ач холбогдолтойг, бизнесээ цахим системд

суурилуулахын давуу талыг харуулж байна. Ерөнхийд нь авч үзвэл, цахим бизнесийн үйл ажиллагаа харьцангуй ашигтай буюу цар тахлын үед илүү хожилтой ажиллаж байгаа юм. Манай улсын хувьд ч мөн ялгаагүй цар тахлын хөл хорионы үед бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэхийн тулд цаг үедээ тохируулан цахим үйлчилгээг нэвтрүүлсэн жишээнүүд ч байна. Тухайлбал, онлайн эмийн сангийн үйлчилгээ, зочид буудал, ресторан, цайны газрын махны нэгдсэн хангамжийн цахим систем, өрхийн хэрэгцээний хүнсний ногооны онлайн захиалга хүргэлт зэрэг үйлчилгээ нэвтэрчээ.

Харин эсрэгээрээ хямралд хамгийн ихээр өртөж буй салбарууд бол аялал жуулчлал болон агаарын тээвэр салбар гэдгийг ВВС тэргүүтэй дэлхийн хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллэв. Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлөөс гаргасан судалгаанаас харахад цар тахлын улмаас тус салбарт 50 сая ажлын байр үгүй болж, энэ онд гэхэд аялал жуулчлалын зах зээл 25 хувиар хумигдана гэж тооцжээ. Иймд зарим улс орнууд хямралд өртөж буй салбаруудаа онцгой анхаарч үйл ажиллагааг нь дэмжих хөтөлбөрүүдийг батлаж эхэллээ. Жишээлбэл, Япон улс дотоодын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор өнгөрсөн долдугаар сараас эхлэн “Go to Travel” хөтөлбөрийг хэрэгжүүлээд байна. Энэхүү хөтөлбөр нь аялал жуулчлалын бизнес эрхлэгч дотоодын компаниудынхаа үйл ажиллагааг тасалдуулахгүй, аялагчдыг татах зорилготой урамшууллын хөтөлбөр юм. Мөн “Go to Eat” хөтөлбөрөөр дамжуулан дотоодын сүлжээ ресторанууд болон хоол үйлдвэрлэлийн бизнес эрхлэгч компаниудынхаа үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 25%-ийн хөнгөлөлт үзүүлэх гэх зэргээр хямралд өртөж буй бизнесүүдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Дэлхийн улс орнууд энэ мэтчилэн ажлын байрыг хамгаалахад түлхүү анхаарч, хямралыг эрсдэлгүй давах бодлого боловсруулан ажиллаж байгаа бол манай орны хувьд жижиг дунд бизнес эрхлэгчдэд тийм ч таатай орчин бүрдэж чадаагүй хэвээр байна.

Коронавирусний тархалтын улмаас үүссэн цар тахал дэлхийн улс орнуудын эдийн засаг, улс төр, нийгмийн харилцаанд томоохон өөрчлөлт авч ирэх нь тодорхой байгаа бөгөөд хэр их өөрчлөлт, хор хөнөөл бий болгох вэ гэдэг нь улс орнуудын төрийн бодлого, шийдвэр хэрхэн үр ашигтай хэрэгжихээс шалтгаалах юм.

Европ тэргүүтэй гадаадын орнуудад корона вируст халдварын хоёр дахь давалгаа эхэлж, халдвар авагсдын тоо сая саяар нэмэгдэж байгаа нь цаашид ч тодорхой хугацааны турш цар тахлын нөхцөл байдал үргэлжилж, хүн төрөлхтөнд аюул учруулсаар байх нь нэгэнт ойлгомжтой болжээ. Харин үүнээс үүдэлтэй эрсдэл тэр дундаа эдийн засгийн хямралыг хэрхэн даван туулж ямар сорилт, боломжтой нүүр тулах тухай вэ гэдэг зөвхөн таамаг төдий боловч нэгэнт нүүр тулсан цар тахалтай дасан зохицох аргаар зогсонги байдалд орсон эдийн засгийн урсгалаа сэргээх бодлогыг дэлхийн улс орнууд хэрэгжүүлж байна.

• ***Цар тахлын дараах бизнесийн орчин хэрхэн өөрчлөгдөх талаар олон улсын судлаачид юу хэлэв?***

“Олон улсын судлаачдын ихэнх нь цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнууд дотоод хэрэгцээгээ хангах бүтээгдэхүүнээ өөрсдөө үйлдвэрлэх шаардлага бий болж байна гэдгийг тодотгоод, цаашид дэлхий даяар шинжлэх ухаан, технологийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, ирэх 10 жилд хүн төрөлхтөний амьдрал цахимжих (digitalization) үйл явц хүчтэй өрнөж энэ нь нийгэм, эдийн засгийн бүх

салбарт хүчтэй тархснаар, аж үйлдвэрээс технологийн шинэ эрин үед шилжих чиг хандлагатай байгааг онцолжээ.”

Жижиг дунд бизнесийг дэмжих, дотоодын эдийн засгийн эргэлтийг тэлэх, гадаад худалдаанаас хамаарах хамаарлыг бууруулах чиглэлээр хийгдэж буй Засгийн газруудын төсөл, хөтөлбөрийн үр дүнд эдийн засаг дахь төрийн оролцоо эрчимтэй нэмэгдэж байгааг дийлэнх судлаачид онцолж байна. The Council of Foreign Relations дэх Латин Америкийн асуудал хариуцсан судлаач Шэннон К'Онейлын хэлж байгаагаар, ихэнх компаниуд түүхий эдийн нийлүүлэлт нь хаанаас хамааралтай байсныг ойлгож дотооддоо түүхий эд бүтээх шинэ арга замууд бий болгоно гэв.

Харвардын Их Сургуулийн профессор Пол Антрас Эдийн засгийн бодлогын судалгааны төв(CEPR)-ийн зохион байгуулсан онлайн хэлэлцүүлгийн үеэр тавьсан илтгэлдээ “Дэлхийн эдийн засагт цар тахлын учруулж буй нөлөө нь бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд урт хугацаанд үргэлжлэх өөрчлөлт бий болгоно” хэмээн таамаг дэвшүүлжээ. Дэлхийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, нийлүүлэлтэд томоохон байр суурь эзэлдэг Хятад улс цар тахалтай холбоотойгоор 2-3 сар түр зогсолт хийсэн. Энэ нь бусад улсуудад ихээхэн цочроо өгч, өөр шинэ гарц хайх сэдлийг төрүүлэв. Мөн дэлхийн хамгийн том эдийн засагтай орнуудын удирдагчид Хятад улсаас үйлдвэрээ гаргах, үйлдвэрлэлийн байршлын тоог өөр улсад нэмэгдүүлэхийг уриалж эхэлсэн юм. Жишээлбэл, Европын холбооны худалдааны төлөөлөгч Фил Хоган өнгөрсөн дөрөвдүгээр сард хийсэн мэдэгдэлдээ худалдааны хараат байдлыг багасгана гэсэн бол Япон улс 2.2 тэрбум ам.долларын багцыг Хятад дахь үйлдвэрээ өөр улсад нүүлгэн шилжүүлэх өөрийн улсын компаниудад санхүүгийн урамшуулал олгоход зарцуулах шийдвэр гаргав.

Хямралын дараах эдийн засгийн нөхцөл байдал, бизнесийн орчны талаар байр сууриа илэрхийлж, таамаглалаа дэвшүүлсэн олон улсын судлаачдын ихэнх нь цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнууд дотоод хэрэгцээгээ хангах бүтээгдэхүүнээ өөрсдөө үйлдвэрлэх шаардлага бий болж байна гэдгийг тодотгоод, цаашид дэлхий даяар шинжлэх ухаан, технологийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, ирэх 10 жилд хүн төрөлхтөний амьдрал цахимжих (digitalization) үйл явц эрчимтэй өрнөж энэ нь нийгэм, эдийн засгийн бүх салбарт хүчтэй тархснаар, аж үйлдвэрээс технологийн шинэ эрин үед шилжих чиг хандлагатай байгааг онцолжээ.

• ***Цар тахлын дараах Монгол дахь бизнесийн орчин ямар байх вэ?***

Эдийн засаг дахь эрэлт, нийлүүлэлтийг зэрэг хумисан энэхүү цар тахал хэзээ намжиж бүрэн хяналтад орох вэ гэдэг тодорхой бус байдал нь Монгол төдийгүй дэлхийн бизнесийн салбарт хамгийн том сорилт болоод байна.

“Хямралын дараах үеийг ашиглан экспортод чиглэсэн үйлдвэрлэл эрхэлж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийг зээлээр дэмжих, санхүүгийн хүртээмжийг сайжруулах оновчтой хэлбэрийг олох, мөн түнш улс орнуудтай хамтран дэвшилтэт технологи бүхий экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулах хэрэгтэй байна.”

Олон улсын түвшинд тив дамжсан худалдаа, ханган нийлүүлэлт хэвийн горимдоо шилжих эсэх нь халдварын тархалттай холбоотой учраас бизнесийн салбар дахь цар тахлын нөлөөг бууруулах, зах зээлд итгэх итгэлийг сэргээж, нийт эрэлтийг тэтгэн эдийн засгийн огцом уналтаас зайлсхийх бодлого хэрэгжүүлээд явж байна. Харин манай орны хувьд дээрх алхмыг хэт оройтож эхлүүлсэн нь жижиг дунд

бизнес эрхлэгчдээ элгээр нь хэвтүүлэхэд хүргэлээ.

Цар тахлын улмаас гадаад хилээ хааж, дотооддоо хөл хорио тогтоосноор дотоодын хэрэглээ түр хугацаагаар бууралтад орж, бизнесийн орчин болон аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн талаарх үзэл бодол өөрчлөгдөн тодорхой бус байдал бий болов. Үүний улмаас хөрөнгө оруулалт багасах, тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээний нийлүүлэлтэд хоцрогдол гарах, бэлэн мөнгөний хомсдолд орох, үйлдвэрлэлийн хангамж нийлүүлэлтийн сувгууд болон худалдаа арилжаагаар дамжин эдийн засгийн бусад хэсгүүдэд эрэлтийн цочрол үүссэн болохыг МҮХАҮТ-аас гаргасан “Covid 19-Бизнес дэх нөлөөллийн судалгааны нэгдсэн тайлан” -д дурджээ. Урт хугацаанд үргэлжилсэн хөл хорио нь орон даяар ханган нийлүүлэлтийн сүлжээг доголдуулах гол шалтгаан болов. Энэ бүгдээс харахад, дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, нийлүүлэлт, хангалтад онцгой анхаарал хандуулж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг төрөөс дэмжих урт хугацааны боловсронгуй хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага нэгэнт бий болжээ.

Нөгөөтэйгүүр, хямралын үед үргэлж боломж гардаг гэдэгчлэнгээр эрдсийн зах зээлд таатай нөхцөл үүсэв. Цар тахлын нөлөөгөөр үүссэн тодорхойгүй байдал нь алтны ханшийг өсгөж, түүхэн дээд үзүүлэлтийг авчирлаа. Манай улсын экспорт буурсан үзүүлэлт гарсан ч алт, зэсийн ханш өсөх тал руугаа эргэсэн нь эдийн засгийн үзүүлэлтийг оны сүүлээр илүү дээрдүүлэх шалтгаан болно гэсэн эерэг хүлээлттэй байна. Учир нь Хятадын эдийн засаг хоёр дугаар улиралд эерэг өсөлттэй, сүүлийн саруудад үйлдвэрлэлийн салбарт тэлэлттэй байгаа нь экспортын гол түүхий эдийн эрэлт болон үнэд эерэгээр нөлөөлж байгаа юм.

Мөн манай улсын эдийн засгийн гол хөшүүрэг болсон уул уурхайн салбар өнгөрсөн 2 улиралд 30% орчим уналтад ороод байсан ч наймдугаар сараас эхлэн сэргэлт ажиглагдсан нь орлогын эх үүсвэр нэмэгдэх төсөөлөлтэй байна. Гэвч манай улс түүхий эдэд суурилсан орлогодоо найдвар тавьж байгаа нь эрсдэлтэй буюу гадаад зах зээлийн өөрчлөлтөд амархан өртөнө гэдгийг дотоодын эдийн засагчид сануулж байгааг мартаж болохгүй.

Цар тахлын хүндрэлт нөхцөл байдлаас үүссэн энэ үеийг ашиглаад төр ч бай, бизнесийнхэн ч бай эдийн засгийн алдаатай бүтцээ сууриар нь засах боломж гэж харах нь зүйтэй. Энд хэд хэдэн зүйл ажиглагдаж байгааг дурдвал, төрийн зүгээс хяналт, шалгалтаас илүүтэй бизнесийн салбарын үйл ажиллагааг тэлэх, дэмжих оролцоотой байх ёстой гэдгийг сануулж байна.

Хямралын дараах эдийн засгийг сэргээж, бизнесийн орчныг дэмжихийн тулд бусад салбарын экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг мөн энэ үе харууллаа. Экспорт гэхээр зөвхөн нүүрс, эрдэс, махаар хязгаарлагдахгүй. Байгаль орчинд ээлтэй “эко” гэх бүтээгдэхүүн дэлхийд эрчээ авч байгаа энэ үед манайд энэ төрлийн бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэх боломж бий. Нэг үеэ бодвол манай бизнес эрхлэгчид гадагшаа чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийхийг зорьж байна. Гэтэл экспортын чадамжтай бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах нь нэг бизнесийн байгууллага, компанийн ажил биш. Иймд хямралын дараах үеийг ашиглан экспортод чиглэсэн үйлдвэрлэл эрхэлж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийг татварын бодлогоор болон зээлээр дэмжих, санхүүгийн хүртээмжийг сайжруулах оновчтой хэлбэрийг олох, мөн түнш улс орнуудтай хамтран

дэвшилтэт технологи бүхий экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулах хэрэгтэй байна.

Төр засаг гадаад худалдааг дэмжих, гадны хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татах, боловсруулах үйлдвэрийг байгуулах, экспортыг дэмжих замаар валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлага бий болоод байгааг одоогийн нөхцөл байдал харууллаа.

Жижиг дунд бизнес эрхлэгчид орлого багатай байж болох ч, олон тооны ажлын байр бий болгож байдаг учраас эдийн засгийн тогтвортой байдалд маш чухал үүргийг гүйцэтгэдэг учир жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогыг урт хугацаанд үр ашигтай байхаар боловсруулахыг цар тахлын үеийн хямрал шаардаж байна.



Орчин цагийн түүхэнд буюу 1800 оны дунд үеэс хойш дэлхий дахинд нийтдээ 14 удаагийн эдийн засгийн хямрал тохиожээ. Харин Дэлхийн эдийн засгийн форумын эрсдэлийн шинжээчдийн үзэж байгаагаар коронавирусний тархалтаас улбаатай энэ удаагийн эдийн засгийн хямрал нь Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи хамгийн хохирол ихтэйд тооцогдож байна.





**Боржигин Дарханхүүд овогт
Төмөрийн Болдбаатар**

1968-1978 онд сумынхаа ЕБС-ийн 10 жилийн анхны төгсөгчдийн нэг.

1978-1983 онд МУИС-ийн ХБФ-ийг МХУЗ-ын багш-судлаачаар, 1995 онд ЗГ-ын дэргэдэх ТЗУХИ-ийн үндсэн ангийг төрийн удирдлагын зохион байгуулагч-арга зүйч мэргэжлээр тус, тус дүүргэсэн.

1983-1988 онд АУДус-ийн хичээлийн эрхлэгчээр, 1988-1989 онд “Ялалт” сонины утгазохиолын ажилтнаар,

1989-1991 онд Сүмбэр сум-САА-н ҮЭ-ийн зөвлөлийн даргаар,

1991-1992 онд Чойр хотын АХГЗ-ны Хэрэг эрхлэх хэлтсийн даргаар, 1992-1994 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргаар,

1995-1997 онд тус аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтнаар,

1997-1999 онд мөн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар,

2002-2003 онд аймгийн хэвлэл-мэдээллийн төвийн даргаар, 2016 оноос тус аймаг дахь МҮОНР радиогийн сурвалжлагчаар ажиллаж ирсэн байна.

БИЗНЕС ЭНГИЙН АМЬДРАЛ

Хаа газар албаны хэллэгээр нийгмийн амьдралын хэв маяг, оролцоо, идэвх чармайлтаараа үлгэр загвар болохуйц, хэлсэн, хийснээс нь санаа авахгүй байхын аргагүй сэхээрлэг улс байдаг.

Гүйлгүү ухаан, сийрэг хөнгөн толгойтой нэг үгээр аливаа шинэ санаа сэдлийг тусгаж авахдаа гаргуунхурдтай, хэнхүндөөрийгөө ойлгуулахдаа нээлттэй авхаалж овсгоотой хүмүүсийн нэг МҮХАҮТанхимын Говьсүмбэр аймаг дахь салбарын тэргүүн, ГСБЭХ (Говьсүмбэр Бизнес эрхлэлтийн хөгжил хадгаламж зээлийн хоршоо)-ны гүйцэтгэх захирал МЗЭ-ийн болон С.Буяннэмэхийн нэрэмжит шагналт, яруу найрагч, хүүхдийн зохиолч, Боржигин судлаач Рагчаагийн Батжаргалын Цэцэгээтэй хөөрөлдсөн ярилцлагаа эрхэм уншигч танд толилуулж байгаадаа нэн таатай байна.

-Сайн байн уу? Ажил алба нь аятай байна уу?

-Сайн байна аа. Таны ажил төрөл сайн уу?

-Хоёулаа бизнес гэдэг үгийн талаархи санаа онооноос ярилцлагаа эхэлвэл гэж бодогдчихлоо, ямар санагдана вэ?

-Бололгүй дээ, манайхан бизнес гэхлээр уулсаас тасарч, наран хөөрсөн шиг алс холын юм бодож сэтгэлийн ачаалал аваад байх шиг харагддаг. Бизнес хүн бүрийн, айл өрхийн өдөр тутмын л хэв зандаа амьдрал юм шүү дээ. Зөвхөн лангуу түшиж, ачаа бараа зөөсөн, мөнгө багцалж тоолсон хүмүүсийн үйл биш. Амьдрал өөрөө байнгын бизнес гэдгийг ойлгох хэрэгтэй. Амьдрал залгуулах, болох бүтэхтэй явах ухаан юм. Заавал онолынх нь талаас зай завсар гаргаж хүндрүүлж хүлээж авахын хэрэггүй ухагдахуун байгаа биз...

-Өнөө маргаашдаа ажил хэрэгч хүмүүсийн санааг чилээж байгаа асуудлын талаар санал солилцоё гэж бодогдчихлоо. МУСК “Сэрэлт”-д гол дүр Бумаа гуай, орос эмч хоёрын ярианд гардагчлан сүүлийн хагас жил тойрон урьд өмнө үзэгдэж сонсогдож байгаагүй хожим хойшид ч дахин бүү дурсагдаг гэмээр “Цар тахал гэх мам” дэлхий даяарыг цочоох нь байтугай бусниулж байгааг хэн хүнгүй мэдэж мэдэрч, өдөр тутмын ажил амьдралд мэдэгдэхүйц нөлөөлж эхлээд байгаа талаар...

-Харин тийм ээ. Энэ гэнэтийн сүрхий өвчний тархалт аливаа эрсдэлээс хохирол чирэгдэл багатай, хор уршиг амсахгүй ар дээр нь гарах бие, сэтгэлийн эрч хүч, итгэл үнэмшил, бизнесийн бэлэн байдалд байхыг шаардаж байна. Энгийн ярианы үгээр хэлэхэд, цар тахлаас улбаатай сүүдэр тусаагүй салбар хаа байхав дээ. Тэр дундаа улс орны хөгжил дэвшил, бодлого төлөвлөлтөд онцгой үүрэгтэй бизнесийн салбарт мэдэгдэхүйц сөрөг үр дагавар цөхөх юмгүй нүүрлэж эхэллээ.

Адаглаад л олон нийтийг хамарсан ажиллагаа хязгаарлагдаж, бүх үйл ажиллагаа дэг журамд шилжиж, байсхийгээд л хөл хөсийн хорио цээр тогтоож байнгын, тогтвортой нийтийн ажил үйлчилгээний горим алдагдаж байна.

Жишээ татахад...

Манай байгууллагад мэдэгдэм байгаа. Төсөл боловсруулах захиалга, хамтарч ажилладаг түншүүдийн харьцаа, хандлага, бизнес эрхлэлтийн хэвийн гольдрол гээд өглөө болгон л шинэ эрсдэл, бэрхшээл учрах төлөв яахын аргагүй ажиглагдаж байна. Ухаандаа эхлүүлсэн жижиг бизнес нь доголдоод эхлэнгүүт эрхлэгчдийнх нь санаа зовж, сэтгэлийн хямралд орох, итгэл алдрах түүнчлэн бидний хувьд ч эргэлзээ төрөх, хандсан болгонд зээл, төсөл олгохын аргагүй болох жишээний. Ажил үйлчилгээ доголдож өдөр тутмын орлого хомсдоод эхлэхээр өндөр өртөгтэй түрээсийн лангуу, талбайнханд эрсдэл үүсэж хаах, татгалзахаас аргагүй болно. Хамрагдагсадын төлбөрт суурилдаг хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуулиуд хаалгаа барихдаа тулах,арилжааны банкуудаас зээлтэй жижиг, дунд үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэгчдийн хувьд гэнэтийн цохилт болж цөөн тооны ажилчдаа алдах, зээлийн хүүгийн өр үүсэх, аливаа ажил үйлчилгээний эрэлт захиалга мэдэгдэхүйц буурах, гаргасан зардлаа нөхөх найдваргүй болох, ахуйн хэрэглээндээ өртөг зардал гаргахаас татгалзах, арвилан хэмнэлтийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх, үр ашиггүй өөрөөр хэлбэл, зугаа цэнгэл, найр наадмын ажиллагаа зэрэг ашиг унахгүй илүү зардлаас зайлсхийж сурахыг цар тахал харанга дэлдэн шаардаж байгааг анхаарч,анзаарах л хэрэгтэй.

-Танай байгууллагуудын зүгээс харилцагч, хамтрагч түншүүдтэй ямар бодлого баримталж ажиллаж байгаа вэ? Энэ чинь бусдад туршлага, сургамж болох нь лавтай.

-Тийм шүү. Туршлагын хэмжээнд сүржигнэдэггүй юмаа гэхэд санаа өгч, авалцах орц, гарц юм л даа.

-Дав дээр шинэ бизнес эхлүүлэхээ харзнах, төсөл, зээлд хамрагдахаа амсхийхийг нөхөрсөг байдлаар зөвлөж эхэлсэн. Аль, аль талынхаа эрсдэлийг бодож болгоомжлох нь шулуун. Ялангуяа манай ХЗХ бол олон хүмүүсийн сайн дураар нэгдэж бүрдүүлсэн хуримтлалаас бүрдсэн хөрөнгөтөй ганц, хоёрхон хүн эз мэдэж захиран зарцуулах эрхгүй мэдэл нь олон эхтэй, нарийн хяналт шалгууртай нэгж . Ахицгүй болсон үйлдвэрлэл-үйлчилгээний салбарыг хэлбэр, чиглэлээ өөрчлөөд үзэхийг санал болгож байна. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж барилгын материал, төмөр хийц, бэлэн хувцасны худалдааг хүлээзнэх нь зөв шигээ.

-Цар тахлын ул мөрнөөс ямар сургамж төрж байна вэ? Гэрийн эзэгтэй, нийгмийн салбарын идэвхитэй эмэгтэй удирдагчийн хувьд. Саналаа хуваалцана уу.

-Нэг сайхан уламжлал дурдаяа. Монголчуудын аяганы уутандаа зэс, мөнгөн аягаа хийж хаа яваа газраа хэрэглэж байсан дадал нэгийг хэлж байж уу гэх бодол төрдөг. Эрүүл мэнддээ анхаарч, элдэв халдвараас сэргийлэх, болзошгүй өвчлөлөөс өөрийгөө хамгаалахад суралцах, энэ тал дээр нийтийн “өмч”-ийн хэрэглээ, сэтгэлгээнээс салах хэрэгтэй бишүү. Зөвхөн цар тахал биш хэзээ цагт ямар ч аюул эрсдэл, байгалийн давагдашгүй хүчин зүйлтэй тохиолдлоо гэхэд өөрийгөө, гэр бүлийнхнийгээ, өрөөл бусдыг хамгаалах мэдлэгтэй, энэ талын мэдээллийг сонирхохыг цаг үе, нөхцөл байдал аргагүй л шаардаж байна даа. Монголчуудын хүнсний зүйлээ он, сараар хатааж боловсруулдаг, сүү цагаан идээг голчлон хэрэглэдэг одооныхоор эрүүл аюулгүй хоол хүнсний хэрэгцээ, хангамжийг эрхэмлэх нь элдэв эрсдэлээс эрүүл, амь насанд халгаагүй гарах нэг арга юм. Эрүүл биеийн саруул ухаанаар амьдарч, ажиллах хэвшилтэй болсон байхад алзах юмгүй дээ.

Олноор нэгэн байршилд удаан хугацаагаар бөөгнөрөхгүй байх, амны хаалтаа хийж дадах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтэц шиг иргэдэд эрүүл аюулгүй орчин нөхцөл, дэд бүтэц бий болгох. Үргүй зардлаа танаж олон нийтийн үйлчилгээний газруудад гар хүрэхгүйгээр орж, гарах хаалга, мөн шилэн хийцний тусгаарлах тоног төхөөрөмж угсрах, сургалт семинарыг цахимаар хийж занших, хоол хүнсний тал дээр вакуумжсан нэг удаагийн савлагаа, сав баглаа боодлын асуудлыг шийдэх гээд.

Дархлаа сайжруулах, дэмжих эм бэлдмэлийн үйлдвэрүүдийг олноор нээж ажиллуулах, орчны агааржуулалтыг хангах, бохирдлыг устгах талаар соён гэгээрүүлэх ажлыг дээхэн үеийн эмнэлэг гэгээрлийн өдөр шиг явуулж хэвшвэл үр дүнгээ өгөх нь мэдээж. Ариун цэвэр халдваргүйтгэлийн аж ахуйн нэгжүүд байгуулж, хэрэгцээ шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг эх орондоо байгаа нөөцөөрөө бэлтгэж хангавал яанав. Саяхан зурагтаар гарна лээ. Хог хаягдал, цэвэрлэх байгууламжийн үнэр дарах зорилгоор лууль, шарилжийг хатааж ариутгалын бодис үйлдвэрлэхээр бэлтгэл хангаж байгаа тухай болж л байгаа санаа шүү дээ.

Сэргийлж, хамгаалахын тухайдад бодсоноо хэлчихэд, орон нутгийн замын гудагт ажиллаж байгаа энэ олон хоол цайны газруудыг хаах хэрэгтэй. Ямар ч хяналт шинжилгээгүй дээрээс нь замын хүмүүс шавааралдаж үйлчлүүлэх нь замбараагаа алдах аюултай хэрэг. Нэг талдаа аж ахуйн нэгж байтугай айл өрхийн хувьд ч арилжааны банктэй зээлийн гэрээгүй нь бараг л байхгүйг харгалзаж үзье ч гэсэн дагалдах аюул, осолтой үр дагавар ихтэй болохоор тоймтой арга хэмжээ авах төрийн бодлого байх хэрэгтэй. Энэ жил аялал жуулчлал, буудлын үйлчилгээ манай орон нутагт л лав зогсож төлөвлөсөн ажил дагалдаад орлого олно гэж тооцоод авсан зээл эргэн төлөгдөхөд хүндрэл гарч байгаа нь тодорхой харагдаж байна.

-Нэмж хэлэх асуулт оноогоогүй зүйл байвал тодотгож ярина уу..?

-Тохиолдсон хоёрхон жишээ түшиж ярья л даа. Манай ХЗХ-ны гишүүд он гарсаар долоо хоног тутам хадгаламжид мөнгө хийж, хуримтлалаа арвижуулж эхэлсэн энэ талаар уралдаан өрнүүлсэн нь хэт ирээдүйд ашигтай гэдгийг тооцоолж байгаа хэрэг. Ер нь ня-бо бүртгэлийн системд өөрчлөлт оруулж, эрсдэлийн сантай болох, төрөлжсөн сангуудыг ажиллуулахад тун гэмгүй гэх санааг өнөө жилийн

явц байдал хэлээд өглөө. Хүмүүс олноороо ажлаас халагдах, өвчин эмгэг нэрмэх гэх мэтчилэн төсөвлөгөөгүй өндөр өртөгтэй зардлууд гараад ирэхэд яах вэ гэхэд арга, хариулт нь бэлэн л байх ёстой болж дээ. Манай хоршоо бүх гишүүдийн хурлаа онлайнгаар хийхэд түвэг учраагүй болж л байна лээ. Манай аймгийн “Буян Го- Го” нэртэй хувийн цэцэрлэгийн сургалтын чанар үр нөлөө тун дажгүйд тооцогддог. Төмөр замын баруунаар байрлаж үйл ажиллагаа явуулдаг хайлуур жоншны баяжуулах гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн монгол ажилчид энэ хавар “Буян Го-Го” цэцэрлэгт хүүхдээ бөөнөөр нь хамруулж сургалтын ажлын үр өгөөжид нь талархахдаа зарим нэгэн тавилга үнэ өртөггүй хийж өгсөн байсан. Хотын утаа тортог ихсэх үеэр бас ажлын таван хоногийн турш нийслэлээс хүүхдээ нэгдсэн журмаар авчирч хамруулах үйлчилгээ нэвтрүүлэх боломж байгааг, хувийн цэцэрлэгийн хамрах хүүхдийн тоо санхүүгийн чадамжтай холбоотойгоор хумигдаж байгаа болохоор дэмжлэг үзүүлэх гэсэн санаа. Аймгийн төвийн цэцэрлэг 200 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөл хийж байгаагаас ч шалтгаалж байгаа хэрэг.

Цар тахлын улмаас ахуйн дэг ч өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байна. Үүдэндээ зориулалтын тусгаарласан өрөөтөй болж тэндээ гараа ариутгаж, гутал, хувцсаа сольж тус, тусад нь өлгөх гээд. Бага юм биш. Цагийн байдалтай уялдаж сэтгэлгээнд гарч байгаа хувьсал өөрчлөлт гэж үзэхэд болно.

Сэтгүүлчийн хүсэлтийг хүлээн авч тодорхой сэдвээр илэн далангүй ярилцсан танд баярлалаа. Ажлын амжилт хүсье.



**Дашинамжил овогтой
Баяржаргал**

*1997-2007 он Архангай
аймгийн Хайрхан сумын ЕБС,*

*2007-2011 он МУБИС
сэтгүүлч мэргэжлээр төгссөн.*

*2011-2014 “Өглөөний сонин”-д
сурвалжлагч,*

*2014 оноос МҮОНРТ-н
Хурд агентлагт сурвалжлагч,
редактор, тоймчоор ажиллаж
байна.*

МҮОНРТ

**КОВИД19 ЦАР ТАХАЛ ХЭЗЭЭ НАМЖИХЫГ ХЭН
Ч МЭДЭХГҮЙ Ч ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ ХЭН
БҮХЭНД МЭДРЭГДЭНЭ**

Ковид19 цар тахлын нөхцөл байдал хэзээ намжих вэ, цар тахлын дараах нөхцөл байдал ямар байх вэ гэсэн асуудлууд иргэд, аж ахуйн нэгжийн дунд байна. Гэвч үүнд яв цав хариулт өгөх хүн монголд битгий хэл дэлхийд алга.

Харин нэг зүйл тодорхой байгаа нь эдийн засгийн хямрал. Гол шалтгаан нь төсвийн алдагдал, хоолойд тулсан гадаад өр. Улсын нийт гадаад өр 2020 оны эхний хагас жилд 30.8 тэрбум ам.доллар болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллар, өмнөх улирлаас 352.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Нийт гадаад зээлийг салбараар авч үзэхэд, нийт зээлийн 35.8 хувь буюу 11.0 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг, 26.3 хувь буюу 8.1 тэрбум ам.доллар нь бусад салбарынх, 25.6 хувь буюу 7.9 тэрбум ам.доллар нь Засгийн газрынх, 5.5 хувь буюу 1.7 тэрбум ам.доллар нь Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх, 6.8 хувь буюу 2.1 тэрбум ам.доллар нь Төв банкных байна.

Ирэх онд Засгийн газар, Төв банк, хувийн хэвшил гээд бүгд түвшинд гадаад зээлийн хэмжээ өснө. Гэхдээ өртөг буюу хүү өндөртэй зээлээр нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Хэдийгээр Олон улсын Зээлжих зэрэглэл тогтоодог байгууллага Standard & Poor's (S&P) агентлаг долоодугаар сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В, тогтвортой” хэвээр үлдээсэн. Түүнээс хойш манай улс Төсвийн тодотгол хийж, алдагдлаа огцом өсгөсөн нь зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй. Учир нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо Нэг хүнд ногдох ДНБ, Авлигын түвшин, Инфляци, Төсвийн тэнцэл, Ажилгүйдэлийн түвшин, Эдийн засгийн урт хугацааны өсөлт зэргийг харгалзан үздэг юм. Эдгээрээс Төсвийн алдагдал 4.8 их

наяд буюу ДНБ-ны 12.5 хувьтай тэнцэж байна. Энэ л манай улсын эдийн засгийг элэгдэж унагаах гол зүйл болчихоод байгаа юм. Эдийн засгийн энэ хямралыг сайд дарга нар үүрэхгүй. Аж ахуйн нэгж, ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэд л үүрнэ. Ковид19 цар тахлын маргааш олон мянган бизнес эрхлэгч эрхэлж байсан ажлаа, зорьж байсан байсан зүйлээ дахин шинээр эхэлнэ. Гэвч эдийн засгийн орчин таагүй байх нь өнөөдрийн нөхцөл байдлаас ойлгомжтой болоод байна.

Олон улсын санхүүгийн байгууллагуудаас төсвийн алдагдлыг зохистой түвшинд барихаас эдийн засаг эрүүлжих, тогтвортой өсөх нөхцөл бүрдэнэ гэж зөвлөдөг. Энэ дагуу 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гаргаж, Монгол улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 2011 онд ДНБ-ий 4%, 2012 онд 3%, 2013 оноос эхэлж ДНБ-ний 2 хувиас ашигтай байна гэж оруулж байсан. Гэвч бодит байдал дээр уг хуулиа төсвийн алдагдалдаа нийцүүлэн өөрчилсөөр байгаад өнөөдрийг хүрсэн. Бид төсвийн алдагдлаа нэмэн нэмэн юуг санхүүжүүлэв. Дийлэнх нь нийгмийн халамжид зарцуулдаг. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих төдий зүйлд зарцуулагдаад дуусдаг. Хоёрдугаарт хөрөнгө оруулалт. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлаас нийгэмдээ, эдийн засагтаа үр нөлөө үзүүлж байгаа зүйл байна уу гээд хайгаад үзэхээр төдийлөн олдохгүй. Ийм нөхцөлд өрийн дарамтаас гарах, эдийн засаг тогтвортой өсөх талаар мөрөөдөхөд бэрх болж таарна. Мэдээж төсвийн алдагдал данхайж байгаагийн өөр нэг шалтгаан нь гадаад зээлийн эргэн төлөлт.

Засгийн газар өндөр хүүтэй бондоор зээлийн эргэн төлөлтөө хийсэн нөхцөлд аж ахуйн нэгжүүд түүнээс дээш хүүтэй зээл авах нөхцөл бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, гадаад зах зээлээс Засгийн газар 10 хувийн хүүтэй бонд гаргасан нөхцөлд, хувийн хэвшил 12 хувийн хүүтэй зээл авах шаардлага үүснэ. Ингээд дотоод зах зээл дээрх зээлийн хүү өндөр байх болно. Бараа бүтээгдэхүүний үнэ өсөх, иргэдийн худалдан авах чадвар муудах гээд макро эдийн засгийн үзүүлэлтүүд хүссэн хүсээгүй уруудаж эхэлнэ.

Гадаад өрийн дарамтаас гарахын тулд яах ёстой вэ? Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжүүлэлтийн талаарх бодлогод зарчмын томоохон өөрчлөлт оруулах ёстой гэдгийг эдийн засагчид зөвлөдөг. Өөрөөр хэлбэл, төсвөөс гарч байгаа төгрөг бүрийн үр ашгийг тооцож, эрэмбэлэх, алдагдлын хэмжээ хязгаар давсан нөхцөлд үлдэж байгаа төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс татгалзах, алгасах арга хэмжээ авч эхлэх шаардлагатай. 2021 оны төсвийн тухай хуулийг хууль эрх зүйн шинэ нөхцөлд хэлэлцэнэ. Тодруулбал, Үндсэн хуулийн 25 зүйлд Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн заалт оруулсан. Энэ зарчмаар бол Засгийн газар хэр чамбай төсөл оруулахаас ихээхэн зүйл хамаарахаар байна.

“

Ковид19 цар тахлын нөхцөл байдал хэзээ намжих вэ, цар тахлын дараах нөхцөл байдал ямар байх вэ гэсэн асуудлууд иргэд, аж ахуйн нэгжийн дунд байна. Гэвч үүнд яв цав хариулт өгөх хүн монголд битгий хэл дэлхийд алга.

”

Shuud.mn



**Гэндэндарам овогтой
Тэгшсүрэн**

2015 онд СУИС-ийн РТМУС-ийг сэтгүүлч мэргэжлээр төгссөн.

2015 оноос “Шууд.мн” мэдээллийн сайтаас ажлын гараагаа эхлэн одоог хүртэл тус сайтад сэтгүүлчээр ажиллаж байна.

“ҮСЧИД ӨДӨРТ ХОЁР, ГОО САЙХАНЧ САРД ГАНЦХАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ УГТАЖ БАЙНА”

Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлын улмаас аж ахуй нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа доголдож, 33 хувь нь ажлын байраа цомхотгоод байгаа судалгааны үр дүнг МҮХАҮТ-аас танилцууллаа.

Судалгаанд оролцсон компаниудын 65 хувийнх нь орлого буурч, 42 хувийнх нь хэвийн үйл ажиллагаа доголджээ. Мөн 30 хувь нь шаардлагатай бүх зардлаа бууруулсан байна. Цаашид 260 мянган хүн ажилгүй болж, 20 мянган компани үүд хаалгаа барих эрсдэл байгааг судалгаанд дурджээ.

Цар тахалтай холбоотойгоор нийтээр мөрдөж буй хязгаарлалт, хорио цээрийн дэглэм нь зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, улмаар тухайн аж ахуйн нэгжүүд болон иргэдийн мөнгөн орлого тасалдаж, төлбөрийн чадвар муудаж, банкуудаас авсан зээлийг гэрээний дагуу төлөхөд хүндрэл үүсэж байна. Давхардсан тоогоор 26 мянган зээлдэгчийн 2.5 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсчээ.

Үүнээс 65.1 хувь нь буюу 2.0 их наяд төгрөг нь аж ахуйн нэгжид, 35.0 хувь нь буюу 545 тэрбум төгрөг нь иргэнд тус тус хамаарч байна. Мөн хуваарийн дагуу хийгдэх ёстой нийт өрийн үйлчилгээнээс 195 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 72 тэрбум төгрөгийн хүү төлөгдөөгүй байна гэж Монголбанкнаас мэдээлсэн.

Тоо яриад суухаас илүүтэй бодит байдлыг сурвалжлахаар хэд хэдэн үсчин, гоо сайхны газрын хаалга татлаа. Багшийн дээд орчимд байрлах үсчин, гоо сайхан гэсэн хаягтай газраар орвол үйлчлүүлэгчгүй, утсаа оролдсон бүсгүйчүүд “Тавтай морил” хэмээн уралдах шахам хэлж уриалгахан угтаж байна.

Жижигхэн өрөөнд гурван үсчин, нэг гоо сайханч ажилладаг юм байна. Үсчний гурван

сандлыг тус тусад нь гурван бүсгүй түрээслэдэг бөгөөд өдрийн 15 мянга, сарын 450 мянган төгрөгийг түрээслүүлэгчид төлдөг байна.

Тэдний нэг нь үсчиний газрынхаа арын өрөөнд бага насны хоёр хүүхдийн хамт амьдардаг бөгөөд энэ өрөөг бүхэлд нь сарын 1 сая төгрөгийн төлбөртэйгээр түрээсэлж ажиллаж амьдардаг аж. Бүсгүй ББСБ-аас лизингийн автомашинтай. Сард 372 мянган төгрөг төлдөг гэнэ. Ингээд сардаа 1 сая 372 мянган төлбөрийг зээл, түрээсэндээ төлдөг тэрбээр өнөөдрийн байдлаар өдөрт ердөө 1-2 хүний л үс засдаг. Зарим өдөр 3 хүний үс засчихвал өөрийгөө ёндоотойд тооцож зогсоо гэж ярилаа. Эдийн засгийн сорилттой тулгарсан энэ хүнд өдрүүдэд ББСБ болоод өрөөний түрээслүүлэгч хоёрын аль аль нь хугацаандаа, бүтнээр нь түрээсээ авах шаардлага тавьж байгаа нь бүсгүйг хүчин мөхөсдүүлэх болжээ.

Үйлчлүүлэгч сайтай бол өдрийн түрээсээ /15 мянган төгрөг/ төлөөд цаана нь 5-10 мянган төгрөгтэй үлдчихдэг. Харин хүн муутай байвал түрээсээ төлөөд цаана нь мянган төгрөгтэй үлдэх өдөр ч байдаг аж. Цэцэрлэг, сургууль амарсан, хөл хориотой эдгээр өдрүүдэд хүнгүй шахам өдрүүд олон гэнэ. Гэсэн ч өрөөний эзэн сар бүрийн түрээсээ яг цагтаа бүтэн төлөхийг шаардсаар байгаа зовлонг үсчид хуваалцлаа.

Харин гоо сайханч эмэгтэйн хүнд өдөр болгон орлогогүй сууж байгаа, 14-20 хоногт нэг л хүн орж ирж байна. Гэтэл өдөрт 10 мянган төгрөг, сард 300 мянган төгрөгийн түрээс төлдөг тухайгаа учирлав. Үнэн учраа хэлэхэд түрээслүүлэгч мөн л “Төлбөрөө цагт нь төлч чадахгүй бол өрөөгөө суллаад гар. Өөр үйл ажиллагаа явуулна” хэмээжээ.

Төлбөрөө бүтнээр нь 30-ндаа өгөхгүй бол өрөөгөө суллаад гараарай гэсэн. Өөр ямар ч арга байхгүй болохоор тэнэгийн дотор уужуу гэгчээр зогсож л байна хэмээн санаа алдан, толгой сэгсрэх бүсгүйчүүд нөхцөл байдлыг ойлгож түрээсээ буулгах, өдөр хоног хойшлуулах зэргээр уян хатан хандахгүй байгаад гомдолтой байгаагаа хэллээ.

Энэ үсчид зөвхөн нэг жишээ. Өөр олон байгууллага, бичил бизнес эрхлэгчид энэ мэтээр үйл ажиллагаа нь доголдон, дампуурал зарлаж байгаа.

Цэдэнбал овогтой Цэрэндолгор нь 2003 онд МУИС-ийн НУФ-ийг сэтгүүлч мэргэжлээр дүүргэсэн. 2003 онд өдөр тутмын “Өнөөдөр” сонины “Ням гараг”-т сурвалжлагчаар орж ажлын гараагаа эхлүүлсэн. 2005-2012 он хүртэл “Улаанбаатар таймс” сонинд ажилласан. 2017 оноос хойш нийгэм, боловсролын мэдээ мэдээллийн Peak.mn сайтад сэтгүүлч, редактороор ажиллаж байна.



Энэ үсчид зөвхөн нэг жишээ. Өөр олон байгууллага, бичил бизнес эрхлэгчид энэ мэтээр үйл ажиллагаа нь доголдон, дампуурал зарлаж байгаа.





**Цэдэнбал овогтой
Цэрэндолгор**

*2003 онд МУИС-ийн НУФ-ийг
сэтгүүлч мэргэжлээр дүүргэсэн.*

*2003 онд өдөр тутмын
“Өнөөдөр” сонины “Ням
гараг”-т сурвалжлагчаар орж
ажлын гараагаа эхлүүлсэн.*

*2005-2012 он хүртэл
“Улаанбаатар таймс” сонинд
ажилласан.*

*2017 оноос хойш нийгэм,
боловсролын мэдээ мэдээллийн
Peak.mn сайтад сэтгүүлч,
редактороор ажиллаж байна.*

Peak.mn

**Ц.ОЮУНЖАРГАЛ: САНХҮҮГИЙН ХЯМРАЛЫГ
БОЛОМЖ ГЭЖ ХАРСАН КОМПАНИУД АСАР
БОГИНО ХУГАЦААНД АМЖИЛТАНД ХҮРДЭГ**

Глобал стратегийн удирдлагын институтийн захирал, стратегийн зөвлөх Ц.Оюунжаргалтай COVID-19 цар тахлын үеийг ААН, бизнес эрхлэгчид хэрхэн хохирол багатай давж гарах вэ сэдвээр ярилцлаа.

-Компаниудад зөвлөх хийдэг хүний хувьд ААН-үүдийн бодит нөхцөл байдлыг хэрхэн харж байна вэ?

-Хүн төрөлхтний түүхэнд сүүлийн 100 жилийн турш тохиогоогүй уг тахлын улмаас дэлхийн улс орнууд эдийн засгийн тэг зогсолт хийхэд хүрч, урт хугацааны хямралт нөхцөл байдал үүсгэлээ. Аливаа улс орны эдийн засагт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн гүйцэтгэх үүрэгтэй. Тийм учраас дэлхийн улс орнуудын Засгийн газраас юун түрүүнд жижиг, дунд бизнесүүдээ онцгой анхаарч дэмжих багц хөтөлбөрийг батлаад байна. Харин манай улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хөтөлбөр нь жижиг, дунд бизнесүүд ажлын байраа хадгалахад болон хямралыг тэсч үлдэхэд одоогоор шууд нөлөө үзүүлэхгүй, дэм тус муутайхан л арга хэмжээ авлаа.

-Стратегич хүний хувьд хямралын үед Засгийн газраас ААН-үүдэд зориулан гаргасан бодлого шийдвэрийг хэрхэн дүгнэх вэ?

-Хямралын үед улс орнууд бодлогын хүүгээ буулгаж жижиг, дунд бизнесүүдээ дэмжиж байна. Жишээ нь АНУ-ын Холбооны нөөцийн банк гэхэд 350 тэрбум долларыг жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээл олгож, 100 хувь баталгаа өгнө гэдгээ зарлачихсан. Ингэснээр арилжааны банкууд нь айдасгүйгээр бизнесүүдийг санхүүжүүлнэ шүү дээ. Гэтэл манайд байдал эсрэгээрээ байна. Монголбанк бодлогын хүүгээ нэг хувиар 2 удаа буулгасан ч жилийн 9 хувь байгаа нь маш өндөр хүү юм. Уг нь Монголбанк хямралын эсрэг энэ хэцүү цаг үед бизнесүүдээ дэмжиж бодлогын хүүгээ 2-3 нэгж

хувиар бууруулсан бол жижиг, дунд бизнесүүдэд илүү бодитой дэмжлэг болох байлаа.

СЭЗДС-ийн хийсэн судалгаагаар ковидын нөлөөгөөр 300 сая хүртэлх төгрөгийн орлоготой бизнесүүдийн борлуулалтын орлого 70 хүртэл хувиар буурсан гэж гарчээ. Засгийн газраас ААН-ийн борлуулалтын орлого нь өмнөх үеэс 50 хувь ба түүнээс доош хувиар буурсан тохиолдолд ажилтанд нь 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр заасан. Гэтэл бусад улс орнууд голдуу ажлын байраа хадгалж үлдсэн тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Гэтэл манайд борлуулалтын орлого нь 50 хувь буурсан үед л ажилчид нь тэтгэмж авах эрхтэй. Энэ бол элгээр нь хэвтсэн хойно нь туслана гэсэн үг шүү дээ. Нэгэнт хаалга барьчихсан хойно туслаад ч яах юм.

- Санхүүгийн хямралын үед ямар стратеги баримтлах ёстой вэ?

-Урьд өмнө нь энэ төрлийн хямрал болж байгаагүй. Тийм ч учраас энэхүү асуудлыг яаж шийдэх вэ гэдэг дээр бэлэн модел загвар, онол алга. Менежментийн зөвлөх үйлчилгээний дэлхийн тэргүүлэх компани McKinsey & Company-иас хямралыг гэтлэх 5R стратегийг баримтлан ажиллахыг санал болгож байна.

-Хямралын үед компаниуд бизнес төлөвлөгөөгөө хэрхэн харах ёстой вэ?

-Ихэнх компаниуд бизнес төлөвлөгөөгөө өнгөрсөн оны 11-12 дугаар сард боловсруулан батлуулдаг. Тухайн үед халдварт цар тахалтай холбоотой санхүүгийн хямралт нөхцөл байдал үүснэ гэдгийг хэн ч таамаглаагүй биз ээ. Иймээс ч борлуулалтаа өсгөнө, шинэ бизнест хүч сорино гэх мэтээр өнөөх өөдрөг төсөөлөл, төлөвлөгөөгөөрөө яваад байгаа нь ажиглагдсан. Тиймээс хямралт нөхцөл байдалтай уялдуулсан санхүүгийн болон бизнес төлөвлөгөөгөө эргэн харж, нөхцөл байдлыг бодитоор харах ёстой.

-Байж болох муу хувилбараар ч тооцох ёстой байх нь ээ, хэрэглэгчдэдээ хэрхэн санаа тавих вэ?

-Манай бизнесийнхэн хөл хорио тавигдангуут л эдийн засаг буцаад хэвийн болно гэсэн хэт өөдрөг төсөөлөлтэй байна. Хямрал үр дагавар ихтэй тэр хэрээрээ удаан хугацаанд үргэлжилдэг учраас нөөц төлөвлөгөөтэй ажиллахаас өөр аргагүй. Зөвхөн жижиг, дунд бизнесүүд л асуудалтай тулгараад байгаа юм биш. Тэгэхээр ААН-үүд хэрэглэгчдэд ямар асуудал тулгарч байгааг олж харж, тэднийг ойлгох ёстой. Жишээ нь одоогийн нөхцөл байдалд нийцсэн төлбөрийн чадварт нь зориулсан хэмнэлттэй бүтээгдэхүүн санал болгож, багцаар нь зардаг байсан бүтээгдэхүүнээ жижиглэнгээр худалдаанд гаргаж болно. Ер нь түүхэнд хямралын үеийг боломж болгон харж янз бүрийн шинэ санаа гаргаж асар их амжилтад хүрсэн компанийн жишээ олон бий.

-Компанийн захирал, удирдагч хүн энэ амаргүй үед ямар зарчим баримталж ажиллах ёстой вэ?

-Хямралын нөхцөлд ажилтнууд “Манай захирал яах бол, ямар шийдвэр гаргах бол...” маш анхааралтайгаар ажиглаж байдаг. Танай компани 50 ажилтантай бол захирал таныг 100 нүд харж, 100 чих сонсож байна гэсэн үг. Ард нь алхам тутамд түрээс, урсгал зардлын төлбөр, ажилчдын цалин гээд стрессдэх шалтгаан, асуудал мундахгүй. Гэхдээ байгууллагыг удирдаж, манлайлж байгаа хүн учраас сэтгэл

зүйн хувьд маш тайван, хүчтэй байж, зөв шийдвэр гаргадаг. Ажилтнууддаа ойрын хугацааны зорилгоо танилцуулж, нээлттэй харилцан мэдээллээ хуваалцах нь чухал. Хэдэн ч ажилтантай бай удирдагч хүн өдөр болгон мэдээлэл өгч, асуудлыг байгаагаар нь нээлттэй, шударгаар ярьж байх ёстой.

-Хямралын үед байгууллагыг манлайлж байгаа хүмүүст юуг чухалчилж зөвлөх вэ?

-Өөдрөгөөр харвал коронавирус бидэнд элдэв зүйлд сатаарах боломжийг багасгаж, тунгааж бясалгах цаг мөчүүдийг хангалттай өгч байна. Бизнес эрхлэгчид англи хэл эзэмшихгүйгээр амжилттай явахад бэрх болчихлоо. Тиймээс яг энэ цаг үед илүү хурдтай суралцаж, өөрийнхөө үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зөвлөнө. Хөдөлмөрийн зах зээл дээр гэхэд англи хэл эзэмшсэн, эзэмшээгүй мэргэжилтний цалин хоёр дахин зөрүүтэй байгаа шүү дээ.

-Хэдийгээр зарим бизнес уналттай байгаа ч нөгөө хэсэг нь өсөлттэй гарсан байсан. Ямар салбар илүү амжилттай явж байна вэ?

-Хямралаас болж компаниуд цомхтгол хийж, дампуурахдаа тулж байхад дэлхийн хамгийн том онлайн дэлгүүр Амазоны бизнес улам цэцэглэсэн. “Амазон” хөл хорионд байгаа иргэдэд үйлчилгээгээ хүргэхийн тулд хэдэн зуун мянган ажилтан шинээр авсан. Үүнээс харахад онлайн бизнес ямар ач холбогдолтойг, бизнесээ онлайн дээр суурилуулахын давуу талыг харж болохоор байна. Ирээдүйд технологи шингээгүй бизнес бүгд өрсөлдөх чадваргүй болно. Дижитал хувьсгал хүчтэй өрнөж байгаа орчин цагт хүссэн ч эс хүссэн ч вэбсайт, нийгмийн сүлжээний хуудас нь борлуулалтын гол платформ болох учраас анхаарч, идэвхтэй ажиллуулахаас өөр аргагүй.

-Зээлээс зээлийн хооронд ажилладаг ААН-үүдэд хямрал хүнд тусаж байна. Үүнээс юуг нь сайнаар хүлээн авч суралцах ёстой вэ?

-Хямралын үед “Cash is King” буюу “Мөнгө бол хаан шиг эрх мэдэлтэй” гэсэн хууль үйлчилдэг. Иймээс ААН-үүд болон хувь хүмүүс хуримтлалтай байх нь хамгийн чухал. Менежмент сайтай компаниуд 6-12 сарын тогтмол зардлаа төлөхүйц хэмжээний хуримтлал үүсгэчихсэн байдаг. Энэ нь хямралыг тооцоолоод түүнд бэлтгэлтэй байх ёстой гэсэн зарчим юм. Монголд эрсдэлийн хуримтлалтай компаниуд бий, гэхдээ тун цөөн. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг компаниуд хямралыг хохирол багатайгаар туулах боломжтой. Энэ удаа яахав ингээд өнгөрлөө гэж бодож болохгүй. Хямрал давтамжтайгаар тохиодог зүйл учраас түүнийг тооцоолох нь чухал.

Уханьд COVID-19 халдварын тархалт асар хүчтэй явагдаж, хатуу хөл хорио тогтоосон бөгөөд хүмүүс нь орон гэрээсээ ч гарч чадахгүй байсныг бид мэдээллийн сувгуудаар хангалттай харсан. Урд хөршийн томоохон хотуудад хатуу хөл хориог 2-3 сар тогтооход хятадууд хямарч сүйд болоогүй. Тэд мөнгө хадгалах эртний соёлтой, тэр нь зан заншил болоод төлөвшчихсэн хуримтлалтай ард түмэн учраас энэ хугацааг ажралгүй давлаа. Харин манайд олсныхоо хэрээр тэр байтугай олсноосоо ч ихийг зарцуулдаг нь хадгалах, хуримтлуулах соёл тааруухан байгааг харуулж байна.



Өөдрөгөөр харвал коронавирус бидэнд элдэв зүйлд сатаарах боломжийг багасгаж, тунгааж бясалгах цаг мөчүүдийг хангалттай өгч байна. Бизнес эрхлэгчид англи хэл эзэмшихгүйгээр амжилттай явахад бэрх болчихлоо.



News.mn



**Шийлэгмаа овогтой
Адъяамаа**

2014 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг мэргэжлийн англи хэлтэй сэтгүүлч мэргэжлээр төгссөн.

2015 онд Zindaа.mn сайтаас ажлын гараагаа эхлүүлсэн.

2015-2018 хүртэл тус сайтад улс төрийн сэтгүүлч,

2018 оноос хойш одоог хүртэл News.mn сайтад Улс төр, эдийн засгийн сэтгүүлчээр ажиллаж байна.

**“ЕРӨНХИЙ САЙД САНХҮҮГИЙН БЯДТАЙ
БОЛСОН КОМПАНИУДАА БҮҮ АД ҮЗ”**

Бизнесийн удирдлагын доктор, эрх зүйч, МҮХА ҮТ-ын ерөнхийлөгч асан Б.Лхагважавтай ярилцлаа.

-Монгол Улсын нийт өрийн хэмжээ үндэсний аюулгүй байдал алдагдах хэмжээнд хүрч нэмэгдэж байна. Гадаад өрийн дийлэнх хэсэг болон дунд хугацааны эргэн төлөлт бүхэлдээ олон улсын санхүүгийн зах зээлээс арилжааны нөхцөлтэй авсан өр төлбөрүүд байгааг эдийн засагчид хэлж байна. Энэ талаар ярилцлагаа эхлүүлье?

-Монгол Улсын нийт өр 30 тэрбум ам.долларт хүрсэн талаар саяхан Ерөнхий сайд тодорхой хэлсэн. Үүнээс ААН-үүдийн өр 18.2 тэрбум ам.доллар, үлдсэн нь Монголбанк, Засгийн газар, арилжааны банкуудын өр. ААН-үүдийн 18.2 тэрбум ам.долларын өрийн 11 тэрбум ам.доллар нь үндсэндээ Оюутолгойн хөрөнгө оруулалтын зээл. Үлдсэн 7.2 тэрбум ам.доллар бол бусад компанийн сүүлийн 30 жилийн хугацаанд авсан зээл гэж ойлгож болно. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид дөрвөн том хямралтай нүүр тулсан. Хамгийн сүүлийнх нь 2012-2016 оны хямрал, үүнээс өмнө 1997, 2009 оны хямрал. Тухайн үед эрх баригч намын хамгийн гол ажил нь дээрх зээл, хөрөнгө оруулалтыг өр болгохгүйн төлөө ажилладаг байсан. Одоогийн Ерөнхий сайдын үүрэг ч мөн адил 30 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай байлгахын төлөө ажиллах явдал юм. Ерөнхий сайдын хувьд Монгол Улсын өр хувийн хэвшлийн, эсвэл төрийнх гэж байхгүй. Монгол Улсын хэмжээнд асуудлыг харах хүн нь Ерөнхий сайд шүү дээ. Тийм учраас төр, хувийн хэвшлийн өр гэж ялгахгүйгээр төрийн бодлогын хүрээнд нийт гадаад өрийн удирдлагын стратеги боловсруулан хэрэгжүүлж байх нь чухал байна.

-Сүүлийн 10 жилд Монгол Улсын нийт гадаад өр 10 дахин өсч, 30 тэрбум ам.долларт буюу ДНБ-ий 220 хувьд хүрлээ. Манай хувийн хэвшил өөрсдөө эрсдэлээ даагаад, эрсдэлээ гаднынхнаар үнэлүүлээд, валютаар эх үүсвэр олж чадаж байгаа нь сайн үзүүлэлт ч гэлээ гадаад өрийн хүндрэлд ордог нийтлэг шалтгаан нь юу вэ?

-1990-2003 он хүртэл манай улс гаднаас хөрөнгө оруулалт татах боломжгүй, зөвхөн буцалтгүй тусламжийн хүрээнд буюу “амь зогоох” үйл явц дээрх онуудад явагдсан. Энэ үед манай улсын төсвийн хэмжээ ч бага байлаа. 2003 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд манай улсын эдийн засаг 10 дахин өссөн. Яагаад гэвэл 2003 онд ЗХУ-д төлөх ёстой байсан 9.2 тэрбум ам.долларын өрийг 250 сая ам.доллараар Н.Энхбаяр Ерөнхий сайдын үед хааснаар, 2004 оноос эхлэн гаднаас албан ёсны хөрөнгө оруулалтууд орж ирэх үүд хаалга нээгдсэн гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, 2004 оноос өмнө ЗХУ-д төлөх 9.2 тэрбум ам.долларын өртэй байхад гаднын хөрөнгө оруулалтууд орж ирэх сонирхолгүй байсан. Ингээд 2005-2009 онуудад газрын хэвлийн баялаг, уул уурхайд хөрөнгө оруулах үйл явц тэсрэлт болсон үе. Үүний цаана ихэнх нь газар ашиглалтын болон хайгуулын лицензээ тавьж, гаднаас зээл авч байсан. Тухайлбал, 2008 оны байдлаар Монгол Улсын газар нутгийн 51 хувийг лицензээр олгочихсон байсан. Үүний хойно 26 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний зээл буюу хөрөнгө оруулалтын өрийг дарчихсан байсан.

Өнөөдрийн 30 тэрбум ам.долларын гадаад өрийг аваад үзвэл уул уурхайн лиценз барьцаалсан том хөрөнгө оруулалтууд. Энэ дунд үйлчилгээ болон уул уурхайн бус бусад салбарын зээл 100 сая ам.доллар ч хүрэхгүй.

Байгалийн баялгийн төрийн, нийтийн хамааралтай хууль гараагүй байсныг ашиглаж, төрийн эрх мэдэлд ойр, төрийн дээд албан тушаалтнууд үүгээр дамжуулж хөрөнгө оруулалтууд нэлээд хийгдсэн гэж боддог.

-Хэдийгээр хувийн хэвшлүүдийн гаднаас авсан өр Засгийн газарт хамаагүй мэт боловч төр, ард түмний мэдэлд байдаг баялаг ашиглах эрх бусдад шилжих, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх, валютын эрэлт нэмэгдэж үнэ, ханш өсөх эрсдэлтэй. Өрийн менежментийг хэрхэн зөв хийх вэ?

-Засгийн газарт хамааралгүй өр гэж нэг ч байхгүй. БШУ-ы сайд нь хувийн сургуулиудыг анхаарахгүй зөвхөн улсын сургуулиудаа авч үзнэ, эсвэл Эрүүл мэндийн сайд нь надад хувийн эмнэлгүүд хамаагүй гээд ярьдаггүй шиг бодлогын хувьд зангидаж, ААН-үүдийн гаднаас авсан хөрөнгө оруулалтуудыг үр ашигтай байлгах, өрийн менежментийг төр хийх ёстой. Засгийн газрын өрийг татвар төлөгчид л төлнө. Ирэх жил “Чингис” бондын эхний 500 сая ам.долларын эргэн төлөлт хийгдэнэ. Энэ зээлийг мөн л татвар төлөгчид төлнө. Хямралын энэ үед том том дүнтэй хөрөнгө оруулалтуудыг унагаах уу, эсвэл нэмж хөрөнгө татах уу, үйлдвэрийг нь бариад дуусгах уу, эсвэл дампууруулах уу гэдэг эгзэгтэй үе нь байдаг. Ерөнхий сайдын санаа зовох асуудал нь энэ.

Нөгөөтэйгүүр ААН-үүд гэрээ хийсэн бол гэрээндээ үнэнч байх нь чөлөөт зах зээлийн хамгийн эрхэм зүйл. Гэрээгээ биелүүлэхийн төлөө хоёр тал хоёулаа оролцож, үр ашгийг нь тэгш хүртэх ёстой. Үүнтэй адил Оюутолгой төслийн 11 орчим тэрбум ам.долларын өрийн 3 тэрбум ам.доллар нь Монголын тал. Том хямралуудыг давж гарахад төрийн менежмент хамгийн чухал.

-Ерөнхий сайд “Чөлөөт зах зээл байхгүй гэж ойлгож байгаа. Одоо төрийн

зохицуулалттай зах зээл гэж байна. Хүн бүр хүссэнээ хийдэг зах зээл үгүй болсон. Дэлхий дээр байхгүй болсон” гэж хэлсэн нь өнөөдөр нийгэмд талцал болж, шүүмжлэл өрнөж байгааг та ч гэсэн харж байгаа байх. Энэ талаар та ямар бодолтой байна вэ?

-Иргэн хүн аж ахуйн нэгжтэй байх эрхийг 1992 оны Үндсэн хуулиар олж авсан. Нөгөөтэйгүүр “Иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд төр нийтийн сайн сайхны төлөө аль алинд нь ашигтай байхаар оролцож болно” гэсэн мөн Үндсэн хуулийн заалт бий. Хэрэв төрийн буруутай үйл ажиллагаанаас болж иргэн, ААН хохирвол төр хохиролгүй болгоно гэсэн хамгаалалтын заалт ч Үндсэн хуулийн 19-д тусгагдсан. 1990 онд хувийн ААН-үүд бүгд нэг цэгээс эхэлсэн. Өнөөдөр 200 мянган компани дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, 1 сая орчим хүнийг ажлын байраар хангаж байна. Энэ бүхэн сүүлийн 30 жилд бий болсон чөлөөт зах зээлийн үр дүн. Төр мэдээж үүнд оролцож ч ирсэн.

Төр оролцдоггүй зах зээл дэлхий дээр хаана ч байхгүй. Төрийн оролцоо татварын бодлого, мөн нийгмийн даатгалын системээр оролцдог. Гурав дахь төрийн хамгийн том оролцоо бол лиценз.

Мөн хөрөнгө оруулалтгүйгээр нэг зоосоо хоёр болгож байгаа улс дэлхийд байхгүй. Хөрөнгө оруулалт татахын төлөө өрсөлдөөнүүд явагдаж байна. БНХАУ 1976 оноос хойш эдийн засгийн бодлогоор хөрөнгө оруулалтууд татаж чадсан. 1990 онд манай улсын инфляц жилийн 300 хувь, банкны зээлийн хүү сарын 25 хувь байсан ийм үед иргэд ахуй амьдралаа өөд нь татах үйл явц 1990-1993 онуудад явагдсан. Дараа нь 25 сая малыг өмчлүүлснээр 1995 оны хүнд бэрхийг давсан.

1997 оны Азийн хямралаас Монгол Улс сул гарсан шалтгаан нь тухайн үеийн Засгийн газар 40 мянган орон сууцыг хувьчлуулсан. Ингэснээр үхмэл байсан орон сууцны хөрөнгө эргэлтэд орж, бүхэл бүтэн барилгын салбарын хөгжлийг бий болгосон. Хоёрдугаарт, залуучууд өөрсдийнхөө компанийг байгуулж, бусдаас хамааралгүй явсны үр дүнд өнөөдрийн том том дүнтэй эдийн засгийн ололтуудыг бий болгосон. Өнөөдөр бүртгэлтэй байгаа 200 мянган ААН-ийн 1000 орчим нь Монгол Улсын нийт татварын орлогыг 99.99 хувийг бүрдүүлж байна. Тэгэхээр өнгөрсөн 30 жилд тоо хэмжээ, хөрөнгө нөөц, хүний нөөцөөрөө ч гэсэн том компаниудтай болж чадсан нь том дэвшил. Үүнд аль ч Засгийн газар, хэн Ерөнхий сайд байхаас үл хамааран ажлын байр олноор бий болгож байгаа эдгээр компаниа хамгаалах ёстой.

*~“АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОЖ БАЙГАА КОМПАНИУДЫГ БӨӨЦИЙЛӨХ НЬ
ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ”~*

-Яаж?

-Мөнгөний бодлогоор эсвэл зээл, татварын бодлогоор хамгаалж байж 1 сая хүнийг ажлын байртай болгож байгаа компаниудын үйл ажиллагааг бөөцийлөх нь Засгийн газрын үүрэг. Хэдийгээр топ 100 ААН ачааны хүндийг үүрч байгаа ч гэлээ ажлын байрны 70-80 хувь нь 1-10 ажилчинтай компани байна. Тэднийг өсгөж, өндийлгөх нь мөн л Засгийн газрын үүрэг. Засгийн газрын үүрэг гээд нэг хэсэгт нь ЖДҮ-ийн зээл өгөөд, эсвэл татварын мөнгийг буцааж хуваарилах нь бөөцийлөлт биш. Засгийн газрын үүрэг бол татвар, төсвийн бодлого, хөрөнгө оруулалтуудыг татах явдал. Өнөөдөр нийгмийн асуудлыг нарийн аваад үзвэл төсвийн нийтийн

санхүүгийн дахин хуваарилалтын асуудал эмзэг цэг болчихсон.

Мөн төрийн нийтийн хамааралтай өмч буюу төрийн өмчийн ашгийн дахин хуваарилалт хэр шударга байна вэ гэдгээс өнөөдөр нийгэмд сайн, муу нь илэрч байна. Зах зээл бол хатуу тоглоом. Жаахан барьц алдахад л үгүй болдог тийм эмзэг. Тийм учраас залуучууд бизнес эрхлэхээс айж байна. Зах зээлд эцсээ хүртэл тэмцэхээс илүү төр рүү шургалахыг илүүд үздэг болсон.

ААН эдийн засгийн эрх чөлөөгөө өөрөө хангаж, тэр эрхийнхээ баяр баяслыг хүртэх нь улам багасч байна. Эсрэгээрээ тэгж явсныхаа төлөө эрүүл мэндгүй болж, эсвэл өрөнд баригдаж, төрийн янз бүрийн шалгалтад орж байна. Ажлын байр бий болгож, жаахан ч гэсэн хөрөнгө гаргасан хүн бүр эргээд дарамтад орж байна. Энэ бол бидний хүссэн зүйл биш.

*~“ЗАСГИЙН ГАЗАР ХУВИЙН ХЭВШИЛТЭЙГЭЭ ХОНЬ, ЧОНЬ БАЙВАЛ
НЭГИЙГ Ч ДАВЖ ГАРАХГҮЙ”~*

-Өрөөр бий болсон санхүүжилтийг бүтээмж муутай, үр ашиггүй ашигласан нь өнөөдөр эргээд өрөө төлж чадахгүй нөхцөлд хүрээд байгаа юм биш үү?

-Гаднаас зээл авахад лицензээ барьцаалах, хоёрдугаарт, өөрийн өмч хөрөнгөө барьцаалдаг. Энэ бүхэн ашиг олохын төлөө хийгдэж байгаа зүйл. Хэн ч алдъя гэж бодохгүй нь ойлгомжтой. Жишээ нь, тухайн компаниас хамаарахгүйгээр өнөөдөр зах зээлд короновирус шууд нөлөөлж байгааг харж болно. Эдийн засаг зогсолтод орлоо. 2014-2019 онд МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа миний нүүр тулсан хамгийн хэцүү асуудал нь яаж энэ компаниудынхаа үнэ цэнийг алдахгүй байх вэ гэдэг асуудал. Энэ миний үүрэг байсан.

2014 онд эдийн засаг уначихсан, хөрөнгө оруулалтууд зогсч, маш хүнд байсан. Энэ дунд бүх хариуцлагаа үүрсэн компаниуд л зовлонгоо үүрдэг. Хэрэв хүнд үед компаниудаа бид дэмжихгүй, 40-50 хувь үнэ цэнээ алдсан компаниуд дампуурахад буцаагаад орон зайг нь, эсвэл компанийг нь ч худалдаж авахад бэлэн мөнгөтэй хүмүүс өмнөд хөршийн иргэдээс эхлээд олон бий. Тэдний туйлын хүсэл хямралд аль болох олон Монгол компани дампуураасай, тэгэнгүүт нь бид хувьцааг нь авна, эсвэл компанийг нь худалдаад авна гэсэн санаархал. Монгол эзэнгүй өмч, олсон ашиг нь өөр хүнд оногддог тэр зам руу явбал бидэнд л маш аюултай.

Хоёрдугаарт, Ерөнхий сайдын мэдэгдэлтэй холбогдуулаад “Нэгэнт хөлөө олчихсон, тодорхой хэмжээнд бядтай болсон компаниудаа бүү ад үз”

гэж хэлмээр байна. Өнөөдөр магадгүй 50 сая ам.доллар, цаашлаад нэг тэрбум долларын хөрөнгө босгоод, ажлын байр гаргаад явж байгаа энэ компаниуд үнэндээ Засгийн газрын хийх ёстой ажлыг хийж байна. Тэднийгээ байхгүй болговол тэр орон зайг нь хэн эзлэх вэ гэдгийг төр сайтар бодох хэрэгтэй. Цар тахлын үед яаж хамтдаа давж гарах вэ гэдэг л чухал болохоос биш яаж хавчих вэ гэж болохгүй. Өмнөх туршлагаудаас харахад, төрийн зөөлөн бодлогоор хямралаас гарч байсан. Засгийн газар, МҮХАҮТ компаниудтайгаа хамтарч ажиллаж байсных. Хөрөнгө оруулалтын асуудалд ч харилцан ойлголцож, тэр орон зайг нь бий болгож байсан. Түүнээс хонь, чонь болоод, харилцан эсрэг байвал нэгийг ч давж гарахгүй.

-Та хэт нэг талыг барьж ярьж байна. Нөгөө талдаа компаниуд ч гэсэн асуудал бий шүү дээ?

-Тэгэлгүй яах вэ. Компаниудад асуудал байгаа нь үнэн. Энхийн цагаан тагтаа бас биш. Монголбанк, улсын төсвөөр дамжуулаад нийтийн цугласан мөнгөнөөс шударга бусаар олж авдаг, “Би амьд гарч байвал бусад нь хамаагүй гэсэн сэтгэлгээтэй хүмүүсийн хандлага хямралын үед бүр ч тод харагддаг. Тэгэхээр төрийн хараа хяналт нийтийн мөнгөнөөс олз хайдаг хүмүүс рүү чиглэгдвэл “бай”-гаа ононо. Зээл болгоны хойно төлөх эзэн, ААН нь байгаа.

Харин 10-20 жилийн өмнө орж ирсэн тусламжийн маш их хэмжээний мөнгө эзэнгүй алга болсон. Нийтийн мөнгөөр нийтэд зориулсан аливаа ажлыг чанартай хийхэд хянадаг механизм манайд байхгүй нь асуудлын гол.

-Манай улсын хувьд 2021-2024 онуудад зээлийн том төлбөр төлнө. Засгийн газрын гадаад өрд тооцогдож буй “Чингис” бонд нэг тэрбум ам.доллар, “Мазаалай”

бонд 500 сая ам.доллар, “Хуралдай”

бонд 600 сая ам.доллар, “Гэрэгэ”

бонд 800 сая ам.доллар гэх мэт том дүнтэй өр төлбөрүүд шил даран хүлээж байна. Төлөх боломж байгаа болов уу?

-Оюутолгойн гүний далд уурхай ашиглалтад орчихвол жилийн 5-6 тэрбум ам.долларын эргэлттэй үйлдвэрлэл бий болно. Ингэснээр Оюутолгойн хөрөнгө оруулалтын 11 тэрбум ам.долларын гадаад өрийг амархан шийдэж чадна. Монгол Улсад илэрсэн байгалийн баялаг 3.5 их наяд ам.доллараар үнэлэгдсэн. Энэ бол нэлээд олон жилийн өмнөх тоо. Менежментээ зөв хийчихвэл. Жишээ нь, нүүрсээ нэг цонхоор үнэд хүргэхэд төрийн зохицуулалт жинхэнэ гарч ирэх ёстой.

Байгалийн баялгаа сэглэж, сорчилж, зөвхөн хэсэг хүний хувийн хэрэгцээг хангахад ашиглах нь ашиглалт биш. Өнгөрсөн 30 жил төрийн өмчийг олборлох, ашиглах, захиран зарцуулах бүх эрхийг хуульчлаагүйгээс дээр хэлсэн 3.8 их наяд төгрөгөөр үнэлэгдэх өмч дээр очихын тулд төрийн институтийг ашиглаж ирсэн. Төрийн өмчийг хамгаалсан хуульгүйг ашиглаж, төрийн институтийг ашиглаж очсон нөхдүүдийн хооронд дахь зодоон Монгол Улсыг тамирдуулж байгаа. Түүнээс биш уул уурхайн бус салбарууд гай огт чирээгүй.

-Цар тахлын үед ААН-үүдийн эрх ашгийг хангах, хамгаалах чиглэлд МҮХАҮТ хэр ажиллаж байна вэ?

-Танхимын үндсэн үүрэг чөлөөт зах зээл буюу ААН-үүдийн эдийн засгийн эрх чөлөөг хамгаалдаг байгууллага. Энэ эрх чөлөө рүү ямарваа нэгэн байдлаар албан тушаалтнууд үгээр, эсвэл үйлдлээр дайрвал танхим хамгаалах ёстой. Сая Ерөнхий сайдын хэлсэн үгтэй холбогдуулж танхим том мэдэгдлүүд гаргах байх гэж бодож байна. Өнөөдөр цар тахлын улмаас эдийн засгаас гадна нийгмийн том хямрал болохыг үгүйсгэхгүй. Нийгмийн хямрал болгохгүйн тул аль ч орнуудад нийтийн төлөө ажилладаг бүх байгууллага хамтарч нэгдэж байна.

Нийгмийн байгууламжаа, үнэт зүйлээ авч үлдэхийн тулд төр нь тодорхой хэмжээгээр мөнгө хүртэл хэвлэж байна гаднын орнуудад. АНУ гэхэд чөлөөт зах зээлээ авч үлдэхийн тулд юугаа ч хайрлахгүй тэмцэж, өнгөрөгч гуравдугаар сард 2 их наяд ам.доллар хэвлэж тараалаа. Энэ нь нийгмийнхээ үнэт зүйлийг авч үлдэхийн тулд хийж буй золиос. Өнөөдөр бид нийгмийнхээ үнэт зүйлсийг авч үлдэхийн төлөө

нэгдэх цаг нь болсон.Өнгөрсөн 30 жил олж авсан чөлөөт эдийн засгаа авч үлдэхийн тулд хөдөлмөрийн зах зээл рүүгээ мөнгө гаргах хэрэгтэй.



Г.Жамьян
(Монгол Улсын Соёлын
гавьяат зүтгэлтэн)

“Зууны мэдээ” сонин

САРЬСАН БАГВААХАЙ ЧАМД АЛТАН ХӨШӨӨ БОСГОЁ

1.ЭХЛЭЛ

Ноднин намар яг л өдийд, БНХАУ-ын Ухань хотод тааж танигдашгүй халдварт өвчин гарч гэнэ гэсэн яриа чих дэлсэж билээ. Хэн ч төдийлэн анзаараагүй байх. Удалгүй “Өнөөх өвчин хүнээс хүнд халдварлаж, хүмүүс нас барлаа. Нууцалж байсан өвчнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дэлгэн тавьсан Ли эмч баривчлагдаж гэнэ. Тэгснээ өнөөх аюулт өвчнөөрөө нас барж гэнэ” гээд л шуугисан. Энэ өвчинд гол буруутан нь сарьсан багваахай, сүүлдээ корона гэдэг могой болж таарсан. Тэгээд өвчнийг “коронавирус” гэж нэрлээд, дэлхийн эрүүл мэндийн (ДЭМБ) байгууллага хүртэл эхний үсгээр нь “КОВИД-19” гэж нэрлэж, өнөөгийн аюулт цар тахал дэлхийн 216 орныг хамарч, гучаад сая хүнд халдварлан бараг сая шахам хүний амь насыг авч одоод байгаа билээ.

Дэлхий цочирдсон. Цар тахлын талаар бичээгүй, дуугараагүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл байхгүй байх. Шинжилж судлаагүй эрдэмтэн мэргэд ч ховор үлдсэн. Эмч эмнэлгийн ажилтнууд хүртэл хэдэн зуу, мянгаараа өвчилж таалал төгссөн. Улс гүрнүүд байтугай дэлхий даяар онц байдал зарлагдан, хөл хорионд орсон. Газар, ус, агаарын замууд тэр аяараа хаагдан, унааны түгжрэл ярьдаг байсан бол хүний түгжрэл ярих болсон. Зарим том гүрнүүд таалал төгсөгчдөө хийх хайрцаггүй, оршуулах газаргүй, хөргөгч, хөлдөөгчид хадгалж байлаа.

Дэлхий даяараа сарьсан багваахайг л хараан зүхэж, энэ амьтнаас болж дэлхий сүйрлээ гэж гасалцгаасан. Сарьсан багваахайтай бүх улс гүрэн энэ амьтныг үзэн ядаж, махыг нь лангуун дээрээсээ хураагаад газрын гүнд булж байлаа. Манайхан ч ялгаагүй, сарьсан багваахай ихтэй газраасаа нүүж Отгонтэнгэр мэтийн арц хүжтэй газраа бараадсан сураг байна.

Манайханд сарьсан багваахайн тухай домог мэт яриа их бий л дээ. “Хараалч амьтан, хавьтаж ойртож болохгүй”. “Арцтай газраас их зугтаадаг, Отгонтэнгэр мэтийн их арцтай газар нутагладаггүй”. “Харин энэ өвчнийг арцаар эмчлэх талаар судлавал яасан юм?”... гэхчлэн дэл сул яриа их хөвөрсөн л дөө. Олон улсын эмч мэргэд коронавирусыг эмчилдэг эм, сэргийлдэг вакцин гаргаж авах гэж нүдээ улайтал, шүдээ зууртал суугаад одоо хэр нь бүрэн баталгаажсан эм вакцин гаргаж авч чадаагүй, тэр битгий хэл энэ аюулт цар тахал чухам юунаас, хаанаас, ямар замаар анх гарч ирснийг ч бүрэн тогтоож чадаагүй байгаа юм гэсэн. Олон янзын сэтгэгдэл, таавар яриа хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан. Түүнээс хамгийн итгэл үнэмшилтэй нь “Дэлхийн хүн амыг цөөлөх биологийн зэвсгийг гаргаж авах гэж АНУ, БНХАУ-ын эрдэмтэд Уханы нууц лабораториосоо, сарьсан багваахайд байдаг вирусыг алдснаас энэ өвчин тархсан” гэдэг нь арай илүү дөхөм юм. Тэгээд ч хятадууд нууцалж хугацаа алдсан, АНУ-ын төрийн тэргүүн Д.Трампа эс тоомсорлосон байдлаар “Жирийн л нэг ханиад томуу” гээд өөрөө маскнаас татгалзаж байсан зэргийг харвал, мань хүмүүс мэдэж байсан, дэлхийн хүн амыг өндөр настнаас нь эхлэн цөөлөх “Ухаалаг” вирус гаргаж авах бодлоготой байсан юм биш байгаадаа гэсэн таавар төрөхөд хүрдэг юм.

Жирийн нэг амьтнаас тархсан гэхэд итгэмээргүй, дэндүү “ухаалаг” энэ вирусыг XXI зууны эрдэмтэд, тэр дундаа дэлхийн “гавал”-ууд бүтээсэн гэдэгт би ердөө эргэлздэггүй. Мутацад орж олон хувирахын зэрэгцээ, нэг, хоёр, гурав, хэчнээн ч давалгаа үүсэх юм, бүү мэд. Зарим эрдэмтэд “энэ өвчин дэлхийгээс салахгүй, үе үе намжин, дахин гарч ирээд, хүн төрөлхтнийг, тэр дундаа хүүхэд хөгшчүүдийг зовооно доо” гэж бичсэн байна билээ. Манай орны хувьд оргил үе нь энэ оны аравдугаар сард гэж биднийгээ айлгасаар л байгаа.

2.ӨРНӨЛ

Коронавирус буюу цар тахал, дэлхий дахины хүн амыг өвчлүүлж, үхүүлж сүйрүүлэхээс гадна хэдэн муу үр уршиг дагуулж явна. Гол нь эдийн засгийн сүйрэл. Улс үндэстнүүд хил хязгаараа хааж, хорио цээр тогтоож, үйлдвэрлэл үйлчилгээ нэлэнхүйдээ зогссоноос хүн төрөлхтний 80-90 хувь нь “туйлдаж ядарлаа” гэж гадны хэвлэлд бичсэн байна. Энэ оны есдүгээр сарын 1-ний байдлаар дэлхийн эдийн засаг 10 гаруй хувиар агшиж. Зарим хүчирхэг орны эдийн засаг 2-3 жилд сэргэж чадахгүй гэж бичсэн байна.

Олон улсын, тухайлбал, “Ковид-19” тархсан 216 орны тухай ярихаа больё. Монгол минь яаж байгаа билээ?! Цар тахлыг “ялж” байгаа цөөн орны тоонд Монгол багтаж ДЭМБ-аас “үлгэр жишээ авах улс”-ыг Монгол тэргүүлж байгаа. Аюулт цар тахал хамгийн их тархаж олон мянган хүнээ энэ өвчнөөр алдсан Орос, Хятад хоёрын хооронд, олон улсын бараг бүх зам холбоо дайрч өнгөрдөг манай улс коронавирусыг хазаарлаж бариад нутаг дотроо ганц ч тохиолдол гаргалгүй, нэг ч хүн нас баралгүй арван сар болно гэдэг гайхамшиг. Саяхны байдлаар /есдүгээр сарын 1-ний/ Монголд зөөвөрлөгдөн орж ирсэн 306 тохиолдлын 300-г нь эмчилж эдгэрүүлээд ХӨСҮТ-д зургаахан өвчтөнтэй тэдний нэг нь л хүндхэн байлаа. Үүүнийг чинь амжилт гэхээсээ гайхамшиг гэмээр юм биш үү?! Энэ бол Монгол Улсын төр засгийн зөв мэргэн бодлого, Эрүүл мэнд, Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, сэтгүүлчид, цагдаа, хил гаалийнхны шаргуу хөдөлмөр гэхээсээ баатарлаг үйлсийн үр дүн гэлтэй.

Цар тахлын өмнө монгол хүн сөхөрсөнгүй ээ!

Мал нь өсөөд 80 сая давж, тариа ногооных нь ургац дээд цэгтээ хүрч, гол бүтээгдэхүүн болох гурил, төмс хоёроо дотооддоо хангана гэнэ. Эдийн засгийн гол үзүүлэлтийг авч явдаг үйлдвэрлэл, тэр дундаа уул уурхайн үйлдвэрлэл, зам тээвэр, аялал жуулчлал бага зэрэг агшиж. Агшихад хоёр тал бий.

Цар тахлын нөлөө зайлшгүй байгаа. Дэлхийн бараг бүх орны эдийн засаг унаж байхад Монголынх өснө гэж байхгүй л дээ. Гэхдээ, бидний алдаа бий гэж миний хувьд хардаг. Хилээ хаасан нь зөв бодлого байлаа. Гэхдээ дотоодын үйлдвэрлэлээ эрч далайцтай явуулж болох байсан. Оюутолгой, Эрдэнэт, Таван толгой, бусад үйлдвэр үйлчилгээний газрууд нарийн зохион байгуулалттай, хяналттай ажиллаж болох байсан. Нүүрс, зэс, нефть болон бусад олборлолтоо явуулж, гол хэдэн боомтоороо экспортоо тасалдуулахгүй явуулах боломж байсан гэж эдийн засагчид, судлаачид үздэг юм билээ.

Хариуцлагын тогтолцоо зарим газар хэтэрхий суларсан. Үүнийг Улаанбаатар-Дарханы замаар жишээлж болно. Зам тээврийн яамны удирдлагууд, зөвхөн хувийн ашиг сонирхлын үүднээс бодлогогүй алхам хийсэн. Тендер будлиантуулж энэ чухал замын ажлыг гадныханд өгснөөс их бүтээн байгуулалт саатна билээ. Гадныхан авилга их өгдөг учраас Хятадын компаниудыг шалгаруулдаг, тэд нар нь цар тахлын үеэр хилийн чанадад хашигдсан. Яагаад монгол барилгачидаараа, монгол замчдаараа бариулж болоогүй юм!

Монголчууд Улаанбаатар-Дарханы зам байтугай Дорноговь аймагт хоёр том төмөр зам, бас засмал замыг өөрсдөө барьчихлаа. Замын энэ том бүтээн байгуулалтад алдаа гаргасан сайд дарга нарт хариуцлага тооцох нь бүү хэл дахиад л УИХ-д нэр дэвшүүлж, сонгож байх юм.

Бас аялал жуулчлал уналаа, сүйрлээ гэнэ. Энэ чинь коронавирусынх биш, энэ салбарын түрүүчийн удирдлагуудын хэтэрхий хариуцлагагүй байдал. Гадаад жуулчлал зогссон нь үнэн. Дотоодын аялал жуулчдаас хэдий л бол хэдий орлого олж болох байсан. Улаанбаатараас бусад газарт халдвар тархсангүй. Хаа л бол хаа чөлөөтэй аялж болох байлаа. Яам газрынх нь удирдлагууд хааяа нэг “Аялал жуулчлалын салбарын төчнөөн хүн ажилгүй боллоо” гэж зовлон тоочоод л суугаад байгаа. Аялал жуулчлалынхныг татаж хөрөнгө босгоно гэж Хэнтийд хэдэн шавар овоолчихоод санаа амарсан.

Би харамсдаг юм. Дэлхийд гайхагдмаар газар орон Монголд бий. Хаа ч байхгүй түүхийн дурсгал Монголд л бий. Даанч түүнийгээ сурталчилж ард түмэндээ ойлгуулдаггүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголоо сурталчлахгүй хэрнээ “Миний очих дуртай 100 газар” “Үүргэвчтэй аялал” гээд бусад улс орнуудыг л орой болгон телевизээр сурталчилж цацаж байх юм. Ингэхээр дотоодын аялал жуулчлал яаж хөгжих билээ дээ!

Хотын бүтээн байгуулалт гээд байгаа зүйлийг хар даа. Долдугаар сарын 1 хүртэл сонгууль гэж шоудсан. Дараа нь бүгд амралтаа аваад алга болсон. Айраг архинд умбаж умбаж ирээд, яг сургууль цуглаж хөдөлгөөн ихсэх үеэр зам талбайнуудыг ухаж сэндийлээд хаячихсан. Тэгээд “түгжрэл” гэж сүржигнэлээ. Засгийн газар түгжрэлийг бууруулах талаар хариуцсан байгууллага, хүмүүсээс санал авсныг та нар ажигласан байх. Тэнд улс орны эрх ашиг, нийслэлийнхний сайн сайхны төлөө дуугарсан хүн бараг алга. Бүгд л хувийн, салбарын ашиг сонирхолд хөтлөгдсөн.

Банк санхүүгийнхэн гэхэд л татвар хураамж нэмье л гэж хашгиралдсан. Замын түгжрэл гэдэг чинь Улаанбаатарын гудамжинд байгаа юм биш. Дарга сайд нар, баячуудын толгойд байгаа юм.

Жилд өчнөөн мянган машин хил гаалиар оруулж ирээд байхад түгжрэлийг арилгана гэж зүүдлээд яах юм. Энэ томчууд чинь жилд өчнөөн машин оруулж ирээд, албандаа 2-3, ар гэртээ 2-5 машинтай болсон байна. Би таван жилийн өмнө гадаадаас машин оруулж ирэхээ 5-6 жил хориглооч гэж саналаа бичиж байсан. Тэгсэн чинь юун хориглох, таван жилд улам олон машин орж ирсэн байна билээ. Одоо улаанбаатарчууд унаагаар хангагдсан. Түргэн тусламж, галын машинаас бусдыг нь тодорхой хугацаагаар хориглох хэрэгтэй шүү дээ. Ингэж л байж замын түгжрэл буурна.

Ингээд харахаар Монголын эдийн засаг, цар тахлын хямралыг хохирол багатай даван туулах бүрэн бололцоотой байсан, цаашид ч “эзэн хичээвэл, заяа хичээнэ” шүү дээ.

3.ТӨГСГӨЛ

Одоо хүн бүрийн сэтгэлд “Цар тахлын дараа яах вэ?” гэсэн асуулт явж байгаа. Гэхдээ энэ аймшигт цар тахал хэзээ дуусах юм?, Ер нь дуусах юм уу, ингээд л үргэлжлээд байх юм уу?, Бүр хоёр, гуравдугаар давалгаа гээд дэлхийн улс үндэстнийг сүйрүүлэх юм уу?

Хэн ч тодорхой хариулт өгөөгүй л байгаа. Улс болгонд л коронавирусын эсрэг эм тариа, вакцин үйлдвэрлэж байгаа сураг байна. Энэ нь хүн төрөлхтнийг аврах санаа агуулсан гэдэгтэй маргахгүй. Гэхдээ нэр хүндний төлөө, борлуулалтын төлөө, их олз ашгийн төлөө өрсөлдөж байгаа гэсэн мэдээлэл ч бий. ОХУ хамгийн түрүүнд “Спутник-5” вакцин гаргаснаа зарлаж, В.Путины охин болон нэр хүндтэй хүмүүс нь өөр дээрээ туршсан. Гэтэл ДЭМБ энэ вакциныг “шаардлага хангаагүй” хэмээн зөвшөөрөхгүй байгаа юм байна. Ер нь аль ч вакциныг бүтээлээ гэхэд 1.8-2 жилийн туршилтын хугацаа заавал шаарддаг гэсэн. Ингэхлээр коронавирус гэх аюулт цар тахлын төгсгөл нэг л бүдэг санагдаад байгаа юм.

Тэгвэл Монгол минь одоо яах вэ? Энэ цар тахлыг хохирол багатай яаж даван туулах вэ? гэсэн асуултад бүгд л хариулт бэлдэж байгаа, би ч хувийн бодлоо нэмэрлэе.

Манай эрхэм дээдэс оны төсөвтөө, ард түмнээрээ өчнөөн сар шаардуулж байж тодотгол хийсэн чинь 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталчихлаа. Эрдэмтэн судлаачид “тодотгоод улам дордуулчихлаа” гэж байна. Магадгүй л юм. Хоёр жил тэсчихэж болохоор тэр олон барилга байшин, хэрэгтэй хэрэггүй юмыг яах гэж төсөвт оруулаад байгаа юм бэ?. Барилга нь нураад уначихсан, дарга нь гадаа ширээ сандалтайгаа сууж байгаа газар байгаа юм уу. Тэгвэл бүгдийг цомхотгочих л доо. Эдийн засагч бүсгүй “Төсвийн 50 хувь нь хасчихаж болох л зүйл байна билээ” гэж телевизээр ярьсан. Дарга сайд нар минь, ингэж үрэлгэн загнаад цар тахлын хохирлыг арилгана гэвэл эндүүрэл байх шүү.

Гол нь бизнесийн орчноо л тэлж өгье. Уул уурхайнууд нь ажилладгаараа ажиллаж, хил гаалиараа гаргадгаа гаргая. Уртасгасан цагаар, ээлжийн системээр гээд экспортын баялгаа нэмэгдүүлэх олон гарц бий дээ. Тэр бүхнийг ашиглаж, олз

олбороо нэмье.

Жижиг дунд үйлдвэрүүдийг зогсоочихсон. Ажилчид нь хаа яваа нь бүү мэд. Энэ бол төр засгийн бодлогын нэг номерын асуудал. Өнөө жил, дараа жилийн төсвийн гол нь үүнд л чиглэх ёстой байсан. Дараа жилийн төсвийг удахгүй батална. Үүндээ эн тэргүүнд тусгах зүйл ЖДҮ.

УИХ-ын намрын чуулган хэдхэн хоногийн дараа эхлэнэ. Чуулганы хэлэлцэх асуудлын нэгдүгээрт, ЖДҮ-г дэмжих, зах зээлийг нь нээж өгөх, арьс шир, ноос ноолуурын гэх мэт дотооддоо үйлдвэрлэж болох бүх зүйлийг дэмжсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлээсэй гэж бодох юм.

Монголын хөрөнгийн тал хувь нь гадаадад яваа. Нэг нь оффшор бүсэд хадгалуулсан валют, нөгөө нь дэлхийн хамаг тансаг газруудад барьж босгосон үл хөдлөх хөрөнгө. Гадаад улс орнууд харьд гаргасан хөрөнгөө татаж эхлэлээ шүү дээ. Манайх бол эздийг нь барьж хорьчихоод юм уу, хилийн хориг тавьчихаад л хараад суугаа. Харин АТГ-ын шинэ удирдлагууд, тухайлбал, З.Дашдаваа тэргүүтэй дарга нар нь сүүлийн үед хууль бусаар олж аваад нуусан хөрөнгөтэй “дайн” зарлаж байгаа юм билээ. Эхлээд, хаана аль улсад хэний нэр дээр ямар хөрөнгө нууцаар хадгалагдаж байгааг тухайн улсын хууль хяналтын байгууллагатай хамтран шалгаж, дараа нь тэр улсын хууль эрх зүйн үндэслэлийнх нь дагуу гэрээ хэлцэл байгуулан “нуугдмал хөрөнгө”-ийг татаж авчран улсын орлого болгох гэнэ. Энэ ажиллагаа эхлэхийг.

Дэлхийн баячууд тэрбумтнууд өөр өөрийнхөө улс орны энэ хүнд үед жинхэнээсээ тусалж байна. Манайхан таг чиг. Надад нэг ийм санал байгаа юм. Хууль бусаар хөрөнгөжсөн, гадаад улс орнуудад эдлэн газар, орд харштай болчихсон хүмүүс сайн дураараа тэр хөрөнгөө энэ хүнд хэцүү үед улсдаа хандивлачихвал ял шийтгэлээс чөлөөлж болох юм. Зөвхөн АНУ-д 9 хаустай С.Баяр байсан бол Сөүлийн хамгийн тансаг хороололд 3 хаустай сайд тодорлоо. 5-10 сая ам.долларын авлига авсан сайд, УИХ-ын гишүүдийн нэр удахгүй зарлагдана гэсэн. Бас Австралиас, Оюутолгойн холбогдолтой авлига авсан монголчуудын нэрс, хөдөлшгүй баримт ч ирэх сураг гарлаа. АТГ-ын шинэ удирдлага маш өргөн цар хүрээтэй, дайчин шуурхай ажиллаж байгаа ч гэсэн, шүүх прокурор нь яах юм бол. Нэгдэж чадвал, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж чадвал, улсын төсвөөс илүү их хөрөнгө ороод ирэх юуны магад.

Дотоодын эрдэмтэн мэргэд, инженер техникчиддээ итгэл хүлээлгэе. Нэг дарга нь гарч ирээд л метро байгуулна гэдэг, нөгөө нь гарч ирээд агаарын дүүжин зам барина гэж шоуддагаа больё л доо. Дарханыхаа замыг, гэр хорооллуудынхаа зам, далан сувгийн барилга байгууламжийг юуны түрүүнд өөрийнхөө барилгачдын хүч хөрөнгөөр хийе. Улаанбаатарт эмнэлэг, сургууль хоёроос өөр барилга барихыг хатуу хориглоё. Нууц хуйвалдаанаар хотын захиргааг Арцатын ам руу нүүлгэх гэсэн санаархлыг таслан зогсоож Арцатад барьчихаад байгаа байгууламжийг халдвартын эмнэлгийн зориулалтаар ашиглая. Хавдар судлалын үндэсний төвийн хашаанд баригдсан 120 ортой эмнэлгийн барилга, Түлэнхийн төвийн барилга зэрэг объектуудыг нэн яаралтай ашиглалтад оруулъя.

Дээрээсээ эхлээд бүх зүйлд хэмнэлттэй хандъя. Эдийн засгийн энэ хүнд үед яам, агентлаг, газар, хэлтсүүдийг нэмж өөрсдийнхөө садан төрөл, танил талд суудал гаргаж өгдөгөө болил доо!

ГХЯ-нд гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг байгуулах гэнэ. ЭМЯ-нд эмийн

агентлагтай болно. Кембриджийн сургалттай тусгай сургууль бий болгохыг завдлаа. Энэ татварын хэдэн төгрөгийг чинь хэн дуртай нь ингээд “суйлдаг” болсон байна шүү дээ. Кембриджийн сургалт гэдгийг чинь Монголд арваад жилийн өмнөөс туршсан. Би сайн мэднэ. Төсвийн мөнгийг ёстой л “иддэг” юм билээ. Харийн ийм хөтөлбөрийг оруулж ирэн, үндэсний сургалтын тэр сайхан уламжлалаа нам цохих хэнд хэрэгтэй байгаа юм?!

Ер нь тэгээд хувийн сургууль, хувийн эмнэлгүүд ард түмнээсээ барж ядсан их мөнгө нэхэж авч байхад улсын төсвөөс олон тэрбумыг олгодог нь ямар учиртай юм. Үүнийг болих хэрэгтэй.

Ингэж л “өөрийн” “хүний” гэсэн ялгавартай сэтгэлгээнээсээ салж байж цар тахлын дараах эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулна даа.

Би, энэ бяцхан өгүүллээ Сарьсан багваахайгаар эхэлсэн. Бас түүгээрээ өндөрлөө. Хөөрхийдөө, энэ нэг далавчтай амьтан ямар ч буруугүй хэрнээ яасан их нүгэл хураав!

Олон янзын өвчний вирус тээж, хоол эрж явдаг жирийн л амьтдын нэг. Хүн рүү дайраагүй, хүнд халдаагүй. Хүн төрөлхтөнд ямар ч хор зэм хүргээгүй. Энэ амьтныг алаад түүхий нойтон махыг нь идсэнээс өвчин тархсан бол хүний л буруу. Энэ амьтныг барьж аваад лабораторт тарчлаан тамласан бол бас л хүний буруу. Тэгтэл энэ амьтан удам судраараа яаж дормжлогдов! Яаж хараалгаж зүхүүлэв! Яаж тамлуулж алуулав. Хүн л тэгсэн!

Амиараа дэнчин тавьсан энэ хөөрхий, сарьсан багваахай хүн төрөлхтөнд, амьтны ертөнцөд олон чухал сургамж үлдээлээ. Хятадаас эхлээд олон улс орон, зэрлэг амьтан жигүүртэн шувуудыг алж хүнсэнд хэрэглэхийг хориглолоо. Амиараа дэнчин тавиад бусдыгаа аварчих нь энэ.

“Унтаж байсан” хүн төрөлхтөнийг сэрээлээ. Зарим улс орнууд энэ тахлаас болж өвчтөн хэвтүүлэх оргүй, шарил хадгалах газаргүй болж сандарлаа. Байгалийн давагдашгүй хүчин зүйл хэзээ ч тохиолдож болно, бэлэн байдалд байх ёстой гэдгийг мартсан байсныг санууллаа.

Хүчирхэг улс гүрнүүд од гариг руу аялж, онгоц пуужин бүтээгээд, хүн хийх нь холгүй байсан хэрнээ ганцхан вируст яаж дарлуулж болдгийг удирдагчид, эрдэмтэн мэргэдэд нь мэдрүүлээ. Эмчлүүлэх гэж харь орныг зорьж, хамаг мөнгөө барсан, хаа нэг газар ном сурах гэж махарсан, харин эх орноо муулж эргэж харалгүй зугтаасан, олз ашиг хөөж орон дэлхийг хэрсэн, олон улс дамжин биеэ үнэлж явсан гээд бүх хүн өнөөдөр Монголоо саналаа. Алтаар сольж болшгүй аугаа сайхан эх оронтой хүн гэдгээ хэн хүнгүй мэдрэв бололтой. Онгоц онгоцоор ирцгээлээ. Ор дэрийг нь засчихаад хүлээж байлаа. Сарьсан багваахайн буянаар садан төрлүүд уулзлаа, уйлалдлаа. Дэлхийн улс үндэстнүүдийг ойлголцуулж, халуун цэгийнхнийг хүртэл харилцан буулт хийлгэлээ.

Дэлхийн улс орнуудыг хэмнэлтэд сургалаа. Ямар ч тооцоо судалгаагүй үрэгддэг, хаягддаг, далайд аваачаад цацчихдаг зүйл хэрэг болох цаг байж шүү гэдгийг хүн болгонд ойлгууллаа. Эдийн засгийг хэмнэлтийн зарчмаар хохиролгүй авч гарна гэсэн бодлого давамгайлах боллоо.

Ийм олон сургамжийг Сарьсан багваахай гэдэг хөөрхий нэгэн амьтан, амь насаараа дэнчин тавин байж хүн төрөлхтөнд үлдээж байна даа. Тэгээд л би сарьсан багваахайн алтадмал хөшөөг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үүдэнд босгоё гэж санал тавиад байгаа юм.



Энхтайван овогтой Батцэцэг

2003 онд “Шинжээч XXI”
НЭЗДС-д Сэтгүүл зүйн
бакалавр,

2009 онд МУИС-ийн
НШУС-д Улс төр судлалын
магистр,

2019 оноос ЭЗҮДС-ийн Бизнес
удирдлагын магистрантаар
суралцаж байна.

2003 онд Kopica Minolta
ХХК-д гэрэл зурагчин,
фильм оператор, 2005-2014
онд “Хүмүүсийн амьдрал”,
“Хүмүүс” сонинд парламентын
сурвалжлагч, редактороор
ажилласан.

2014 онд “Монгол брэнд”
сэтгүүлийн эрхлэгч, 2018
оноос хойш Засгийн газрын
мэдээ сонинны Эдийн засаг, уул
уурхайн мэдээллийн албаны
сэтгүүлчээр ажиллаж байна.

**ЭКСПОРТЫН “ЦАХИМ БООМГ”-ЫГ ИРГЭН
БҮР НЭЭЖ ЧАДНА**

*~СҮҮДЭРТ ДАГЖИЖ НУУГДАЛГҮЙ,
ГЭРЭЛТЭЙ ТАЛД НЬ ХҮЧЭЭ СОРИХ ЦАГ
ИРЭЭД БАЙНА~*

Цартахлын хөлхориог сулруулж, үйлчилгээний газруудыг нээж эхэлсний дараахан Италийн нэгэн кафед үйлчлүүлсэн эрхэм тооцоонд нэг евро төлөх байсан ч 50 евро өгчээ. Талархлынх нь хариуд тэрбээр, “Би төрийн албан хаагч. Өглөө бүр танайд аяга кофе уудаг байсан юм. Харин танайх 50 хоног ажиллаагүй. Энэ хугацаанд орох байсан орлогын чинь бяцхан хувийг нөхөн олгож байгаа минь энэ. Би энэ хугацаанд ажлаа хийж л байсан” гэж хариу талархсан тухай түүх бий. Дэлхий нийтээр хөл хорионд сөхөрсөн бизнесүүдийг яг үүн шиг төр нь аварчихна хэмээн найдаж хүлээх нь өрөөсгөл билээ.

Харин COVID-19-ийн “ачаар” шинээр бий болсон боломжуудыг шүүрэн авч өндийх нь аж ахуйн нэгжүүдийн өмнө сорилт, мөн боломж болж гарч ирлээ. Энэ бол хөл хорионоос үүдэн хаагдсан, доголдсон үйл ажиллагаагаа дахин идэвхжүүлж, хил хязгааргүй өрнүүлэх цахим эринд шилжих явдал юм.

Хоёр жилийн өмнө Хонконгт болсон нэн чухал бизнес уулзалтад Монголын нэгэн байгууллага зардлыг нь гаргах боломжгүйгээс ажилтнаа явуулж чадаагүй юм. Гэтэл тэндээс эхэлсэн бизнес модул өдгөө улам боловсронгуй болж, тив алгасан цахим уулзалтаар үргэлжлэн тэлсээр байна. Тухайн үед нислэгийн болон байр хоолны зардал болох 2000 орчим ам.доллар олдоогүйгээс оролцож чадаагүй ажилтан нь өнөөдөр ердөө 300 ам.доллар төлөөд, унтлагын өрөөндөө богино өмдтэйгөө суугаад бизнесийн шинэ модулыг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд эхэлсэн нь COVID-ын л “ач” гэлтэй.

Есдүгээр сарын 27-ны байдлаар www.worldconferencealerts.com-д 8681 чуулга уулзалт, форумын зар байршаад байна. Тэдгээрийн талаас илүү хувь нь цахим ертөнцөд бизнесээ хэрхэн удирдах

талаар дэлхийн өнцөг булан бүрт буй гүйцэтгэх захирлууд, эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүдийг хамруулан ямар шинэчлэл шаардлагатайг хэлэлцүүлж, хөрөнгө оруулалт татах, түншлэх орон зайг бий болгоход чиглэж байна.

Тухайлбал, аравдугаар сарын 24-25-нд Бизнесийн шинэ загварын олон улсын бага хурал зохион байгуулахыг <http://eurasiaweb.com/> мэдээлж, уул уурхай, ашигт малтмал, металлын боловсруулалт дахь хяналт, оновчлол, автоматжуулалтын талаар туршлага солилцох тул салбарын удирдлагууд, шинжээчид, инженерүүдийг нээлттэй оролцохыг уриалсан байна. Түүнчлэн 11 дүгээр сарын 1-2-нд болох “Нано шинжлэх ухаан ба нанотехнологийн олон улсын бага хурал”-д https://conferencealert.com/conf-detail.php?ev_id=351432 линкээр орж бүртгүүлээд, өөр өөр оронд боловсруулж, хэрэгжүүлж буй орчин үеийн технологийн шийдэл, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн салбар, төрийн байгууллагуудын оролцоо зэргийн талаарх мэдлэг, мэдээлэл авах боломжтой болсон байх жишээтэй.

Зөвхөн инженерчлэл, үйлдвэрлэлийн шинэчлэлээр энэхүү цахим түншлэл хязгаарлагдахгүй. Банк санхүү, эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг, үл хөдлөх хөрөнгө, худалдаа, экологи гээд бүхий л салбарт ямар өөрчлөлт шинэчлэл өрнүүлж буйг хуваалцах олон төрлийн арга хэмжээний мэдэгдлийг <http://associationforum.org/>, <https://www.eventbrite.com/>, <https://www.insidermedia.com/> гэх мэтчилэн наад захын вэбсайтаас харж болно.

Дээрх цахим арга хэмжээнүүдийн гишүүнчлэл болон зочны тасалбар өөр өөр ханштай бөгөөд дунджаар 50-200 ам.долларын төлбөр шаардлагатай. Мөн зарим эвент, сургалтууд үнэ төлбөргүй явагддаг.

Монголын сая гаруй иргэнийг “тэжээж” буй хувийн хэвшлүүд дор бүрнээ дэлхийтэй нэг нүдээр харж, нэг чихээр сонсдог болохын төлөө эрмэлзэх шаардлагыг цар тахал улам хурдлууллаа. Цахим эрин, XXI зууны иргэн гэж хоосон цэцэрхэж суусан монголчуудыг цаг үетэйгээ хөл нийлүүлж, технологид суурилсан инновацыг нутагшуулж, түүндээ дөрөөлөн эдийн засгаа өөд нь татах боломжийг цар тахал ийнхүү олголоо гэхэд хилсдэхгүй. Дэлхий улам хавтгай болж, та бидэнд бэлэн платформоо санал болгож байна.

Энгийн нэг жишээ авъя. Үйлчилгээний салбарт ажилладаг танил маань халагдсан даруйдаа онлайн худалдаанд хүч сорих болсон юм. Хэрэглээг хялбаршуулсан гэр ахуй, гоо сайхны бараа Хятадын вэбсайтаар дамжуулан захиалж аваад, өөрийн фэйсбүүкээр сурталчилж, гурван түгээгчээр зэрэг хүргүүлэх маягаар ажилладаг. Сардаа дунджаар 50 орчим сая төгрөгийн борлуулалт хийдэг. Үүнээс 70 хувь нь импортоор авах бараа, тээврийн зардал, сурталчилгааны хөлсөнд төлдөг гэв. Ингээд ямар ч түрээс төлөхгүй, түгжрэлд зоогдохгүй, цалин хүлээхгүйгээр гэрээсээ ажиллаж, сардаа арав гаруй сая төгрөгийн цэвэр ашиг олдог аж. Ийм онлайн худалдаачид улам олширсоор байна. Тэд хэдийгээр цөөхөн гэр бүлийн амьжиргааг залгуулж байгаа боловч импортын урсгалд хүч нэмсээр байгаа нь харамсалтай. Харин энэ мэт аргачлалаар гадагшаа мөнгө урсгах биш, дотооддоо татаж байвал эдийн засгийн өсөлт, иргэдийн амьжиргааг дэмжихэд нөлөөлж эхэлнэ.

Цар тахлын дараа эдийн засгаа өсгөх гол хүчин зүйлийг экспорт нэмэгдүүлэх явдал гэж МҮХАҮТ-аас дэвшүүлсэн. Экспортыг зөвхөн уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр төлөөлдөг эдийн засгийн бүтцээ өөрчлөхийг тэд онцолж буй.

Хэрэв онлайн худалдаагаар сардаа хагас зуун саяыг эргэдүүлдэг танил шиг маань олон хүн өдөр бүр цахим ертөнцөд сая саяаараа сүлжилдэн уулзалдаж буй дээрх эвентүүдэд оролцож, наад зах нь Монголынхоо экологийн цэвэр бараа бүтээгдэхүүнийг танилцуулж, түншлэл байгуулж чадвал эдийн засгаа өсгөхөд оруулж буй хувь нэмэр нь болно. Хааяа нэг гардаг “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнгийн үеэр хахдаг эсгий болон арьсан урлалыг эхний ээлжинд онлайн худалдаанд зуучлахад төрийн бодлого хүлээх шаардлагагүй. Цахим орчинд чөлөөтэй ажиллаж дадсан, гадаад хэлээр ойлголцдог “сийрэг толгойтон” л байхад хангалттай. Ийм боломжийг дэлхий нийтэд сүүдрээ тусгасан коронавирус бидэнд олгоод байна. Сүүдэрт дагжин нуугдалгүй, гэрэлтэй талд нь хүчээ сорих цаг ирээд байна.

Энгийн нэг үйлчилгээний ажилтны бизнес модулыг томруулж хараад, нутагшуулж чадвал Монголын жижигхэн эдийн засгийг хэд дахин нугалсан өсөлт энүүхэнд байгааг хувийн хэвшлийнхэн ойлгож, энэ зүгт боловсон хүчнээ бэлтгэж байгаа. Харин төрийн бодлого тэдэнтэй өрсөлдөж, хорьж хавчих, дүрэм журам тогтоож нугалаа үүсгэн, авлига нэхэх орон зайг бий болгохгүй толгой дохин дэмжиж, эрсдлээс хамгаалахад чиглэгдээсэй.

Icon.mn



Баярболд овогтой Даваабазар

*2017 онд МУБИС-ийг
сэтгүүлч мэргэжлээр төгссөн.*

*2017- онд ИТОИМ мэдээллийн
сайтаас ажлын гараагаа
эхэлсэн.*

*2018-2019 онд Орхон аймгийн
ETV телевизэд сэтгүүлч,*

*2019 оны хоёрдугаар сараас
хойш icon мэдээллийн сайтад
сэтгүүлчээр ажиллаж байна.*

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ТЭСЭЖ ҮЛДЭХ ҮҮ?

2019 онд 570,262 жуулчин Монголд ирж, жуулчдын тоо хамгийн дээд хэмжээндээ хүрсэн. Ингэснээр нийт 607 сая ам.доллар буюу 1.7 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан өсөлттэй жил байв.

Гэвч цар тахлаас үүдэн 2020 оны эхний гурван сард л гэхэд Улаанбаатар хотын эдийн засагт аялал жуулчлалын салбараас шууд олох боломжтой байсан 30.5 тэрбум, шууд бусаар 325 тэрбум төгрөгийг алдсан гэдгийг МҮИС-ийн багш, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн гишүүн, судлаач Б.Ербахыг хийсэн судалгаагаараа танилцуулсан юм.

COVID-19 цар тахлаас үүдэн олон хүндрэл, саад бэрхшээлийг хүн төрөлхтөн амссаар найман сарыг ардаа үджээ.

Баян ядуу, хөгшин залуу гэж ялгаагүй шинэ коронавирусээс болж олон хүний амь үрэгдэн, олон ч салбар ганхан гуйвж байна. Үүний нэг нь яах аргагүй АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ билээ.

“Дэлхийн аялал жуулчлалын өдөр” есдүгээр сарын 27-нд тохиодог. Иймээс тус өдрийг тохиолдуулан Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, салбарыг хамгаалах төрийн бодлого хэрхэн хэрэгжиж байгаа зэрэг асуудлыг сурвалжилснаа хүргэж байна.

2020 онд жуулчдын худалдан авалт хотын эдийн засагт оруулах мөнгөн дүн 10.1%-аар өсөж, 619.8 сая ам.доллар болох төлөвтэй байгааг салбарынхан ярьж байв. Харамсалтай нь энэ орлогыг олох нь байтугай аялал жуулчлалын салбар өнөөдөр ажилчдынхаа цалинг тавьж чадахгүй боловсон хүчнүүдээ алдаж ТЭГ ЗОГСОЛТ хийгээд байна.

С.Амгаланбат: Энэ цаг үе бол Монголын аялал жуулчлалын салбарын түүхэнд байж болох хамгийн хүнд сорилт

“Өдгөө манай улсын аялал жуулчлалын

салбарт 1,300 ААН, байгууллага 88 мянга гаруй ажлын байр шууд болон шууд бусаар хамаарагддаг. COVID-19 гарсантай холбоотойгоор нэгдүгээр сард өвлийн жуулчлал гэж цөөхөн жуулчид аваад түүнээс хойш огт жуулчин аваагүй. Үндсэндээ жуулчдын 99% нь цуцлалт хийсэн.

Өөрөөр хэлбэл, 300 гаруй зочид буудал, 460 гаруй тур оператор компани, 400 гаруй жуулчны бааз болон шууд бусаар ажилладаг хөтөч, жолооч, тогоочид, малчид гэх мэт гэрээт ажилчид гээд нийт 88 мянга гаруй хүн орлогогүй болсон. Аялал жуулчлалын нийт компаниудын 90% нь цалин мөнгөө тавьж чадахгүй зогссон. Манай компани ч гэсэн цалингаа тавьж чадахгүй зогссон. Энэ цаг үе бол Монголын аялал жуулчлалын салбарын түүхэнд байж болох хамгийн хүнд сорилт” гэж Монголын аялал жуулчлалын хорооны УЗГ С.Амгаланбат хэлсэн юм.

Хүндрэлтэй нөхцөл байдал цаашид 2-3 жил үргэлжилнэ. Мөн улирлын чанартай аялал жуулчлалын салбар өмнөх шигээ сэргэхэд тийм ч амар байхгүй гэдгийг дэлхийн олон улсын судалгааны байгууллагууд хэлж буй.

Гэтэл манай улсын төр засгийнхан, шийдвэр гаргагчид удахгүй Монголын аялал жуулчлалын салбар сэргэнэ хэмээгээд хэний ч ой тойд багтахааргүй жуулчдын их тоо хэлж буй нь гайхшрал төрүүлнэ.

Тухайлбал, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ энэ оны дөрөвдүгээр сард “Холбогдсон дэд бүтцийн цикл дунд үндсэндээ бидний тооцож байгаагаар 400 орчим сая жуулчин ирэх хүчин чадал байна гэж үзэж байгаа. Монгол туургатантай холбоотой буриад зон, бусад халимаг, тува зэрэг... Мөн худалдааны том, зүүн бүсийн ийм, Улаанбаатар хоттой холбогдох том төслийн гүүр нь энд харагдаж байна гэсэн үг” хэмээн ярьсан. Өөрөөр хэлбэл, Хэнтий аймгийн Чингис Хот, Дадал сумыг 200 км замаар холбож, шинэ гүүртэй болсноор ийм боломж үүснэ хэмээн түүний баг тооцоолсон аж.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл “Монгол Улс 2019 онд 577 мянган жуулчин хүлээж авсан. Тэгвэл ирэх дөрвөн жилд энэ тоог 1 сая болгох зорилт тавин ажиллаж байна. Цар тахалтай холбоотойгоор аялал жуулчлалын салбар зогсонги байдалд байгаа ч буцаад сэргэх төлөвтэй байна. Түүнчлэн цар тахлыг бид нэг талаараа боломж гэж харж байгаа. Тиймээс бид бэлтгэлээ сайн хангаж байх хэрэгтэй” хэмээн зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг зохион байгуулах үеэр хэлсэн байсан.

Аялал жуулчлалын өнөөгийн болон цаашидын нөхцөл байдалд үүссэн асуудлыг илүү тодруулах үүднээс салбарын төлөөллүүдтэй ярилцлаа.

**~ЭНЭ САЛБАРТ ӨНГӨРСӨН ХУГАЦААНД БЭЛТГЭГДСЭН БОЛОВСОН,
АЖИЛЧДАА АЛДАЖ БАЙНА. ЭНЭ БАЙДЛААРАА 400 САЯ БАЙТУГАЙ 400
МЯНГАН ЖУУЛЧИН Ч ХҮЛЭЭЖ АВЧ ЧАДАХГҮЙ~**

Монголын Аялал жуулчлалын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн С.Амгаланбат

- Энэ жил цар тахлаас шалтгаалаад олон салбар уналтад орсны нэг нь аялал жуулчлалын салбар байлаа. Хэр хүнд туссан талаар эхлээд асуумаар байна?

- 2020 оны хоёрдугаар сараас бид шат дараатай арга хэмжээнүүд авч ажилласан. Анх карантिलाхад 2-3 сар л болно гэж бодоод хүмүүсээ сургаж, цахим сурталчилгаагаа явуулж, ажилласан. Гэтэл тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилж, салбарынхан өөрсдийнхөө хэмжээнд хохирол багатай даван туулах гэж бүх хүчээ дайчилсан. Сүүлдээ компаниуд цалингаа тавих, сургалт явуулах ч мөнгөгүй болоод, зарим газар эхнээсээ хаалгаа барьсан. 2019 онд гаднын жуулчдаас 1.7 их наяд төгрөгийн орлогыг улсдаа оруулсан байдаг. Энэ нь 2019 онд 2018 оныхоос 10%-ийн өсөлттэй байж чадсан гэсэн үг. Тэр утгаараа бид ирэх жилийнхээ таамгийг дэвшүүлэхэд 2020 онд дор хаяж 10 хувийн өсөлттэй байна гэж бодож байсан боловч байдал эсрэгээрээ эргэсэн.

- Цалин мөнгөгүй газар ажиллаад байж чадахгүй болохоор ажиллах хүчний хувьд асуудал их үүсэж байгаа байх тийм үү?

- Энэ салбарт өнгөрсөн хугацаанд бэлтгэсэн боловсон, ажилчдаа алдаж байна. Ингэж тарж алга болоод дуусвал 400 сая байтугай 400 мянган жуулчин ч хүлээж авч чадахгүй. Ажилчид маань ч өөрсдийн боломжоороо тэсээд эцэс сүүлдээ өөр газруудад ажиллахаар явж байгааг буруутгах аргагүй. Бүх бэлтгэсэн хүний нөөц, боловсон хүчнүүд байхгүй болж, цалинг чинь тавьж чадахгүй нь уучлаарай гэж хэлээд сууж байна. Одоо л нэг хөгжих нь гэж харсан салбар маань ийм байдалд орсон.

Мэдээж хэрэг энэ салбарыг төр засаг авраад л цалин мөнгийг нь тавиад явна гэж байхгүй. Тэгэх ч боломжгүй ба хувийн хэвшил өөрсдөө эрсдлээ даах ёстой. Гэхдээ ганц хоёр компани биш бүхэл бүтэн Монголын аялал жуулчлалын салбар хохирчихоод байгаа учраас ядаж энэ салбарыг авч үлдэхийн тулд салбарт чиглэсэн бодлого л хэрэгтэй.

- Энэ талаар Монголын аялал жуулчлалын холбооноос хуралдаад гаргасан санал зөвлөмж гэж байгаа юу?

- Аялал жуулчлалын бизнес эрхлэгч байгууллагууд хуралдаад, компаниудаас нөхцөл байдлаа хэрхэн даван туулах санал гаргасан. Хүмүүсээ бэлдэх, хөнгөлөлттэй зээл тусламж, нөхөн олговрыг компаниудад өгөх зэрэг 4-5 хамтарч ажиллах чиглэл гарган Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, БОАЖ-ын сайдад хүргүүлсэн.

Шадар сайдын хэлснээр бол ирэх жилийн хагас хүртэл хил нээхгүй гэсэн. Ингээд бодохоор ирэх жил ч аялал жуулчлал салбарын үйл ажиллагаа бүтэн зогсохоор дүр зураг ажиглагдаж байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын судалгаагаар аялал жуулчлалын салбар 2024 оноос урьдын хэв маяг руугаа дөхнө гэсэн. Тэр болтол яаж тэсэж гарах вэ гэдэг нь л асуудал. Хоёр жил бид нар хүмүүсийнхээ цалинг тавиад яваад байж чадахгүй. Энэ байдал үргэлжилбэл манай улсын хувьд аялал жуулчлалын салбар ирэх жил ч тэг зогсолт хийх бололтой. Аялал жуулчлал бол үйлчилгээний экспорт. Аялал жуулчлал бол үйлчилгээний экспорт. Манай аялал жуулчлалын салбар хэчнээн Монголд эдийн засаг хямарч, уул уурхайн түүхий эдийн үнэ унасан ч тогтвортой байж, жилд 600 сая орчим ам.долларын орлогыг гаднаас оруулдаг онцлогтой учраас энэ хүнд үед нь төр засгийн дэмжлэг маш их хэрэгтэй байна.

- Бусад улс орнууд аялал жуулчлалын салбараа сэргээхээр ямар арга ажлуудыг хийж байгаа бол. Жишээ байна уу?

- Тайвань, Солонгост гэхэд компаниудын сарын цалингийнх нь 60-70 улсаас нь нөхөн олговор хэлбэрээр өгч байгаа гэсэн. Төв Азийн Казахстан, Узбекистан зэрэг адилхан нүүдэлчин ахуйг судалдаг манайхтай аялал жуулчлалаараа өрсөлддөг улсуудад улсаас нь нөхөн олговор олгох арга хэмжээ авч байна. Хүмүүсийнхээ ажлын байрыг хамгаалахын тулд тэд салбараа хамгаалж байгаа хэрэг. Энэ салбарынхан тараад алга болбол дахин аятайхан үйлчилгээ үзүүлээд босохын тулд тулд 5-10 жил шаардлагатай. Манай улс 200 мянган төгрөгийг гурван сар өгсөн. Гэхдээ зарим компани л арай гэж авсан. Хил хаагаад дотоодын аялал жуулчлал нэмэгдэхийн хувьд нэмэгдсэн болохоор аялал хийдэггүй байсан компаниуд хүртэл бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан. Гэхдээ яг тур оператор мэргэжлийн компаниар дамжиж явсан хүмүүс тун цөөхөн байсан юм. Монголчууд маршрутаа аваад, судалж байгаад өөрсдөө явчихдаг. Судалгаагаар Монголчуудын 90 хувь нь дан хувиараа аялдаг гэж гарсан. Үүнд хүмүүсийг буруутгах аргагүй.

~АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫНХАНД БОДЛОГЫН ХАРИУЛТ ХЭРЭГТЭЙ БАЙНА~

Монголын Аялал жуулчлалын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Д.Наранцэцэг:

- Одоо тулгамдаж буй асуудлаасаа хуваалцахгүй юу?

- Тийм ээ, хэцүү байгаа нь үнэн. Нэгэнт хүнд байдалд орсон нь ойлгомжтой байхад цаашид энэ салбараа бүр мөхөөхгүйн тулд л арга хэмжээ авах хэрэгтэй. Хил нээгдээд жуулчид авахад яг ямар шаардлага тавих зэрэг тодорхой хариултгүй суугаа нь илүү том асуудал. Жишээ нь жуулчид манай улсад орж ирлээ гэхэд халуунаа хэмжүүлсэн байх уу, вакцин хийлгэсэн байх ёстой юу, хийлгэсэн бол аль улсын вакциныг хүлээн зөвшөөрөх вэ, жуулчин ирээд каранталагдах уу, яг аль улсаас ирэхэд нээлттэй байх вэ, эсвэл бүгд нээлттэй юу гэх зэрэг тодорхой нарийн зүйл хэрэгтэй.

Зарим улс орон тодорхой болгоод эхэлчихсэн. Тухайлбал, Австрали Шинэ Зеланд хоёр хоорондоо хилээ нээж, ажиллана гээд аялал жуулчлалын бодлогоо хэрэгжүүлж эхэлсэн. Гэтэл манай улс хилээ хэзээ нээх нь мэдэгдэхгүй, нээсэн ч хэсэгчилж нээх үү, бүх улсаас ирсэн жуулчид орж болох уу гэдэг нь ч мэдэгдэхгүй.

Гаднын түншүүд маань “танай хил хэзээ нээгдэх гэж байна, хэзээнээс аяллаа зарлаж болох вэ” гэж эхнээсээ асууж байгаа. Бидэнд үнэндээ хариулах хариулт алга. Аялал жуулчлалын салбарынханд бодлогын хариулт хэрэгтэй. Эхний ээлжид шууд нислэгтэй газрууд болох Япон, Солонгос, Хонг Конг, Хятад, Орос, Турк улсуудтай ямар арга хэмжээн дор хамтран ажиллахаа ярих хэрэгтэй байх.

- Аялал жуулчлалын салбарын ирээдүйг олон улсын байгууллагууд хэрхэн төсөөлж байгаа бол?

- Олон улсын байгууллагууд янз бүрийн судалгаа хийж байна. Сүүлд гарсан нэг судалгаагаар аялал жуулчлал 2023 он хүртэл 2019 оныхоо түвшинд очихгүй гэж гарсан. Өөрөөр хэлбэл бид 2021, 2022 ондоо жуулчид хүлээж авах нь хэцүү болсон гэсэн үг. Тэр тусмаа холоос жуулчид авч чадахгүй нь тодорхой болжээ.

Бас Европын сэргээн босголтын банк, Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас хийсэн судалгаагаар хүмүүс холын улс орнууд руу аялахгүй, ойр орчмынхоо улсууд руу аялна. Европууд европ дотроо, Ази нь Ази дотроо аяллын маршрутаа бий

болгоно гэсэн байсан.

- Энэ жил хил хаасантай холбоотойгоор дотоодын аялал жуулчлал харьцангуй нэмэгдсэн. Энэ нь Монголын аялал жуулчлалын салбарт тус болсон уу?

- Гадагшаа явж чадахгүй байгаа учраас дотоодын аялал жуулчлал тодорхой хэмжээнд нэмэгдсэн нь үнэн. Үнэн хэрэгтээ Монголчууд маань гадаадын жуулчин шиг аялдаггүй. Аялна гээд зүгээр л агаар салхинд гарч, танин мэдэхүйн юм ч үзэж харахгүй явсаар нэг амралтад очоод идэж ууж байгаад л ирдэг. Өнгөрсөн хавар МУИС-ийн аялал жуулчлалын багш нар “Та аялал жуулчлалын компаниар дамжиж аялах уу” гэж иргэдээс авсан судалгаагаар 95% нь “Үгүй, өөрөө аялна” гэж хариулсан байсан. Тэгэхээр яг аялал жуулчлалын салбарт тэгтлээ их нөлөөлөөд байсан зүйл байхгүй гэхэд болно. Ийм болохоор л манай улс яг аль чиглэлд илүү анхаарал тавьж, аялал жуулчлалын салбараа авч үлдэх вэ гэдгийг бодолцох ёстой гэж хэлээд байгаа юм.

~САЛБАРЫН ХУВЬД БАС ЭНЭ ОНЫГ ДАВАХААС ГАДНА ИРЭХ ОНЫГ ЯАЖ ДАВАХ ВЭ ГЭДЭГ ХҮНД АСУУДАЛ ТУЛГАРААД БАЙНА~

- 400 сая жуулчин, 157 сая жуулчин гээд их л том тоонууд яригдаж байгаа. Бодлого, шийдвэр гаргагч нараас та бүхнийг хэр сонсож байна. Төр засгаас та бүхнээс нэн түрүүнд хүсэх зүйл юу байна?

- Манай салбарыг онцгойлон харж үзээсэй л гэж хүсэх байна. Улсын хэмжээнд одоо хорио цээр харьцангуй тавигдаад бусад салбарынхны үйл ажиллагаа харьцангуй жигдэрч эхэлж байгаа нь сайн хэрэг. Харамсалтай нь аялал жуулчлалын салбарынхан хил нээгдсэн ч хэвийн байдалдаа хурдан шилжихгүй. Угтаа бол энэ салбар Монгол Улсын эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд бусад бүх салбарт ч нөлөөлдөг.

Иймд аялал жуулчлалын компаниуд тэг зогсолт байгаа учраас салбараа авч үлдэхэд туслах хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж хүсмээр байна. Манай салбарынхан ЖДҮ-ийн зээл, ногоон зээлд хамрагдаж чаддаггүй. Одоогийн байдлаар зарим газар нь хадгалсан хэдэн төгрөгөөрөө л ажилчдаа цалинжуулаад явж байгаа. Хил нээгдсэн гэдэг хэцүү л байх. Манай салбарын хувьд бас энэ оныг давахаас гадна ирэх оныг яаж давах вэ гэдэг хүнд асуудал тулгараад байна.

- Та сая хэллээ тэсэж үлдэх болов уу даа гээд. Манай улсын аялал жуулчлалын салбарын өнөөдрийн энэ бий болсон түвшинд хүрэх гэж олон жилийн хүч хөдөлмөр урссан нь гарцаагүй. Салбарын ажилчдад мэдээж хэрэг хэцүү тусаж байгаа байх?

- Тэгэлгүй яах вэ. Хэн ч таамаглаагүй байсан зүйл дэлхий дахинд учирсан. Тэг зогсолт хийчихээр олон жил ажилласан хөтөч, жолооч нараас авахуулаад ажилчдын маань амьдралд хүнд цохилт болсон. Монголын аялал жуулчлалын салбарт одоогийн байдлаар 1,300 гаруй ААН, байгууллага 88,000 гаруй ажлын байр байдаг. Энэ салбарт гэр бүлээрээ ажилладаг хүмүүс ч их. Гэтэл энэ жил манай салбар бараг -600 сая ам.долларын алдагдалтай ажиллаж байгаа гэхэд болно.

Манай компанид гэхэд олон жил бэлтгэгдсэн боловсон хүчин олон бий. Тэднийгээ алдахгүйн тулд тэг зогсолт хийсэн ч гэсэн хадгалж хуримтлуулж байсан нөөц хөрөнгөө гаргаад цалинжуулаад явж байна. Хил нээгээд хэдэн жуулчин авах гэтэл боловсон

хүчнээ алдсан байвал дахиад шинээр бэлдэх гэж цаг хугацаа, хөрөнгө мөнгөнөөс эхлээд хүндрэлтэй тулгарна. Тийм болохоор боловсон хүчнээ үлдээхээр чармайн ажиллаж байна.

“

Цар тахлаас үүдэн 2020 оны эхний гурван сард л гэхэд Улаанбаатар хотын эдийн засагт аялал жуулчлалын салбараас шууд олох боломжтой байсан 30.5 тэрбум, шууд бусаар 325 тэрбум төгрөгийг алдсан гэдгийг МҮИС-ийн багш, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн гишүүн, судлаач Б.Ербахыт хийсэн судалгаагаараа танилцуулсан юм.

”

Toim.mn



**Энхтайван овогтой
Мөнхцэцэг**

*2012 онд Сэтгүүлч дээд
сургуульд сэтгүүлч мэргэжлээр,*

*2020 онд Монгол Улсын
Эрдмийн их сургуулийг
орчуулагч мэргэжлээр тус тус
төгссөн.*

*2012 онд өдөр тутмын
Үндэсний шуудан сониноос
ажлын гараагаа эхлүүлсэн.*

*2015 онд мэдээллийн iToim.mn
сайтыг үүсгэн байгуулалцаж,
өнөөдрийг хүртэл тус сайтад
сэтгүүлч, редактороор
ажиллаж байна.*

Б.ЛХАГВАЖАВ: НИЙГМЭЭРЭЭ ЭРГЭЭД НЭГ, ХОЁР ХҮНЭЭС АЙДАГ, БИЗНЕСИЙНХЭН Ч ХАДАГ БАРИН СӨГДДӨГ БОЛЛОО

*Бизнесийн ухааны доктор, эрх зүйч
Б.Лхагважавтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

-Дэлхий улс орнууд коронавирусын халдвараас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хямралтай нүүр тулж байна. Улс орон бүр энэхүү хүндрэлийг хохирол багатай даван туулахаар өөрсдийнхөө нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг авсаар байгаа. Монгол Улсын авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээ хэр дүр дүнтэй байгаагаас яриагаа эхэлье.

-Коронавирус хоёрдугаар сард ид дэгдэхэд л эдийн засгийн болон нийгмийн том асуудлууд үүснэ гэдгийг хэлж байсан. Тухайн үед эрүүл сэтгэлгээ, эрүүл дүгнэлтүүдийг хүлээж авах процесс бага байсан л даа. Учир нь, сонгууль дөхсөн, түүнд зориулсан төсөв баталсан учраас үнэнтэй хөл нийлүүлэхгүйгээр тэр чигээрээ явчихсан. Өнөөдөр бодит байдалдаа гүйцэгдэж байна шүү дээ. Гэтэл дэлхий дээр гурав, дөрөвдүгээр сард үйл явц өөрөөр эргэсэн. Гуравдугаар сараас БНХАУ, Европын холбоо, дараа нь АНУ-д хүндэрлээ. Үүнийг дагаад хөрөнгийн бирж дээрх том хувьцаануудын ханш унаж, дайны байдал бий болсон. АНУ, Европын хөрөнгийн биржийн арилжаа зогссон шүү дээ.

Хятад улс нийгэм, эдийн засгийн системийн бүтэц, иргэдийнхээ итгэл үнэмшлийг алдагдуулахгүйн тулд хөрөнгүүд гаргасан. АНУ ч чөлөөт зах зээлийнхээ үнэ цэнийг нэг удаагийн хямралд алдахгүйн тулд маш их хэмжээний мөнгө хэвлэсэн. Европын холбоо том системээ авч үлдэхийн тулд мөнгө санхүүгийн стандарт бус аргуудыг хэрэглэлээ. Европ 500 тэрбум евро, АНУ хоёр их наяд ам.долларын хөрөнгийг эдийн засагтаа оруулсан. Эдгээр арга хэмжээг гурав,

дөрөвдүгээр сард авч хэрэгжүүлсэн. Харин манай улсын хувьд ерөнхийдөө тайван, унтуулах байдалтай явж байгаад сонгуулийн дараа найм, есдүгээр сараас эдийн засгийн асуудал руу орж, бодит мэдээлэлд тулгуурласан арга хэмжээ авах гэж дөнгөж оролдож байна. Манай улс эрүүл мэндийн хувьд хамгаалалт хийж чадсан. Харин эдийн засаг, нийгмийн асуудалдаа хожуу арга хэмжээ авч байгаа. Өнгөрсөн хавар бол амь аргацаасан арга хэмжээг авсан. Хамгийн гол нь ажлын байр бий болгож, татвар төлж байгаа аж ахуйн нэгжээ том, жижиг гэлтгүйгээр тогтвортой ажиллах боломжоор хангах ёстой юм.

-Тэгэхээр таны хувьд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ажлын байрыг хамгаалах, ААН-ийг дэмжихэд бүрэн чиглээгүй гэж хэлэх гээд байна уу?

-Зургаан сарын хугацаатай хэрэгжсэн арга хэмжээ бол үзэгдэл дөнгөж эхэлж байх үед авсан арга хэмжээ. Одоо ААН-үүд дампуурах, иргэд ажлын байраа алдах эрсдэл рүү орно. Өөрөөр хэлбэл, манай төр амь зогоох л арга хэмжээ авсан. Тухайн үед вакцин гарчихна, дэлхийн байдал буцаад хэвэндээ орно гэж тооцож байсан ч өнөөгийн хүндрэл хоёр жил үргэлжлэх хандлагатай байна. Бид тэнхээтэй үлдэхийн тулд ажлын байраа хадгалах чиглэлд мөнгө хийх хэрэгтэй. Хоёрт, гуравдугаар сар бол манай эдийн засгийн нөөцийн оргил үе байдаг. Цагаан сардаа бэлтгэж, айл бүр тодорхой нөөцийн хадгаламжтай байсан. Цагаан сарын 300-400 тэрбум төгрөгийн худалдан авалт хийгдээгүй, хувь хүн, өрхдөө үлдсэн. Бизнесүүдийн хувьд ч өвөлдөө зогсонги, нөөцийн оргил үедээ байдаг. Энэ хуримтлагдсан нөөцөө бид аравдугаар сар хүртэл хэрэглэчихлээ. Үндсэндээ дотоод нөөц шавхагдсан гэсэн үг.

-ААН-д чиглэсэн ажлын байрыг хадгалах, хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулахын тулд төр ямархуу зохистой арга хэмжээ аваасай гэж Та бодож байна вэ?

-Гаднах механик хаалтуудаас болж эдийн засгийн эргэлт зогссон шүү дээ. Өнөөдөр Монголд бүртгэлтэй 200 мянган компани байгаа. Үүнээс татварын орлогын 99.9 хувийг бүрдүүлдэг 1000 орчим компани бий. Гэхдээ нийт ажлын байрны 70-80 хувийг бүрдүүлдэг нь үлдэж буй 80 мянга гаруй компани юм. Ерөнхийдөө идэвхтэй ажил хөдөлмөр эрхэлж байгаа нэг сая хүний 800 мянгыг нь хувийн хэвшлийнхэн ажилтай байлгаж байна. Үлдсэн 200 мянга нь төрийн албан хаагчид. Тиймээс төр коронавирусийн нөхцөл байдлыг ашиглаад даатгалын системээ зөв замд нь оруулах хэрэгтэй байна. 2016 онд НӨАТ-ын хууль хэрэгжиж, татвараа маш сайн төвлөрүүлж чаддаг болсон. Үүнтэй адил буруу замаар явсан, гажиг даатгалын системээ одоо засах боломж гарч байна. Таван төрлийн даатгалын сангаа хөрөнгөжүүлэх байдлаар дахин идэвхжүүлж, татвар төлж байгаа иргэн, ААН-ээ хамгаалах хэрэгтэй. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийг хөрөнгөжүүлнэ гэсэн үг.

-Хөдөлмөрийн зах зээлээ хөрөнгөжүүл гэдэг нь...?

-Жишээ нь, хөрөнгийн зах зээлээ хөрөнгөжүүлбэл цалингийн 50 хүртэлх хувийг ажилгүйдлийн даатгалаар дамжуулж татвар, даатгал төлсөн хүмүүст өгч болно. Төрийн албан хаагчид 100 хувь цалингаа авч байгаа шүү дээ. Цаана нь хувийн хэвшилд ажиллаж байгаа 800 мянган хүн бий. Хувийнханд цалингийн 50 хувийг өгөхөд нэг сард 360 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд 10, 11, 12, 1, 2, 3 гээд зургаан сарын хугацаанд хоёр их наяд төгрөг хэрэгтэй. Үүнийг заавал мөнгө хэвлэж шийдэхгүйгээр даатгалаас төвлөрдөг эх үүсвэрээс шийдэж болно. Жилд зөвхөн даатгалаас 2.4 их наяд төвлөрүүлдэг. Ирэх 2021, 2022 онд ойролцоогоор 4.8 их наяд төгрөг цуглана. Үүнийхээ 50 хувиар зээл авч болно. Монголбанкнаас

Хөдөлмөрийн яамаар дамжуулж бонд гаргаад тухайн эх үүсвэрийг татвар, даатгал төлж байгаа компаниудад цалингийн 50 хувийг өгчихвөл хөдөлмөрийн зах зээлээ хамгаалаад гарч чадна. Өнөөгийн нөхцөлд стандарт бус аргуудыг хэрэглэж байгаад ч хамаагүй коронавирсийн вакцин гарч, ердийн амьдралдаа шилжих хүртэлх хоёр жилийг давах ёстой. Хэрвээ идэвхтэй 60 мянга, бүр илүү идэвхтэй 10 мянган компани тараавал дахиад ийм хамт олон бүрдэхэд 20-30 жил шаардлагатай. Тэгэхээр одоо бий болгосон компаниудын үнэ цэнийг унагахгүйн тулд ажлын байрыг нь дэмжсэн стандарт бус арга хэмжээг авах ёстой. Нөгөө талаас бидэнд хямралыг давсан туршлагауд бий. 1990 оноос өдийг хүртэл дөрвөн том хямралтай нүүр тулсан. 1990-1992 оны хямрал бол нийгэм, эдийн засаг, улс төрийн маш том хямрал болж, бүх зүйлээ тэгээс эхэлсэн. Дараа нь 1997, 2009, 2013-2016 оны хямралаас гарахдаа тухайн нэг салбарт байгаа уналтыг тэтгэх маягаар даван гарсан. Одоо нийт уналтыг тэтгэхийн тулд өмнөх хямралуудаас туршлага аваад хаашаа мөнгө хэвлэж оруулах уу, хаанахын бонд авах уу, алинд нь хөрөнгө оруулалт хийх үү гэдгээ зөв шийдэх хэрэгтэй.

-Мөнгө хэвлэж, бонд гаргаж байсан туршлагауд бий. Гэхдээ хэдхэн компани, нэг салбарыг дэмжиж, эргээд үр ашиггүй зарцуулалт болж хувирсан нь олон шүү дээ?

-Өнөөгийн нөхцөл бол дайны байдалтай адилхан. Нэгийг нь онцолж бөөцийлөх маягаар бусдыг нь хаядаг үеийн хямрал биш. Өмнөх хямралуудын ихэнх нь уул уурхайн салбар, тэр дундаа түүхий эдийн үнийн уналтаас үүдсэн хямрал байсан. Одоо уул уурхайгаас гадна нийгмийн салбарыг хамарсан үйл явц болох гээд байна. Одоо төр үндсэн үүргээ л биелүүлмээр байна. Хямралын үед төсөв, мөнгөний зөв бодлого, хөрөнгө оруулалтаар хангах ёстой. Гэхдээ маш сайн механизмыг нь олж хийхгүй бол 2013 он шиг 250-хан компанид мөнгө хэвлэж өгөөд, буцаад есөн сарын дараа мөнгөний ханшаа 40 хувиар унагасан гашуун алдааг давтаж болохгүй. Өөрөөр хэлбэл, нэг гараараа мөнгө хэвлэж өгчхөөд, нөгөө гараараа мөнгөний ханшаа 40, 50 хувиар унагавал зээл авсан хүмүүс, компани нь хохирно.

-Та коронавирсийн нөхцөл байдлыг ашиглаад даатгалын системээ зөв голдиролд нь оруулчих гэж байна. Үүнтэй адил хямралыг боломж гэж хараад эдийн засгаа эрүүлжүүлэх, банк санхүүгийн салбартаа шинэчлэл хийх боломж хэр байгаа бол?

-2004 оноос хойш Монголын эдийн засаг 10 дахин өссөн. Эдийн засаг өсөх тусам манай Засгийн газрын зардал өсч байгаа. Таван их наяд байсан төсөв гурван жилийн дараа 11 их наядаар яригдаж байна. Үүнийг дагаж өсч байгаа зардлыг дундажлаад харахад, цуглуулж байгаа татварынхаа 70 хувийг зарцуулаад байгаа. Сая төсвийн тодотголоор энэ зардлаа ядаж 50 хувь руу оруулах байсан. Төсөв, мөнгө санхүү, нийгмийн даатгалтай холбоотой асуудлыг хавар шинэчлэх ёстой байсан ч сонгуулиар хаасан. Одоо шинээр бүрдсэн УИХ, Засгийн газарт реформ хийх туршлага байна уу. Хоёрт, шинэ бүрэлдэхүүнд шинэчлэл хийх эр зориг байна уу. Ерөнхийдөө УИХ, Засгийн газар хоёрхон хүнээс айж давхиад байгаа шүү дээ. Монголын нийгэм эргээд нэг, хоёрхон хүнээс айдаг боллоо. Манай бизнесийнхэн ч нэг, хоёрхон хүмүүст хадаг бариад, сөгдөж байна. Сөгдсөн нь илүү ашгаа авч байна, буцаагаад лицензээ алдахгүйн тулд бүх зүйлээ л тавиад тууж байна. Ийм байхад реформ хийж, сэтгэлгээний шинэ менежмент хийж чадахгүй болов уу гэж харж байна даа. Шинээр бүрэлдсэн УИХ, Засагт Монголын гайгүйхэн сэхээтнүүд багтаж, шинэ сэтгэлгээ гарсан бол өөр байх байсан.

-Зарим хүн УОК-ийг дэргэдээ маш сайн судалгаа шинжилгээний багтай болохыг зөвлөж байгаа. Үүнтэй адил эдийн засгийн хямралыг даван гарах баг хэрэгтэй юм болов уу?

-Эрүүл мэнд талдаа зөв хамгаалалт хийсэн шиг эдийн засаг дээр тусгай комисс гарах ёстой. Үе, үеийн хямралыг даван гарсан Ерөнхий сайд нар, сайн зөвлөхүүдийг цуглуулж, Ерөнхий сайдын дэргэд маш хүчтэй баг ажиллаж, энэ хямралыг даван гарна. Цэвэр макро эдийн засагчдыг цуглуулж, гадаад, дотоодын бүх нөхцөлд дүн шинжилгээ хийж, түүнд тулгуурласан шийдвэрүүд гаргах учиртай. Өнөөдөр ганцхан Хүрэлбаатар гэдэг Сангийн сайд макро эдийн засгийн бодлогыг барих гээд байна. Энэ хүн дээр макро бүх бодлого төвлөрч болохгүй. Алдаж, онох олон асуудал бий. Даатгалаа санхүүжүүлэх үү, хөрөнгө оруулалтаа санхүүжүүлэх үү, татвараа хөнгөлөх үү гэдгийг ганц хүн биш, баг шийдэх ёстой. Олон ургалч үзлээр олон талаас цуглаж энэ асуудлыг шийдэх нь хамгийн оновчтой. Хоёрт, ямар ч хямралыг аж ахуйн нэгж, иргэний эдийн засгийн эрх чөлөө, хувь хүний амьдралаа авч явах гэсэн хүсэл тэмүүлэл л давж гарсан байдаг. Зарим хямралын үндэс нь төрийн эрх мэдэлтнүүдийн шийдвэртэй холбоотой байсан. Гэтэл хямрал руу оруулсан нэг ч улстөрч хариуцлага хүлээгээгүй, зарим нь УИХ-д хүртэл сууж байна. Энэ нь өөрөө асуудал шүү.

У.Хүрэлсүхэд 30 дахь Ерөнхий сайд байхдаа хийсэн гавьяа бий. Одоо 31 Ерөнхий сайд байхдаа хийх гавьяа нь...

-Хэрвээ бид ажлын байраа хамгаалж чадахгүй, хэдэн зуун мянгаараа ажилгүй болбол жинхэнэ нийгмийн том асуудал болж хувирах байх.

-Тийм шүү. Одоо аль болох бизнесийг суллаж өгөөд, ажлын байраа хадгалж үлдэхийн төлөө зүтгэх ёстой. Тиймээс төр ажлын байраа хадгалж байгаа иргэн, аж ахуйн нэгжээ дээдэлсэн зөөлөн бодлого бариасай. Төр цалингаа тавьж компанийн хажуугаар нүдээ аниад өнгөр л дөө. Сая гэхэд талх, гурилын үнэ нэмлээ гэдэг сургаар төрийн 12 ажилтан нэг компанид хяналт, шалгалт хийсэн гэнэ. Өнөөдөр 100 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компани үнээ 50 төгрөгөөр нэмээд ч хамаагүй бүтээгдэхүүн гаргаж байгаа нь чухал. Учир нь, тэр үйлдвэрийн цаана 100 гаруй хүн ажилтай байна шүү дээ. Ерөнхий сайд талх, гурилын үнэ нэмлээ гээд загнахад л төрийн зарим байгууллага нь ажлын байраа хадгалаад ажиллаж байгаа компани, ААН рүү шалгалт оруулж, дарамталж байна. Одоо ийм шаардлага хэрэггүй. Харин нэг ч ажлын байраа алдаж болохгүй шүү гэдэгт сэтгэл зовж, бодлого гарга л даа. Өнөөдөр гадна, дотнын компани сонин биш. Хамгийн гол нь хүнээ ажилтай байлгаж байгааг нь хүндэтгэх ёстой.

Өмнөх Засаг, У.Хүрэлсүх Монгол Улсын 30 дахь Ерөнхий сайд байхдаа хийсэн хамгийн том гавьяа бол Татварын багц хуулийг батлуулж чадсан явдал. Энэ хуулийн ачаар санхүүгийн тайлан хоёрхон удаа гаргаж, нийт компаниудын 93 хувь нь нэг хувийн татвартай болсон. Энэ сайн талууд нь иргэн, ААН-дээ татварын талаас ирэх дарамтыг багасгаж байна. Одоо У.Хүрэлсүхийн дараагийн том гавьяа бол нийгмийн даатгалын системийг цэгцэлж, үүгээр дамжуулан хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах асуудал юм.

-Ерөнхий сайд “Бүх зүйлийг чөлөөт зах зээл гэдэгт даатгаад орхиж болохгүй, зарим салбарт зайлшгүй төрийн оролцоо байх ёстой” гэж хэлснийг хувийн хэвшлийнхэн нэлээд хүндээр тусгаж авсан санагдсан. Гэхдээ цаад санаа нь коммунист үеийнх шиг

бүх зүйлийг төр шийднэ, хийнэ гэж хэлээгүй юм шиг байсан. Миний хувьд төр сайн хууль гаргах нь хамгийн зөв оролцоо юм шиг. Таны хувьд төр оролцооно гэдгийг юу гэж ойлгодог вэ?

-Дэлхий дээр өнөөдөр төр оролцдоггүй нийгэм хаана ч байхгүй. 100 хувийн төрийн зохицуулалт хоёрхон улс бол Хойд Солонгос, Куба. Бусад газар холимог яваа. Манай Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх үүрэгт мөнгөний бодлого, улсын төсөв, татвар бий болгох, татварыг хүчингүй болгох, нийгмийн даатгал, газар, газрын хэвлийн баялаг буюу өмчийн 99.99 хувийг төр мэдэж байгаа. Дээр нь компани байгуулах, үйл ажиллагаа явуулах эрхийн бичгийг төр олгож байгаа. Манайд төр оролцохгүй салбар гэж байхгүй шүү. Харин энэ оролцоо зөв явж байна уу гэдэгт л асуудал бий. Өнөөдөр 10 мянган такси явах газарт 100 мянган таксины лиценз олговол төрийн оролцоогоор энэ салбарыг дампууруулж байна гэсэн үг. Тиймээс төрийн зохицуулалт шударга, оновчтой, ил тод байх ёстой. Нөгөө талаас орчин үеийн улстөрчийн гол шалгуур бол нийтийн санхүү, нийтийн өмчийг хэрхэн зөв, захиран зарцуулахад чиглэх ёстой. НӨАТ-ын системээр хөдөлж байгаа болгоноос татвар авч байна. Гэтэл цуглуулаад өгсөн мөнгийг дахин зарцуулахад одоо хүртэл зөв оновчлолтой биш, шийдэхгүй байна. Жижиг эрх мэдэлтнээс том дарга хүртлээ захиран зарцуулж байгаа бүх зүйл нь шилэн байх ёстой. Гэтэл өнөөдөр нөгөө шилэн данс цемент болчихсон. Хяналтгүй, ил тод биш байгаагаас болж нийтийн төлөө хийж байгаа бүхэн маш чанаргүй байна. Төр чанаргүй юм хийдэг, чанаргүй үйлчилгээ үзүүлдэг, хариуцлагагүй чанаргүй төрийн систем нь Монголын хямралын хамгийн том үндэс болсон. Эдийн засгийн 30 гаруй хувийг бүрдүүлдэг төрийн байгууллагуудын төвлөрсөн мөнгө үнэ цэнэтэй. Хоёрт, төрийн өмчийн хамааралтай улсын өмчийн 500 үйлдвэр байна. Тэднээс 120 үйлдвэр ДНБ-д том хувь эзэлдэг. УБТЗ, Эрдэнэт, Эрдэнэс-Тавантолгой, Монголросцветмент, МИАТ гэх мэт. Гэтэл эдгээр компаниуд цэвэр зах зээлийн зарчмаар явахгүй байгаа. Тиймээс төрийн оролцоог зөв оновчтой болгох нь Ерөнхий сайдын гол ажил байх ёстой. Төрийн зөв оролцоог төр өөрөөсөө эхлэх учиртай. Төрийн оролцоогүй салбар гэж байхгүй шүү.

-Монгол Улсын нийт гадаад өр 30.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүний дийлэнх нь хувийн хэвшлийн замбараагүй тавьсан өр гэдгийг Ерөнхий сайд шүүмжилсэн. Та үүнтэй санал нийлэх үү?

-Нийт гадаад өрийн 18.5 тэрбум нь хувийн компаниуд өр гэж байгаа. Үүний 11 тэрбум нь дангаараа Оюутолгойн өр. Энэ нь Засгийн газрын оролцоотой төсөл шүү дээ. Цаана үлдсэн 7-8 тэрбум долларын өр нь бүгд эзэнтэй байгаа. Засгийн газрын 7.2 тэрбум ам.долларын өрийг хасаад бусад нь бүгд лицензээр барьцаалагдсан өр. Өнөөдөр 23 тэрбум ам.долларын үнэ цэнэ хүрэх зүйл бол газрын хэвлийн баялаг. Тиймээс төрд мэдэгдэлгүйгээр компаниуд лицензээ тавиад өрөнд орчихлоо гээд байгаа юм. Манай улсын 30 тэрбум ам.долларын цаана гурван их наяд ам.доллаароор үнэлэгдэх газар газрын хэвлийн баялгийг ашиглах процесс явагдаж байгаа. Ийм хэмжээнд үнэлэгдэх баялаг байгаа гэсэн үг. Гурван их наядар үнэлэгдэх баялгийг ашиглахын тулд 30 тэрбумын хөрөнгө оруулалт авах л ёстой. Ийм процессыг олж харахгүй бол асуудал болно. Ерөнхий сайдын хувьд хувийн хэвшлийн өр, төрийн өр гэж ялгаж ярих нь зохиомжгүй, тийм ойлголт байдаггүй юм шүү. Ерөнхий сайд бол Монгол Улсын газар нутаг дээрх бүх зүйлд санаа зовж, зарцуулалтыг хянах ёстой.

Энэ бол Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг. Харин аж ахуй эрхлэх, эдийн засгийн чөлөөт байдлыг коронавирус, цар тахлаар булааж болохгүй.

-Намрын чуулганаар 2021 оны төсвөө батална. Ирэх оны төсөв дээр Та ямар санал хэлэх үү?

-2021 оны төсвийг хэлэлцэхээс урьдаж 2020 оны төсвийг дахиад тодотгох болов уу гэж харж байна. Сая аргацаасан тодотгол болсон учраас дахиад зардлаа танах нөхцөл үүсч байна. Ирэх оны төсөв нэлээд чамбай болох ёстой. Төрийн 200 гаруй мянган албан хаагчийн 80 мянга нь дарга байгаа. Ядаж үүнийхээ хорин мянгыг нь цомхотгох хэрэгтэй. Төр өөрийнхөө зардлыг багасгах асуудлыг нэгд тавь. Хоёрт, төрийн өмчит улсын үйлдвэрийн газруудаас ашигтай ажиллаж байгаагаас бусдыг нь хувьчлах хэрэгтэй. Гуравт, ирэх жил болох Ерөнхийлөгчийн сонгуульд зориулж янз бүрийн нийгмийн асуудлыг шийдэх нэртэй том мөнгө хэвлэх асуудалд төр засаг хянамгай хандаж, мэргэжлийн байх учиртай.

-Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

“

Манай улс эрүүл мэндийн хувьд хамгаалалт хийж чадсан. Харин эдийн засаг, нийгмийн асуудалдаа хожуу арга хэмжээ авч байгаа. Өнгөрсөн хавар бол амь аргацаасан арга хэмжээг авсан. Хамгийн гол нь ажлын байр бий болгож, татвар төлж байгаа аж ахуйн нэгжээ том, жижиг гэлтгүйгээр тогтвортой ажиллах боломжоор хангах ёстой юм.

”



Ганзоригийн Санжааханд

2016 онд УБИС-ийг төгссөн.

2017 онд "Монголын мэдээ"

сониноос ажлын гараагаа эхлүүлсэн.

2018 оноос "Засгийн газрын мэдээ" сонины Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах албанд ажиллаж байна.

“Засгийн газрын мэдээ” сонин

**"КОВИД БА БИЗНЕС"
ЦУВРАЛ СУРВАЛЖИЛГА**

*~ХООЛНЫ САЛБАРЫН ХОДООД
“ХОНХОЛЗОЖ” ЭХЭЛЛЭЭ~*

Сард 7-8 сая төгрөгийн ашигтай ажилладаг зоогийн газрууд сая төгрөг олж байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2019 онд 479.6 тэрбум төгрөг болж, 20 орчим хувиар өсөж байлаа. Харин энэ онд тус салбарын орлого огцом буурахаар байна.

Коронавирусийн халдвараас болж зоогийн газруудын орлого 30-60 хувь буурчээ. Хүн бүр гадуур хооллохоос татгалзаж байгаа нь орлогод хамгийн ихээр нөлөөлсөн гэдгийг үйлчилгээ эрхлэгчид хэлж байна. ҮСХ-ны мэдээллээр нийтийн хоолны салбарт 11,000 хүн ажилладаг. Орлого нь огцом буурснаар дээрх ажлын байр үгүй болох эрсдэл өндөр байна. Тав тух, амт чанар, тансаг үйлчилгээгээр Монголдоо манлайлдаг зоогийн газруудын орлого 40 хувиар буурсан аж. Эдгээр томоохон газрууд 2-3 дугаар сард уналттай байдаг ч гуравдугаар сарын дундаас орлого нь нэмэгддэг. Гэтэл тухайн нөхцөл байдал энэ жил 1-5 дугаар сар хүртэл үргэлжилжээ.

Тухайлбал, Monet ресторан амралтын өдрүүдэд ямар ч орлогогүй болсон учир сүүлийн гурван сар тухайн өдрүүдэд амрах хуваарь гаргасан байна. Үүнтэй холбоотойгоор ажилчдын цаг багассан учир жинхлээгүй болон ээлжийн амралттай байсан 70 орчим хүнээ цомхотгожээ. Хоёрдугаар сард түрээсийн зардал 20 хувь буурсан нь ихээхэн дэм болсон хэдий ч дараа сарын түрээс нь хөнгөлөгдөөгүй байна. Өмнөх оны ашгаараа хоёр болон гуравдугаар сарын зардлаа зохицуулсан тул өнгөрсөн сараас хүнд байдалд орсон гэнэ.

Тус рестораныг ажиллуулдаг MGC Star

Group ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал Ш.Гантулга “COVID-19-ийн халдвараас болоод хилээр орж ирэх боломжгүй болсон бүтээгдэхүүнээр хийдэг хоолоо танаж, хураангуй цэс гаргасан. Өнгөрсөн жил хоёрдугаар сард жуулчид гэрээгээ хийгээд дууссан байдаг байлаа. Гэтэл энэ жил ганцхан компани гэрээ хийсэн” гэв. Тус компани зургаан салбартай бөгөөд цаашдаа хорио сунгагдвал аль нэг салбараа татан буулгах арга хэмжээ авахаас өөр аргагүй болжээ.

Харин хотын төвд байрлалтай, олон хүн үйлчлүүлэх боломжтой Багшийн дээдийн автобусны буудлаар эгнэн байрлах зоогийн газруудын орлого 50-60 хувиар буурсан байна. Хоолны газар ажиллуулаад таван жил болсон Сүхбаатар дүүргийн иргэн сүүлийн хоёр сарын түрээсээ 50 хувь хөнгөлүүлсэн хэрнээ түрээсээ төлж чадахгүй, ажилчдынхаа хэрэгцээг хангахын тулд ажиллаж байгаагаа хэлсэн юм.

Тэрбээр “Орлого 60 хувиар буурсан. Түрээсээ төлөхөд ч хэцүү байна. Оюутнууд амарсан хэдий ч оффис ажилтай хүмүүсийн хөл тасардаггүй байлаа. Гэтэл энэ зуны хувьд нөхцөл байдал их бүрхэг байна. Хүмүүсийн хөдөлгөөн эрс багассан. Цагаан сараар гэр рүүгээ явсан орон нутгийн гурван ажилчнаа нөхцөл байдал хүнд байхад ирээд хэрэггүй гэж хэлсэн. Зээлээ гурван сараар хойшлуулж, дараа сарууддаа хувааж өгөх зэргээр аргалж л байна. Байдал удаан үргэлжилбэл эргэн төлөлт нэмэгдсээр хэцүү байдалд орох эрсдэл үүссэн.

Хүмүүс гадуур хооллохоос зайлсхийсэн учир зоогийн газрын салбарт нөхцөл байдал хүнд л байна. Мөн нарийн ногооноос гадна хүнсний ногооны үнэ хүртэл нэмэгдсэн” гэв. Түүнчлэн Sunday худалдааны төв болон Нарантуул захын эргэн тойронд байх зоогийн гуанзнууд орлого ч мөн буурчээ. Баянзүрх дүүргийн иргэн Ц.Шүрэнцэцэг өдөрт хоёр сая төгрөгийн орлого олдог байсан бол одоо гурав дахин буурсан гэв.

Өглөө эрт эмнэлэг орох ажилтай, цайгаа уугаагүй гэрээсээ гарсан хүмүүс л мэр сэр орж ирдэг гэнэ. 24:00 цагт хаадаг байсан бол одоо 17:00 цагаас хойш хоол идэх гэсэн хүмүүс өдрийн од шиг болжээ. Тэрбээр “Түрээсээсээ 500 мянган төгрөг хасуулах гээд бүтээгүй. Банкны зээлээс чөлөөлөгдөх гэж хөөцөлдсөн ч бас л бүтэхгүй байна. Цайны газар зээлийн хөнгөлөлтөд хамрагдах боломжгүй гэж арилжааны банкууд хэлсэн. Манай орлого өнгөрсөн нэгдүгээр сараас хойш багасаж эхэлсэн. Өрх толгойлсон эмэгтэйчүүд ажиллуулдаг болохоор ар гэрийнхнийг нь бодоод цалинг нь 5-10 мянган төгрөгөөр багасгаад ажиллуулж л байна” хэмээв.

Тэр хавьдаа томд тооцогдох тус зоогийн газар сард 7-8 сая төгрөгийн ашигтай байдаг байсан бол одоо сая төгрөг л олох болжээ. Уг салбарынхны орлого ямар ч үед доголдохгүй гэж хүн бүр боддог ч COVID-19-ийн халдвар зоогийн газруудыг ч “ганхуулж” эхэлжээ.

~БЭЛЭН ХУВЦАСНЫ БОРЛУУЛАЛТ 50-80 ХУВЬ БАГАСЧЭЭ~

Захиалсан бараа нь 15 хоногийн дараа ирж байгаа учир мөнгөө эргэлдүүлж чадахаа больжээ

"Өөрсдөө очиж бараагаа авахгүй болохоор хятадууд гоё зураг харуулчихаад муу хувцас явуулах нь ихэссэн. Нэгэнт ирсэн барааг буцааж болохгүй болохоор өөрсдөө л хохирч байна" гэв

Коронавирусийн халдвараас болоод бэлэн хувцасны борлуулалт 50-80 хувь буурчээ. Борлуулалт буурах болсон гол шалтгаан нь их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг орохгүй байгаатай шууд хамааралтай болохыг худалдагчид хэлж байсан юм. Ямар ч үед үйлчлүүлэгчдийнхээ хөлд дарагдаж байдаг Бөмбөгөр худалдааны төв коронавирус гарснаас хойш сэлүүхэн байх болжээ. Үйлчлүүлэгчид нь эрс багассанаас болж бэлэн хувцасны борлуулалт 70 хувь буурсан аж.

Тус төв эхэндээ түрээсээ 30 хувь хөнгөлж байсан ч сар бүр арав арваар бууруулсаар одоо 10 хувь хөнгөлж байгаа гэнэ. Бөмбөгөр худалдааны төвийн худалдагч “Сургууль, цэцэрлэг орохгүй байгаатай холбоотойгоор орлого эрс багассан. 30 хувийн орлогоор амьдралаа залгуулж байна. Хөл хорионоос болоод нөхцөл байдал үнэхээр хүнд байна. Орлого багасахаас гадна хил хаасантай холбоотойгоор бараагаа авч ирэхэд асуудал их гарах боллоо. Өөрсдөө очиж бараагаа авахгүй болохоор хятадууд гоё зураг харуулчихаад муу хувцас явуулах нь ихэссэн. Нэгэнт ирсэн барааг буцааж болохгүй болохоор өөрсдөө л хохирч байна.

Мөн захиалсан бараа 15 хоногийн дараа ирж байгаа учир мөнгөө эргэлдүүлж чадахаа больсон. Юань өссөн учир зардал ч нэмэгдэж байгаа. Гэтэл бид бэлэн хувцасныхаа үнийг нэмж зарах бус 5-10 мянган төгрөгөөр хямдруулж байгаа нь бүр их алдагдалд оруулж байна” гэв.

Тэрбээр түрээс, ажилчдын цалин зэрэг зардлаа төлөөд сард сая төгрөгийн ашиг олдог байжээ. Гэтэл одоо олох ёстой ашиг нь хасах зааж, өр болон хуримтлагдах болсон тул банкнаас авсан зээлээ гурван сараар хойшлуулахаас өөр аргагүй болсон аж. Харин бэлэн хувцасны зах зээлд томоохон байр суурь эзэлдэг Teganavo брэндийн хувьд орлого нь 50 хувиар буурчээ.

Хороололд байрлах салбарын худалдааны ахлах зөвлөх О.Бямбасүрэн “Сургууль, цэцэрлэг орохгүй байгаатай холбоотойгоор хүүхдийн хувцасны борлуулалт эрс багассан. Эцэг, эхчүүд одоо хуучин хувцсаараа аргалж байгаад намар хичээл эхлэхээр шинэ хувцас авч өгье гэж хүүхдүүддээ хэлж байна лээ. Үйлчлүүлэгчдээ алдахгүйн тулд ойр ойрхон 50-80 хувийн хямдрал зарлаж байна. Хямдрал зарласан тулдаа л борлуулалт 50 хувьтай байгаа юм. Ажилчид маань борлуулалтаараа цалинждаг болохоор орлогоо дагаад цалин ч буурсан.

Мөн ажиллах цаг ч багасаад нөхцөл байдал хүндхэн л байна” хэмээлээ. Дүнжингарав худалдааны төвийн хувьд орлого нь 80 хувь буурсан байна. Тус төвийн худалдагчид бэлэн хувцасны борлуулалт эрс буурсан талаар ам уралдан хэлж байлаа. 40 орчим насны эмэгтэй “Үйлчлүүлэгч үнэхээр муу байна. Нэг ч төгрөгийн орлого олохгүйгээр гэртээ харих өдрийн тоо нэмэгдсээр байгаа. Хүүхдүүдээ хоногийн хоолгүй болгочихгүйн тулд өөр ажил хажуугаар нь хийхээр болсон. Гэтэл лангуун дээр суух хүн олдохгүй хэцүү байна. Арга ядахдаа хамаатан садныхаа хүүхдүүдийг гуйдаг ч үйлчлүүлэгч байхгүй үед цагтаа онгойх хэрэг байхгүй гэж уурлаад 2-3 цаг л нээлттэй байлгах юм.

Би завтай болохоороо 10-20 мянган төгрөг нь хаа юм гээд өглөөнөөс орой хүртэл нүдээ ширгэтэл хүлээн сууна. Хямдрал зарлаад ч борлуулалт нэмэгдэхгүй байна” хэмээн учирлалаа. COVID-19 цар тахлын хөл хориог сунгасаар байгаа нь бизнес эрхлэгчдийн орлогод ихээхэн нөлөөлөх болсныг тэд хэлж байлаа. Мөн хил хааснаас болж бараа бүтээгдэхүүний үнэ улам нэмэгдэж, ихээхэн хохирол амсах болсон тул

ЭНЭХҮҮ ДАРАМТЫГ ХӨНГӨЛЖ ӨГӨХИЙГ ТӨР ЗАСГААСАА ГУЙСАН ЮМ.

~ИМПОРТЫН ГУТАЛНУУД МӨНГӨ БУС, ӨР БОЛЖ БАЙНА~

Коронавирусийн халдвараас болоод гутлын худалдаа эрхлэгчдийн орлого 50-100 хувь буурчээ. Орлого буурах гол шалтгаан нь иргэдийн худалдан авалт муу байгаатай холбоотой гэнэ. “Нарантуул” олон улсын худалдааны төвийн хувьд орлого нь 50-70 хувь буурсан байна. Тус төвийн гутлын тасгаар явахад бум бужигнаж, түм түжигнэдэг байсан бол корона вирусийн халдвараас болоод эл хуль байх болжээ.

Хаврын түрийтэй гутал, пүүз, зуны углааш, сандаал зэрэг төрөл бүрийн гутал зардаг лангуунуудын дийлэнх нь үйлчлүүлэгчгүй байв. COVID-19 цар тахал хэрхэн нөлөөлж байгаа талаар худалдагчдаас асуухад 40 гаруй насны эмэгтэй “Үйлчлүүлэгчгүй байгааг харахгүй байна уу. Ямар сайндаа утсаараа тоглоод сууж байх вэ. Нэг ч гутал зарахгүй өдөр хүртэл байна. Хүмүүс авах байх гэж бодоод төрөл бүрийн гутал авчирсан. Гэтэл одоо байгаа байдлыг нь хар” хэмээн уцаарлав. “Нарантуул” олон улсын худалдааны төвд 1000 гаруй гутлын лангуу байдаг аж.

Үйлчлүүлэгч багасаж, орлого буурснаас болж 10 орчим лангуу нь үйлажиллагаагаа зогсоожээ. Тус төвийн худалдагч Н.Хишигсүрэн “Үйлчлүүлэгчид гутал үнэтэй бол авахгүй. Хямд бол чанаргүй гээд бас авахгүй юм. Ажиглаад байхад дундаж үнэ л сонирхоод байх шиг байсан. Орлого буурсан болохоор түрээсээ арай гэж төлөөд өдрийн хоолны мөнгөтэйгөө үлддэг. Нарантуул зах түрээсээ 15 хувь бууруулсан нь нэмэр болж байна. Гэхдээ гутал зарахгүй өдөр цөөнгүй байгаа учраас нөхцөл байдал үнэхээр хүнд байгаа.

Мөн хөл хорионоос болоод импортоор авах гутлын үнэ нэмэгдсэн. БНХАУ-ын худалдаачид хүссэн үнээ хэлдэг. Тэгсэн хэрнээ чанар муутай, ижил буруу гутал их явуулах болсон. Цахимаар захиалга өгдөг болохоор хулхидаад байна. Үүнээс гадна захиалга өгсний дараа 7-10 хонож ирдэг. Тэгэхээр улирлын чанартай гутал зарагдахгүй болох эрсдэл үүснэ” гэсэн юм.

Өөрт байсан мөнгөөрөө зуны гутлууд авчиртал борлуулж, мөнгөө гаргаж авч чадахгүй болчихлоо. Бараа байсан бол идэхсэн. Гэтэл одоо энэ их гутлыг яалтай билээб.

Харин Sunday худалдааны төвийн орлого бараг л 100 хувь буурчээ. Үйлчлүүлэгч өдрийн од шиг байх болсон гэнэ. Тус төвийн худалдагч 50 орчим насны эмэгтэй “Орлого тэг заасан. Гутал сонирхож байгаа боловч мөнгөгүй болохоор хүмүүс авч чадахгүй байна. Гутлаа оруулж ирэхдээ өмнөх жилийнхээс илүү үнэтэй авч байгаа хэрнээ хямдруулж зарж байгаа. Өөрт байсан мөнгөөрөө зуны гутлууд авчиртал борлуулж, мөнгөө гаргаж авч чадахгүй болчихлоо. Бараа байсан бол идэхсэн. Гэтэл одоо энэ их гутлыг яалтай билээ. Өдрийн хоолоо ч авч чадахгүй байдалтай тулгараад байна. Өдий настай болсон намайг хэн ч ажилд авахгүй хэн ч тэжээхгүй шүү дээ. Тиймээс зээлээс зээлийн хооронд өдөр хоногийг өнгөрөөж байна” хэмээлээ. Тэрбээр түрээс, ажилчдын цалин зэрэгт сардаа хоёр сая төгрөг төлдөг.

Гэтэл одоо 14 хоногтоо 600 мянган төгрөгийн орлого олох болсон учир урд хормойгоороо хойд хормойгоо нөхөөд өдөр хоногийг аргацааж байгаа аж.

“Алтжин бөмбөгөр” худалдааны төвийн хувьд орлого нь мөн 80-100 хувь буурчээ. Борлуулалт муу байхад түрээсээ нэг ч төгрөг хөнгөлөхгүй байгаад нь худалдагчид гомдолтой байгаагаа учирлалаа. Тус төвийн худалдагч 25 гаруй насны эмэгтэй “Үйлчлүүлэгч байхгүй болохоор утсаа оролдоод тарах цагаа хүлээдэг. Нэг ч гутал зарахгүй байх өдрийн тоо ихэссээр байгаа. Манай эзэн түрээсээ арай гэж өгдөг болохоор миний цалинг өгдөггүй. Сүүлийн хоёр сар нэг ч төгрөг аваагүй.

Энэ өвчин гайгүй болвол нөхцөл байдал дээрдэх байх гээд хүлээж л байна. Одоо ажлаасаа гарлаа гээд надад ажил олдохгүй нь ойлгомжтой. Тэгэхээр авах зүйлийн учир олдоно гэж бодоод гутлаа сайн зарагдаасай гэж бодоод сууна” гэсэн юм. Төрийн алдаатай шийдвэрээс болоод жижиг, дунд бизнес эрхлэгчид дандаа хохирдог хэмээн худалдагчид ихээхэн гомдолтой байлаа. Нэг хүний ард хэчнээн нүд бүлтэлзэж, ам нь ангалздаг гэдгийг төр засаг мэдэх цаг нь хэдийн болжээ. Сонгуулийн пи-ар хийж, худлаа дүр эсгэсэн нэр дэвшигчдийн шийдвэр хэзээ нүдээ олохыг иргэд хүлээн сууна.

~ГУТАЛЧИН, ОЁДОЛЧНЫ ОРЛОГО 40-100 ХУВИАР БУУРЧЭЭ~

Сард сая төгрөгийн орлого олдог байсан бол одоо 100 хувь орлогогүй болсон гэв

"Өдөрт дунджаар 40-50 хүн үйлчлүүлдэг байсан бол одоо хоёр дахин багассан. Энэ нөхцөл байдал цаашид улам хүндэрвэл хэрхэн тэсэж гарахаа мэдэхгүй байна" гэв

COVID-19-ийн халдвараас болж дэлхийн хэмжээнд эдийн засгийн хямрал нүүрлэж, хүндхэн байдалтай байгаа энэ үед жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал ямар байгаа талаар сурвалжиллаа. Энэхүү цуврал сурвалжлагынхаа эхний дугаарт оёдолчин болон гутал засварчин хүмүүсийн орлогод хэрхэн нөлөөлсөн талаар бодит байдлыг хүргэж байна. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын орлого 40-100 хувь буурсан болохыг тэд хэлсэн юм. Өөрсдийнх нь хүсэлтээр нэрсийг нь нууцалсан болно. 20 гаруй жил гутал засвар ажлуулсан Баянзүрх дүүргийн иргэний орлого 40 хувиар буурчээ. Тэрбээр “COVID-19-ийн халдвараас болж бүхий л салбарын эдийн засаг хүнд байдалтай байна. Өдөрт дунджаар 40-50 хүн үйлчлүүлдэг байсан бол одоо хоёр дахин багассан. Хямд үнээр үйлчилдэг болохоор орлого улам багасаж байна. Мөн хөл хорионоос болж материалын олдоц багасах боллоо. Түрээсийн мөнгө төлдөггүй ч би зээлтэй. Монголд зээлгүй хүн байхгүй шүү дээ. Энэ нөхцөл байдал цаашид улам хүндэрвэл хэрхэн тэсэж гарахаа мэдэхгүй байна” гэв.

Харин урт цагаанд үйл ажиллагаа явуулаад жил болж буй гутал засварчин өмнө нь олдог байсан орлогынхоо 30 хувийг арай гэж олдог гэнэ. Шатны доод талыг ашиглан хийсэн умгар өрөөг 300 мянган төгрөгөөр түрээсэлдэг. Тэрбээр “Өдөрт 20 орчим хүн орж ирдэг байсан, гэтэл одоо 2-3 хүн л үйлчлүүлэх болсон. Урт цагаан хэвийн үйл ажиллагаа явуулдаг байхад түрээсээ асуудалгүй төлдөг байлаа. Одоо өдөрт 30 мянган төгрөг л олж байна. Цаашид түрээсээ төлөх боломжгүй болсон ч энэ газраасаа хөөгдөхгүйг хичээхээс өөр арга алга” хэмээлээ.

COVID-19-ийн халдвар гарсантай холбогдуулан ажилгүй, мөнгөгүй болсон хүмүүс олширсон талаар үйлчлүүлэгчид нь ам уралдан ярьдаг гэнэ. 20 жил Урт цагаанд оёдолчноор ажилласан эмэгтэй ажлын байрыг нь буулгана гэх сургаар өөр газар түрээсэлсэн боловч орлогогүйгээс ялгаагүй байгаа аж. Түүний орлого

бараг 100 хувь буурчээ. Сард ойролцоогоор 600-700 мянган төгрөг өлхөн олдог байсан тэрбээр одоо ямар ч орлогогүй мөртлөө сард 800 мянган төгрөгийн түрээс төлдөг гэв. Мөн эхний сарын түрээсээ төлсөн ч орлогогүй болохоор цаашид түрээсээ яаж төлөхөө мэдэхгүй байна. Энэ байдлыг харж үзээд түрээсээ ядаж 10-20 хувиар бууруулахад асар их дэм болно. Хил хаагдсан учраас материалын үнэ хүртэл нэмэгдсэн” гэсэн юм.

Түрээсийн байр хайсан ч үнэ тохиролцож чадаагүй Чингэлтэй дүүргийн иргэн, 30 гаруй насны оёдолчин бүсгүй байнгын үйлчлүүлэгдийнхээ хувцсыг гэртээ оёчихоод Урт цагаан дээр байдаг хуучин ажлын байран дээрээ хүлээн сууж байв.

Тэрбээр “Тог, ус, цахилгаан зэргийг тасалж түрээслэгчээ ажилгүй болгосон. COVID-19-ийн халдвар гайгүй болсны дараа энэ асуудлаа шийдэж болоогүй юм байх даа. Одоо ажилгүй маш хүнд байна. Урт цагаан байхгүй болсон гээд хүмүүс үйлчлүүлэхээ больсон. Сард сая төгрөгийн орлоготой ажилладаг байлаа. Одоо 100 хувь орлогогүй болчихоод байна” хэмээн уцаарлангуй хэлэв.

COVID-19-ийн халдвараас болж хоёрдугаар сараас хөл хорио тогтоож эхэлснээс болж орлого нь буурсан хувийн хэвшлийнхэн мухардалд орсноо ийнхүү ярилаа. Бүх үйлчилгээ нь нэг дор төвлөрдөг Урт цагааны үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсан өдрөөс эхлэн нөхцөл байдал улам хүндэрчээ. Ус, тог, цахилгаангүй болсон түрээслэгчид хуучин ажлын байраа тойрон тархан суурьшсан байна.



COVID-19-ийн халдвараас болж дэлхийн хэмжээнд эдийн засгийн хямрал нүүрлэж, хүндхэн байдалтай байгаа энэ үед жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал ямар байгаа талаар сурвалжиллаа. Энэхүү цуврал сурвалжлагынхаа эхний дугаарт оёдолчин болон гутал засварчин хүмүүсийн орлогод хэрхэн нөлөөлсөн талаар бодит байдлыг хүргэж байна.



Хөл хорионы үед улс орнууд ИРГЭДЭЭ ХЭРХЭН ДЭМЖИЖ БАЙНА ВЭ?



АНУ

Америкийн Нэгдсэн Улс иргэн бүртээ 1200 ам.долларын чек олгож байна.

3,340,404₮



Хонгконг

Хонгконгийн засгийн газар 6 сарын турш ажилчдын цалингийн 50 хувийг олгоно. Нэг ажилтны мөнгөн тусламж ойролцоогоор 1160 ам.доллар.

3,897,138₮



Япон

Япон улс 120 сая иргэндээ тус бүр 930 ам.долларын бэлэн мөнгө олгоно.

3,229,057₮



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Хөл хорионы үед улс орнууд ИРГЭДЭЭ ХЭРХЭН ДЭМЖИЖ БАЙНА ВЭ?



Герман

Берлин дэх ажил олгогчдод болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 5000 ам.доллараас дээш тусламж үзүүлж байна.

13,918,350₮



Франц

Хөл хорионоос болж бизнесээ үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсвэл бизнес нь 70 хувиар буурсан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 1600 ам.доллар хүртэлх бэлэн мөнгө олгож байна.

4,453,872₮



Бельги

Брюссель хот хөл хорионы улмаас ажиллах боломжгүй болсон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 1400 ам.долларын бэлэн мөнгө олгож байна.

3,897,138₮



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Хөл хорионы үед улс орнууд ИРГЭДЭЭ ХЭРХЭН ДЭМЖИЖ БАЙНА ВЭ?



Монгол

Үйл ажиллагаа нь хүндэрсэн ААН-д ажилтны тоогоор 200 мянган төгрөг олгоно. Гэхдээ үүнийг авахын тулд ашиггүй, орлогогүй, тэг зогсолттой байсан ч тухайн ААН нэг ч хүн халаагүй, цалин өгсөөр байх ёстой.

Иргэддээ чиглэсэн арга хэмжээ аваагүй, нийслэлийн төв талбайдаа ногоон байгууламж устган том усан оргилуур барьж байгаа.

200,000₮



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Бэлтгэсэн:
МУХАУТ-ын
Маркетинг,
Олон нийттэй
харилцах газар

2020.04.08



САНХҮҮГЭЭ КАРАНТИНЛАХ



31 | Т

ДЭГЛЭМ



Танхимд ханд ³¹

Бизнес тань тулгарч буй асуудлаар Танхимд ханд, гишүүнээр алсч хураллаа тэл. Шийдлийн төлөө нэгдэцгээе.

Танилц ¹ Эдийн засгийн нөхцөл байдалтайгаа танилц	Төсөөл ² Хувийн санхүүд учирч болох нөхцөл байдлаа бодитой төсөөлж, эрсдэлээ тооц	Төлөвлө ³ Орлого, зарлагаа төлөвлөж, гарах зайшгүй зардлуудаа жагсааж бич.	Танд ⁴ Бусад ААН, бизнес эрхлэгч ямар арга хэмжээ авч бизнесээ хамгаалж, байгаа туршлагаагаа судалж танд.	Тайван ханд ⁵ Хүнд цаг үед тайвнаар хандаж, ухаалаг шийдвэр гарга. Хий түгшүүрт бүү авт.
Тэнцвэртэй бай ⁶ Худал мэдээлэлд авталгүй, найдвартай эх сурвалжаас тэнцвэртэй мэдээлэл ав.	Төсөвлө ⁷ Дараагийн алхмуудаа бодож, шаардлагах төсвийн тооцоог гарга.	Тана ⁸ Хэрэгцээгүй зардлаа танаж, эдийн засгийн нөхцөл байдал хэвийн болтол сахилга баттай бай.	Тохиролц ⁹ Бизнесийн түншүүдтэй харилцан тохиролцож, түншлэл, итгэлцлээ хэвээр хадгалж үлд.	Тур азна ¹⁰ Хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгө авах зэрэг том шийдвэрүүдээ түр хойшлуул, ажигла.
Тооцоол ¹¹ Хорио цэрийн нөхцлөөс бий болох давуу талуудыг судалж тооцоол. Бүх зүйл муу байдаггүй.	Турээсэл ¹² Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдаж авалгүй турээсээр ашиглах боломж хай.	Төл ¹³ Заавал төлөх татвар, зээлийн хүү зэргээ хугацаанд нь төл. Хөнгөлөлт, чөлөөлөлтөд бүү найд.	Тансаглалаас зайлсхий ¹⁴ Онцйн шаардлагагүй нэмэлт зардал, баяр ёслол, аяллаас татгалз.	Тодотго ¹⁵ Бизнесийн үйл ажиллагааныхаа дараагийн алхмуудыг ухаалгаар тодотгож, зөөлөлд.
Тогтмол хадгал ¹⁶ Бага гэлтгүй мөнгө тогтмол хадгалж, эрсдэлийн хуримтлал үүсгэ.	Тэмүүл ¹⁷ Юу ч тохиолдсон хүсэл тэмүүлээ бүү алд.	Тэвч ¹⁸ Авахыг хүсч байсан эд зүйл, хувцас хэрэглэл эхнээн хямдарсан ч бай авахыг бүү яар. Зар сурталчилгаанд бүү авт.	Туйлширч болохгүй ¹⁹ Зөвхөн өөрийн бодлоор, эсвэл бусдын тухирснаар асуудалд хандаж, яаран шийдвэр гаргаж болохгүй.	Тайлагна ²⁰ Нөхцөл байдлаа үнэн зөвөөр амжилтан, албан хаагч, бизнесийн түншүүддээ тайлагнаж шийдлийг хамтдаа хай, ярилц.
Татгалз ²¹ Хаа сайгүй бизнес хүндэрч байгаа энэ үед ашигтай мэт санагдах хөрөнгө оруулалт, хямд үнэтэй объект зэрэгт мөнгө үрээсээ татгалз.	Таларх ²² Хүнд хэцүү цаг үед тусалж дэмжиж байгаа баг хамт олон, ойлгож хүлээцтэй хандаж байгаа харилцагчдаа таларх.	Төсөл хай ²³ Олон улсын хөгжлийн банкуудаас санал болгодог бага хүүтэй зээл, төсөл хөтөлбөрүүдийг судал.	Торгуулиас сэргийл ²⁴ Татвар, хураамж, төлбөрөө цаг тухайд төлж торгууль, алдангид орохоос сэргийл.	Тууштай байх ²⁵ Шинээр хэвшүүлж буй эрүүл ахуйн болон санхүүгийн зөв дадлуудаа тууштай мөрд.
Технологийг ашигла ²⁶ Технологийн дэвшилтэй хөл нийлүүлж, бизнесийн шинэ гарц, онлайн суугуудыг ашигла.	Томоор сэтгэ ²⁷ Эдийн засагч хямарч болохч бизнесийн зорилгоо алдалгүй, өргөн сэтгэ.	Тусла ²⁸ Бусдад тусалж чадах зүйл байвал харамгүй гар сунга.	Тэмдэглэ ²⁹ Санхүүгийн дэглэм барьсан сарын хугацаанд ойлгоон, сурч мэдсэн, судалсан зүйлээ тэмдэглэ.	Түгээ ³⁰ Бусдад хэрэгтэй санаа, олж мэдсэн зүйлсээ хуваалц. Нэгэн цагт хариу нь ирнэ.

Бэлтгэсэн:
МУХАУТ-ын
Маркетинг,
Олон нийттэй
харилцах газар
2020.03.02

ТАЛАРХАХ

5 ЗҮЙЛ

Таны бизнест хүндрэл учирч,
хэрхэх учраа олохгүй байгаа бол
Танхимд хандаарай.

Бид Таны бизнесийн дуу хоолой болж,
шийдлийн төлөө хамтдаа ажиллах болно.



АЖИЛТАЙ БАЙГААДАА

Хөл хориогоор далимдуулж ажлаас
чинь халаагүй удирдлагадаа, бага ч
гэсэн орлоготой байгаа ажилдаа
таларх.



ИНТЕРНЭТТЭЙ БАЙГААДАА

Хэзээ ч хаанаас ч холбогдох сүлжээ,
хямд wifi байгаад таларх.



МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙГААДАА

Цаг алдахгүй зөв мэдээлэл авч,
өөрийгөө болон гэр бүлээ хамгаалж
байгаадаа таларх.



ТАНИН МЭДЭЖ БАЙГААДАА

Завгүй хэмнэлээс хэсэг амсхийснээр
эргэн тойрноо өөрөөр харж, шинэ
зүйл сурч байгаадаа таларх.



НЭГДМЭЛ БАЙГААДАА

Ямар ч асуудал тулгарсан ганцаараа
биш, бусадтай ярилцаж, нэгдсэнээр
гарц олдож, шийдэлд хүрэх боломж
байгаад таларх.

Бэлтгэсэн:
МУХАУТ-ын
Маркетинг,
Олон нийттэй
харилцах газар
2020.03.11



This project is funded by the European Union.